# lendmn

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

## ЛЭНДМН ББСБ ХХК

| Хувь | Нийт тоо ширхэг | Нэрлэсэн үнэ |
|---|---|---|
| **100%** | **800,000,000** | **10 ₮** |

**НИЙТЭД САНАЛ БОЛГОХ**

| Хувь | Нийт тоо ширхэг | Үнэ |
|---|---|---|
| **25%** | **200,000,000** | **25 ₮** |

| | Хувь | Тоо ширхэг | Нийт |
|---|---|---|---|
| **ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ** | 12.5% | 100,000,000 | **2,500,000,000** |
| **СТРАТЕГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД САНАЛ БОЛГОХ** | 12.5% | 100,000,000 | **2,500,000,000** |

**ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ**

**5,000,000,000 ₮**

Арилжааны арга хэлбэр : Тогтоосон үнийн арга

2018 он

MIRAE ASSET Securities

lendmn ҮНЭТ ЦААСНЫ

БҮРТГЭВ
№ 01

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу олон нийтэд анх удаа хувьцаагаа нээлттэй санал болгон гаргаж байгаа болно.

Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 13.1.4-рт заасны дагуу үнэт цаас гаргагчийн олон нийтэд худалдаалах үнэт цаас нь МХБ-ийн хувьцааны бүртгэлийн III дугаар ангиллын шалгуурыг хангаж байгаа тул мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгон арилжаална.

МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 13.1.4-рт заасны дагуу мэргэжлийн хөрөнгө оруулагч биш этгээд худалдан авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үнэт цаас нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн компанидаа бичгээр мэдэгдсэн байна.

"ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА"

Тус үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны хувьцаа худалдан авах шийдвэр гаргалтанд туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтанд танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болох буюу лавлах тодруулах зүйл гарвал Үнэт цаас гаргагч ЛэндМН ББСБ ХХК болон Андеррайтерийн "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" ХХК-д хандана уу.

201 11 19

# ТОВЪЁОГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД 1
ТОВЪЁОГ 2
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР 5
ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ХЭХ-ЫН ШИЙДВЭР 6
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД 7

## НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 8
1.2 ЯАГААД ЭНЭ БИЗНЕСТ ХӨЛ ТАВИХ БОЛОВ? 14
1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭ ШИЙДЭЛ 17
1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 19
1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТУХАЙ 20
1.6 ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ 24
1.7 САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ 25
1.8 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО 30

## ХОЁР. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 32
2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ 46
2.3 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА 66
2.4 ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ 74

## ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 82
3.2 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 82
3.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ 86
3.4 АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 97
3.4.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ 97
3.4.2 АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГА ХЭЛБЭР 103
3.5 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ 105
3.6 ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ҮҮРЭГ 106
3.7 ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ДҮГНЭЛТҮҮД 108
3.7.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ 108
3.7.2 ХУУЛИЙН ДҮГНЭЛТ 146
3.8 АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ 164
3.9 АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА 172

LENDMN

20180119

## ЗУРГИЙН ТОВЪЁОГ

Зураг1. Форбес сэтгүүлд гарсан нийтлэлийн зураг 8
Зураг2. Хөрөнгө оруулагч үндэстэн чуулганд оролцох үеэр 12
Зураг3. Үнэт цаас гаргагчийн оффисын байршил 13
Зураг4. LendMN аппликейшний танилцуулга 17
Зураг5. ЛэндМН ББСБ ХХК-ийн хамт олон 20
Зураг6. Анд Системс ХХК-ийн хамт олон 22
Зураг7. Зээлийн хэрэгцээ шийдэл 57

## ХҮСНЭГТИЙН ТОВЪЁОГ

Хүснэгт1. Бичил санхүүгийн зах зээлд тулгамдсан асуудал 14
Хүснэгт2. Хугацаа хэтэрсэн зээлийн үзүүлэлт 16
Хүснэгт3. Харилцагчийн өсөлтийн тоон үзүүлэлт 16
Хүснэгт4. Анд Глобал компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц 21
Хүснэгт5. Жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч, түүний холбогдох этгээд 23
Хүснэгт6. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц 24
Хүснэгт7. Гүйцэтгэх удирдлагын бүтэц 24
Хүснэгт8. Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан 26
Хүснэгт9. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт 29
Хүснэгт10. Дунд хугацааны бизнесийн загвар 33
Хүснэгт11. Зах зээлийн дийлэнхи хувийг хангах стратеги 36
Хүснэгт12. Биет бус үнэ цэнэтэй баялагуудаа хамгаалах 36
Хүснэгт13. Тайлан тэнцлийн таамаглал 39
Хүснэгт14. Орлогын тайлангийн таамаглал 40
Хүснэгт15. Мөнгөн гүйлгээний таамаглал 41
Хүснэгт16. Орлогын таамаглалын дэлгэрэнгүй 42
Хүснэгт17. Орлогын тайлангийн таамаглал 45
Хүснэгт18.Интернэт болон мобайл банк хэрэглэгчдийн тоо 49
Хүснэгт19.Бичил хэрэглээний зээлийн салбарын оролцогчид 51
Хүснэгт20.Үйлчилгээний харьцуулалт 53
Хүснэгт21.Санхүүгийн аппликейшн татсан үзүүлэлт 60
Хүснэгт22.Шинэ гарсан санхүүгийн аппликейшн татсан үзүүлэлт 61
Хүснэгт23.Хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамж 66
Хүснэгт24.Монгол улсын ДНБ тэлэлтийн төлөв 70
Хүснэгт25.Монгол улсын ЗГ-ийн зээлжих зэрэглэл 73
Хүснэгт26.Хувьцаа гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц 82
Хүснэгт27.Бэлэн мөнгөний хэрэглээний төсөөлөл 85
Хүснэгт28.Хувьцааны ханшийн өгөөжийн таамаглал 88
Хүснэгт29.Нийтлэг хэмжээст тайлан тэнцэл 91
Хүснэгт30.Нийтлэг хэмжээст орлогын тайлан 92
Хүснэгт31.Нийтлэг хэмжээст мөнгөн гүйлгээ 92
Хүснэгт32.2017 Дупонт шинжилгээ 93
Хүснэгт33.2018 Дупонт шинжилгээ 93
Хүснэгт34.2019 Дупонт шинжилгээ 94
Хүснэгт35.2020 Дупонт шинжилгээ 94
Хүснэгт36.2021 Дупонт шинжилгээ 95
Хүснэгт37.2022 Дупонт шинжилгээ 95
Хүснэгт38.Дупонт шинжилгээний тайлбар 96
Хүснэгт39.Финтек бүтээгдэхүүний ирээдүйн өсөлт 100
Хүснэгт40.Орлогын хандлагаар хийсэн үнэлгээний дүн 102
Хүснэгт41.Нэгж хувьцааны үнэ цэнэ 102
Хүснэгт42.Нэгж хувьцааны үнэ цэнийн өсөлт 103
Хүснэгт43.Мөнгө байршуулах заавар 104

## СХЕМИЙН ТОВЪЁОГ

Схем1. Санхүүгийн зах зээлд финтек нэвтэрсэн байдал 15
Схем2. ЛэндМН үйлчилгээний шийдлүүд 17
Схем3. ЛэндМН аппликейшнийг ашиглах алхмууд 18
Схем4. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт 19
Схем5. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн бүтэц 20
Схем6. Анд Глобал компанийн хувь эзэмшлийн бүтэц 21
Схем7. Анд системс ХХК-ийн хувь эзэмшлийн бүтэц 22
Схем8. ЛэндМН-ийн маркетинг 38
Схем9. Анхдагч зах зээлд байршуулах хуваарь 97

## ГРАФИКИЙН ТОВЪЁОГ

График1. Идэвхитэй хэрэглэгчдийн өсөлт 44
График2. ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт зээлд эзлэх бусад зээлийн хувь 46
График3. ББСБ-ын салбарын нийт олгосон зээлийн хэмжээ 46
График4. Банк болон ББСБ-ын нийт актив, олгосон зээлийн өсөлт 47
График5. ББСБ-ын нэг хүнд хогдох дундаж зээлийн үлдэгдэл 48
График6. ББСБ-ын зээлдэгчийн тоо, насны бүтэц 48
График7. 2017оны 1-р улиралын банкны зээлэнд эзлэх хэрэглээний зээл 49
График8. Дэлхийн хэмжээнд Финтекийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 54
График9. Хиймэл оюун ухаан ашиглаж буй салбарууд 54
График10. Арилжааны болон цахим банкны зардлын харьцуулалт 56
График11. Боловсон хүчний зардал 57
График12. Нийт үйл ажиллагааны зардал 57
График13. Хэрэглэгчийн нас болон цалингийн ангилал 59
График14. Ажил эрхлэгчийн орлого, технологийн хэрэглээ 61
График15. Ипотекийн зээлтэй иргэдийн дундаж нас 62
График16. Ипотекийн зээлтэй иргэдийн орлого 62
График17.Өрхийн орлого зарлага улсын дундаж 62
График18. ЛэндМН-ийн нийт олгосон зээлд эзлэх хэрэглээний зээл 64
График19. ЛэндМН-ийн зээлийн үлдэгдэл 64
График20. Хятад улсын интернэт зээл хэрэглэгчдийн статистик 65
График21. Төсвийн тэнцал ба ДНБ-д эзлэх хувь 67
График22. Монгол улсын эдийн засгийн тэргүүлэгч салбарууд 68
График23. ДНБ, түүний тэлэлт, ГШХО 69
График24. Мөнгөний нийлүүлэлт ба валютын нөөц 69
График25. Монгол улсын гадаад худалдааны үзүүлэлт 70
График26. Төгрөгийн ханш 72
График27. ГШХО ба түүний хүчин зүйлс 73
График28. Монгол улсын хөрөнгө оруулалтын орчны жагсаалт 73
График29. Монгол улсын бизнесийн орчны үнэлгээ 74
График30. Бэлэн мөнгөний хэрэгцээ ба шинэ хэрэглэгчид 83
График31. Нийт актив ба бэлэн мөнгөний үлдэгдэл 84
График32. Балансын бүтцийн төсөөлөл 84
График33. Сарын хөрөнгийн өгөөж ба зээлийн үлдэгдэл 86
График34. 2017 оны зээлийн үйл ажиллагаа 87
График35. 2018 оны зээлийн үйл ажиллагааны таамаглал 87
График36. Хөрөнгийн эргэц 89
График37. Ашигт ажиллагааны харьцаа 90
График38. Өгөөж 90
График39. Санхүүгийн хөшүүрэг 91

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC

LENDMN

20180119

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Хувьцаагаа олон нийтэд худалдахаар санал болгож буй компани |
| Финтек | Санхүүгийн үйлчилгээг технологитой хамтатгасан бизнесийн төрөл |
| Бичил зээл | Бага хэмжээтэй хэрэглээний зээл |
| Аппликейшн | Гар утсанд суулгаж ашигладаг программ |
| Андеррайтер | Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг гүйцэтгэгч байгууллага |
| Lendmn | Гар утсанд суулгаж ашигладаг зээл олгох үйлчилгээ |
| Их хэмжээний хэлцэл | Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувиас дээш хэмжээтэй гэрээ,хэлцэл |
| Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасныг ойлгоно |
| Анхдагч зах зээл | Анх удаа олон нийтэд хувьцаагаа худалдаж байгаа арилжаа |
| Арилжаа | Үнэт цаас худалдах, худалдан авах ажиллагаа |
| Хиймэл оюун ухаан | Өөрийгөө хөгжүүлж байдаг төгс программ |
| Start-Up of the Year | Оны шилдэг гарааны бизнес |
| Business Council of Mongolia | Монголын Бизнесийн зөвлөл |
| Лиценз | Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх |
| Хараат бус аудит | Бие даасан санхүүгийн хяналт |
| Хаалттай бонд | Хаалттай хүрээнд гаргасан өрийн бичиг |
| Номиналь данс | Андеррайтерийн харилцагчийн нэгдсэн данс |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| PC | Personal Computer(Компьютер) товчилсон үг |
| IT | Information Technology(Мэдээллийн технологи)товчилсон үг |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ГШХО | Гадаадын шууд хөрөнгө оруулалт |

20180119

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн 2018 оны 01 сарын 19-ний өдрийн хурлаас Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.6, 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4, 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, "ЛэндМН ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6.1.1, 6.2.7 дахь заалт, хувьцаа эзэмшигч "Анд Системс" ХХК (цаашид "Хувьцаа эзэмшигч" гэх)-ийн дүрмийн 6.1.6(а) дахь заалтыг тус тус удирдлага болгон, хувьцаагаа анх удаа нийтэд санал болгож Монголын Хөрөнгийн Бирж (цаашид "Бирж" гэх)-ээр арилжих тухай шийдвэрийг гаргасан байна.

***Нэг.*** *Компанийн одоо гаргасан байгаа нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 600,000,000(зургаан зуун сая) ширхэг энгийн хувьцаан дээр 200,000,000(хоёр зуун сая) ширхэг энгийн хувьцаа буюу 25 хувийг нэмж гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсүгэй.*

***Хоёр.*** *"Гэрэгэ Эстимэйт" ХХК-ийн гаргасан ""ЛэндМН ББСБ" ХХК-ийн Хараат бус бизнесийн үнэлгээний тайлан", "Мирэ Эссет Секьюритис Монгол" ҮЦК-ийн андеррайтерийн мэргэжлийн зөвлөгөөг харгалзан компанийн нэмж гаргасан 200,000,000 ширхэг буюу компанийн нийт гаргасан хувьцааны 25(хорин таван) хувьтай тэнцэх энгийн хувьцааны нийтэд санал болгох нэг бүрийн үнийг 25(хорин тав) төгрөгөөр тогтоож, Биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийтэд санал болгосугай.*

***Гурав.*** *Компанийн нэмж гаргасан 200,000,000 ширхэг хувьцаанаас 100,000,000 ширхэг буюу компанийн нийт гаргасан хувьцааны 12.5 хувьтай тэнцэх энгийн хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2 дахь хэсгийг үндэслэн хаалттай хүрээнд буюу стратегийн хөрөнгө оруулагчдад танилцуулахаар тогтоож, тус ажлыг зохион байгуулахыг компанийн ТУЗ /Д.Бат-Очир/, андеррайтер "Мирэ Эссет Секьюритис Монгол" ҮЦК /Н.Цэвээмид/ нарт үүрэг болгосугай.*

***Тав.*** *Анхдагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг байхаар тогтоож, уг мөнгөн хөрөнгийг Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахаар шийдвэрлэсүгэй.*

20180119

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

АНДЕРРАЙТЕР

MIRAE ASSET Securities

**МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК ХХК**
Монгол Улс, Улаанбаатар хот 14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо ,
Блю Скай Тауэр, 4 давхар, 406 тоот
n.tsevegmed@miraeasset.com
+976-70110806
+976-70110899

АУДИТЫН КОМПАНИ

EY

**ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛ ХХК**
Монгол Улс, Улаанбаатар хот 14251,
Сөүлийн гудамж, Найман зовхист төв
200 тоот
www.ey.com
+976-11 314032
+976-11 312042

ХУУЛИЙН ФИРМ

MDSKhanLex

**ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЭКС ХХН**
Монгол Улс, Улаанбаатар хот 14200,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр,
13-р давхар, 1301 тоот
info@mdsa.mn
+976-11 330048
+976-11 330049

ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

**ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК**
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу,
36Б байрны Үйлчилгээний төв
gantulga@geregepartners.mn
+976-11 319743, 9910-7317
+976-11 319743

ТУСЛАН БОРЛУУЛАГЧ

MIBG Mongolian Investment Banking Group

**ЭМ АЙ БИ ЖИ ҮЦК ХХК**
Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Нэгдсэн Үндэстний гудамж 6/6,
Монруд оффис 100 тоот
info@mibg.mn
+976-11 362620
+976-11 362620

20180119

# НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Компанийн оноосон нэр | "ЛэндМН ББСБ" |
| Байгуулагдсан огноо | 2006 он 01 сар 13 өдөр |
| Компанийн хэлбэр | ХХК |
| Өмчлөлийн хэлбэр | 100%- Хувийн өмчит |
| Үйл ажиллагааны чиглэл | Банк бус санхүүгийн зээлийн үйлчилгээ |



Зураг1. Форбес сэтгүүлд нийтлэгдсэн зураг

"ЛэндМН ББСБ" ХХК нь анх 2006 онд "Дуусашгүй-Ундарга" ХХК нэртэйгээр байгуулагдаж, 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдөр СЗХ-ноос банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр СЗХ-ны даргын тушаалаар компанийн оноосон нэрийг "ЛэндМН ББСБ" ХХК болгон өөрчилсөн цахим санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага юм.

"ЛэндМН ББСБ" ХХК нь Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан Финтек бизнесийг LendMN аппликейшнээр дамжуулан дотоодын санхүүгийн зах зээлд амжилттай нэвтрүүлээд байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч Анд Системс ХХК-ийн удирдлага, хамт олон 2015 оноос хойш ЛэндМН төслийн шийдлийг боловсруулж,

хөгжүүлэлтийг хийж байна. Энэхүү төслийн санаа нь найз нөхөд, хамт олон, ойр дотны хүмүүсийн хооронд бага дүнтэй зээл авах, өгөх харилцаа ихээхэн түгээмэл байдаг боловч уг зээлээс ихэнхи тохиолдолд харилцааны сөрөг асуудал үүсдэгийг хэрхэн яаж зохицуулах вэ? гэсэн асуултаас эхлэлтэй байсан гэдэг.

Энэхүү дотны хүмүүсийн хооронд гарч байгаа албан бус зээлийн хэрэгцээг хангах, түүнээс үүдэж болзошгүй харилцааны асуудлыг дэвшилтэт технологи ашиглан шийдвэрлэх түүгээрээ дамжуулан харилцагчдын санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, санхүүгийн хариуцлага, сахилга батад суралцах боломжийг олгох нь энэ үйлчилгээний гол зорилго чиглэсэн байна.

Мөн банк санхүүгийн байгууллагаас үйлчилгээ авах боломжгүй иргэдийн санхүүгийн хэрэгцээг шийдвэрлэж, зээлийн түүх үүсгэх цаашлаад тухайн харилцагч банкны үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх давуу талтай юм.

LendMN аппликейшнийг бүтээсэн буюу цаашид Монголын санхүүгийн брэнд үйлчилгээг олон улсын зах зээлд гаргахаар зорьж ажиллаж буй үүсгэн байгуулагч, санаачлагчдыг танилцуулж байна.



Үүсгэн байгуулагч, санаачлагч – Чинбаатар АНАР

- Системийн инженер мэргэжилтэй
- Монгол улсын үүрэн холбооны 4дэх оператор компанийг үүсгэн байгуулсан
- ЛэндМН төслийг санаачлагч, үүсгэн байгуулагч
- Анд Глобал компанийн Гүйцэтгэх захирал
- Анд Системс ХХК-ийн ТУЗ-ийн дарга
- ЛэндМН ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Үүсгэн байгуулагч, санаачлагч – Очирсүрэн БОЛДБААТАР

- Санхүүч, Аудитор, ОУ-ын Мэргэшсэн нягтлан бодогч
- ЛэндМН төслийг санаачлагч, үүсгэн байгуулагч
- Анд Глобал компанийн Санхүүгийн албаны захирал
- Анд системс ХХК–ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал
- ЛэндМН ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Үүсгэн байгуулагч - Үүеэ ОТГОНБАЯР

- Математикийн ухааны мастер, доктор
- ЛэндМН төслийн үүсгэн байгуулагч
- Хиймэл оюун ухааны багийн ахлагч
- Анд Глобал компанийн Менежментийн багийн гишүүн



Үүсгэн байгуулагч - Пүрэвсүрэн ОТГОНБАЯР

- Программ хангамжийн инженер, мастер
- ЛэндМН төслийн үүсгэн байгуулагч, хөгжүүлэгч
- Анд Глобал компанийн Менежментийн багийн гишүүн
- АндСистемс ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Үүсгэн байгуулагч - Пүрэвсүрэн НАРАНБАЯР

- Төрийн захиргаа, Олон улсын харилцааны доктор
- ЛэндМН төслийн үүсгэн байгуулагч
- Шинэ Монгол Бүрэн дунд сургууль Гүйцэтгэх захирал

ЛэндМН төслийг санаачлагчид нь анх 2015 онд Монгол улсад Номад инвест нэртэй компанийг байгуулан төслийн судалгааг эхлүүлсэн байна. 2016 оны эхэн гэхэд төслийн эхний шатны санхүүжилт болох 1 сая ам.долларыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл дээр үндэслэн хүлээн авч ЛэндМН төслийн техникийн шийдлийн хөгжүүлэлтийг эхлүүлсэн юм.

Улмаар Монгол залуусын оюуны бүтээл ЛэндМН төслийг олон улсад нэвтрүүлэх, экспортлох, дараагийн шатны хөрөнгө оруулалтыг олон улсын томоохон хөрөнгө оруулагчдаас татах зорилгоор Номад Инвест компанийн нэрийг Анд Системс ХХК болгон өөрчилж, тус компанийн толгой компани болох And Global Pte.ltd(Анд Глобал) компанийг 2017 оны 3-р сард Сингапур улсад байгуулсан билээ. Үүний үр дүнд Анд Глобал компани нь 2017 оны 08 сард төслийн дараагийн шатны нэмэлт санхүүжилт болох 4 сая ам.долларыг Япон болон Монголын хөрөнгө оруулагчдаас амжилттай босгосон.

Энэхүү Анд Глобал компаниар дамжуулан босгосон 4 сая ам долларын хөрөнгө оруулалтаас нийт 2.1 сая ам.долларыг Монгол улсад бүртгэлтэй Анд Системс ХХК-аар дамжуулан ЛэндМН ББСБ ХХК-ийн дүрмийн санг нэмэгдүүлэн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Ийнхүү ЛэндМН төслийг амжилттай хэрэгжүүлснээр ЛэндМН ББСБ ХХК нь өнөөдрийн байдлаар нийт 19 мянга гаруй харилцагчтай буюу Монгол улсын хамгийн олон харилцагчтай банк бус санхүүгийн байгууллага болоод байна.

## АЛСЫН ХАРАА

Харилцагчийг дээдэлсэн, үнэ цэнэтэй үйлчилгээг түгээгч, цахим санхүүгийн чадварлаг байгууллага болох

20180119

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийд танигдсан цахим санхүүгийн үйлчилгээг Монгол хүн бүрт

## КОМПАНИЙН УРИА

Асаа. Асуудлаа шийд

## КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛ

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтнууд нь тухайн салбартаа олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, хоорондоо нэгдмэл сонирхолгүй, бие даан шийдвэр гаргах бүрэн чадвартай бөгөөд сайн засаглалын зарчмыг мөрдлөг болгон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ил тод байдал, шударга өрсөлдөөн, компанийн тогтвортой хөгжлийг ханган ажиллана.

## МОНГОЛ ЗАЛУУС ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох Сингапур улсад бүртгэлтэй Анд Глобал компани нь Сингапур, Филиппин , Малайз, Индонез, Япон зэрэг Ази Номхон Далайн өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд ЛэндМН төслийн үйл ажиллагааг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Тодруулбал LendMN төслийг олон улсын зах зээлд нэвтрүүлэх зорилгоор Филиппин улсын 60 жилийн түүхтэй TRBI банктай стратегийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд 2018 оны эхний хагаст багтаан 110 сая хүн амтай Филиппин улсын харилцагч нарт үйлчилгээг нэвтрүүлэх ажилдаа ороод байна. Япон улсад ЛэндМН технологийн шийдэлд суурилсан Финтек санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор TechStar Japan компанитай хамтран 2018 оны 03-р сард Hackaton тэмцээнийг зохион байгуулж ЛэндМН төслийг Япон улсын зах зээлд нэвтрүүлэх боломжийг эрэлхийлж байна.

Мөн 250 сая хүн амтай Индонез улсад үйл ажиллагаагаа нэвтрүүлэх зорилгоор 2018 оны I-р улиралд Анд Глобал болон Анд Системс ХХК-ийн олон улсын үйл ажиллагаа хариуцсан баг Индонез улсад айлчилж, тус улсад хамтран ажиллах түнш байгууллага сонгон шалгаруулахаар төлөвлөж байна. Үүнээс гадна 2018 ондоо багтаан нэмж 2 улсад үйлчилгээгээ нэвтрүүлэхээр судалгааны ажлаа эхлүүлсэн байна.

ЛэндМН төслийн үйл ажиллагааны талаар олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 20 гаруй өгүүллэг мөн 10 орчим нийтлэлүүд гарсан байна. Тухайлбал Форбес, Герман улсын Deutsche Welle, Tech in Asia, Никкей Азийн тойм гэх мэт хэд хэдэн олон улсын мэдээллийн хэрэгслээр нийтлэлүүд гарсан байна.

## ШАГНАЛ УРАМШУУЛАЛ




Зураг2. Ч.Анар- Хөрөнгө оруулагч үндэстэн чуулганд оролцох үеэр

**START-UP OF THE YEAR** - Улаанбаатар хотноо 2017 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан "Хөрөнгө оруулагч үндэстэн" чуулга уулзалтад компанийн үүсгэн байгуулагч, санаачлагч Ч.Анар LendMN аппликейшний талаар танилцуулга хийж мэргэжлийн оролцогчдын дунд чөлөөт хэлэлцүүлэг хийсэн. Тус арга хэмжээний үеэр "ЛэндМН ББСБ" ХХК нь шилдэг гарааны бизнесийн шагналыг хүртсэн юм.

**GOOGLE BLACKBOX CONNECT** – Google компаниас жил бүр зохион байгуулдаг шилдэг технологийг хэрэгжүүлэгч гарааны бизнесүүдийг шалгаруулах тэмцээнд олон улсын 200 гаруй технологийн компани өрсөлдсөнөөс Анд глобал компани ЛэндМН төслөөр оролцож шилдэг 16 компанид шалгарсан Монгол улсын анхны амжилт юм. Энэ нь ЛэндМН ББСБ ХХК олон улсад өөрийн цахим санхүүгийн үйлчилгээг сурталчилах, компанидаа шилдэг технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулагчдад компаниа таниулах, гадаадын хөрөнгө оруулалт татах өргөн боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

**APP OF THE YEAR** – 2017 оны 12 сарын 02-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "UNPLUG 2017 by Unread" арга хэмжээний үеэр хиймэл оюун ухаанд суурилсан гар утасны LendMN аппликейшнийг 2017 оны "ШИЛДЭГ АППЛИКЕЙШН"-р шалгаруулсан байна.



## ХАЯГ, БАЙРШИЛ

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн Хуулийн гудамж, Нью Майнд Групп ХХК-ийн байр |
| Утас: | +976 7707-0101, +976 7722-2949 |
| Цахим шуудан: | service@lend.mn |
| Цахим хуудас: | www.lend.mn |
| Байршил: | Нийслэлийн ШШГГ-ын зүүн урд талд |



Зураг3. Үнэт цаас гаргагчийн оффисын байршил

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр: | ЛэндМН ББСБ ХХК |
| Байгуулагдсан огноо: | 2006 он 01 сар 12 өдөр |
| Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: | 2006 он 01 сар 13 өдөр |
| Улсын бүртгэлийн дугаар: | 9015003079 |
| Регистрийн дугаар: | 5039754 |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл: | Банк бус зээлийн үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагчийн тоо: | Нэг гишүүнтэй |
| Дүрмийн сангийн хэмжээ: | 6,0 тэрбум төгрөг |

20180119

## 1.2 ЯАГААД ЭНЭ БИЗНЕСТ ХӨЛ ТАВИХ БОЛОВ?

### Санхүүгийн үйлчилгээний салбарын "Сорилт" юу байв?

Дэлхий дахинд санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг нүүрээ таниулан эсвэл иргэний үнэмлэхээ ашиглан хаанаас ч гар утсаараа дамжуулан авах боломжтой хэмжээнд хүрсэн байна. Тэгвэл манай улсын санхүүгийн үйлчилгээ ямар төвшинд байна вэ? Зээл авахын тулд уламжлалт арга барилаараа олон шат дамжлага дамжсаар байна уу? Иймээс Дэлхийн санхүүгийн үйлчилгээний технологийг Монгол улсдаа нэвтрүүлье гэсэн бодол үнэт цаас гаргагчийг энэхүү салбарт хөл тавихад хүргэсэн байна.

### Зээл авахад ямар "Хүндрэл" байна вэ?

Таны өдөр тутмын амьдралд гэнэтийн бага хэмжээний мөнгөний хэрэгцээ гарах үе олон тохиолддог. Энэ үед гэр бүл, хамаатан садан, найз нөхөд, ажлын хамт олон гээд хамгийн ойрын нэгнээсээ тусламж хүсэх эсвэл барьцаат зээл авах зэргээр шийдвэрлэх нь элбэг байдаг. Тэгвэл та яагаад хэн нэгнээс асуухгүйгээр гэнэтийн мөнгөний хэрэгцээгээ өөрөө шийдэж болохгүй гэж?

### Өнөөгийн бичил санхүүгийн зах зээлд тулгамдсан асуудал

| Субъект | Технологи | Зээл хүсэгч | Зээлдүүлэгч |
|---|---|---|---|
| Гол асуудал | Санхүүгийн үйлчилгээг дэвшилтэт технологитой хослуулах нь хүндрэлтэй | Түргэн шуурхай, бага хүүтэй зээлийн эрэлтийг шийдвэрлэх | Муу зээлээс сэргийлж илүү оновчтойгоор зээл хүсэгчийг үнэлж, тодорхойлох |
| Тулгамдаг асуудал | ✓ Олон нийтийн сүлжээ болох Facebook, Instagram, Wechat, Twitter хэрэглэгчийн тоо 1.7 саяд хүрсэн ба тэдний 50% нь гар утсаараа холбогддог байна. *(Эх сурвалж: nathouse.mn)*<br>✓ Бид яагаад гар утсаараа зээл авч болдоггүй байсан юм бол? | ✓ Хэнээс яаралтай зээл авч болох вэ?<br>✓ Яг одоо ажиллаж байгаа ломбард байгаа болов уу?<br>✓ Юугаа барьцаалж хэдэн төгрөг зээлэх вэ?<br>✓ Найзруугаа утас цохилоо ав сангүй одоо яанаа?<br>✓ Банк бусаас зээлэхэд арай л бага мөнгө байгаад байдаг?<br>✓ Хоногоор өндөр хүүтэй зээл дүүлэгч нар эрсдэлтэй гэсэн дэмий байхдаа?<br>✓ Ломбарданд тавьсан зүйлд минь сэв суучихвийдээ? | ✓ Хүнээс хэт хамааралтай алдлыг яаж бууруулах вэ?<br>✓ Зээл хүссэн хүнд итгэж болох уу?<br>✓ Танилын нүүр халуун гэгчээр таван төгрөг зээлэх ч хэцүү зээлэхгүй байх ч хэцүү юмдаа.<br>✓ Хүнд төвөг удалгүй зээл дүүлчих арга зам байдаг гүйн байхдаа? |
| Шийдэл | lendmn<br>Финтекийг бүрэн утгаар нь ашигласан зээлийн үйлчилгээг гар утасны аппликейшнээр дамжуулан олгоно. | lendmn<br>Ямар ч хүнд суртал, барьцаагүй, шуурхай зээлийг 24/7 буюу хүссэн цагтаа, хаанаас ч хэдхэн минутанд танд шилжүүлнэ. | lendmn<br>Хиймэл оюун ухаан; машин сургалтаар зээл хүсэгчийг 1-3-хан минутанд шударгаар тодорхойлж хормын дотор зээл олгогдоно. |

Хүснэгт1. Бичил санхүүгийн зах зээл тулгамдсан асуудал

20180119

**Бичил хэрэглээний зах зээлд тулгамдсан асуудлыг ЛэндМН үйлчилгээ нэг товчоор шийдвэрлэж байна.**

**ЛэндМН-ийн шийдэл: АСАА. АСУУДЛАА ШИЙД**

## Та өөртөө санхүүгийн үйлчилгээ үзүүлэх "ШИЙДЭЛ"

ЛэндМН төслийг санаачлагчдын нөр их хөдөлмөрийн үр дүнд хэрэглэгчиддээ хиймэл оюун ухаанд суурилсан технологийн шийдэлд тулгуурласан барьцаагүй, хурдан шуурхай, урамшуулалттай, цахим зээл олгох Финтек үйлчилгээг цоо шинээр бий болгосон билээ.

## Яагаад финтек гэж?

**Санхүүгийн зах зээлийн бүхий л талбарт Финтек нэвтрээд байна.**




Схем1. Санхүүгийн зах зээлд Финтек нэвтэрсэн байдал

**Монгол залуус Финтекийн зах зээлд хөл тавьлаа.**

## ХАРИЛЦАГЧИД ЭНЭХҮҮ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРХЭН ХҮЛЭЭЖ АВАВ ?

### "Санхүүгийн сахилга бат"

ЛэндМН ББСБ ХХК санхүүгийн зах зээлд "LendMN" гар утасны аппликейшнээр дамжуулан бичил зээл олгож эхэлснээс хойш 1 жил гаруйн хугацаанд 18,998 харилцагчид 64 мянган удаагийн үйлчилгээгээр 10,7 тэрбум төгрөгийн зээлийг авч ашигласан байна.

LendMN төслийг анх эхлүүлж барьцаагүй буюу харилцагчдад итгэж зээл олгоход хамгийн таамаглахад амаргүй хүчин зүйл нь эргэн төлөлт байсан юм. Харин 1 жилийн үр дүнгээс харахад бичил хэрэглээний зээл дээр харилцагчдын итгэл даах чадвар өндөр буюу санхүүгийн сахилга бат сайн болох нь харагдсаар байна.

| Агуулга | Анхны төсөөлөл | Өнөөгийн үр дүн |
|---|---|---|
| Хугацаа хэтэрсэн зээл /30-с дээш хоног/ | 20% ~ 30% | 1,2% (2017.11.30-ны байдлаар) |

Хүснэгт2. Хугацаа хэтэрсэн зээлийн үзүүлэлт

### "Технологи"-ийн шийдэлд таатай хандав

Мэдээллийн эрин зуун, техник технологийн хурдацтай хөгжлийн явцад түүнтэй хөл нийлүүлэн алхах зайлшгүй шаардлагатай эрин үед бид амьдарч байна. Тийм ч утгаараа гар утасны LendMN аппликейшн бүтээгдсэн хэдий ч энэхүү технологийг ашиглах боломжтой харилцагчдын тоо хязгаарлагдмал байж болзошгүй хэмээн анхлан төсөөлж байв. Гэвч өнөөдрийг хүртэлх жил гаруйн хугацаанд харилцагчийн тоо хурдацтай өссөн нь иргэд технологийн дэвшлийг хурдан хугацаанд ашиглаж чадаж байгаагийн илэрхийлэл юм. 2017 оны 12 сарын 07-ны өдрийн байдлаар нийт 90 мянга гаруй хэрэглэгч LendMN аппликейшнийг ашиглан бүртгэл үүсгэснээс 18,998 нь ЛэндМН үйлчилгээний харилцагч болоод байна.

| Хугацаа | 2017.03.31 | 2017.06.30 | 2017.09.30 | 2017.10.31 | 2017.11.30 | 2017.12.07 |
|---|---|---|---|---|---|---|
| Харилцагчдын тоо[1] | 1,024 | 3,421 | 8,003 | 12,307 | 17,937 | 18,998 |

Хүснэгт3. Харилцагчийн өсөлтийн тоон үзүүлэлт

### Хамтын зорилго – Харилцагчийн санхүүгийн хариуцлага + ЛэндМН-ийн урамшуулал

LendMN аппликейшнээр дамжуулан үзүүлж буй цахим санхүүгийн үйлчилгээ нь бүхэлдээ харилцагчийг санхүүгийн хариуцлага, сахилга батад суралцуулах зорилгыг агуулан бүтээгдсэн цогц шийдэл юм. Өөрөөр хэлбэл ЛэндМН-ийн харилцагчиддаа **"барьцаагүй санхүүгийн үйлчилгээ үзүүлье,** харин таны эргэн төлөлт хугацаандаа сайн байвал **шимтгэл бууруулж урамшуулъя"** гэдэг бодлого нь харилцагчийг санхүүгийн сахилга баттай, хариуцлагатай болоход хөтөлж буй гол түлхүүр нь юм.

[1] Цахим зээлийн эрх нээх гэрээ байгуулсан харилцагч

## 1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭ ШИЙДЭЛ

### Зээлийн үйлчилгээнд гаргасан шинэ шийдэл




Схем2. ЛэндМН үйлчилгээний шийдлүүд




Зураг4. LendMN аппликейшнийн танилцуулга

**Таны санхүүгийн шийдэл "Таны гарт"**

- Дэлхийд зөвшөөрөгдсөн технологид суурилсан бүрэн автомат санхүүгийн үйлчилгээний систем
- Хүнээс үл хамаарах "Хиймэл оюун ухаан" зээлийн шийдвэрийг шударгаар гаргана.
- Хэрэглэхэд хялбархан, ойлгомжтой
- Харилцагч зээл авахад ердөө 1-3 минут л шаардлагатай
- Ямар ч барьцаагүй
- 24 цагийн турш хаана ч байсан ашиглах боломжтой

**Таны дотны анд**

- Таны хамгийн дотны найз нөхөд мэт танд үргэлж нээлттэй
- Яаралтай үеийн санхүүгийн асуудлыг "**Нэг товч**"-оор шийдвэрлэнэ.
-

20180119

## Үйлчилгээнд хамрагдах заавар

| Алхам 1 | Алхам 2 | Алхам 3 | Алхам 4 | Алхам 5 | ! |
|---|---|---|---|---|---|
| LendMN аппликейшн татаж суулгах | Хэрэглэгч мэдээллээ бүртгүүлэх | Хиймэл оюун ухааны алгоритмын тусламжтайгаар дүн шинжилгээ хийж Зээлийн эрх тооцоолно. | Зээлийн гэрээ байгуулж, зээлийн хэмжээ болон хугацааг хэрэглэгч сонгож зээл авна. | Зээлээ эргэн төлж , урамшуулал авна. | Хугацаандаа зээлээ төлөөгүй бол утсаар болон цахим хаягаар хүрвэс ингэнэ. |

Схем3. LendMN аппликейшнийг ашиглах алхмууд

## Бид хэрэглэгчдийнхээ үнэт цаг, мөнгийг хэмнэсээр байна.

**56,994 цаг**

Зээл авахад зарцуулдаг цагийг эрс бууруулснаар хэрэглэгчийн **алдагдсан боломжийн өртгийг** хэмнэж байна. Нэг хэрэглэгч бичил зээл авахаар ББСБ-д зарцуулах цагийг дунджаар 3 цаг гэж тооцвол өнөөг хүртэл ЛэндМН-с зээл авсан 18,998 хүний **56,994 цаг буюу 2,374 өдөр, 6,5 жилийг хэмнэсэн байна.**

**329 сая.төг**

Дунджаар 1 сая төгрөгийн цалинтай хэрэглэгч зээл хөөцөлдөхөд 3 цагийг зориулахын оронд ажлаа хийж байсан бол алдагдсан боломжийн өртөг дунджаар 17,361 төгрөг болох тул нийт 18,998 харилцагчийн **329,8 сая төгрөгийг хэмнэсэн** байна.

**192,000 хүн**

Энэхүү үйлчилгээ нь өнөөг хүртэл нийт 64 мянган удаагийн давтамжтай зээл олгосон бөгөөд хэрвээ энэхүү шийдлийг нэвтрүүлээгүй байсан бол 1 хүн дунджаар 2-3 хүнээс мөнгө зээлэх тухай асуудаг гэж тооцвол ойролцоогоор 192,000 хүнээс асуух байсан харилцааг **ганцхан товчоор шийдвэрлэж чаджээ.**

**64,000 барьцаа**

Барьцаагүй зээл олгодог учраас 18,998 харилцагчийг 64 мянга гаруй удаа эд хөрөнгө, нэр хүндээ барьцаалах байсан үйлдлээс ангижруулж чадсан байна.

20180119

## 1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Схем4. Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт



Зураг5. ЛэндМН ББСБ ХХК-ийн хамт олон

### 1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТУХАЙ




Схем5. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн бүтэц

ЛэндМН ББСБ ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч нь Анд системс ХХК бөгөөд Анд системс ХХК –ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч нь Сингапур улсад бүртгэлтэй Анд глобал толгой компани юм. ЛэндМН ББСБ ХХК-ийн зэргэлдээ компани болох Анд Системс тех ХХК нь Анд Системс ХХК-ийн 100 хувийн охин компани юм.

## АНД ГЛОБАЛ КОМПАНИ

Сингапур улсад бүртгэлтэй АНД Глобал компани нь группийн хөрөнгө оруулалт, стратеги болон менежментийн асуудлыг хариуцан ажилладаг. Мөн Анд системс ХХК болон Сингапур улсад бүртгэлтэй AND FSG Pte.ltd компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч билээ. AND FSG Pte.ltd компани нь АНД Глобал компанийн хөрөнгө оруулалттай санхүүгийн компаниудыг хариуцсан холдинг компани болох зорилгоор байгуулагдсан юм.

## Анд Глобал компаниийн хувь эзэмшлийн бүтэц




Схем6. Анд Глобал компанийн хувь эзэмшлийн бүтэц

Сингапур улсын Нягтлан Бодох Бүртгэл, Компанийн Зохицуулалтын Асуудал Эрхэлсэн Төрийн Байгууллага(Accounting and Corporate Regulatory Authority)-ын цахим хуудсанд тавигдсанаар Анд Глобал компанийн нийт энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн бүтцийг танилцуулж байна.

| № | Овог нэр/ Хуулийн этгээдийн нэр | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|
| 1 | IRO Consulting Singapore PTE.LTD | 34% |
| 2 | Гаравсүрэнгийн Идэрмаа | 24% |
| 3 | Таками Юичи | 13% |
| 4 | Батболдын Дэлгэөн | 13% |
| 5 | Ясуёо Мацумото | 6% |

Хүснэгт4. Анд Глобал Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

20180119

## АНД СИСТЕМС ХХК

Анд системс ХХК(РД:6005861) нь 2015 онд Номад Инвест нэртэйгээр байгуулагдсан, Монгол улсад бүртгэлтэй, Мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Анд системс тех ХХК болон ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьцааг 100 хувь эзэмшдэг холдинг компани бөгөөд LendMN аппликейшнийн хөгжүүлэлт, өргөжүүлэлтийг хариуцан ажилладаг технологийн компани юм.




Схем7. Анд Системс ХХК-ийн хувь эзэмшлийн бүтэц



Зураг6. Анд Системс ХХК-ийн хамт олон

## АНД СИСТЕМС ТЕХ ХХК

Анд систем тех ХХК нь Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу 2017 оны 10 сард Анд Системс ХХК-ийн программ хангамж, хөгжүүлэлт болон судалгааны үйл ажиллагааг тусгаарлах замаар байгуулагдсан Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд бөгөөд Мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг LendMN аппликейшнийн оюуны өмчийн эрхийн хууль ёсны өмчлөгч болно.

Анд систем тех ХХК нь энэхүү оюуны өмчийн эрхээ 2017 оны 07 сарын 01-ний өдөр байгуулсан "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх(лиценз)-ийн гэрээ"-ээр ЛэндМН ББСБ ХХК-д 50 жилийн хугацаатайгаар Монгол улсын нутаг дэвсгэрт онцгой эрхтэйгээр ашиглах эрхийг олгосон байна.

## КОМПАНИЙН ЖИНХЭНЭ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

### ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

Анд Глобал компанийн хувь нийлүүлэгч Сингапур улсад бүртгэлтэй IRO Consulting Singapore компанийн Гүйцэтгэх захирал, энгийн хувьцааны 20 хувийг эзэмшигч, Анд Глобал компанийн гурван захирлын нэг, Анд системс ХХК-ийн ТУЗ-ийн дарга, ЛэндМН ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн **Чинбаатарын Анар** болон IRO Consulting Singapore компанийн энгийн хувьцааны 20 хувийг эзэмшигч, Анд Глобал компанийн ТУЗ-ийн гишүүн, Анд системс ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, ЛэндМН ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн **Очирсүрэнгийн Болдбаатар** нарыг хамтад нь ЛэндМН ББСБ ХХК-ийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч хэмээн тодорхойлж байна.

## ЖИНХЭНЭ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ, ТҮҮНИЙ ХОЛБОГДОХ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

| 1 | **Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид** | **Чинбаатар Анар** | **Очирсүрэн Болдбаатар** |
|---|---|---|---|
| 2 | Регистрийн дугаар | СФ82071816 | ЙЮ80100817 |
| 3 | Албан тушаал | ЛэндМН ББСБ ХХК ТУЗ-ийн гишүүн | ЛэндМН ББСБ ХХК ТУЗ-ийн гишүүн |
| 4 | Хаяг | УБ хот, БЗД, 13-р хороолол, 99б байр 303 тоот | УБ хот, СБД, 1-р хороо, 14 байр, 49 тоот |
| 5 | Холбогдох этгээд | М.Золзаяа/Эхнэр<br>А.Хүлэгт<br>А.Цэцэнгоо | Д.Удвал/эхнэр<br>Б.Ананд<br>Б.Баясгалан<br>Б.Батмэнд<br>Б.Нандин |

Хүснэгт5. Жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч, түүний холбогдох этгээд

# 1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

| № | ТУЗийн албан тушаал | Овог нэр | Мэргэжил | Эрхэлж буй албан тушаал | Нэгдмэл сонирхолтой этгээд байгаа эсэх | Гэмт хэрэгт холбогдож байсан эсэх | Өр төлбөртэй эсэх |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дарга | Д.Бат-Очир | ОУ-ын Санхүүгийн мэргэжилтэн | Хөгжлийн банк Хараат бус гишүүн | Байхгүй | Үгүй | Үгүй |
| 2 | Гишүүн | С.Оюун | Банк санхүү, эдийн засаг | Кингдом консалтинг ХХК Гүйцэтгэх захирал | Байхгүй | Үгүй | Үгүй |
| 3 | Гишүүн | Ч.Анар | Системийн инженер | Анд Глобал Гүйцэтгэх захирал | Байхгүй | Үгүй | Үгүй |
| 4 | Гишүүн | О.Болдбаатар | Санхүүч, Аудитор, ОУ-ын МНБ | Андсистемс ХХК Гүйцэтгэх захирал | Байхгүй | Үгүй | Үгүй |
| 5 | Гишүүн | А.Билгүүн | Мэргэшсэн санхүүгийн мэргэжилтэн | ЭмАйБиЖи ҮЦК Гүйцэтгэх захирал | Байхгүй | Үгүй | Үгүй |
| 6 | Нарийн бичиг | Ч.Намираа | Санхүүгийн менежмент | Анд системс тех ХХК Ерөнхий менежер | Байхгүй | Үгүй | Үгүй |

Хүснэгт6. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

| № | Албан тушаал | Овог нэр | Мэргэжил | Ажилласан туршлага | Нэгдмэл сонирхолтой этгээд байгаа эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гүйцэтгэх захирал | М.Түвшинжаргал | Бизнесийн удирдлагын магистр | 10 жил | Байхгүй |
| 2 | Ерөнхий нягтлан бодогч | Д.Отгонгэрэл | Нягтлан бодогч | 12 жил | Байхгүй |
| 3 | Маркетинг борлуулалтын албаны дарга | О.Амгаланбаяр | ОУ-ын банк, санхүү нягтлан бодогч | 8 жил | Байхгүй |

Хүснэгт7. Гүйцэтгэх удирдлагын бүтэц

## ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3-р заалтын дагуу ЛэндМН ББСБ ХХК-ийн дүрэм болон бусад холбогдох баримт бичигт үндэслэн тус компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт түүний ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, маркетинг, борлуулалтын албаны дарга, ерөнхий нягтлан бодогч нарыг хамруулан авч үзлээ.

2018.11.19

## 1.7 САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

### ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

| Санхүү байдлын тайлан /Мянган төгрөг/ | 2017.10.31 | 2016.12.31 |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 320,043 | 507,939 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 2,110,270 | 124,160 |
| Урьдчилж төлсөн орлогын албан татвар | 240 | - |
| Бусад хөрөнгө | 44,521 | 14,700 |
| | **2,475,074** | **646,799** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Биет бус хөрөнгө | 270,210 | 295,000 |
| Үндсэн хөрөнгө | 64,337 | 23,073 |
| | **334,547** | **318,073** |
| **Нийт хөрөнгө** | **2,809,621** | **964,872** |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Хаалттай бондын өглөг | 300,200 | - |
| Бусад сан | 15,805 | - |
| Бусад өр төлбөр | 71,813 | 170,092 |
| Орлогын албан татварын өглөг | - | 162 |
| **Нийт өр төлбөр** | **387,818** | **170,254** |
| **Эздийн өмч** | | |
| Хувьцаат капитал | 2,500,000 | 800,000 |
| Хуримтлагдсан алдагдал | (78,197) | (5,382) |
| **Нийт эздийн өмч** | **2,421,803** | **794,618** |
| **Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч** | **2,809,621** | **964,872** |

| Орлогын тайлан /Мянган төгрөг/ | 2017.10.31 | 2016.12.31 |
|---|---|---|
| Хүү ба түүнтэй адилтгах орлого | 469,100 | 6,299 |
| Хүүний зардал | (34,078) | - |
| **Хүүний цэвэр орлого** | **435,022** | **6,299** |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал | (11,590) | - |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **423,432** | **6,299** |
| Удирдлага, үйл ажиллагааны зардал | (486,558) | (12,890) |
| Бусад зардал | (8,346) | (592) |
| **Татварын өмнөх алдагдал** | **(71,472)** | **(7,183)** |
| Орлогын албан татварын зардал | (1,343) | (281) |
| **Тайлант хугацааны цэвэр алдагдал буюу Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй алдагдал** | **(72,815)** | **(7,464)** |

| Өмчийн өөрчлөлтийн тайлан /Мянган төгрөг/ | Хувьцаат капитал | Хуримтлагдсан ашиг(алдагдал) | Нийт өмч |
|---|---|---|---|
| **2016.01.01-ний өдрийн байдлаар** | 400,000 | 2,082 | 402,082 |
| Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | (7,464) | (7,464) |
| Нэмж гаргасан энгийн хувьцаа | 400,000 | - | 400,000 |
| **2016.12.31-ний өдрийн байдлаар** | 800,000 | (5,382) | 794,618 |
| Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй алдагдал | - | (72,815) | (72,815) |
| Нэмж гаргасан энгийн хувьцаа | 1,700,000 | - | 1,700,000 |
| **2017.10.31-ний өдрийн байдлаар** | 2,500,000 | (78,197) | 2,421,803 |

| Мөнгөн гүйлгээний тайлан /Мянган төгрөг/ | 2017.10.31 | 2016.12.31 |
|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Татварын өмнөх алдагдал | (71,472) | (7,183) |
| Тохируулга: | | |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал | 11,590 | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 8,317 | 1,003 |
| Биет бус хөрөнгийн хорогдол | 24,790 | 5,000 |
| Хуримтлагдсан хүү | 200 | 1,678 |
| Бусад сангийн өөрчлөлт | 15,805 | - |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал** | **(10,770)** | **498** |
| Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд: | | |
| Харилцагчид олгосон зээл ба урьдчилгааны цэвэр өсөлт | (1,997,700) | (122,482) |
| Бусад хөрөнгийн цэвэр өсөлт | (29,821) | (14,700) |
| Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт | 54,721 | 13,736 |
| **Үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ** | **(1,983,570)** | **(122,948)** |
| Албан татварын төлөлт | (1,745) | (340) |
| **Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,985,315)** | **(123,288)** |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | (49,866) | (21,807) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | (153,000) | (147,000) |
| Үндсэн хөрөнгө худалдан борлуулсны орлого | 285 | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ** | **(202,581)** | **(168,807)** |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Нэмж гаргасан энгийн хувьцаанаас орсон мөнгө | 1,700,000 | 400,000 |
| Хаалттай бонд гарсанаас орсон мөнгө | 645,000 | - |
| Зээлээр авсан эх үүсвэр | 750,000 | - |
| Хаалттай бондын эргэн төлөлт | (345,000) | - |
| Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт | (750,000) | |
| **Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ** | **2,000,000** | **400,000** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт** | **(187,896)** | **107,905** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 507,939 | 400,034 |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **320,043** | **507,939** |

Хүснэгт8. Аудитлагдсан санхүүгийн тайлан

## АУДИТЫН ДҮГНЭЛТЭЭС

ЛэндМН ББСБ ХХК-ийн 2017 оны 10 сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд Эрнст энд Янг Монголиа ХХК Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, 2017 оны 12 сарын 08-ны өдөр дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

"Бидний дүгнэлтээр ЛэндМН-ийн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон арван сарын хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна" гэж дүгнэсэн байна.

20180119

2017 оны 10 сарын 31-ний өдрийн байдлаарх аудитлагдсан тайланд тусгагдсанаар үнэт цаас гаргагч компанийн биет болон биет бус хөрөнгө нь дараах хэмжээтэй байна.

## Үндсэн хөрөнгө

| | Тавилга, оффисын хэрэгсэл мян.төг | Компьютер, тоног төхөөрөмж мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|
| **2017 оны 10 дугаар сарын 31** | | | |
| **Өртөг** | | | |
| 2017 оны 1-р сарын 1-нээр | 19,312 | 4,764 | 24,076 |
| Нэмэгдсэн | 18,312 | 31,554 | 49,866 |
| Данснаас хассан | - | (330) | (330) |
| 2017 оны 10-р сарын 31-нээр | 37,624 | 35,988 | 73,612 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | |
| 2017 оны 1-р сарын 1-нээр | 274 | 729 | 1,003 |
| Тайлант хугацааны элэгдэл (Тодруулга 6) | 2,377 | 5,940 | 8,317 |
| Данснаас хассан | - | (45) | (45) |
| 2017 оны 10-р сарын 31-нээр | 2,651 | 6,624 | 9,275 |
| **Дансны цэвэр дүн** | 34,973 | 29,364 | 64,337 |

Үндсэн хөрөнгөд оффисын тавилга, компьютер, тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл багтаж байна.

## Биет бус хөрөнгө

Компанийн биет бус хөрөнгө нь 2016 оны 12 дугаар сард Анд Системс ХХК-с худалдаж авсан, зээлийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий ЛэндМН технологийг Монгол улсын нутаг дэвсгэрт ашиглах тусгай эрх бүхий лицензээс бүрдэнэ. ЛэндМН технологи нь харилцагчийг бүртгэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, төлөлт хийх, тайлагнах, харилцагчид техникийн тусламж үйлчилгээ үзүүлэх, болон ЛэндМН аппликейшнээс бүрдэнэ. ЛэндМН системийн тусгай лицензийг авахад 1 удаагийн 300,000 мянган төгрөг төлөх ёстой ба компани энэ төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.

Лиценз нь анх 2016 оны 12 дугаар сард туршилтын зорилгоор 5 жилийн хугацаатай олгогдсон ба туршилтын хугацаа 2017 оны 7 сарын 1-ний өдрөөр дуусгавар болж, лицензийн хугацааг 2016 оны 12 дугаар сараас хойш нийт 50 жил болгож, нэмэлт төлбөргүйгээр сунгасан. 2 тал харилцан тохиролцсон үед эсвэл Компани зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй болсноос бусад тохиолдолд лицензийн гэрээг цуцлах нөхцөл байхгүй. Лицензийн хугацаа хэдийгээр 50 жил боловч, удирдлага лицензийн ашиглалтын хугацааг 10 жил гэж дүнгэж байгаа тул, лицензийг 10 жилээр хорогдуулан бүртгэж байгаа.

2017 оны 10 сарын 31-ний өдрийн байдлаарх аудитлагдсан тайланд тусгагдсанаар үнэт цаас гаргагч компани нь нийт 2,809.6 сая төгрөгийн хөрөнгөтэй, 387,8 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Нийт өр төлбөрийн дийлэнх нь буюу 300,2 сая төгрөгийг хаалттай бондын өглөг эзэлж байна.

СЗХ БҮРТГЭВ №01

# ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН ТАЛААР

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нэр түүний гол нөхцөл | Гэрээний огноо, дугаар | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Анд системс" ХХК | "Зээлийн гэрээ"-2 сарын хугацаатай, сарын 1,5 хувийн хүүтэй, 75 сая төгрөгийг зээлдүүлсэн | 2017.02.22, №10000001 | Сонирхлын зөрчилтэй | 2017.04.05-ны өдөр хаасан |
| 2 | "Анд системс" ХХК | "Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ"-сарын 1,5 хувийн хүүтэй, 2017.11.22-ны өдрийг хүртэл хугацаатай, 345,000,000 /гурван зуун дөчин таван сая/ төгрөгийн хаалттай өрийн бичиг гаргаж худалдсан | 2017.08.22 №01 | Их хэмжээний бөгөөд сонирхлын зөрчилтэй | 2017.09.27-ны өдөр хаасан |
| 3 | "Анд системс" ХХК | "Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ"-жилийн 18 хувийн хүүтэй 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгийн өрийн бичиг гаргаж "Анд системс" ХХК-д худалдсан | 2017.10.30 №02 | Их хэмжээний бөгөөд сонирхлын зөрчилтэй | 2017.11.10-ны өдөр хаасан |
| 4 | "Кингдом Инвест ББСБ" ХХК | "Зээлийн гэрээ"-2 сарын хугацаатай, сарын 2 хувийн хүүтэй, 250,000,000 төгрөгийг зээлсэн | 2017.06.02 №06/2017 | Их хэмжээний | 2017.09.27-ны өдөр хаасан |
| 5 | "Чойжин Брос ББСБ" ХХК | "Зээлийн гэрээ"-2 сарын хугацаатай, сарын 1.5 хувийн хүүтэй, 320,000,000 төгрөгийг зээлсэн | 2017.08.30 № ЗГ170801 | Их хэмжээний | 2017.09.27-ны өдөр хаасан |
| 6 | Нью Майнд Групп ХХК | "Түрээсийн гэрээ" – СБД, 5-р хороо, "Нью майнд" группын 101.59 ам.метр бүхий байрыг 2018.01.02-ний өдрийг хүртэл түрээслэх | 2017.01.02 | Сонирхлын зөрчилтэй | Хэрэгжиж байгаа бөгөөд хэрэгжих боломжтой |
| 7 | Иргэн Ж.Оюунгэрэл | "Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ"-жилийн 16 хувийн хүүтэй 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгийн өрийн бичгийг 1 жилийн хугацаатай гаргаж иргэн Ж.Оюунгэрэлд худалдсан | 2017.11.10 | Их хэмжээний хэлцэл | Хэрэгжиж байгаа бөгөөд хэрэгжих боломжтой |
| 8 | М.Төвшинжаргал | "Зээлийн гэрээ" – 25 сарын хугацаатай, сарын 1%-ийн хүүтэй, 8,000,000 төгрөгийг зээлсэн | 2016.12.01 №06/2016 | Сонирхлын зөрчилтэй | 2017.12.06-ны өдөр хаасан |

Хүснэгт9. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTSK LLC

LENDMN

2018 01 19

ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

Тус компани нь сүүлийн 3-н жилийн хугацаанд хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй 8 гэрээ ирүүлснээс 2 гэрээнээс бусад нь хэрэгжиж дууссан, дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна. Эдгээр 8 гэрээг "Компанийн тухай хууль"-ийн 11, 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу байгуулсан байна. Одоо хэрэгжилтийн шатанд байгаа 2 гэрээ нь цаашид хэрэгжих боломжтой хэмээн хуулийн дүгнэлт гарсан байна.

## 1.8 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 сарын 01-ний өдрийн хурлаас компани хэлбэрээ өөрчилж анхны хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах "Ногдол ашгийн бодлого "-ын төслийг дараах агуулгаар боловсруулж баталсныг хураангуйлан хүргэж байна.

### Ногдол ашиг хуваарилах нөхцөл

Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нөхцлөөс гадна дараах тохиолдолд ногдол ашиг хуваарилах нөхцөл үүссэн гэж үзнэ.

- Компанийн тухайн жилийн цэвэр ашгийг тухай жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх;
- Шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар сайн байх;

### Ногдол ашиг хуваарилах тухай

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2017 оны 12 сарын 07-ны өдрийн хурлаар 2018-2019 оны ногдол ашгийн тухай дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

- Ногдол ашгийн бодлогын "Ногдол ашиг хуваарилах нөхцөл"-д заасан нөхцөл байдал хангагдсан тохиолдолд 2018, 2019 оны цэвэр ашгаас хуваарилах ногдол ашгийн хэмжээг тайлант үеийн аудитлагдсан цэвэр ашгийн 20-оос багагүй хувиар тогтоосугай.
- Ногдол ашгийн хувь хэмжээг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ-өөс шийдвэрлэнэ.
- Ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлэх бодлого баримтална.

20180119

# ХОЁР. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

## 2.1 ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1.1 Төсөл хэрэгжүүлэх үндэслэл: Санхүүгийн зах зээлийн "Сорилт"
2.1.2 Төслийн ач холбогдол
2.1.3 Салбарын өрсөлдөх чадвар
2.1.4 Маркетингийн төлөвлөгөө
2.1.5 Бизнесийн үр ашгийн тооцоо
2.1.6 Санхүүгийн үзүүлэлтүүдийн таамаглал

## 2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### 2.2.1 Бичил хэрэглээний зээлийн өнөөгийн байдал

1. Зээлийн эрэлт нийлүүлэлт ба ББСБ-ын өнөөгийн байдал
2. ББСБ-ын зээлдэгчийн үзүүлэлт
3. Хөдөлгөөнт банкны хэрэглээ
4. Бичил санхүүгийн салбарын оролцогчид
5. Өрсөлдөгчийн судалгаа

### 2.2.2 Санхүүгийн үйлчилгээний дэлхийн чиг хандлага

1. Дэлхийн улс орнуудад нэвтэрч буй бичил зээл олголтын шинэ арга, хэрэгсэл
2. Уламжлалт санхүүгийн үйлчилгээний бизнес загвар шинэчлэлийг шаардаж байна.
3. Уламжлалт болон уламжлалт бус ББСБ-ын харьцуулалт

### 2.2.3 Бичил хэрэглээний зээлийн зах зээлийн судалгаа

1. ЛэндМН ББСБ-ийн хэрэглэгчдийн өнөөгийн байдал
2. Нас, орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид
3. Технологи хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгчид
4. Өрхийн орлого, зарлагад суурилсан хэрэглэгчдийн судалгаа
5. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үзүүлэлт
6. Бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж

## 2.3 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

## 2.4 ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 2.1 ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.1.1. Төсөл хэрэгжүүлэх үндэслэл: Санхүүгийн зах зээлийн "Сорилт"

### Финтекийн довтолгоо

**"Интернет" : Холыг ойртуулсан үйлчилгээ**

Малчин Дүгэр Хөвсгөл аймгийн нутагт хэдэн үеэрээ мал маллан амьдарч ирсэн. Түүний хувьд Америкт суугаа том охинтойгоо утсаар ярих нь битгий хэл Улаанбаатарт байгаа хүүтэйгээ мэдээлэл солилцоно гэдэг өвлийн шуурганд туугдсан малтайгаа хөөцөлдөхөөс ч хүндхэн даалгавар. Урьд цагт хүнээс сураг сонсож, шуудангаар хааяа нэг Улаанбаатарт суугаа миний хүүд гэдэг шиг захидал илгээдэг байсан бол одоо ухаалаг гар утас, утасгүй интернэтийн тусламжтайгаар хүссэн цагтаа бүр нүүрийг нь харж байгаад сонин хачнаа ярилцдаг болсон байна.

**"Банк": Хоёр сайхан шарыг нь хоёрхон муу оготно иддэг үеийн асуудлыг шийдсэн санхүүгийн үйлчилгээ**

Банкны үйлчилгээ нэвтэрч, картаар ганц "арчаад" л тооцоогоо хийчихдэг, хоёр битгий хэл хоёр мянган малынх нь буян шингэсэн хөрөнгийг нь банк найдвартай хадгалж, эргээд хэрэгтэй нэг нь орлогоо батлаад, бичиг цаас бүрдүүлж зээлийн хүсэлтээ өгөөд ажлын 2-3 хоногт зээл авдаг болсон билээ.

**Сорилт: Та гар утастай байхад өөртөө санхүүгийн үйлчилгээ үзүүлэх боломжтой эрин үед амьдарч байна. Харин "Монголчууддаа энэ боломжийг хэрхэн олгох вэ?"**

Ухаалаг гар утасны асар хурдтай хэрэглээг дагаад хүмүүсийн цаг завыг хэмнэсэн олон боломжийг Финтек бий болгоод байна. Санхүүгийн үйлчилгээг технологийн дэвшилтэй хослуулан хүмүүст олон янзын үйлчилгээг хялбар шуурхай хүргэдэг болжээ.

Финтек бол үнэхээр шинэ довтолгоо бөгөөд цаг завгүй орчин үеийн хүмүүс элдэв дараалал, хүнд суртлаас ангид байх санхүүгийн үйлчилгээг бий болгохоос гадна тасралтгүй хөгжсөөр байгаа юм.

Монголчууд бидний хувьд финтекийн хөгжлөөс мобайл банк, и-баримт, зээлийн карт, интернэт банкны үйлчилгээг идэвхитэй хэрэглэж ирсэн боловч "Зээлийн үйлчилгээ"-г гар утаснаасаа авах боломж хязгаарлагдмал байлаа.

**Монголчууддаа санхүүгийн үйлчилгээний дэлхийн чиг хандлагад ойртуулан, цаг хугацаа хэмнэсэн, хүнээс хамааралгүй, барьцаагүй зээлийг 1-3 минутад авах боломжийг олгох нь тус төслийг санаачилах үндэс болсон юм.**

20180119

## Дунд хугацааны "Сорилт"

Дэлхий даяар хиймэл оюун ухаан, автоматжуулалт, нано технологийг нэвтрүүлсэн үйлдвэрийн 4 дэх хувьсгал[2] нь, санхүүгийн салбарын хөдөлгөх хүч болж байна.

2016 онд Дэлхийн эдийн засгийн чуулганыг үүсгэн байгуулагч Klaus Schwab-ын бичсэн нийтлэлд

> "Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн өөрсдийн аж амьдрал, ажлын орчин нөхцөлөө сайжруулахын тулд мэргэн оюун ухаанаа харамгүй зарцуулж, заримыг нь бараг шавхаж байна. Hargreaves-ийн анх зохиосон эргэлдэх хөдөлгөөнөөр ноос самнах машинаас авахуулаад Ford-ийн машин үйлдвэрлэл, угсралтын анхны шугамууд, Wozniak-ийн компьютерийн хэрэглээнд хувьсгал гаргасан шийдлүүдийг энд дурдаад байвал дуусашгүй. Харин өнөөдөр бид хоорондоо холбогдсон хэдэн тэрбум төхөөрөмжүүд, 3D хэвлэгч, супер ухаалаг роботуудыг нэгэнт бүтээж чадсан болохоор **"Дэлхийн аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал"**-ын тухай нухацтай ярих цаг нь нэгэнт болжээ. Энэ хувьсгал зөвхөн манай нийгэм ба эдийн засгийг өөрчлөөд зогсохгүй хүн гэдэг бодьгалийн шинж төлөвийг ч өөрчлөх хүчтэй байна. Харин ХҮН бид үүнд бэлэн үү?"

гэж дурдсан байдаг. Технологи өнөөдөр бидний амьдралыг улам хялбаршуулан санхүүгийн салбараас гадна **хоол+технологи *(foodtech)*, *боловсрол+технологи (edtech), эрүүл мэнд+технологи(healthtech)***зэрэг олон салбарт нэвтэрсээр байна. Үүнтэй зэрэгцэн санхүүгийн салбарт Финтек ***санхүү+технологи(Fintech)***ч мөн адил маш хурдацтай хөгжиж байна.

*Дунд хугацааны бизнес загвар*

| 1.Хэрэглэгчийн хүрээг тэлэх | 2. Ашиг орлогоо тогтворжуулах | 3. Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх |
|---|---|---|
| **Түргэн шуурхай бичил зээл** | **Бусад зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх** | **Бусад санхүүгийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх** |

Хүснэгт10. Дунд хугацааны бизнесийн загвар

## *Сорил: Бичил бизнесийн зээлийн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх*

Монгол улсад үүргийн худалдаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа эргэлтийг дэмжих бас нэг бүтээгдэхүүн бол "бичил бизнесийн зээл"-ийн үйлчилгээ юм. Монгол банкны 2015 оны 8 сард хийсэн "Үүргийн худалдаа"түүвэр судалгаанаас[3] харахад Нарантуул, Бөмбөгөр, Сандэй Плаза,

[2] 2016 онд Швейцарын Давос-Клостерст зохиогдсон Дэлхийн Эдийн Засгийн Чуулганы сэдэв нь "Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал". Клаус Шваб энэ ойлголтыг анх албан ёсоор тодорхойлж хэлсэн байдаг.

[3] *Эх сурвалж: Монгол банкны түүвэр судалгаа*

Алтжин Бөмбөгөр, Барс, Шөнийн зах, Дүнжингарав худалдааны төвүүд дээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 8,423 худалдаа эрхлэгч байна. Мөн тус судалгаанд дурдсанаар Монгол улсын хэмжээнд сард дунджаар 67 тэрбум төгрөгийн импорт бэлэн валютаар төлөгддөг, үүнээс 47 тэрбум үүргийн худалдаанд зарцуулагддаг болохыг тогтоожээ.

### 2.1.2 Төслийн ач холбогдол

1. Бага мөнгөн дүнтэй, ихэвчлэн ойр дотны хүмүүсийн хооронд явагддаг албан бус хэрэглээний зээлийн асуудлыг шийдэн, зээлийн үйлчилгээнд ШИНЭ ЗАХ ЗЭЭЛ үүсгэсэн.
2. Барьцаагүй
3. Эргэн төлөлт хийгдсэнээр урамшууллын оноо олгодог.
4. Бага мөнгөн дүнтэй боловч зээлэхэд хүндрэлтэй, хүмүүс хоорондын харилцаанд ихэвчлэн сөргөөр нөлөөлдөг байсан хэрэглээний зээлийг хялбаршуулсан.
5. Уламжлалт ББСБ-уудтай харьцуулахад шууд бус зардал багатай тул зээлийн өртөгийг багасгах боломжтой.
6. Нэг зээл авахад зарцуулдаг цагийг эрс бууруулсан. Энэ нь тухайн хэрэглэгчийн алдагдсан боломжийн өртгөөр хэмжигдэх ба нэг хүн бичил зээл авахаар ББСБ-д зарцуулах цагийг дунджаар 3 цаг гэж тооцох юм бол өдийг хүртэл ЛэндМН-ээс зээл аваад буй 18,998 хүний 56,994 цаг буюу 2,374 өдөр, 6,5 жилийг хэмнэсэн байна. Энэ цагт ажиллаж байсан бол дунджаар 1 сая төгрөгийн цалинтай мэргэжилтэн хүний 3 цагт алдагдсан боломжийн өртөг дунджаар 17,361 төг буюу нийт 18,998 хүний 329,8 сая төгрөгийг хэмнэсэн байна.
7. Иргэдийн санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, санхүүгийн соёл болон зээлийн түүх үүсгэж өгснөөр банкнаас илүү өндөр дүнтэй зээл авах суурь боломжийг бүрдүүлж өгч байна.
8. Хиймэл оюун ухаан дээр суурилсан тул хүнээс хараат бусаар өөрийн зээлийн дүнг тодорхойлуулах боломжтой.
9. Шинээр 60 ажлын байр үүсгэсэн.
10. Бусад санхүүгийн байгууллагуудын зээлийн эргэн төлөлтийг сайжруулах хосолсон бүтээгдэхүүн байх боломжтой.
11. Банк бус санхүүгийн байгууллагын салбарт 2 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт татсан.
12. Монгол улсын анхны Финтек шийдлийг нэвтрүүлсэн компани гэдэг утгаараа олон улсын зах зээлд Монгол улсын санхүүгийн зах зээлийг таниулах жишиг компани болж байна.

https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/samplesurvey/shuttlesurvey.pdf

БҮРТГЭЭ 01
20180119

### 2.1.3 Салбарын өрсөлдөх чадварын шинжилгээ

#### 1. Бүтээгдэхүүний "Амьдралын мөчлөг"

Жеоффрей Муур гэх эрдэмтэн "Ангалыг давахуй: Хэрхэн дэвшилтэт технологийн бүтээгдэхүүнийг зах зээлд хүргэн борлуулах"[4] номондоо "Инновацилаг, шинэ технологийн бүтээгдэхүүний хувьд хамгийн бэрх үе нь эртэч хэрэглэгчдээс эртэч олонх гэх сегмент руу нэвтрэх болон тэлэх үе буюу энэ хоёр сегментийн дунд бүтэлгүйтвээс маш том ангал үүсдэг" хэмээн дурдсан байдаг. Иймд технологийн компани нь үүнээс сэргийлэн арга хэмжээ авах ёстой.

LendMN аппликэйшнийн хувьд одоогийн байдлаар 90'000 хэрэглэгчид бүртгүүлэн ашигласнаас 18,998 нь ЛэндМН-ийн гэрээтэй харилцагч болсон буюу эртэч хэрэглэгчид хэрэглээд байгаа ба нийт зорилтот сегментийн багахан хувийг энэ тоо бүрдүүлж байгаа юм. Иймээс эртэч олонхи буюу нийт зорилтот зах зээлийн дийлэнхи хувийг хангахын тулд ангалыг эртнээс тооцоолох, бизнесийн стратегидаа тусган анхааралдаа авах шаардлагатай.

| | Үе шатууд | Онцлогууд | Хэрэгжүүлэх стратегийн аргууд |
|---|---|---|---|
| 1 | **Нэвтрэлт**<br>Өрсөлдөөн бага: онцгойролт болон инноваци чухал | • Хиймэл оюун ухаан дээр тулгуурласан, зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн гадгаараа давуу талтай<br>• Хурдан, шуурхай, барьцаагүй зээл<br>• Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ ойлгомжтой<br>• Тодорхой хүрээний хасэг сегментэд их хүртээмжтэй<br>• Ажил хэрэгч 24-35 насны залуучууд | • Зорилтот хэрэглэгчдэд түлхүү танигдах<br>• Давуу талуудаараа зах зээлийн байршлаа сайжруулах<br>• Зорилтот зах зээлээ бүрэн хангахаар эрмэлзэх |
| 2 | **Өсөлт**<br>Их өсөлт бий болж шинэ тоглогч нэвтрэхэд бага саадтай байдаг: өсөлтийг бэхжүүлэх нь чухал | • Зах зээлд анхдагчийн давуу талыг бэхжүүлэх<br>• Хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралын бичил санхүүгийн асуудлыг шийдэгч<br>• Зорилтот зах зээлээс гадна өөр сегментүүд сонирхож эхлэх<br>• Шинэ тоглогчид болон ижил төсөөтэй үйлчилгээнүүд нэвтрэх<br>• Санхүүгийн байгууллагуудаар зогсохгүй өөр томоохон өргөн хүрээний хэрэглээний тоглогчид ижил төсөөтэй бичил зээл олгож эхлэх магадлалтай<br>• Манай бүтээгдэхүүн нэвтэрч болох, хамтрагч байгууллагуудтай хамтрах | • Бүтээгдэхүүнийг төрөлжүүлж зах зээлээ тэлэх<br>• Хиймэл оюун ухааныг илүү боловсронгуй бөгөөд халдлагад тэсвэртэй, найдвартай систем болгох<br>• Зах зээлд итгэл даахуйц дүр төрхтэй нэгнээр сурталчлуулах, дижитал маркетинг хийх<br>• Хэрэглэгчдэд танигдахын хэрээр хангалттай хөрөнгө татан төвлөрүүлэх |
| 3 | **Тогтворжилт**<br>Бага өсөлт, бүтээгдэхүүний стандартчилал ажиглагдаж, шинэ тоглогч зах зээлд нэвтрэх нь ярвигтай | • Нэгэнт танигдсан үйлчилгээ, тогтмол хэрэглэгчид<br>• Өрсөлдөгчид тодорхой болж, зарим өрсөлдөгчид зах зээлээс гарна | • Зах зээлийн хэсгээ тогтоон барих<br>• Олон улсын түвшинд өрсөлдөхүйц үнэ бүтээгдэхүүнүүддээ санал болгох<br>• Гадаад зах зээлд нэвтэрч болох бизнес түншлэлүүдийг бий болгох |

[4] Crossing the Chasm: Marketing and Selling High-Tech Products to Mainstream Customers

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **Remarketing** Олон тоглогч зах зээлээс гарч үнийн өрсөлдөөн явагдана. Зардлаа танах чухал | • Хамтрагч байгууллагуудтай нэмүү үнэ цэнэ үүсэх<br>• Бүтээмж өндөр, зардал бага | • Хиймэл оюун ухааны багийн боловсон хүчнээ сайжруулах<br>• Зардлаа танах аргаар үнээ бууруулах<br>• Судалгаа, хөгжүүлэлтэд хөрөнгө оруулалт хийж IT инженерүүдтэй, судлаачидтай хамтран шинэ сегментүүдийг нээн илрүүлэх |

Хүснэгт11. Зах зээлийн дийлэнхи хувийг хангах стратеги

## ЛэндМН-ийн "Үнэ цэнэ"-ийн анализ

### VRIN' (Valuable, Rare, Inimitable, Non-substitutable) загварчлал:

Аливаа бизнест өрсөлдөөний давуу талаа удаан хугацаанд хадгалж үлдэх нь нэн чухал байдаг. Бизнесийн давуу талуудыг өрсөлдөгч болон хөндлөнгийн талууд нь дуурайх болон орлуулах боломжгүй байх тусам тухайн бизнес ашгаа ихэсгэх боломж бүрддэг. Тиймээс, топ менежерүүд биет болон биет бус үнэ цэнэ бүхий дотоод нөөц баялгуудаа хамгаалан сайжруулж, тэдгээрээс боломжит удаан хугацаанд хөрөнгө оруулалтын өндөр өгөөж хүртэх талаар онцгой анхаарал хандуулах ёстой байдаг.

| | |
|---|---|
| Үнэ цэнэтэй | - Хэрэглэгчдийн үнэт цагийг хэмнэдэг, шуурхай үйлчилгээ<br>- Хэрэглэхэд хялбар, зөвхөн утаснаасаа<br>- Хэрэглэгчдийг урамшуулдаг хөтөлбөрүүд |
| Ховор | - Барьцаагүй зээлийн үйлчилгээ<br>- Хурдан шийдвэр гаргалт<br>- Уг чиглэлээр нарийн бэлтгэгдсэн мэргэжилтнүүд<br>- Урт хугацаанд хийсэн бизнес хөгжүүлэлтийн судалгаа<br>- Зах зээлийн арвин туршлага<br>- Монголоос дэлхийн зах зээлд өрсөлдөхөөр эрмэлзэж буй алсын хараа<br>- Үнэнч болон тогтмол хэрэглэгчид |
| Дуурайх боломжгүй | - Хиймэл оюун ухаан буюу хэрэглэгчдэд зээл олгож буй алгорифм. Хэрэглэгчдийн зан байдлыг судлах, шинжлэх ухаан дээр суурилсан шийдвэр гаргалт, зээл олголт |
| Орлуулах боломжгүй | - Патент, оюуны өмчийн эрх<br>- Олонд танигдсан бренд<br>- Топ менежерүүдийн алсын хараа, тэдний бизнестээ сэтгэлээ өгсөн байдал<br>- Дотоодын зах зээлд богино хугацаанд өндөр амжилт үзүүлж буй цөөхөн старт-ап компанийн нэг |

Хүснэгт12. Биет бус үнэ цэнэтэй баялагуудаа хамгаалах

### Цаашид анхаарах зүйлс: Портерийн 5 хүчин зүйл

Тухайн бизнесийн үйл ажиллагаа явуулах гэж байгаа салбарт гол нөлөөлөгч талуудын зүгээс ирэх дарамтыг системчилэн харахад Портерийн 5 хүчин зүйлийг ашигладаг. Үүнийг урьдчилан тооцоолсноор бизнест учирч болохуйц эрсдлийг урьдчилан тооцоолж, бизнесийн стратеги төлөвлөгөө боловсруулан арга хэмжээ авах боломжтой.

**Зах зээлд шинээр нэвтрэгчид:**

MIRAE ASSET MONGOLIA ҮЦК LLC
LENDMN
2018 01 19

- Аппликейшн нэгэнт зах зээлд танигдсан учир дуураймал, ижил төсөөтэй үйлчилгээтэй бүтээгдэхүүн гарч ирэх магадлалтай.
- Ялангуяа, бичил хэрэглээний зээлийн салбарт томоохон санхүүгийн байгууллагууд болон бусад боломжит харилцаа холбооны компаниуд нэр хүнд, дэд бүтэц дээрээ тулгуурлан дуурайн гарч ирэх өндөр магадлалтай.

**Худалдан авагчид:**

- Зөвхөн үүрэн телефонд суурилсан
- Бодит байдал дээр зээлийн шаардлага хангадаг ч алгорифмын хувьд зээл олгохоос татгалзаж байгаа олон сегментүүд орхигдох магадлал
- Хэрэгцээ байгаа ч ухаалаг утсыг сайн ашиглаж чадахгүйн улмаас хэрэглэж чадахгүй байгаа бүлэг хэрэглэгчид

**Нийлүүлэгчид:**

- Хууль эрх зүйн тодорхой бус орон зай
- Аппликейшн бэлтгэн нийлүүлэгч мэргэжилтнүүд ховор
- Хиймэл оюун ухааныг боловсруулан сайжруулах, системийг байнга сайжруулж, хамгаалах шаардлагатай

**Орлуулагчид:**

- Зээлийн карт
- Байгууллагуудын өрсөлдөөн ихэсч хөнгөлттэй нөхцлөөр, зарим тохиолдолд аливаа төлбөргүйгээр бүтээгдэхүүн худалдан авах боломж

**Шууд өрсөлдөөн:**

- 2017 оны 9 сарын байдлаар нийт 535 ББСБ үйл ажиллагаа явуулж байна
- Системийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагуудын олгож буй цалин, тэтгэврийн зэрэг бичил зээлүүд
- Шинээр ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй тоглогчид

### 2.1.4 Маркетингийн төлөвлөгөө

#### Дижитал маркетинг

Мэдээллийн технологийн эрин үед бараа бүтээгдэхүүнийг технологийн хэрэглээ өндөр хэрэглэгчдэд хүргэх хамгийн үр дүнтэй арга бол дижитал маркетинг учир ЛэндМН-ийн гол маркетингийн стратеги нь өөрийн бүтээгдэхүүнийг дижитал маркетингийн арга хэрэгсэл ашиглан олонд мэдээллийг хүргэх юм.

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC

LENDMN

2018 01 19

Монгол улсын хэмжээнд нийт 2.4 сая гаруй хүн ухаалаг утас ашиглаж байгаа энэ цаг үед, мэдээлэлд ойр бөгөөд мэдрэг хэрэглэгчдийн нийгмийн сүлжээний хандалт, ямар контентыг түлхүү үзэж байгааг, тренд болох магадлалтай сэдэв, веб хуудсаар зочилсон хандлага зэрэгт дүн шинжилгээ хийж, хувь хүн, тодорхой бүлэгт чиглэсэн үр дүнтэй маркетинг хийх замаар хэрэглэгчийн тоог нэмэхэд голлон зорьж байна.

Хэрэглэгчид хүргэх агуулгыг олон өгүүлбэрээр илэрхийлэхийн оронд дүрслэл, зураглалаар хэдхэн секундэд хүний ой санаанд тод үлдээх боломжтой учир ЛэндМН нь бүтээгдэхүүнийхээ талаар чанартай контентоор дамжуулан бүх насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өргөн хэрэглэдэг нийгмийн сүлжээ, фэйсбүүк, твиттер, инстаграммаар маркетинг хийж гэр бүл, анд нөхөд, ажил хөдөлмөрт зарцуулах "үнэт цаг"-ийг хэмнэхийн хажуугаар санхүүгийн мэдлэг, зөв зохистой хэрэглээг дэмжин ажиллаж байна.



Гүүгл компанийн гүйцэтгэх захирал Эрик Шмит хэлэхдээ "Эхлээд гар утас" гэдэг стратегиас "Зөвхөн гар утас" гэдэг (Mobile First to Mobile Only) стратегид шилжих болсноор ухаалаг утас хэрэглэгч "ХҮМҮҮС"-д чиглэсэн дижитал маркетинг ямар хүчтэй борлуулалтын арга хэрэгсэл болсныг олон маркетеруудад ойлгуулсан байдаг. Өөрөөр хэлбэл ухаалаг утсанд суурилсан үйлчилгээг нэвтрүүлсэн ЛэндМН-ийн дижитал маркетингийн гол зэвсэг нь хэрэглэгчийн гарт атгуулсан ухаалаг утас байх юм.

**ЛэндМН-ийн хэрэглэгч төвтэй маркетинг**




Схем8. ЛэндМН-ийн маркетинг

## 2.1.4 САНХҮҮГИЙН ТААМАГЛАЛ

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТААМАГЛАЛ

| ТАЙЛАН ТЭНЦЭЛ (Сая төгрөг) | 2017 [1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах | 2,085.0 | 4,158.7 | 4,038.7 | 2,354.4 | 4,480.4 | 4,440.2 |
| Харилцагчдад олгосон нийт зээл | 4,635.4 | 20,738.0 | 37,362.6 | 55,734.7 | 71,966.5 | 88,267.8 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц | (46.4) | (311.1) | (747.3) | (1,114.7) | (1,799.2) | (2,648.0) |
| Нийт цэвэр зээл | 4,589.0 | 20,426.9 | 36,615.3 | 54,620.0 | 70,167.3 | 85,619.8 |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 380.6 | 462.4 | 424.8 | 387.2 | 355.5 | 238.8 |
| | | | | | | |
| **Нийт хөрөнгө** | **7,054.6** | **25,048.1** | **41,078.9** | **57,361.6** | **75,003.2** | **90,298.8** |
| | | | | | | |
| Өр төлбөр | 1,000.0 | 10,000.0 | 21,000.0 | 30,000.0 | 38,500.0 | 41,460.0 |
| | | | | | | |
| **Нийт өр төлбөр** | **1,000.0** | **10,000.0** | **21,000.0** | **30,000.0** | **38,500.0** | **41,460.0** |
| | | | | | | |
| Эздийн өмч | 6,000.0 | 11,000.0 | 11,599.0 | 12,383.6 | 13,515.2 | 14,943.0 |
| Хуримтлагдсан ашиг | 54.6 | 4,048.1 | 8,479.9 | 14,978.0 | 22,988.0 | 33,895.8 |
| Өнгөрсөн оны хуримтлагдсан ашиг | (5.4) | 54.6 | 4,048.1 | 8,479.9 | 14,978.0 | 22,988.0 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | 60.0 | 3,993.4 | 5,230.5 | 7,544.2 | 9,518.8 | 12,811.5 |
| Тараасан ногдол ашиг | - | - | (798.7) | (1,046.1) | (1,508.8) | (1,903.8) |
| **Нийт эздийн өмч** | **6,054.6** | **15,048.1** | **20,078.9** | **27,361.6** | **36,503.2** | **48,838.8** |
| | | | | | | |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **7,054.6** | **25,048.1** | **41,078.9** | **57,361.6** | **75,003.2** | **90,298.8** |

[1] *Хуулээдэж буй аудитлсан*

Хүснэгт13. Тайлан тэнцлийн таамаглал

## Орлогын тайлангийн таамаглал

| ОРЛОГЫН ТАЙЛАН (Сая төгрөг) | 2017 [1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Хүү ба түүнтэй адилтгах орлого | 1,005.0 | 7,925.6 | 11,746.7 | 16,724.7 | 21,279.9 | 27,257.8 |
| Хүүгийн зардал | (41.3) | (746.7) | (2,420.0) | (4,013.3) | (5,370.0) | (6,330.9) |
| Зээлийн эрсдлийн сангийн зардал | (78.2) | (284.4) | (480.2) | (438.8) | (778.3) | (971.0) |
| | | | | | | |
| **Цэвэр хүүгийн орлого** | **885.6** | **6,894.6** | **8,846.5** | **12,272.5** | **15,131.6** | **19,955.9** |
| | | | | | | |
| Цалин | (268.3) | (559.9) | (648.1) | (767.6) | (981.1) | (1,202.2) |
| Бусад зардал | (460.4) | (907.7) | (819.4) | (958.0) | (1,056.1) | (1,170.3) |
| Системийн засвар үйлчилгээний зардал | (90.2) | (702.3) | (1,005.1) | (1,087.9) | (1,002.6) | (1,101.3) |
| | | | | | | |
| **Нийт үндсэн үйл ажиллагааны зардал** | **(818.9)** | **(2,170.0)** | **(2,472.5)** | **(2,813.5)** | **(3,039.9)** | **(3,473.8)** |
| | | | | | | |
| **Татварын өмнөх ашиг** | **66.7** | **4,724.6** | **6,374.0** | **9,459.0** | **12,091.8** | **16,482.1** |
| | | | | | | |
| Татвар | (6.7) | (731.1) | (1,143.5) | (1,914.7) | (2,572.9) | (3,670.5) |
| | | | | | | |
| **Цэвэр ашиг** | **60.0** | **3,993.4** | **5,230.5** | **7,544.2** | **9,518.8** | **12,811.5** |

[1] *Хөлөөдөж буй аудитлагдсан*

Хүснэгт14. Орлогын тайлангийн таамаглал

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC

2018U119

СЭХ БҮРТГЭВ № 01

LENDMN УЛААНБААТАР ХОТ

## Мөнгөн гүйлгээний таамаглал

| МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Сая төгрөг) | 2017 [1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | | | | |
| Гаргасан зээл | (17,699.6) | (196,517.3) | (440,609.7) | (714,024.1) | (938,087.0) | (1,220,889.7) |
| Зээлийн эргэн төлөлт | 13,156.5 | 180,394.9 | 423,941.1 | 695,580.5 | 921,761.5 | 1,204,466.2 |
| Хүүгийн орлого | 1,005.0 | 7,925.6 | 11,746.7 | 16,724.7 | 21,279.9 | 27,257.8 |
| | | | | | | |
| Цалин | (268.3) | (559.9) | (648.1) | (767.6) | (981.1) | (1,202.2) |
| Удирдлагын зардал | (423.0) | (839.5) | (731.8) | (860.3) | (944.4) | (1,053.6) |
| Системийн засвар үйлчилгээний зардал | (90.2) | (702.3) | (1,005.1) | (1,087.9) | (1,002.6) | (1,101.3) |
| Татвар | (6.7) | (731.1) | (1,143.5) | (1,914.7) | (2,572.9) | (3,670.5) |
| Зээлийн хүү | (41.3) | (746.7) | (2,420.0) | (4,013.3) | (5,370.0) | (6,330.9) |
| **Нийт үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(4,367.4)** | **(11,776.2)** | **(10,870.4)** | **(10,362.8)** | **(5,916.8)** | **(2,524.3)** |
| | | | | | | |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | | | | |
| Үндсэн хөрөнгө худалдан авалт | (100.0) | (150.0) | (50.0) | (60.0) | (80.0) | - |
| Биет бус хөрөнгө худалдан авалт | (155.6) | - | - | - | - | - |
| **Нийт хөрөнгө оруулалт** | **(255.6)** | **(150.0)** | **(50.0)** | **(60.0)** | **(80.0)** | - |
| | | | | | | |
| САНХҮҮЖИЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | | | | |
| Нэмж гаргасан хувьцаа | 5,200.0 | 5,000.0 | 599.0 | 784.6 | 1,131.6 | 1,427.8 |
| Нэмж авсан зээл | 1,650.0 | 9,000.0 | 11,000.0 | 9,000.0 | 8,500.0 | 3,500.0 |
| Зээлийн эргэн төлөлт | (650.0) | - | - | - | - | (540.0) |
| Ногдол ашиг [2] | - | - | (798.7) | (1,046.1) | (1,508.8) | (1,903.8) |
| **Нийт санхүүжилт** | **6,200.0** | **14,000.0** | **10,800.3** | **8,738.5** | **8,122.8** | **2,484.1** |
| | | | | | | |
| **Цэвэр мөнгөн гүйлгээ** | **1,577.0** | **2,073.8** | **(120.0)** | **(1,684.3)** | **2,126.0** | **(40.2)** |
| | | | | | | |
| Эхлэл Бэлэн Мөнгө | 507.9 | 2,085.0 | 4,158.7 | 4,038.7 | 2,354.4 | 4,480.4 |
| Эцсийн бэлэн мөнгө | 2,085.0 | 4,158.7 | 4,038.7 | 2,354.4 | 4,480.4 | 4,440.2 |

[1] *Хуулээдэж буй аудитлаагүй*

[2] *Компанийн ногдол ашгийн бодлогоор доод тал нь жилийн ашгийн 20% байхаар тусгасан*

Хүснэгт 15. Мөнгөн гүйлгээний таамаглал

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC

LENDMN

20180119

Орлогын таамаглалд дараах үндсэн үзүүлэлтүүд орсон болно:

| | Орлогын таамаглалын дэлгэрэнгүй | 2017[1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Идэвхтэй харилцагчид | 22,325 | 59,920 | 80,362 | 90,844 | 100,744 | 105,888 |
| 2 | Өдөрт гарах зээлийн дундаж тоо | 277 | 2119 | 3411 | 4220 | 4537 | 4984 |
| 3 | Зээлийн тоо | 99,723 | 762,801 | 1,228,076 | 1,519,176 | 1,633,445 | 1,794,169 |
| 4 | 1 хүнд ногдох дундаж зээлийн хэмжээ (мян.төг) | 177 ₮ | 258 ₮ | 359 ₮ | 470 ₮ | 574 ₮ | 680 ₮ |
| 5 | Гаргасан зээл (сая.төг) | 17,700 ₮ | 196,517 ₮ | 440,610 ₮ | 714,024 ₮ | 938,087 ₮ | 1,220,890 ₮ |
| 6 | Нийт зээлийн үлдэгдэл (сая.төг) | 4,365 ₮ | 20,738 ₮ | 37,363 ₮ | 55,735 ₮ | 71,986 ₮ | 88,268 ₮ |
| 7 | Хүү ба түүнтэй адилтгах орлого (сая.төг) | 1,005 ₮ | 7,926 ₮ | 11,747 ₮ | 16,725 ₮ | 21,280 ₮ | 27,258 ₮ |
| | | | | | | | |
| 8 | *Зах зээлийн багтаамж /харилцагчдын тоогоор/* | *331,981* | *348,580* | *366,009* | *390,000* | *435,000* | *500,000* |
| 9 | *Зах зээлд эзлэх хувь /харилцагчдын тоогоор/* | *7%* | *17%* | *22%* | *23%* | *23%* | *21%* |
| | *[1] Хүлээгдэж буй гүйцэтгэл* | | | | | | |

Хүснэгт16. Орлогын таамаглалын дэлгэрэнгүй

1. Компанийн харилцагчдын тоо тус тайланг бэлдэх үеийн байдлаар 10 сард 3,800, 11 сард 6,483-р тус тус өссөн бөгөөд тус өсөлт 12 сард бага зэрэг буурран 5,218 болохоор байгаа ба 2018 оны 1 сард олон нийтэд хувьцаагаа санал болгохтой холбогдуулан арай илүү өсөлттэй/6,500/ байна хэмээн тооцоолсон бөгөөд үүнээс цаашид сар бүр шинэ харилцагчийн тоо буурран дунджаар 2,700 орчим байна гэж тооцоолоход 2018 оны эцсээр 59.9 мянган харилцагчтай байна гэсэн төсөөлөл гарсан болно.
   Түүнчлэн шинэ харилцагчдын тоо 2019 онд сард дунджаар 1,667, 2020 онд 849, 2021 онд 817, 2022 онд 417-р тус тус нэмэгдэнэ хэмээн тооцоолсон болно.

2. Оны эхний хагаст компанийн үйл ажиллагаа дөнгөж олон нийтэд танигдаж эхэлж байсан бол оны сүүл рүү идэвхитэй харилцагчдын тоо огцом өсч ирсэн. Үүнд 2017 оны 6 сарын байдлаар нийт харилцагчдын тоо 3.4 мянга байсан бол 11 сарын байдлаар 19 мянга болж 5.6 дахин өссөн байна. Ийнхүү оны сүүлрүү хурдтай өсч байгаа тоо үзүүлэлтийг нийт жилийн дундаж харьцуулсан тул 2017 оны дундаж зээлийн тоон үзүүлэлт харьцангүй доогуур гарч буйг авч үзүүштэй.
   2017 оны 10 сард өдөрт дунджаар 465 ширхэг зээл гарч байсан нь 11 сард өдөрт дунджаар 760 болж өссөн байна. Өдөрт гарах зээлийн тоо нь нийт харилцагчийн тоотой шууд хамааралтай байдаг бөгөөд нэг харилцагчийн сарын дундаж зээлийн тоог энэхүү таамаглалд ашигласан болно.

3. Компанийн харилцагч нь өөрийн нийт эрхийн хэмжээнд хэдэн ч удаа зээл авч болдог ба зээл нь 30 хүртэлх хоногийн хугацаа байдаг тул тухайн сардаа төлөөд дахин зээлэх боломжтой байдаг. Энэхүү зээлийн тоо нь компанийн харилцагч нарын давтамжтайгаар дахин дахин авсан зээлүүдийн нийлбэр дүн болно. Компанийн олгосон зээлийн тоо нь энэхүү төсөөллийн чухал ач холбогдолтой хэсэг ба нийт харилцагчийн тооноос нэг харилцагчийн сард авдаг зээлийн дундаж тоогоор үржүүлж тооцоолсон болно.

4. Нэг харилцагч нэг удаа авдаг зээлийн дундаж мөнгөн дүн. Компанийн зээлийн бодлогын дагуу харилцагчийн зээлийн эргэн төлөлт хугацаандаа байх тохиолдолд тухайн зээлдэгчийн авч болох зээлийн хэмжээ нь

автоматаар нэмэгдэж байгаа ба хүрч чадах хамгийн дээд хэмжээг хиймэл оюун ухааны тусламжтайгаар анхнаас нь бодон тухайн харилцагчид мэдэгдсэн байдаг. Иймд нэг харилцагчийн авах дундаж хэмжээ нь тухайн хэрэглэгчид батлагдсан дээд хэмжээний хүрээнд сар тутамд нэмэгдсэн байдлаар тооцоолсон ба энэ нь эхний 10 сарын гүйцэтгэл дээр үндэслэн гаргасан болно. Мөн 2018, 2019 онуудад зээлийн дундаж хэмжээ өмнөх оноосоо инфляцийн дагуу өснө гэж тооцоолсон нь компанийн баримталж буй зээлийн бодлоготой уялдаж байгаа болно. Зээлийн дундаж хэмжээ 2017 онд 177 мянган төгрөг байсан бол цаашид тогтвортой өсч 2022 онд 680 мянган төгрөг болохоор байгаа нь компанийн урамшууллын оноотой уялдан хэрэглэгч тус бүрт олгох зээлийн дээд хэмжээ өсч байгааг илэрхийлнэ.

5. ЛэндМН–ийн одоо байгаа бүтээгдэхүүн нь богино хугацааны зээлийн бүтээгдэхүүн тул нийт гаргасан зээлийн хэмжээ нь зээлийн үлдэгдэлтэй харьцуулахад өндөр харагддаг онцлогтой. ЛэндМН-ийн зээлийн хугацаа нь 7-30 хүртэлх хоног бөгөөд дундаж хугацаа нь 26 өдөр байдаг тул зээлийн эргэлт буюу хөрөнгийн эргэлт маш түргэн ба жилийн(365 хоног) эргэц 14 удаа байна. Өөрөөр хэлбэл Финтекийн технологийн шийдлийг ашиглаж буй бизнес загварын онцлог буюу хөрөнгийн эргэц харьцангуй өндөр байдаг нь нийт олгосон зээлийн дүнг нэмэгдүүлж байдаг. Иймд уламжлалт зээлийн үйл ажиллагаатай харьцангуйгаар нийт олгосон зээлийн дүн нийт зээлийн үлдэгдлээс олон дахин илүү байх онцлогтой юм.
6. Тус бизнес загварын онцлог нь "богино хугацаатай"(дундаж хугацаа 26 хоног) зээл олгогдож байгаа бөгөөд өмнөх 11 сарын туршид олгогдсон зээлийн 99% нь төлөгдсөн байна. Иймд зээлийн үлдэгдэл нь ерөнхийдөө тухайн тайлант жилийн зөвхөн сүүлийн сард олгогдсон зээлээс эргэн төлөгдөж амжаагүй байгаа зээлийн үлдэгдлийг илэрхийлж байгааг анхаарах нь зүйтэй.
7. Компанийн бизнес төлөвлөгөө, суурь таамаглалууд дээр үндэслэсэн нийт зээлийн шимтгэлийн орлогыг харуулж байна. ЛэндМН-ийн зээлийн бүтээгдэхүүний онцлог нь тухайн харилцагч авсан зээлээ хугацаандаа эргэн төлөх болгонд урамшууллын оноо олгож тухайн харилцагчийн зээлийн шимтгэлийн түвшинг 10 үе шаттайгаар бууруулдаг тул нэг харилцагчийн зээлийн шимтгэлийн орлого нь тогтмол буурч байдаг ба шинэ харилцагч бүртгүүлснээс хойш дунджаар 12 сарын дараа шимтгэлийн хамгийн доод түвшиндээ хүрч байгаа. Хүү болон шимтгэлийн нийт орлогын өсөлт нь нийт харилцагчийн тооны өсөлт болон зээлийн хэмжээний өсөлттэй шууд хамааралтайгаар өсөж байгаа болно. Бичил хэрэглээний зээлийн зах зээлийн хандлагыг нас, орлогын түвшнээр авч үзэхэд 2017.11.30-ны байдлаар ойролцоогоор 331,981 иргэн байна гэсэн таамаглал дэвшигдсэнийг зах зээлийн судалгаа хэсэгт үзүүлсэн болно.

   Түүнчилэн бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамжийн тооцооллоор авч үзэхэд тус бизнес 2021-2022 онуудад тогтворжих үедээ шилжих хандлагатай байна.

   Өнөөгийн байдлаар финтекийн хувьд бусад улсаас түрүүнд буюу зах зээлийн тогтворжилтын үе дээрээ байгаа Хятад улсын жишээн дээр

хийсэн судалгаанаас харахад 2017-2020 он хүртэл жилд дунджаар 7.5% өсч, хүн амын 13%-16%[5] финтекийн үйлчилгээнд хамрагдахаар байна.

Энэ нь өнөөдөр авч ашиглаж болохуйц хамгийн боломжит таамаглал хэмээн авч үзэхэд манай улсын хувьд бизнесийн мөчлөгийн тогтворжилтынхоо үед ойролцоогоор 400-500 мянган иргэнийг хамрах төлөвтэй байна.[6]

8. Компани 2018-2022 онуудад зах зээл дээрх нийт боломжит хэрэглэгчдийн 17%-23%-д хүрч үйлчилгээгээ үзүүлэхээр зорин ажиллаж байна.
ЛэндМН–ийн Финтек технологийн шийдэл нь зах зээл дээр "Шинэ зах зээл"ийг бий болгож, түргэн шуурхай хялбар зээлийн үйлчилгээг санал болгож байгаа тул зээлийн давтамж, эргэн төлөлтийн хурд, хөрөнгийн эргэц зэргийг уламжлалт зээлийн бүтээгдэхүүнтэй харьцуулах боломжгүй юм. Өөрөөр хэлбэл бидний зах зээлийн судалгаагаар авч үзсэн 600 тэрбум төгрөг–1.3 их наяд төгрөг зах зээлийн багтаамж нь ойролцоогоор нэг харилцагч сард нэг удаа хэрэглээний бичил зээл авахад гарч болох боломжит дүн билээ.

Иймд бид нийт зорилтот зах зээлийн багтаамжаас зах зээлд эзлэх хувийг тооцох нь зохистой юм.

Дээрхи таамаглал дээр үндэслэсэн нийт идэвхитэй хэрэглэгчдийн тоон өсөлтийг дараах байдлаар харуулав.




График1. Идэвхитэй хэрэглэгчдийн өсөлт

[5]Меритэ Стратеги ҮЦК-ний судалгааны хурээлэн, 2017
[6]Ситибанкны "Финтек бүтээгдэхүүний эрин үеийн судалгаа"-гаар 2017 - 2023 оны хооронд буюу ирэх 6 жилийн хугацаанд Хойд Америкийн банкны хэрэглээний зээлийн 17%-ийг(өдгөө 1.1%) финтекийн зах зээл бүрдүүлнэ хэмээн үзсэн нь тус статистикийг дэмжиж байна.

Орлогын тайлангийн таамаглалд:

| ОРЛОГЫН ТАЙЛАН(Сая төгрөг) | 2017[1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Хүү ба түүнтэй адилтгах орлого | 1,005.0 | 7,925.6 | 11,746.7 | 16,724.7 | 21,279.9 | 27,257.8 |
| Хүүгийн зардал | (41.3) | (746.7) | (2,420.0) | (4,013.3) | (5,370.0) | (6,330.9) |
| Зээлийн эрсдлийн сангийн зардал | (78.2) | (284.4) | (480.2) | (438.8) | (778.3) | (971.0) |
| | | | | | | |
| **Цэвэр хүүгийн орлого** | **885.6** | **6,894.6** | **8,846.5** | **12,272.5** | **15,131.6** | **19,955.9** |
| | | | | | | |
| Цалин | (268.3) | (559.9) | (648.1) | (767.6) | (981.1) | (1,202.2) |
| Бусад зардал | (460.4) | (907.7) | (819.4) | (958.0) | (1,056.1) | (1,170.3) |
| Системийн засвар үйлчилгээний зардал | (90.2) | (702.3) | (1,005.1) | (1,087.9) | (1,002.6) | (1,101.3) |
| | | | | | | |
| **Нийт үндсэн үйл ажиллагааны зардал** | **(818.9)** | **(2,170.0)** | **(2,472.6)** | **(2,813.5)** | **(3,039.9)** | **(3,473.8)** |
| | | | | | | |
| **Татварын өмнөх ашиг** | **66.7** | **4,724.6** | **6,374.0** | **9,459.0** | **12,091.6** | **16,482.1** |
| | | | | | | |
| Татвар | (6.7) | (731.1) | (1,143.5) | (1,914.7) | (2,572.9) | (3,670.5) |
| | | | | | | |
| **Цэвэр ашиг** | **60.0** | **3,993.4** | **5,230.5** | **7,544.2** | **9,518.8** | **12,811.5** |

[1] Хугацаагаар бүтээгдэхүүн

Хүснэгт17: Орлогын тайлангийн таамаглал

## Зардлууд

1. Эх үүсвэрийн зардал: Ирэх 5 жилийн дотор компанийн хэрэглэгчдийн өсөлтийг гүйцэхийн тулд компани зах зээлийн өрсөлдөхүйц өртгөөр зээлжих чадвартай байх хэрэгтэй. Иймээс орлогын тайлангийн таамаглалд ирээдүйн хүүгийн зардлуудыг шинээр авсан зээлийн 16% байхаар тооцоолов. Хэдийгээр зах зээлийн хүү урт хугацаанд буурах магадлал их хэдий ч ийнхүү тогтмол тооцоолсон нь ирээдүйн санхүүгийн өгөөжийг болгоомжтой таамаглах зарчимтай нийцсэн гэж үзэв.
2. Эрсдлийн сан: ЛэндМН ББСБ ХХК нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс 10 сарын дараа буюу 2017 оны 10-р сарын эцсээр компанийн нийт хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ тухайн сарын сүүлээр бүртгэгдсэн нийт зээлийн үлдэгдлийн 0.51% байв, харин зээлийн эрсдэлийн санг 2022 он хүртэл 0.94%-2.24% байхаар тооцож байгуулав. Энэхүү тооцоолол өнөөгийн байдлаар LendMN аппликейшнийг суурилуулсан 60 мянган хэрэглэгчээс ердөө 20 мянга нь зээлжих эрх авсан, мөн компанийн урамшууллын онооны тогтолцоо нь зээлдэгчдийн эргэн төлөлтөд эерэг нөлөөтэй байх боловч цаашид муу зээлийн хэмжээ 2-4 дахин нэмэгдэнэ хэмээн таамаглав.
3. Цалингийн зардал: Компанийн засаглалын бүтцэд суурилж албан тушаал тус бүрээр тооцсон болно. Технологийн дэвшилд суурилсан бизнес загвар тул ирэх жилүүдэд өнөөгийн ажиллагсдын тоонд төдийлөн их өөрчлөлт гарахааргүй бөгөөд зөвхөн нийт хэрэглэгчдээс хамааран хувьсах ажлын байрууд нэмэгдэх хандлагатай. Тухайлбал өр барагдуулах газарт 2022 оныг хүртэл дуудлагын төвд шинээр 18 ажлын байр бий болно хэмээн тооцоолсон бол өр барагдуулах газарт 22 шинэ ажлын байр үүснэ хэмээн таамаглав. Нийт цалингийн зардлыг 2022 он хүртэл жилд 13-20% өсөхөөр тооцоолсон нь Монгол Банкны онилж буй 8% инфляцаас өндөр байхаар байна. Цалингийн зардалд мөн Нийгмийн Даатгалын Шимтгэлийн зардлуудыг оруулан тооцов.
4. Бусад зардал: Элэгдэл ба удирдлагын зардлуудыг багцалж тооцсон. Элэгдлийн зардал нь компанийн үндсэн хөрөнгө болох авто машин ба

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA ҮЦК LLC
20181119
LENDMN

бусад оффисын хэрэгслүүдийн зардлыг нягтлан бодох бүртгэлийн зарчмаар элэгдэл тооцож таамагласан ба ирээдүйд хийгдэх оффисын засвар үйлчилгээ болон сургалтын танхимын элэгдлийг энэхүү хэсэгт тооцов. Харин удирдлагын зардалд төрийн зохицуулагч байгууллагуудтай холбоотой шимтгэл, аудит, маркетинг, харилцаа холбоо, програм хангамж гэх мэт компанийн удирдлагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах зардлуудыг өнөөгийн бодит зардалд тулгуурлан ирээдүйд жилийн 6% өсөлттэй байхаар тооцоолж оруулав.

5. Системийн засвар үйлчилгээний зардал: ЛэндМН ББСБ ХХК нь өөрийн харилцан хамааралтай этгээд болох Анд Системс Тех ХХК-тай 50 жилийн хугацаанд буюу 2067 оны 7-р сар хүртэл Монгол улсын нутаг дэвсгэрт LendMN аппликейшнийг онцгой эрхтэйгээр ашиглах зардал болно. Энэхүү зардал нь нэгж гүйлгээнд суурилсан хувьсах зардал хэдий ч нэгжийн зардал 2022 он хүртэл 40% буурах гэрээний дагуу тооцоолов. Ингэснээр 2017 онд нийт борлуулалтын орлогын 9% тэнцэхээр тооцоолсон системийн засвар үйлчилгээний зардал 2022 он хүртэл аажим буурч нийт борлуулалтын орлогын 4%-д хүрэхээр байна.

## 2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### 2.2.1 Бичил хэрэглээний зээлийн өнөөгийн байдал

#### 1. Зээлийн эрэлт нийлүүлэлт ба ББСБ-ын өнөөгийн байдал

2013 оноос хойш Монгол улсын голлох экспортын бүтээгдэхүүн болох түүхий эдийн үнийн уналт, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, эдийн засаг саармагжиж эхэлснээр нийт зээлийн өсөлт буурч эхэлсэн боловч ББСБ-уудын хувьд өндөр өсөлттэй он жилүүд болсон.

**ДНБ, нийт зээлийн өсөлт, нийт хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь**




График 2. Эх сурвалж: Монголбанк, 2017

**ББСБ-ын салбарын хэмжээнд нийт олгосон зээлийн хэмжээ, нийт активын хэмжээ**




График 3. Эх сурвалж: Монголбанк, 2017

20180119

2008 - 2016 оны хооронд Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос гаргасан мэдээллээр банк бус санхүүгийн салбарын нийт активийн хэмжээ 78.53 тэрбум төгрөгөөс 787.17 тэрбум төгрөгт хүрч тэлсэн буюу энэ салбарын өсөлт (2-р граф) **902.4%-д** хүрсэн үзүүлэлт гаргасан байна. Энэ нь Монголын санхүүгийн зах зээлийн хамгийн огцом болон хурдацтай өсөлтийн нэгд орно.

**Банк болон ББСБ-ын салбарын нийт актив, олгосон зээлийн өсөлт**




График 4. Эх сурвалж: Монголбанк, 2017

ББСБ-ын салбарын активийн хэмжээ болон зээл олголтын өсөлтийн хэмжээ 2008-2016 оны хооронд жилд дунджаар **34%**-тай байжээ (2-р хүснэгт). Энэ нь банкны салбарын нийт активын дундаж өсөлт буюу **19.6%**-тай харьцуулахад 67% ахиу үзүүлэлт юм. Банкны салбарын өсөлт 2014 болон 2016 онуудад нэг оронтой тоо руу (8%) орж, 2015 онд хасах (-5%) үзүүлэлт рүү орсон бол ББСБ-ын хувьд хэдий өсөлтийн хувь буурсан ч нийт актив дунджаар 19%-32% өссөн байна.

ББСБ-ын салбараас нийт олгосон зээлийн хэмжээ 2008 - 2016 он буюу 12 жилийн хугацаанд 46 тэрбумаас 478 тэрбум болтлоо өссөн бөгөөд 939%-д хүрсэн байна. Энэ хугацаанд нийт ББСБ-ын тоо 131-ээс 518 болтлоо нэмэгджээ.

Монгол улсын хэмжээнд 2017 оны 3-р улирлын байдлаар нийт 535 ББСБ 1.4 сая харилцагчид 10 төрлийн санхүүгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгээр үзүүлж байгаагаас зээлийн үйлчилгээ эрхэлдэг ББСБ-ын тоо 465 хүрсэн байна. Мөн 2017 оны 2-р улирлын байдлаар ББСБ-ын нийт үйл ажиллагааны орлогын 73.7% нь хүүгийн орлого, санхүүгийн үйлчилгээний орлого 4.8%, үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого 2.6%, гадаад валютын арилжаа 2.2%, мөнгөн гуйвуулга 0.34% эзэлж байна.

**Монгол улсын хэмжээнд 2017 оны 3-р улирлын байдлаар нийт 535 ББСБ 1.4 сая харилцагчид 10 төрлийн санхүүгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгээр үзүүлж байгаагаас зээлийн үйлчилгээ эрхэлдэг ББСБ-ын тоо 465 байна.**

20180119

БҮРТГЭВ
№ 01

## 2. ББСБ-ын зээлдэгчийн үзүүлэлт

ҮСХ-оос гаргасан мэдээллээс үзвэл ББСБ-ын тоо болон зээлдэгчийн тоо 2012 оноос хойш тасралтгүй өсч ирсэн ба 2017 оны III улирлын байдлаар зээлийн үлдэгдэл 554,9 тэрбум төгрөг, нийт харицлагчийн тоо 1 сая 392 мянга буюу нэг зээлдэгчид ногдох зээлийн үлдэгдлийн дундаж хэмжээ 396 мянган төгрөг байна.

**ББСБ- ын нэг хүнд ногдох дундаж зээлийн үлдэгдэл**




График5. Эх сурвалж: ҮСХ, 2017

Харилцагчийн тоо огцом өссөн нь СЗХ-ноос "Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам" баталж, боловсронгуй болгож ирсэнтэй холбоотой бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хороо(ХХЗХ)-ноос авсан мэдээллээр үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 3.7 сая, үүнээс ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 2.4 сая, дата хэрэглэгчдийн тоо 2.4 сая гэж мэдээлсэн нь цаашид манай улсад технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу финтекийг нэвтрүүлэх таатай орчин бүрдсэнийг харуулж байна.

**ББСБ-ын зээлдэгчдийн тоо болон насны бүтэц**




График 6. Эх сурвалж: СЗХ, 2017

СЗХ-ноос энэ оны II улиралд гаргасан статистик тоо баримтаас үзвэл насны ангиллын хувьд ББСБ-ын харилцагчийн 40.1% нь 18-35 насныхан, 35.5% нь 36-45 насныхан зээлж, 18-45 насны залуучууд ББСБ-аас зээл авах хандлага өндөр байна. Зээлдэгчдийн 45% буюу 603,744 эрэгтэй, 55% буюу 749,399 эмэгтэй байгаа нь манай улсын эмэгтэйчүүдийн санхүүгийн оролцоо харьцангуй өндөр байгааг харуулж байна. Нөгөөтэйгүүр гэр бүлийн ахуйн хэрэгцээг шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн үүрэг илүү байгааг харуулсан гэж үзэж болох юм.

**Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо 3.7 сая, үүнээс ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 2.4 сая, дата хэрэглэгчдийн тоо 2.4 сая гэж мэдээлсэн нь цаашид манай улсад технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу финтекийг нэвтрүүлэх таатай орчин бүрдсэнийг харуулж байна.**

LENDMN

### 3. Хөдөлгөөнт банкны хэрэглээ

2017 оны II улирлын байдлаар ББСБ-аас 314.3 тэрбум төгрөгийн зээл шинээр олгосноос 45.5% буюу 142.9 тэрбум төгрөг нь хэрэглээний зээл байна. Нийт олгосон зээлийн эргэн төлөлтөнд эзлэх хувиар нь харахад хэрэглээний зээлийн эзлэх хэмжээ 106.1 тэрбум төгрөг буюу 44.8% байна. Эндээс харахад ББСБ-ын олгосон зээлийн дийлэнхи хувийг хэрэглээний зээл зээлдэг ба эргэн төлөлтийн хувь хэмжээ бусад салбаруудаас илүү байдгийг харж болохоор байна.

**2017. I улиралд иргэдэд олгосон банкны зээлэнд эзлэх хэрэглээний зээл**




Арилжааны банкнаас энэ оны эхний улиралд иргэдэд олгосон зээлийн 56.6% буюу 3.75 их наядыг цалин, картын зээл, хадгаламж барьцаалсан зээл зээлж байна. Үүнээс банкуудын картын зээлийн үлдэгдэл эхний улирлын байдлаар 179.9 тэрбум төгрөг, II улирлын байдлаар 187.3 тэрбум төгрөг байна.

График 7. Эх сурвалж: Монголбанк, 2017

Банкуудын картын зээлийн үлдэгдэл 2012 оноос 2014 он хүртэл өсч эхэлсэн нь макро эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарсан зээлийн картын эрэлт өссөнтэй холбоотойгоор тайлбарлагдаж байна. Картын зээлийн хэмжээ 2015 оноос буурч тогтворжиж эхэлсэн нь орлуулах бүтээгдэхүүн болох интернэт болон мобайл банкны хэрэглэгчдийн тоо мөн энэ үеэс огцом өссөнтэй хамааралтай харагдаж байна.

**Интернэт болон мобайл банкны идэвхитэй хэрэглэгчдийн тоо**

Нэгж:мян.хүн

| Үзүүлэлт | 2015.II | 2016.II | 2017.II | Өсөлт 2Q17/ 2Q16 | |
|---|---|---|---|---|---|
| Картын тоо | 3,757 | 3,846 | 3,866 | 20 | 0.5% |
| Идэвхитэй ашиглаж буй картын тоо | 1,835 | 1,369 | 1,592 | 223 | 13% |
| Интернэт банкны хэрэглэгч | 774 | 958 | 1,171 | 213 | 18% |
| Мобайл банкны идэвхитэй хэрэглэгч | 451 | 1,160 | 1,497 | 337 | 22% |

*Эх сурвалж: Playstore*

Хүснэгт18. Интернэт болон мобайл банк хэрэглэгчдийн тоо

2018 01 19

Төлбөрийн карт, интернэт банк, мобайл банкны хэрэглэгчдийн тоон мэдээллээс харахад 2015 онд төлбөрийн карт ашиглаж буй идэвхитэй хэрэглэгчийн тоо 1.8 сая байсан бол 2016 онд энэ тоо 25%-иар буурсан байна. Харин энэ хугацаанд интернэт банкны хэрэглэгч 184 мянгаар, мобайл банкны идэвхтэй хэрэглэгчийн тоо 708 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

2016 онд арилжааны банкууд зээлийн картын үйлчилгээг төрөлжүүлж, хадгаламж барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн зах зээлд гаргаж ирснээр төлбөрийн карт идэвхитэй хэрэглэгчдийн тоо 2017 оны II улирлын байдлаар өмнөх оноос 13% өссөн байна.

**2015 оноос банкууд интернэт банк, мобайл банкны үйлчилгээ нэвтрүүлснээр хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээг цахимаар хэрэглэж эхэлсэн ба 2017 оны 2-р улирлын байдлаар мобайл банкны идэвхитэй хэрэглэгчдийн тоо 1.5 саяд хүрэв.**

### 4. Бичил хэрэглээний зээлийн салбарын оролцогчид

Мөнгөний хэрэгцээ гарахад ямар их цаг зарцуулж, эрсдэл үүрдгийг доор жишин харуулъя.

| | LENDMN | Зээлийн карт | Хоногоор зээлдүүлэгч | Барьцаалан зээлдүүлэгч | Найз, гэр бүл |
|---|---|---|---|---|---|
| **Харилцагч болох** | 5-8 минут | 30 минут | 1 цагаас 1 өдөр | 30 минут | Утсаар ярих |
| **Зээлийн хэмжээ (төгрөг)** | 50,000-1,000,000 | 100,000-5,000,000 | 50,000-20,000,000 | 50,000-2,000,000 | 5000-500,000 |
| **Барьцаа** | Барьцаагүй | Хадгаламж, орлого | Лангуу, эд бараа(өөрийгөө том эрсдэлд оруулна) | Үнэт эдлэл, электрон бараа | Нэр хүнд |
| **Үнэ (төгрөг)** | Хиймэл оюун ухаан шийддэг. 900-32,000 | Хүү 3% Шимтгэл 35,000-45,000 | 10-30% Өдөр бүр зээлийн дүнгээс ээ эргүүлэн төлдөг | Хүү 5-7% Шимтгэл 100-2000 | 0-10% Зарим танилууд тодорхо хүүт эйгээр зээлдүүлдэг |
| **Зээлийн бодлого (Урамшуулал)** | Хугацаандаа төлсөн зээлдэгчийг урамшуулдаг. | Байхгүй | Байхгүй | Байхгүй | Байхгүй |
| **Зээлийн шийдвэр** | 1-3 минут | Картаа автал 7 хоног, зээл авахад 1-3 хоног | Таны барьцаа хөрөнгөөс хамаарна | 30 минут | Тодорхойлох боломжгүй |
| **Зээл авах шат дамжлага** | Хамгийн ойр гэрээ байгуулах цэгт очиж гэрээ байгуулж 30 минут болно. (зөвхөн ганц удаа) | Дараалалд зогсох, бичиг баримт бүрдүүлэх, салбар дээр очих 1-3 цаг (зээл авах бүрт) | Тодорхойлох боломжгүй | Үнэлгээ хийх, дараалалд зогсох, барьцаалулах 30 минутаас 2 цаг (зээл авах бүрт) | Утсаар ярина, гэрт нь очино, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Алдагдсан боломжийн ӨРТӨГ /таамаглал/ | 1 удаа | 5680 | 11,360 | | 17,070 | 22,720 |
| | Давтамж | 1 удаа | Зээл авах бүрт | | | |
| | | Нэг удаа гэрээ байгуулна. 30 минут зарцуулна гэвэл 5680 төгрөгийн алдагдсан боломжийн зардал гарна. | Ойр банкны салбар болон АТМ хайх дараалалд зогсох, зээл авах бүртгээ АТМ/салбараар үйлчлүүлэх Зээл авах бүрт 1-2 цаг зарцуулна. | Хурдан байх боломжтой боловч өртөг өндөр тул сайн тооцоолоогүй тохиолдолд эргэн төлөлтийн эрсдэлд орох боломжтой | ББСБ/ барьцаалан зээл дүүлэх газар очих, Барьцаа бэлдэх, дараалалд зогсох гэвэл 2-3 цагийг зарцуулна гэвэл зээл авах бүр 17,040 төгрөгийн өртөгтэй | Утсаар ярих, очиж авах гэх мэт зээлэх бүрт 1 -4 цаг зарцуулах боломжтой. Алдагдсан боломжийн өртөг нь 22,720 төгрөг. |

Хүснэгт19. Бичил хэрэглээний зээлийн салбарын оролцогчид

*Дээрх алдагдсан боломжийн өртгийг 1 сая төгрөгийн цалинтай мэргэжилтнээр жишин авав.*

Бид зээл авахын тулд шимтгэл болон хүүгийн төлбөрөөс гадна тухайн зээл авах үед зарцуулсан цаг хугацаанд алдагдсан боломжийг тооцож үздэг байх шаардлагатай.

Жишээ нь найз нөхөд гэр бүлээсээ мөнгө зээлэх бол утсаар ярьж дансны дугаараа өгнө, эсвэл гэр, ажил дээр нь очих шаардлага гарна. Хамгийн багадаа 1 цагаас 1 бүтэн өдөр ч зарцуулагдах үе байдаг. Харин зээлийн картын хувьд төлбөр тооцоо хийхэд түргэн боловч, бэлэн мөнгөний хэрэгцээ гарсан үед заавал БЭЛЭН МӨНГӨНИЙ МАШИН олж очин, авсан бэлэн мөнгөний 3%-тай тэнцэх хэмжээний шимтгэл төлөх төдийгүй жил бүр 35,000-45,000 төгрөгийн хураамж төлөх шаардлагатай байдаг. ББСБ болон барьцаалан зээлдүүлэх газрын хувьд нөхцөл байдлаас хамаарч тээврийн зардал, барьцаалах эд зүйлээ бэлдэх, дараалалд зогсох зэрэг хугацаагаар хэмжигдэх зардлууд үүсч болно. Хэрэв та дунджаар 1 сая төгрөгийн цалинтай бөгөөд энэ зарцуулсан хугацаанд ажил хийж байсан бол хэр хэмжээний алдагдсан боломж гарч болохыг дээр тодорхойлохыг хичээлээ.

Зээлийн үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллагууд зээлийн шимтгэлээс гадна тухайн зээлийн төрлөөс хамаарч хүү тооцдог бол ЛэндМН нь тус аппликейшнийг ашиглан зээл авсны төлөө урамшууллалтай шимтгэлийн тогтолцоог хэрэгжүүлж байна.

**ЛэндМН үүсгэн байгуулагдаад 1 жилийн хугацаанд түргэн шуурхай барьцаагүй зээлийн үйлчилгээгээрээ 18,998 иргэний 56,994 цаг буюу 6,5 жил, 329 сая төгрөгийн алдагдсан боломжийн өртгийг хэмнэсэн байна.**

### 5. Өрсөлдөгчийн судалгаа

Үүрэн холбооны компаниуд өөрийн дэд бүтэц дээр суурилан Финтек хослуулсан үйлчилгээг нэвтрүүлэн өрсөлдөх боломжтой. Монгол улсын гурван том үүрэн холбооны оператор компанийн нэг болох Мобиком корпорацийн зүгээс өөрийн CANDY цахим урамшууллын бүтээгдэхүүнтэй холбосон мессэж зээлийн үйлчилгээг танилцуулж эхлээд байна. Тус үйлчилгээг "Мобифинанс ББСБ" ХХК үзүүлж байна. Санхүүгийн Зохицуулах Хорооны "Цахим төлбөр тооцоо гүйцэтгэх" зөвшөөрлийн хүрээнд гар утсан дээр суурилсан төлбөр тооцоог онлайн горимд баталгаатай гүйцэтгэх боломж бүхий MobiXpress үйлчилгээг зах зээлд нэвтрүүлээд эдүгээ Улаанбаатар хот болон 21 аймгийн төв, 214 сум суурин газруудад нэвтрүүлж, **212'000** харилцагч, 1600 гэрээт хамтрагч, 600 гаруй төлөөлөгчийн эко системийг бүрдүүлж, цахим мөнгөний үндэсний сүлжээг байгуулаад байна.

| Үйлчилгээний харьцуулалт | ЛэндМН | Мобифинанс |
|---|---|---|
| **Бүтээгдэхүүн** | 50,000-1,000,000 төгрөг | 10,000-500,000 төгрөг |
| **Хүү+хураамж** | Зээлийн дүн, хугацаа, урамшууллын оноо, харилцагчийн төвшингөөс хамаарна. | Зээлийн дүнгээс хамаарч сарын 2.9-5% хүүтэй |
| **Хэрэглэгч болох** | Аппликейшинд бүртгүүлж, өөрт ойр гэрээ байгуулах цэг дээр очиж гэрээ байгуулна. | Мессежээр 555-д ZEEL гэж бичиж эрхээ нээлгээд Мобикомын аль нэг салбарт иргэний үнэмлэхтэйгээ очиж гэрээ байгуулна. |
| **Зээл олгох явц** | Зээлийн нөхцөл хангасан хэрэглэгчдийн дансанд шууд шилжүүлнэ. | Зээл авахын өмнөх өдөр нь мессежээр зээлийн хүсэлтээ явуулна.<br>CANDY дансыг зээлийн дүнгээр цэнэглэнэ.<br>Дараа өдөр нь өөрийн биеэр салбар дээр очиж CANDY-гээ бэлэн мөнгө болгож авна. |
| **Зээлийн нөхцөл** | Аль ч банк, үүрэн холбооны компанийн хэрэглэгч байж болно. | - Зөвхөн мобикомын хэрэглэгч байх<br>- Сүүлийн 11 сарын хугацаанд өөрийн нэр дээр идэвхитэй ашигласан байх<br>- Мобикомд төлбөрийн өглөггүй байх<br>- Хэрэглээ хязгаарлах үйлчилгээ аваагүй байх |
| **Хугацаандаа зээл төлөөгүй тохиолдолд** | Зээлийн мэдээллийн санд зээлийн ангилал буурна. | Зээлийн мэдээллийн санд зээлийн ангилал буурна.<br>Утасны гарах ярианы эрхийг хаана./Зээл, Зээлийн эрх нээх гэрээ/ |
| **Давуу тал** | -Түргэн шуурхай, заавал салбар дээр очих | - CANDY бүтээгдэхүүнтэй нийлэмж үүсгэсэн, толгой |

| | | |
|---|---|---|
| | шаардлагагүй. 24/7 үйлчилгээ.<br>Хиймэл оюун ухаанаар зээлийн үнэлгээг хийдэг учир чанаргүй зээлийн хувь бага, зээлийн хязгаар дотроо хэдэн ч удаа зээл авч болно.<br>-Барьцаагүй | компанийн олон хэрэглэгчийн дотоод мэдээлэл дээр тулгуурлан зээл олгодог.<br>- Барьцаагүй |
| **Сул тал** | -Нэг удаа заавал биеэр очиж гэрээ байгуулна | - Өөр үүрэн холбооны хэрэглэгч зээл авах боломжгүй.<br>- Өөрийн биеэр очих<br>- Ажлын цагийг тааруулах |
| **Баримталж буй стратеги** | - Хандсан хүн бүрт зээл олгодоггүй буюу санхүүгийн сахилга баттай иргэдэд олгох стратеги барьж байгаа нь чанаргүй зээлдэгчийн тоог бууруулах давуу тал болж байна. | - CANDY бүтээгдэхүүнтэй хавсарсан байдлаар нэвтрүүлж байгаа. |
| **Өөрийн биеэр очих эсэх** | 1 удаа өөрийн биеэр очиж гэрээ очиж гэрээ байгуулна | Зээл авах бүрт өөрийн биеэр очно. |

*Эх сурвалж: Мобифинанс танилцуулга материал*

Хүснэгт20. Үйлчилгээний харьцуулалт

**Финтекийн салбарт олон байгууллагууд өөрийн давуу талыг ашиглан өрсөлдөх боломжтой боловч ЛэндМН-ийн адил автомат, хиймэл оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн гаргахад багагүй хугацаа шаардагдана.**

## 2.2.2 "ЗЭЭЛ"-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭ ЭРИН ҮЕ ТАНД ОЙРТСООР

### 1. Дэлхийн улс орнуудад гарч ирж буй бичил зээл олголтын шинэ арга, хэрэгсэл

Дэлхий даяар финтек компаниуд уламжлалт банк санхүүгийн салбарын зах зээл рүү түрэмгий орж ирж байгаагийн улмаас банк санхүүгийн байгууллагууд уламжлалт бизнесээ шинэчлэх, дижитал болгох талаар томоохон сорилтуудтай тулгараад байна.

**Хиймэл оюун ухааныг (AI) ашиглаж буй салбараар ангилбал мэдээлэл технологийн салбарыг санхүүгийн салбар удаалж байна.**




Эх сурвалж: www.consultancy.uk

График8. Хиймэл оюун ухаан ашиглаж буй салбарууд

J.P. Morgan банкны гүйцэтгэх захирал Жэйми Даймон Цахиурын хөндийн тухай өгүүлэхдээ: "Зуу зуун шилдэг оюун ухаанууд мөн их хэмжээний хөрөнгө оруулалт тэнд нийлэн уламжлалт банк санхүүгийн салбарыг орлохоор шамдан ажиллацгааж байна." гэжээ. Судалгаанаас үзвэл 2010- 2015 оны хооронд хувийн хэвшлээс финтек компаниудад оруулсан хөрөнгө оруулалт 10 дахин өссөн байна.

**Дэлхийн хэмжээнд финтекийн салбарт хувийн хэвшлээс оруулсан хөрөнгө оруулалт**




График9. Эх сурвалж: Ситибанк, СБ Инсайтс,2016

Түүнчлэн Сити Банкнаас гаргасан Дижитал Технологийн Сорилт [7] тайланд Хятадад уламжлалт банкууд хэдийнэ зах зээлээ алдаад эхэлсэн бөгөөд Энэтхэг улс араас нь явж байна гэжээ. Иймэрхүү дэлхийн олон оронд бичил зээлийн үйлчилгээг гар утас, интернэтээр дамжуулан олгож хүний цаг, мөнгийг хэмнэсээр байна. АНУ, БНХАУ, Япон, БНСУ(Какаобанк), Энэтхэгт Кэши(Cashe) зэрэг финтекийн хөгжлийг санхүүгийн олон төрлийн үйлчилгээнд амжилттай нэвтрүүлсэн жишээг дурдаж болно.

[7] (Digital Disruption: How FinTech is Forcing Banking to a Tipping Point) (2016)

Бид энэ дундаас Хятадын иргэдийн амьдралын салшгүй хэсэг болоод байгаа Али Пэй болон 2017 оны шилдэг инновацлаг финтек компанийн нэг Германы Кредитек компанийг жишээ болгон танилцуулж байна.

**Алипэй: “Нүүрээ”- таниулан төлбөр хийх боломж**

Alipay™ Алипэй нь энэ оны 9 сарын байдлаар (Блүүмберг , 2017) дэлхий даяар нийт 520 орчим сая хэрэглэгчидтэй болоод байна. Тус төлбөрийн систем нь БНХАУ-с гадна Зүүн Өмнөд Ази болон Европын улс орнууд төдийгүй АНУ-д олон хэрэглэгчидтэй болсоор байна. Баруун Европын улс орнуудад Алипэй-ийн гол өрсөлдөгч нь Аппл Пэй болон Гүүгл Пэй ба одоогоор эдгээр хөгжингүй зах зээлд хятад жуулчид ихээхэн зорчдог худалдааны газруудтай хамтрахаар эрмэлзэж байна.

Али Пэй компани нь Зүүн Өмнөд Азид болон Хятад улсад “Залуус”-ыг зорилтот зах зээлээрээ тодорхойлж байна. Залуу үеийнхний төлбөр гүйцэтгэх үйл явцыг хялбарчлан зах зээлээ өргөтгөх олон аргуудыг хэрэгжүүлэн нэвтрүүлж байгаагийн нэг нь 'smile and pay' буюу нүүр царай танин төлбөр хийх үйлчилгээ юм. Тус "нүүрээр таних" үйлчилгээг Ханжоу хотын КФС цэгүүдэд саяхан нэвтрүүлсэн бөгөөд тухайн үйлчлүүлэгч смарт утастай байх албагүй зөвхөн Али Пэй-д бүртгүүлэн нүүрээ таниулсан байхад хангалттай систем юм.

Kreditech Германы Гамбург хотод байрладаг Кредитек компани нь 2017 оны хамгийн инновацлаг финтек 10 компанийн нэгээр шалгарсан бөгөөд ЛэндМН-тэй адил хэрэглэгчийн онлайн дата дээр дүн шинжилгээ хийж зээл авах боломжтой эсэхийг үнэлдэг ба зээлийн түүхгүй хүмүүст зээл авах үүд хаалга нээсэн компаниудын нэг юм.

2012 оны 2-р сарын 1-нд байгуулагдсан тус компани Орос, Мексик, Испани, Польш зэрэг санхүүгийн зах зээлд үйлчилгээ үзүүлдэг ба одоогийн байдлаар дөрвөн сая гаруй удаа зээл олгосон байна.

Олон улсын санхүүгийн төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг PayU компаниас 110 сая еврогийн хөрөнгө оруулалт амжилттай босгосон тус компани банк санхүүгийн байгууллагаас зээл авах боломжгүй иргэдэд санхүүгийн эрх чөлөөг олгох явдлыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

**Дэлхийн чиг хандлага: Та гар утастайгаа байхад Санхүүгийн бүх үйлчилгээг авах боломж ойртсоор байна.**

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTSK LLC
20180119
LENDMN

## 2. Дэлхийн чиг хандлага: Уламжлалт санхүүгийн үйлчилгээний бизнес шинэчлэлийг шаардаж байна.

Уламжлалт санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага болон финтекийг нэвтрүүлэн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг БНСУ-ын арилжааны банк, Какао цахим банкны зардлын харьцуулалтаас үзвэл мэдээллийн технологийн хөгжилд суурилсан салбаргүй цахим банкны үйлчилгээ нь боловсон хүчний зардлыг 67 дахин, үйл ажиллагааны зардлыг 11 дахин бууруулсан байгааг статистик харуулж байна. Мөн салбар байгуулах, түрээсийн үйлчилгээнд зарцуулсан зардлыг 20 дахин бууруулснаар зардлын үр ашгийн харьцаа өндөр байгааг харуулж байна.

**БНСУ-ын арилжааны банк болон Какао цахим банкны зардлын харьцуулалт**




График10. Эх сурвалж: БНСУ-ын КэйБи Санхүүгийн группын судалгааны хүрээлэн

БНСУ-ын хувьд бусад Ази Номхон Далайн орнуудтай харьцуулахад харьцангуй хожуу салбаргүй цахим банкны үйлчилгээг нэвтрүүлсэн боловч маш хурдтай зах зээлээ тэлсээр байгаа нь дараах хүчин зүйлстэй холбоотой гэж КэйБи санхүүгийн группын шинжээчид дүгнэсэн байна. Үүнд:

1. Ажлын цагт баригдахгүй
2. Бага хэмжээтэй зээлийг түргэн шуурхай олгодог
3. Үйл ажиллагаанаас хэмнэсэн зардлаар шимтгэл хүүгийн уян хатан үйлчилгээ үзүүлэх
4. Банк санхүүгийн байгууллагын өндөр шалгууртай үйлчилгээний гадна үлддэг бага дунд орлоготой иргэдэд бичил зээл шуурхай олгодог

Дээр дурьдсанаас гадна цахим худалдаа эрхлэгчдэд зориулсан данс нээх үйлчилгээ, гадаад мөнгөн гүйлгээ, хамтарсан данс нээх зэрэг нэмэлт үйлчилгээ нэвтрүүлж чадсан нь БНСУ-ын иргэдийн талархлыг хүлээгээд байна.

2018 01 19

### 3. Уламжлалт болон уламжлалт бус ББСБ-ын харьцуулалт

Монгол улсын хувьд зээлийн үйлчилгээ үзүүлдэг 400 гаруй ББСБ байгаагаас интернэтээр зээлийн өргөдөл хүлээн авах, зээлийн төлбөрөө банкны дансаар шилжүүлэх, сунгах зэрэг үйлчилгээгээр финтек бүтээгдэхүүн үйлчилгээ хязгаарлагдаж байна. Мөн уламжлалт ББСБ-ын боловсон хүчний зардал өндөр хэвээр байгаа нь зээлийн хүү болон шимтгэлийн уян хатан бодлого барихад саад болж байгаа юм.

Өдөр тутмын сонинд албан ёсоор нийтлэгдсэн 2 ББСБ-ын 2016 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон ЛэндМН-ийн 2017 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан зардал, зардлын үр ашгийн харьцаа дараах байдлаар харьцуулагдаж байна.




График11. Эх сурвалж. www.ardcredit.com, Өдрийн Сонин 2017 оны 1-р улирал




График12. Эх сурвалж. www.ardcredit.com, Өдрийн Сонин 2017 оны 1-р улирал

ЛэндМН-ийн үйл ажиллагаа 2017 оны 11-р сараас жигдэрч эхэлсэн гэж үзвэл боловсон үйл ажиллагаанд эзлэх боловсон хүчний зардал бага, нийт орлоготой харьцуулсан боловсон хүчний зардал мөн бага байгааг харж болно.

**Финтек шийдлийг ашиглаж санхүүгийн үйлчилгээг хүргэснээр үйл ажиллагааны зардлыг хэмнэх замаар зээлийн өртгийг бууруулж, хөрөнгө оруулагчдын өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой**

## 2.2.4 БИЧИЛ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

### 1. ЛэндМН ББСБ-ийн хэрэглэгчдийн өнөөгийн байдал




Бичил зээлийн үндсэн хэрэглэгчид нь бага дунд орлоготой болон үүргийн худалдаа эрхлэгчид байдаг. Харин ЛэндМН-ийн хэрэглэгчдийн тоон мэдээнээс харахад Монгол улсад оршин сууж байгаа 24-35 насны, ажилтай, орлоготой, мэдээллийн технологийн мэдлэгтэй хүмүүс нийт хэрэглэгчдийн 62 хувийг (2017.11.30) эзэлж байгаа буюу хэрэглээний бичил зээлийн бүтээгдэхүүний гол хэрэглэгчид байна.

ЛэндМН ББСБ-ийн хэрэглэгчдийн дотоод мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр 24-35 насны хэрэглэгчид 60 гаруй хувийг эзэлж байгаа бол сүүлийн үед 22 хүртэл насны залуусын хэрэглээ өндөрсөж байна.

**ЛэндМН ББСБ-ийн хэрэглэгчдийн насны ангиллын судалгаан дээр үндэслэсэн тоон мэдээллээс харахад 24-35 насны иргэдийн бичил хэрэглээний зээлийн эрэлт харьцангуй өндөр байна.**

### 2. Нас, орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид

ҮСХ-ны тоон мэдээллээр Монгол улсын нийт хүн амын 19% буюу 2016 оны байдлаар **587,537** хүн насны ангиллаар 24-35 насныхан байна. Үүнээс ажил эрхэлж буй 700,000 төгрөгөөс дээш цалингийн орлоготой хүн амын тоо **331,981** болж байна. ЛэндМН-ийн хэрэглэгчдийн зээл олголтын тоон үзүүлэлтээс харахад 2017 оны 11-р сарын 30-ны байдлаар нэг хүнд олгосон сарын дундаж зээлийн хэмжээ 168,720 төгрөг байгаа бөгөөд зорилтот зах зээлд багтах хүн амын тоогоор харгалзуулан тооцоход зах зээлийн багтаамж сард дунджаар 56 тэрбум төгрөг буюу **жилийн 672 тэрбум төгрөг** байхаар байна. Энэ нь ЛэндМН-ийн нийт хэрэглэгчдийн 62%-тай дүйцэж буйг харвал (2017.11.30-ны байдлаар) нийт зах зээлийн багтаамж ойролцоогоор 1 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.




График13. Хэрэглэгчийн нас болон цалингийн ангилал

**2017.11.30-ны байдлаар нэг хүнд олгосон дундаж зээлийн хэмжээ болон ажил эрхэлж буй дунджаас дээш цалингийн орлоготой хүн амын тоо 331,981 байгаа бөгөөд, зах зээлийн багтаамж ойролцоогоор 1 их наяд төгрөг байхаар таамаглагдаж байна.**

### 3. Технологи хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгчид

ЛэндМН зорилтот зах зээл нь технологид ойр буюу гар утсыг өдөр тутмын хэрэглээгээ болгосон, санхүүгээ утаснаасаа удирдах сонирхолтой залуус гэж үзвэл бид дараах байдлаар нийт зах зээлийг тодорхойлох гэж үзье.

Монгол улсын хувьд ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо болон гар утасны дата хэрэглэгчдийн тоо тус бүр 2.4 сая байдаг. Харин тэднээс гар утас болон интернэт идэвхитэй ашигладаг хүмүүсийг тодорхойлохын тулд бид дараах уламжлалт бус аргыг хэрэглэж үзэв.

1. **210,000 Фэйсбүүк аналитик:**
   Улаанбаатар хотын эргэн тойронд 40 км зайд гар утсаар Фэйсбүүк аппликейшнд холбогдсон хүмүүсийг байршил, гэрлэлт, ажил мэргэжил, нас, бага насны хүүхэдтэй эсэх, хувиараа бичил бизнес эрхлэх байдал, манай улсын хамгийн олон хэрэглэгчтэй банкны нэг ХААН банкны хуудсанд хандсан, мөн и-баримт хуудсанд хандсан зэрэг 10 үзүүлэлтийг оруулан хайлт хийж үзэхэд 210,000 хүнд хүрэх боломжтой гэсэн тоо гарав.

2. **100,000-500,000**
   Гар утаснаас санхүүгээ удирдах сонирхолтой залуус ихэвчилэн мобайл банк, Mostmoney зэрэг аппликейшнүүдийг татаж хэрэглэдэг байх

магадлалтай гэж үзэн аппликейшн тус бүрээр нь татан авсан тоог авч үзэхэд андройд утсанд 100,000-500,000 гэсэн тоо гарч байна.

3. **500,000-1,000,000**

Орлого зарлагаа хянахыг хичээдэг, санхүүгийн сахилга баттай байх эрмэлзэлтэй хүмүүс түлхүү хэрэглэдэг аппликейшнийг тодорхойлох төвөгтэй байсан боловч өнгөрсөн жилээс хүмүүс идэвхитэй хэрэглэж буй и-баримт аппликейшнийг татан авсан хүний тоог гаргахад андройд системийн утсанд 500,000-1,000,000 татсан гэсэн тоо гарч байна.

Гар утасны аппликейшн ашиглаж санхүүгээ удирддаг, төлбөр тооцоо, гүйлгээ хийдэг байх боломжтой зах зээлийг багадаа **200,000** орчим хүн, ЛэндМН-ийн нэг хүнд олгосон дундаж зээлийн хэмжээ болох 168,720 төгрөг гэж үзвэл зорилтот зах зээлд багтах хүн амын тоогоор харгалзуулан тооцсон зах зээлийн багтаамж сард дунджаар 33.7 тэрбум төгрөг буюу **жилийн 404 тэрбум төгрөг** байхаар харагдаж байна. Энэ нь ЛэндМН-ийн нийт хэрэглэгчдийн 62%-тай дүйцэж буйг авч үзэхэд ('17.11.30) нийт зах зээлийн багтаамж ойролцоогоор **651 тэрбум төгрөг** байхаар таамаглагдаж байна. (Эх сурвалж: ЛэндМН хэрэглэгчийн судалгаа)

### Санхүүгийн аппликейшн татсан үзүүлэлт

| Нэршил | Андройд (Android) | Ай О Эс (IOS) |
|---|---|---|
| Ebarimt | 500,000-1,000,000 | 500,000-1,000,000 |
| Хаан банк | 500,000-1,000,000 | 500,000-1,000,000 |
| Худалдаа хөгжлийн банк | 100,000-500,000 | 100,000-500,000 |
| Most money | 100,000-500,000 | 100,000-500,000 |
| Төрийн банк | 100,000-500,000 | 100,000-500,000 |
| Голомт банк | 100,000-500,000 | 100,000-500,000 |
| Хас банк | 50,000-100,000 | 50,000-100,000 |

*Эх сурвалж: Playstore, Appstore*

Хүснэгт21. Санхүүгийн аппликейшн татсан тоо

## Шинэ гарсан санхүүгийн аппликейшн татсан үзүүлэлт

| Нэршил | Андройд (Android) | Ай О Эс (IOS) |
|---|---|---|
| ЛЭНДМН | 50,000-100,000 | 50,000-100,000 |
| Social Pay | 10,000-50,000 | 10,000-50,000 |
| Хувийн санхүүч | 10,000-50,000 | 10,000-50,000 |
| Төсөвчин | 5,000-10,000 | 5,000-10,000 |

*Эх сурвалж: Playstore, Appstore*

Хүснэгт22. Шинэ гарсан санхүүгийн аппликейшн татсан тоо

** Энэ тоон мэдээлэл нь гар утаснаас төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээ авах сонирхолтой хүмүүсийн давхардсан тоо юм.*

Хэрэглэгчийн нас, орлогын үзүүлэлтээр авч үзэхэд зорилтот зах зээлийн таамаглал дараах байдлаар дүрслэгдэж байна.

**Ажил эрхлэгчийн орлого, технологийн хэрэглээ** (Эх сурвалж: BPS)




Эх сурвалж: Нийгэм Эдийн засаг, амжиргааны түвшир судалгаа, 2016.06

График14. Ажил эрхлэгчийн орлого, технологийн хэрэглээ

**Гар утасны аппликейшн ашиглаж санхүүгийн төлбөр тооцоо хийдэг байх боломжтой зах зээлийг доод багцаагаар 200,000 орчим хүн, ЛэндМН ББСБ-ийн нэг хүнд олгосон сарын дундаж зээлийн хэмжээ 168,720 төгрөг байгааг харгалзан үзэхэд нийт зах зээлийн багтаамж багадаа 651 тэрбум төгрөг байхаар таамаглагдаж байна.**

### 4. Өрхийн орлого, зарлагад суурилсан хэрэглэгчдийн судалгаа

Монгол айл өрхийн хэрэглээний бичил зээл өсөх болсон гол шалтгаанд орон сууцны ипотекийн зээлийг дэмжих хөтөлбөрөөс гадна(8%-ийн орон сууцны зээл), хэрэглээний барааны үнийн өсөлт, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлого буурсан зэрэг олон хүчин зүйлс нөлөөлсөн.

Нэн ялангуяа банк санхүүгийн байгууллагуудын санал болгох зээлийн бүтээгдэхүүн төрөлжиж олон төрлийн лизингийн үйлчилгээ нэвтэрснээр хэрэглэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрөө зээлээр хийх хандлага өсч, өрхийн дундаж зарлагыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, дундаж орлого бууралттай байгаа нь хэрэглээний зээлийн эрэлтийг нэмэгдүүлж байна.

**Орон сууцны зээлтэй иргэдийн дундаж нас  Орон сууцны зээлдэгчийн орлого**




График15. Ипотекийн зээлтэй иргэдийн дундаж нас




*Эх сурвалж: Монгол банк*
График16. Ипотекийн зээлтэй иргэдийн орлого

Орон сууцны зээлдэгчдийн насны ангиллаар харахад 25-35 насны иргэд нийт зээлдэгчдийн 41,9%-ийг эзэлж байна. Ипотекийн зээлийн дундаж хэмжээ 45 сая төгрөг буюу дунджаар сард нэг зээлдэгч 338,000 төгрөг төлж байгаа юм.

**Иргэд илүү зардлаа хаанаас санхүүжүүлж байна вэ?**




График17. Эх сурвалж. Монгол банк НЭЗС-ийн түүвэр судалгаа

Графикаас харахад 2014 оноос буюу ипотекийн зээлийн хөтөлбөр эрчимжиж эхэлснээс хойш өрхийн дундаж зарлага дундаж орлогоо давж байгаа нь бичил хэрэглээний зээлийн эрэлт өндөр байгааг илэрхийлж байна.

Монгол банкны НЭЗС-ийн түүвэр судалгаанд дурдсанаар 2016 оны байдлаар нийт иргэдийн зээлийн үлдэгдэл 2.9 их наяд төгрөг байна. Иргэд орлогоос давсан санхүүгийн хэрэгцээгээ найз нөхөд, ах дүү, гэр бүл(28%), ломбард(16%), ББСБ(4%)-аас зээл авдаг гэсэн байна. Энэ нь судалгаанд оролцсон иргэдийн 48% нь буюу нийт 1.35 их наяд төгрөгийг бидний зорилтот нийлүүлэлтийн сувгаар дамжуулан зээлдэг гэж үзэж болохоор байна.

### Зээлийн хэрэгцээ шийдэл




Эх сурвалж: Монгол улсын санхүүгийн тогвортой байдлын судалгаа, 2016.06

Зураг7: Зээлийн хэрэгцээ шийдэл

**Монгол банкны НЭЗС-ийн түүвэр судалгаанд дурдсанаар 2016 оны байдлаар нийт иргэдийн зээлийн үлдэгдэл 2,886 их наяд төгрөг байна. Судалгаанд оролцсон иргэдийн 48% нь нийт 1.35 их наяд төгрөгийг найз нөхөд, ах дүү, гэр бүл(28%), ломбард(16%), ББСБ(4%)-аас буюу бидний зорилтот нийлүүлэлтийн сувгаар дамжуулан зээлдэг байна.**

## 5. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үзүүлэлт

**Монгол улсын хэмжээнд санхүүгийн зах зээлд олгож буй хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамж:**

2017 оны 2-р улирлын байдлаар нийт арилжааны банкуудын олгосон зээлийн дүн нь 6.8 их наяд байснаас 36.7% буюу 2.5 их наяд нь **хэрэглээний зээлд** хамааргдаж байгаа болно. ББСБ-уудаас олгосон нийт зээлийн хэмжээ мөн үед 314.4 тэрбум төгрөг байснаас **142.9 тэрбум** төгрөг нь хэрэглээний зээлд харьяалагдаж байна.

Мөн үеийн байдлаар ББСБ-ын гаргасан зээлийн үлдэгдэл 554.9 тэрбум төгрөг байсан бол ЛэндМН ББСБ-ийн зээлийн үлдэгдэл 2017 оны 10-р сарын байдлаар 4.8 тэрбум байна.

**Банк болон ББСБ, ЛэндМН-ийн нийт олгосон зээлд эзлэх хэрэглээний зээлийн %**




*График18.Эх сурвалж: Монголбанк, 2017.II улирал*

**ББСБ болон ЛэндМН-ийн зээлийн үлдэгдэл**




*График19.Эх сурвалж: Монголбанк, 2017.II улирал*

**ЛэндМН аппликэйшнээр дамжуулан олгосон зээлийн үлдэгдэл 2017 оны 10-р сарын байдлаар 4.8 тэрбум буюу нийт ББСБ-ын зээлийн үлдэгдлийн 0.9% тай тэнцэж байгаа бөгөөд зээлийн дундаж дүн, харилцагчдын тоо харьцангуй хурдтай өсч байгаагаас тооцон үзэхэд цаашид зах зээлийн багтаамжаа нэмэгдүүлэх бүрэн боломж байгааг харуулж байна.**

### 6. Бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж

Хятад улсыг финтек салбарын хөгжил болон хэрэглэгчдэд хүрсэн байдлаар дэлхийд тэргүүлэгч гэж судлаачид үзэж байна (Эрнст энд Янг, 2016). Үүнд нөлөөлөх болсон гол хүчин зүйл нь Хятадын эрх зүйн орчин, смарт утас хэрэглэгчдийн тооноос гадна финтек бүтээгдэхүүнүүд банкны салбарын хүрч чадаагүй эрэлттэй зах зээл буюу жижиг дунд бизнес болон банкны шаардлага хангаагүй бизнесийнхэнд хүрч эхэлснээр маш том зах зээлийг бий болгож чадсан явдал юм.

Хятадын интернет кредит зээлийн бүтээгдэхүүний хэрэглэгчдийн статистик




График20. Эх сурвалж: Меритз Стратеги ҮЦК-ний судалгааны хүрээлэн

Хятад улс нь дэлхийд финтек хэрэглэгчдийн тоогоор тэргүүлэгч буюу **судалгаанд оролцсон иргэдийн 69%** нь финтек хэрэглэдэг гэжээ.

Хятад улс финтекийн салбарын хувьд бусад зах зээлийн тогтворжилтынхоо оргил үе буюу тогтворжилтийн үе дээрээ байгаа бөгөөд 2017-2020 он хүртэл жилд дунджаар 7.5% өсч, хүн амын 13%-16% финтекийн үйлчилгээнд хамрагдана хэмээн таамаглажээ.
(Меритз Стратеги ҮЦК-ний судалгааны хүрээлэн, 2017)

Финтекийн салбарын хамгийн том оролцогчийн бизнесийн мөчлөгийн судалгаан дээр үндэслэн Монгол улсын финтекийн салбар тогтворжилтынхоо үедээ барагцаагаар хүн амын 13-16% [8] -ийг бүрдүүлнэ гэж үзвэл нийт хэрэглэгчдийн тоо ойролцоогоор **403'000-496'000** хүн амыг хамрах төлөвтэй байна.

Манай улсын банкны салбарын тогтворжилтын зах зээлийн бүтцийн жишгээс авч үзэхэд томоохон арилжааны банкууд бүтээгдэхүүнээсээ хамааран зах зээлийн 20-25%-ийг дангаараа эзэлдэг. Энэ жишгээр финтек салбарын зах зээл эзлэлт тогтворжилтынхоо үедээ хэрэглэгчдийн 20%-25%-д үйлчилгээ үзүүлнэ гэж үзвэл **80'600-124'000** харилцагчтай болно гэж таамаглаж болохоор байна.

**Олон улсын байгууллагуудын финтекийн салбарын бизнесийн мөчлөгийн статистик судалгаан дээр үндэслэн ирэх 5 жилийн хугацаанд тогтворжилтын мөчлөгт орно хэмээн үзэхэд нийт зах зээлийн багтаамж 496,000 иргэд буюу ойролцоогоор 960 тэрбум төгрөг байхаар таамаглагдаж байна.**

[8] Түүнчлэн Ситибанкны "Финтек бүтээгдэхүүний эрин үеийн судалгаа"-гаар 2017 - 2023 оны хооронд буюу ирэх 6 жилийн хугацаанд Хойд Америкийн банкны хэрэглээний зээлийн 17%-ийг(өдгөө 1.1%) финтекийн зах зээл бүрдүүлнэ хэмээн үзсэн нь тус статистикийг дэмжиж байна.

2018 11 19

**Дүгнэлт:**

**Тэвдэж яваа хүн бүрт "Асаа, асуудлаа шийд"** шийдлийг хүргэх зорилготой ЛэндМН ББСБ ХХК-ийн нэвтрүүлсэн бичил хэрэглээний зээлийн бүтээгдэхүүний зах зээлийн багтаамжийг нас болон орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид, өрхийн орлого, зарлагад суурилсан хэрэглэгчид, технологи хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгчид, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үзүүлэлт, бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж зэрэг 5 аргачлалаар тооцон үзэхэд дундаж зах зээлийн багтаамж 900 тэрбум төгрөг байна.

Гэвч цаашид зорилтот зах зээл нь бидний судалгааны цар хүрээгээр хязгаарлагдахгүй өргөжин тэлэх боломжтой юм.

**Монгол улсын Финтект суурилсан бичил хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамжийн төсөөлөл :**

**Нэгж: төгрөг**

| | Судалгааны арга | Зах зээлийн багтаамж |
|---|---|---|
| 1 | Нас болон орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид | 1 их наяд |
| 2 | Технологид хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгчид | 600 тэрбум |
| 3 | Өрхийн орлого, зарлагад суурилсан хэрэглэгчдийн судалгаа | 1.35 их наяд |
| 4 | Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үзүүлэлтээр | 600 тэрбум |
| 5 | Бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж | 960 тэрбум |
| | **Зах зээлийн багтаамж /дундаж/** | **900 тэрбум** |

Хүснэгт23 Хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамж

## 2.5 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БИЧИЛ СУДАЛГАА

### 1. Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Энэхүү үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх хугацаанд Монгол улсын эдийн засгийн өсөлт суларч 2016 оны эцэст 1% тэлсэн, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш сүүлийн 1 жилийн дотор 2350-2460 төгрөгийн хооронд харьцангуй тогтвортой байсан хэдий ч сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр ~50% суларсан, мөн улсын нэгдсэн төсвийн алдагдал 2016 онд ДНБ-ийн 15%-д хүрч өссөн байдалтай байв.

Ийнхүү макро эдийн засгийн тэлэлт саарсан, төсөв ба мөнгөний бодлогын голлогч индекаторууд хямралын шинжтэй болсон нөхцөлд Монгол улсын Засгийн Газар 2016 оны эцсээр Олон Улсын Валютын Санд (ОУВС) хандаж тусламж хүссэн билээ. 2017 он гарсаар ОУВС Монгол улсын Засгийн Газартай хамтран "Өргөтгөсөн Санхүүжилтын Хөтөлбөр" хэрэгжүүлж, ирэх 5

20180119

жилийн хугацаанд 5.5 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг Монгол улсын эдийн засагт нийлүүлэх тохиролцоонд хүрсэн юм. Дээрхи Өргөтгөсөн Санхүүжилтын Хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол улсын Засгийн Газрын төсвийн алдагдал ДНБ-ийн 6% болж буурах төлөв ажиглагдаж байна.




График21. Эх сурвалж: ҮСХ

1990 оноос өмнө Монгол улсын эдийн засгийг хэдийгээр мал аж ахуйд тулгуурласан хэмээн томъёолдог байсан ч ЗХУ задарч социалист дэглэм халагдсан үеэс эхлэн чөлөөт зах зээлийн зарчмаар уул уурхай, эрдэсийн хайгуулын салбар давамгайлах болсон юм. 2000 онд буюу чөлөөт зах зээлийн системд шилжсэнээс даруй 10 жилийн дараа Монгол улсын тэргүүлэгч салбар нь Хөдөө Аж Ахуй (ХАА) (ДНБ-ийн 27.4%) хэвээр байв. Энэ нь 1997 оноос эхэлсэн Азийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр дэлхийн зах зээл дээрхи эрдсийн бүтээгдэхүүний үнэ сул байсан үетэй давхцаж байна.

Харин 5 жилийн дараа буюу 2005 онд уул уурхайн салбар Монгол улсын тэргүүлэгч салбар болж ДНБ-ийн 21.1%-ийг үйлдвэрлэж байсанд хоёр чухал хүчин зүйл бий. Нэгдүгээрт дэлхийн зах зээл дээрхи металын (тэр дундаа алт болон зэсийн) үнэ огцом нэмэгдэж БНХАУ-ын эдийн засаг хурдацтай тэлж байсантай холбоотой. Хоёрдугаарт Монгол улсад 2002 онд нээгдсэн Оюутолгой зэс-алтны ордын мэдээлэл олон улсад түгэн Монгол улсад орж ирэх ГШХО-ийг нэмэгдүүлж уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдийн тоо өсч байсантай холбоотой.

20180119

**Монгол улсын эдийн засгийн тэргүүлэгч салбарууд**




График22. Эх сурвалж: ҮСХ

Монгол улсын эдийн засаг 2010 оны байдлаар харьцангуй төвлөрөл багатай болж эхэлснийг дээрхи үзүүлэнгээс харж болно. Энэ нь тухайн үед 10 тэрбум ам.долларын ДНБ-ийн чадамж бүхий эдийн засагт 1 жилд 4 тэрбум (буюу ДНБ-ын 40% тэнцэх) ГШХО Монгол улсад орж ирж байснаас үүдсэн хөрөнгө оруулалт ба хувийн салбарын идэвхитэй үйл ажиллагааны илрэл байв. 2012 оноос Монгол улсын улс төрийн нөхцөл байдал болон хөгжлийн бодлогод өөрчлөлт гарч уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг саармагжуулах бодлого хэрэгжүүлж эхлэв. Энэхүү арга хэмжээ нь 2012 онд Монгол улсын Засгийн Газар олон улсын өрийн зах зээлд 1.5 тэрбум ам.долларын Чингис бондыг амжилттай борлуулснаар хэрэгжиж эхлэв. Төсвийн тэлэлтийн бодлогын хүрээнд Монгол улсын Засгийн Газрын нэгдсэн төсөв 2011 онд 4.99 их наяд төгрөг байсан хэдий ч 5 жилийн дотор буюу 2016 оны эцсээр 9.52 их наяд төгрөгт хүрсэн нь 5 жилийн хугацаанд 90% өсчээ.

Бодлого боловсруулагчдын гаргасан шийдвэрийн дагуу 2012 оноос эхлэн эдийн засгийн уул уурхайн салбараас хэт хараат байдлыг саармагжуулахаар зорьсон болович энэ нь Монгол улсад орж ирэх ГШХО ба валютын чухал урсгалд сөргөөр нөлөөлсөн нь 2011 онд 17% 2012 онд 12% хурдтайгаар тэлж байсан эдийн засгийн тэлэлтийг удаашруулж, 2016 онд 1% болтол бууруулав.

ДНБ (ам.доллар) , түүний тэлэлт ба ГШХО (ам.доллар)




График23. Эх сурвалж: ҮСХ, Монгол

*Дотоодын нийт бүтээгдэхүүн болон Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт*

Хувийн хэвшил дээр тулгуурласан эдийн засгийн идэвхи сулрахтай зэрэгцэн үүссэн сөрөг үзэгдлүүдийг арилгахаар төсвийн болон мөнгөний зөөлөн бодлогыг 2012 оноос хэрэгжүүлж эхэлсэн нь "Үнэ тогтворжуулах хөтөлбөр", "8% ипотекийн зээл" гэх мэт зах зээл дээр мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрүүд байв. Дээрхи мөнгөний зөөлөн бодлогын хүрээнд нийт M2 мөнгөний нийлүүлэлт 2011 оны эцсээр 6.4 их наяд төгрөг байсан бол 2016 оны төгсгөлд 12.1 их наяд болж 5 жилийн дотор 81% өсч, төв банкны гадаад валютын нөөц 2011 онд 2.3 тэрбум ам.доллар байсан нь мөн хугацаанд 1.3 тэрбум ам.доллар болтол (-43%) буурчээ.

Мөнгөний нийлүүлэлт болон валютын нөөц




График24. Мөнгөний нийлүүлэлт ба валютын нөөц

Ийнхүү төсөв ба мөнгөний бодлогод огцом өөрчлөлт оруулсан нь Монгол төгрөгийн ханшид сөргөөр нөлөөлж гадаад улс орнуудаас орж ирэх импортын хэрэглээ 2011 онд 6.6 тэрбум ам.доллар байснаас буурч 2016 онд 3.4 тэрбум ам.долларт хүрэн 5 жилийн хугацаанд -48% унасан бол экспортын үзүүлэлт мөн хугацаанд 4.8-5.8 тэрбум ам.долларын хооронд хэлбэлзэж байсан нь Монгол улсын гадаад худалдааны салбарыг сүүлийн 3 жилд ашигтай байх нөхцлийг бүрдүүлжээ.




График25. Эх сурвалж: ҮСХ

## 2. Макро эдийн засгийн ирэх 5 жилийн төлөв

ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөр"-тэй холбоотойгоор төсвийн болон мөнгөний бодлогоор эдийн засгийн бодит өсөлтийг дэмжих боломжоо харьцангуй хязгаарлагдмал болж буй. Үүнтэй уялдан ирэх 5 жилийн хувьд Монгол улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь уул уурхайн салбар, эрдсийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрхи ханш байх болно.

2016 онд 1% тэлсэн ДНБ нь цаашид 2017 онд 4-5%, 2018 онд 2,5-4,3%-иар тэлэх боломжтой гэж үзэж байна. Төсвийн орлогын томоохон хувийг бүрдүүлдэг зэс болон нүүрсний үнэ харьцангуй өндөр байх төлөвтэй байгаа нь энэхүү тэлэлтийн гол хүчин зүйл болно.

| Монгол улсын ДНБ тэлэлтийн төлөв | 2018Т | 2019Т |
|---|---|---|
| Монгол улсын Сангийн Яам | 4.30% | 6.80% |
| Азийн Хөгжлийн Банк | 3.0% | - |
| Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк | 3.0% | - |
| Олон Улсын Валютын Сан | 2.5% | - |

Хүснэгт24. Монгол улсын ДНБ тэлэлтийн төлөв

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA ҮЦК LLC

Монгол улсын эдийн засаг түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамаарахаас гадна, ПШХО-ыг хувьцааны болон санхүүгийн өрийн хэрэгслүүдээр хэрхэн татахаас ихэд шалтгаална. Олон улсын банк санхүүгийн байгууллагууд хэдийгээр Монголын эдийн засгийн ирэх онуудын төсөөллийг тооцоолохыг оролддог хэдий ч амжилттай тооцож байсан удаа цөөн. Гэхдээ жолоодогч төсөөллүүд ба тэдний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дурдах нь зүйтэй.

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд тэлэлтийн хурд нь огцом буурч, иргэдийн орлого, худалдан авах чадварт сөрөг нөлөөтэй байсан эдийн засагт ОУВС-гийн хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөрийн" үр нөлөө их байх болно. Үүнд:

1. Төсвийн сахилга батыг сайжруулснаар эдийн засаг дах төрийн оролцоог бууруулах нь богино хугацааны макро статистикт сөргөөр нөлөөлөх хэдий ч дунд хугацаанд (буюу 3-5 жилд) хувийн хэвшил тэр дундаа уул уурхайн салбар идэвхжихэд чухал нөлөөтэй.

2. Иргэдийн орлогод тавих татварын хэмжээ ба тансаг хэрэглээний бүтээгдэхүүнд ногдуулах татварын хэмжээ нэмэгдэх нь хэдийгээр уламжлалт онолоор эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж болох ч Монгол улс шиг хэрэглээнийхээ дийлэнхи хувийг гадаадаас импортоор авдаг ба хуримтлал бага үүсгэдэг оронд эерэг үр нөлөө авч ирэх боломж их гэж үзэж байна.

Мөн Монголын улс төрийн орчинд 2020 оныг хүртэл УИХ-д нэг нам дангаар эрх барьж байгаа нь эдийн засгийн прагматик бодлого хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй.

### 3. Мөнгөний бодлогын талаар

Монголбанкны тэргүүлэгч зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн тогтвортой байдлыг хангахад оршдог. 2012 оноос хойш 5 жилийн хугацаанд ойролцоогоор 50% суларсан Монгол төгрөгийг чангаруулах нь Монгол улсын мөнгөний бодлогын болон ОУВС-тай хамтран хэрэжүүлж буй Өргөтгөсөн Санхүүжилтын Хөтөлбөрийн тэргүүлэгч зорилт байх төлөвтэй.




График26. Эх сурвалж: Монгол Банк

Мөнгөний бодлогын удаах зорилт нь Монгол улсын банк, санхүүгийн салбарын бодлогын хүүг тогтоож, бизнесийн болон төслийн зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд оршино. Гэвч энэхүү бодлого нь тэргүүлэгч зорилттойгоо эрс зөрчилдөх нь гарцаагүй тул ирэх онуудад Монгол улсын мөнгөний бодлого чангарах, Монголбанкны бодлогын хүү аажим өсөх нөхцөл байдал анзааргадаж байна. Энэхүү үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үед Монгол Банкны бодлогын хүү 12% ба зорилтот хэрэглээний үнийн индексийн өсөлтийн түвшин нь 8.2% гэж тодорхойлогдож байна. Харин улсын түвшинд өнгөрсөн 12 сарын хугацааны хэрэглээний үнийн индекс 6.9% байгаа нь бодлогын хүүг буулгаж хувийн салбарын бодит өсөлтийг дэмжих боломж байгааг илэрхийлнэ.

Энэхүү нөхцөл нь Монгол улсын жижиглэнгийн зээлийн зах зээлд эрчимтэй нэвтрэх ЛэндМН ББСБ компанийн үйл ажиллагаанд харьцангуй эерэг нөлөө бий болгох юм.

## 4. Гадаадын хөрөнгө оруулалтын төлөв

Монгол улсыг зорих гадаадын хөрөнгө оруулалтын 70%-ийг уул уурхай, эрдсийн хайгуулын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт эзэлдэг бөгөөд ойрын 5 жилд энэхүү тогтолцоонд өөрчлөлт орохгүй байх магадлалтай. Мэдээж олон улсын зах зээл дээрхи эрдсийн үнэ нь ПШХО-ын голлох чиглүүлэгч болдогийг доорхи үзүүлэнгээс харж болно.




График27. Эх сурвалж: ҮСХ, www.indexmundi.com

Монгол улсад улс төрийн тогтвортой орчин бүрдвэл ГШХО-ын төвлөрөл уул уурхайн салбараас буурч, эдийн засгийн бусад салбаруудад орох магадлал өндөр. Ялангуяа Fitch, Moody's гэх мэт олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд Монгол улсын зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлсэн тохиолдолд Монгол улсын санхүүгийн салбар нь ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт татах боломжтой.

| Монгол улсын ЗГ-ын зээлжих зэрэглэл | Зэрэглэл | Төлөв |
|---|---|---|
| Moody's | Caa1 | Тогтвортой |
| Fitch | B- | Эерэг |

Хүснэгт25. МУ-ын ЗГ-ийн зээлжих зэрэглэл

Одоогоор Монгол улсын хөрөнгө оруулалтын орчинг Frazer Institute-ийн судалгаагаар дэлхийн нийт 104 орноос 81-д эрэмбэлж байгааг, 2012 онд нийт 96 орноос 31-д эрэмбэлж байсантай харьцуулахад харьцангуй суларсан үзүүлэлттэй байна.




График28. Эх сурвалж: Fraser Institute

Харин Дэлхийн Банкны улс орнуудын бизнес эрхлэх орчны нөхцөл байдлаар нь харьцуулан эрэмбэлдэг "Doing Business Survey"-д Монгол улсын үзүүлэлт 2011 онд 89-р байрт байсан бол тогтвортой өсч 2016 оны эцэст нийт 190 орноос 61-р байрт эрэмбэлэгдэж байна.

**Дэлхийн Банк: Монгол улсын бизнесийн орчны үнэлгээ**




График29. Эх сурвалж: Дэлхийн Банк

## 2.6 ЭРСДЛИЙН ШИНЖИЛГЭЭ

### ЛэндМН ББСБ ХХК-ийн үйл ажиллагааны эрсдлийн судалгаа

### I. ЛЭНДМН ББСБ ХХК-ИЙН ЭРСДЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС.

ЛэндМН ББСБ ХХК нь интернэт, үүрэн холбооны сүлжээ, ухаалаг утасны аппликейшн зэрэг мэдээллийн технологийн орчин үеийн дэвшилтэт ололтыг ашиглан Монгол Улсад бичил зээлийн үйлчилгээг барьцаагүйгээр шуурхай үзүүлж байгаа нь урьд өмнө зах зээлд байгаагүй цоо шинэ төрлийн уламжлалт бус үйлчилгээ юм.

ЛэндМН ББСБ ХХК-ийн бичил зээлийн үйлчилгээний үндсэн үүсгэгч болон түгээгч болох ухаалаг утасны "LendMN" аппликейшнийг АндСистемс тех ХХК оюуны өмчийн эрхээр эзэмшдэг бөгөөд Лицензийн онцгой эрхийн гэрээний үндсэн дээр ЛэндМН ББСБ ХХК-д ашиглуулж байгаа болно. Хэдийгээр тус аппликейшнийн хөгжүүлэлт, найдвартай ажиллагааг онцгой нөхцлөөр хариуцаж байгаа ч ЛэндМН ББСБ ХХК нь тус аппликейшн болон бусад мэдээллийн технологийн дэд бүтцийг ашиглан өөрийн банк бус санхүүгийн бичил зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон хэрэглэгчдэд түгээж байгаа тул тус компанид учирч болох эрсдэлийн хүчин зйүлсийг:

1. Үйл ажиллагаа, үүнд үйлчилгээний онцлогоос хамаарсан мэдээллийн технологитой холбоотой эрсдлийн хүчин зүйлс.

20180119

2. Зохицуулалт, өрсөлдөөн, компанийн нэр хүнд, засаглал, бөлтгөн нийлүүлэгчээс хамаарах эрсдлийн хүчин зүйлс гэсэн хэсэгт хуваан авч үзэж байна.

## 1. Үйл ажиллагаа, үүнд үйлчилгээний онцлогоос хамаарсан мэдээллийн технологитой холбоотой эрсдлийн хүчин зүйлс.

Тус компани өөрийн зээлийн үйлчилгээг бий болгон түгээхэд мэдээллийн технологийн дараах орцууд ашиглагддаг ба тэдгээр орцуудтай холбогдох болзошгүй эрсдлүүд ба бууруулах арга хэмжээг дурдвал:

1.1 Зээлийн эрсдэл. Банк бус санхүүгийн байгууллагын секторт учирдаг үндсэн эрсдэл нь зээлийн эрсдэл юм. Зээлийн эрсдэл нь Зээлдэгч гэрээний үүргээ үл биелүүлэх, зээл ба зээлийн хариу төлбөр ("шимтгэл" эсхүл "хүү" гэх)-ийг бүгдийг эсхүл хэсэгчлэн төлөхгүй байхаас үүдэн ББСБ-ын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх, зохицуулах байгууллага буюу Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигддаг шаардлага болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үл хангах, зохицуулагч байгууллагаас үйл ажиллагаанд хориг тавих(тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох) хүртэл арга хэмжээнд өртөж болзошгүй. Түүнчлэн өнөөгийн байдлаар дийлэнх зээлийн үйлчилгээ барьцаатай байгаа бөгөөд барьцаагүй зээл олгохыг хуулиар хориглоогүй. ЛэндМН ББСБ нь зээлээ барьцаагүйгээр олгодог нь гол онцлог бөгөөд зээл эргэн төлөгдөхгүй байх нь боломжит эрсдлүүдийн нэг.

1.2 Интернэт сүлжээний ажиллагаа. Монгол улсад интернэтийн сүлжээ анх 1996 оноос нэвтэрсэн. 2017.06.30-ны байдлаар Монгол улсын нутаг дэвсгэрт 6 ААН 37788 км шилэн кабелийн үндсэн сүлжээ эзэмшин үйлчилгээ үзүүлж байна /эх сурвалж: **www.crc.gov.mn/**. ЛэндМН нь өөрийн үйл ажиллагаан дах найдвартай ажиллагааг хангахын тулд сүлжээний нөөц холболтуудыг бэлэн байдалд байлгадаг.

1.3 "Cloud Storage" серверийн үйл ажиллагаа. Тус компанийн үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг бөгөөд сервер нь аюулгүй байдал, найдвартай ажиллагааны хамгийн дээд түвшний шаардлагын дагуу гадаад улсад болон Монгол улсад байрладаг. Серверийн үйлчилгээ үзүүлэгч олон улсын томоохон нэр хүндтэй компаниуд үйлчлүүлэгчийнхээ мэдээллийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангахын тулд асар өндөр хэмжээний хамгаалалт нууцлалыг санал болгон хэрэгжүүлж байдаг. Өнөөг хүртэл хугацаанд сервертэй холбоотой ямар нэг эрсдэл үүсч байгаагүй ч ийм төрлийн эрсдэл нь компанийн үйл ажиллагаанд хамгийн том сөрөг нөлөөг үзүүлнэ. Мэдээллийг "Encryption" буюу гуравдагч этгээд тайлж ашиглах боломжгүйгээр кодлон хадгалдаг нь харилцагчдын мэдээллийн нууцыг хадгалах ач холбогдолтой.

1.4 "LendMN" аппликейшн-ийн найдвартай ажиллагаа. Тус компанийн зээлийн үйлчилгээ нь хэрэглэгч аппликейшнд бүртгүүлэн зээлийн хүсэлт илгээхээс эхлээд зээл авч ашиглан эргэн төлөх хүртэлх зээлийн үйлчилгээний бүхий л үе шатуудыг "Artificial Intelligence" буюу хиймэл оюун ухаанд суурилсан тооцооллоор хэрэгжүүлдэг бөгөөд үүнд

аппликейшнийн үйл ажиллагаа доголдох, тооцоололд алдаа гарах эрсдэл байх боломжтой. Тус аппликейшнийг өмчлөгч, хөгжүүлэгчийн зүгээс аппликейшнийн найдвартай ажиллагааг нягтлах мөн хэрэглэгчийн зүгээс гаргасан гомдол хүсэлтийн дагуу тухайн хэрэглэгчтэй холбоотой аппликейшнээс гаргасан тооцоолол, шийдвэрийг хүний тусламжтайгаар шалгах боломжтой. Мөн түүнчлэн тус компани зээлийн үйл ажиллагааныхаа статистик үр дүнд үндэслэн зээлийн чанарын эрсдлийг бууруулах, зээлийн хүртээмжийг зохистой түвшинд хүртэл өөрчлөх суурь тохиргоонуудыг аппликейшнд хийх, тодорхой зорилтот хүчин чадлын хязгаарын дотор аппликейшнийн гэнэтийн огцом их ачаалал даах чадварыг тестлэх, холбогдох сайжруулалт, өргөтгөлийн ажлуудыг тогтмол хийдэг.

1.5 Цахилгаан эрчим хүчний хангамж. Тус компанийн зээлийн үйлчилгээгээ хэрэглэгчдэд хүргэдэг бүхий л дэд бүтэц нь цахилгаан эрчим хүчээр тэжээгдэн ажилладаг тул цахилгаан эрчим хүчний хангамжийн доголдол нь боломжит эрсдлүүдийн нэг мөн. Хэдий тийм боловч байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүсэлтэй хот, суурин, бүс нутаг зэрэг асар өргөн хүрээг хамарсан цахилгаан эрчим хүчний доголдол үүсэхгүй л бол компанийн үйл ажиллагаанд бүхэлд нь сөргөөр нөлөөлөх магадлал маш бага гэж үзэж байна.

1.6 Үүрэн холбооны операторуудын үйл ажиллагаа. Тус компанийн зээлийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж буй нэг суваг нь Монголд үйл ажиллагаа явуулж буй үүрэн холбооны Мобиком, Юнител, Скайтел, Жи-Мобайл дөрвөн оператор бөгөөд эдгээр компаниудын хөдөлгөөнт интернэт доголдох нь мөн компанийн үйл ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлөх боломжтой. Үүрэн холбооны сүлжээнд хэсэг газрын түр зуурын саатлууд тохиолдож байсан боловч операторууд хурдан шуурхай арга хэмжээ авч хэвийн байдалд оруулдаг ба өнөөг хүртэл ийм төрлийн саатлаас шалтгаалан компанийн үйл ажиллагаанд ноцтой сөргөөр нөлөөлж байсан зүйлгүй байна.

1.7 Монгол Банкны Зээлийн Мэдээллийн Сангийн үйл ажиллагаа. Хэрэглэгчийн зээлийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхэд Монгол Банкны Зээлийн Мэдээллийн Сан /МБЗМС /-аас авах мэдээлэл чухал үүрэгтэй бөгөөд МБЗМС-ийн үйл ажиллагаанд доголдол үүсэх нь Компанийн зээлийн үйлчилгээг удаашруулах, боломжгүй болгох эрсдэлтэй. Хэдий тийм боловч түр зуурын зарим нэг богино хугацааны саатлыг эс тооцвол МБЗМС-ийн үйл ажиллагаанаас үүдэн компанийн үйл ажиллагаанд ноцтой хэмжээний доголдол гарч байсан удаагүй байна.

1.8 Арилжааны банкуудын сүлжээний үйл ажиллагаа. Компани зээлийн үйлчилгээгээ хэрэглэгчдэд хүргэх нэг салшгүй бүрдэл хэсэг болох арилжааны банкуудын сүлжээний ажиллагааны доголдол нь компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх боломжтой. Арилжааны аль нэг банкийг сонгох нь тухайн хэрэглэгчийн эрхийн асуудал бөгөөд тухайн банкны сүлжээ доголдох нь хэрэглэгчид ч, компанид ч сөрөг нөлөөтэй. Хэдий тийм боловч түр зуурын зарим нэг богино хугацааны саатлыг эс тооцвол банкуудын сүлжээнээс үүдэн компанийн үйл ажиллагаанд

ноцтой хэмжээний доголдол гарч байсан удаагүй бөгөөд банкууд шуурхай арга хэмжээ авч сүлжээгээ хэвийн байдалд оруулдаг.

1.9 Мэдээллийн технологийн аюулгүй байдал. Цахим халдлага, дайралт нь компанийн мэдээллийн бааз, сүлжээнд болзошгүй томоохон эрсдлүүдийн нэг. Компани өнөөдрийн байдлаар өөрийн сүлжээ, мэдээллийн баазын аюулгүй байдлыг хангах, хадгалах, дээшлүүлэх үүднээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- Компанид мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлийн тусгай нэгжийг байгуулж энэ чиглэлээр мэргэшсэн, олон улсад ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнийг томилон ажиллуулж байна.
- Өөрийн сүлжээ, мэдээллийн баазад жилд 2-оос доошгүй удаа "Full security checkup" хийж "Penetration test" буюу гадны халдлага, дайралтаас сэргийлэх шалгалтыг тогтмол явуулж байна.
- Мэдээллийг "Encryption" буюу гуравдагч этгээд тайлж ашиглах боломжгүйгээр кодлон нууцалж өндөр түвшиний хамгаалалтад хадгалж байна.
- Цаашид олон улсад нэр хүнд бүхий мэдээллийн технологийн аюулгүй байдлын хөндлөнгийн хяналтын байгууллагатай хамтран ажиллаж жил бүр мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэхийг зорьж байна.

## 2. Зохицуулалт, өрсөлдөөн, компанийн нэр хүнд, засаглал, бэлтгэн нийлүүлэгчээс хамаарах эрсдлүүд

Компанийн эрхэлж буй үйл ажиллагаа нь Монгол Улсын Аж Ахуйн Үйл Ажиллагааны Тусгай Зөвшөөрлийн тухай хууль, Банк санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо /СЗХ/-ноос батлан гаргасан холбогдох журмын дагуу тусгай зөвшөөрөл авч тодорхой шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах шаардлагатай байдаг. Иймд компанийн үйл ажиллагаа, санхүүтэй холбоотой болзошгүй эрсдлүүд ба тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүд:

2.1 Хууль эрхзүйн зохицуулалттай холбоотой эрсдэл. Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тухай хууль"-ийн 15.3.1-д заасны дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх ёстой. СЗХ нь уг тусгай зөвшөөрлийг олгох, хянах, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон шалгуур үзүүлэлтийг тогтоон мөрдүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. СЗХ-ны 2017.01.13 өдрийн 27 тоот тогтоолоор Улаанбаатар хотод байрлалтай ББСБ-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 он хүртэл үе шаттайгаар нэмэгдүүлэн 2.5 тэрбум төгрөгт хүргэхээр шийдвэрлэсэн. Компани нь 2017 онд өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг гурван удаа өсгөж 2017.11.30-ны өдрийн байдлаар 6 тэрбум төгрөгт хүргээд байна. СЗХ-ны 2016 оны 147 тоот тогтоолоор ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогтоосон. ЛэндМН ББСБ нь

2018 01 19

зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж, 2016 оны жилийн эцсээс эхлэн 2017 оны 3-р улирлыг дуустал нийт 4 удаа тайлангаа СЗХ-д хүргүүлсэн байна.

2.2 Өрсөлдөөний эрсдэл. Бусад банк, үүрэн телефоны оператор зэрэг эдийн засгийн чадавхи сайтай өрсөлдөгчдийн зүгээс компанийн эрхэлж буй энэхүү хиймэл оюун ухаан ашиглаж аппликейшнд суурилсан үйлчилгээтэй ижил төстэй бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэн зах зээлд өрсөлдөх бүрэн боломжтой ба үүний нэг жишээ нь Мобиком корпорацийн хэрэгжүүлж буй "Мессэж зээл" үйлчилгээ юм. Иймд өрсөлдөөний эрсдлийг бууруулах, дасан зохицох, өрсөлдөөнд тэргүүлэх байр сууриа хадгалахын тулд технологийн нууц, найдвартай байдалд байнгын анхаарал тавьж цаашдын хөгжүүлэлтийг хийж байх шаардлагатай. "Мессэж зээл" үйлчилгээтэй харьцуулахад ЛэндМН ББСБ-ийн үйлчилгээг Мобикомын хэрэглэгчдээс гадна бусад бүх үүрэн холбооны хэрэглэгчид ашиглах боломжтойгоороо давуу талтай.

2.3 Нэр хүндийн эрсдэл. Байгууллагын үндсэн үйл ажиллагааг зохицуулах бодлого, журам байхгүй эсвэл шаардлага хангахгүй байх, журмыг мөрдөхгүй байх, мэдээлэл, технологийн систем доголдох, ажиллагаагүй болох, харилцагчийн мэдээллийн нууцлал алдагдах, хувь хүний санамсаргүй алдаа болон санаатай гэмт хэргийн шинж чанартай үйл ажиллагаа болон гадаад орчны үзэгдэл, үйл явдлаас нөлөөлөх эрсдэлтэй.

2.4 Нэг бэлтгэн нийлүүлэгчээс хараат байгаа эрсдэл. ЛэндМН ББСБ нь өөрийн үйлчилгээний технологийн шийдэл LendMN аппликейшнийг бүхэлд нь Анд Системс тех ХХК-иас онцгой эрхийн Лицензийн гэрээний үндсэн дээр түрээслэн/50жил/ ашиглаж байгаа. Иймээс ЛэндМН ББСБ-ийн үйл ажиллагаа нь цорын ганц бэлтгэн нийлүүлэгч АндСистемс тех ХХК-иас бүрэн хамааралтай байгаа нь 1. Хүний хүчин зүйлээс 2. Техник технологийн хүчин зүйлээс хамаарч ЛэндМН ББСБ-ийн үйл ажиллагаа энэхүү шууд хараат байдлаас үүдэн доголдох, тасалдах эрсдэл байна.

## II. ЛЭНДМН ББСБ ХХК-ИЙН ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО, ЗАРЧИМ

Хувь нийлүүлэгчид болон зээлдүүлэгчдийн хөрөнгийг алдагдалд оруулах, хөрөнгө оруулагчид болон манай бизнесийн үйл ажиллагааны нэр хүндэд сөргөөр нөлөөлж болох ***зээл, үйл ажиллагаа, төлбөрийн чадвар, зах зээл, эрх зүй, зохицуулалтын орчны*** эрсдлүүдийг удирдахад чиглэсэн тодорхой бүтцийг бий болгон, шаардлагатай гэж үзсэн эрсдлийн удирдлагын арга хэмжээнүүдийг үйл ажиллагааныхаа цар хүрээтэй уялдуулан авч хэрэгжүүлдэг. Байгуулага нь эрсдлийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаагаа удирдан явуулахдаа дараах зарчмуудыг баримтлан ажилладаг. Үүнд:

i. Ажилтан бүр холбогдох чиглэлээрээ эрсдлийг хэмжих, үнэлэхэд шаардлагатай мэдлэг, үнэлгээний арга хэрэгслээр хангагдсан байх;

ii. ТУЗ-ын үүргийг хэрэгжүүлж байгаа хувь нийлүүлэгчдийн зүгээс тодорхойлсон бизнесийн стратеги, зорилтуудтай нийцүүлж тогтоосон эрсдэл тус бүрт тавигдах шаардлагуудтай байгууллагын үйл ажиллагааг нийцүүлэн ажиллах;

iii. Байгууллагын гүйцэтгэлийн зорилтууд нь хүлээн зөвшөөрөх эрсдлийн хязгааруудтай уялдсан байх;

iv. Өөрийн хөрөнгийн хүрэлцээг хүлээж байгаа болон хүлээж болох эрсдлийн түвшинтэйгээ уялдуулан хангах;

ТУЗ-ын үүргийг хэрэгжүүлж байгаа хувь нийлүүлэгч нь байгууллагыг эрсдлийн удирдлагын зарчим, стратеги, бодлогын удирдлагыг хангаж ажилладаг ба эрсдлийн хяналтыг хамтран хэрэгжүүлдэг.

## 1. Зээлийн эрсдлийн удирдлага

Байгууллагын одоогийн үйл ажиллагаатай холбоотойгоор учирч байгаа гол эрсдэл нь зээлийн эрсдэл юм. Байгууллагын зээлийн эрсдэл нь зээлийн эрсдлийг үнэлэн зээл батлах үйл ажиллагаа болон олгосны дараа зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор үүсдэг.

Байгууллага нь тухайн зээлдэгчийн эрсдлийг үнэлэх, зээл батлах болон олгох үйл ажиллагаатай холбоотой гардаг зээлийн эрсдлийг Анд Систем тех ХХК-ийн зохион бүтээсэн хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг утасны аппликейшнийг ашиглан олон улсын арга аргачлалаар зээлийн ажилтан буюу хүний субьектив хүчин зүйлийн оролцоогүйгээр системд автоматаар зээлдэгч нэг бүрт зээлийн скоринг тооцоолон бодож, зээл ба шимтгэлийн хэмжээг тогтоон санал болгох замаар удирдаж байгаа бөгөөд энэ нь тухайн зээлдэгчдэд эргэн төлөх боломжтой дүнгээр зээл батлагдаж зээлийн дарамт үүсгэх нөхцөлийг бууруулдаг.

Эрсдлийг бууруулж буй дараагийн арга зам нь зээлийн лимит тогтоох болон урамшууллын систем юм. ЛэндМН ББСБ-ын зээлийн үйлчилгээ нь уламжлалт биет барьцаа шаарддаггүйгээрээ эрсдэл өндөр байх боломжтой. Энэ эрсдлийг зээлийн лимит буюу ЛэндМН-ийн нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг 1,000,000 (нэг сая) төгрөгөөр хязгаарлах замаар хянаж, зээлийн сахилга бат сайтай зээлдэгчид урамшууллын оноо олгох, уг оноог зээлийн дүнг нэмэгдүүлэх мөн шимтгэлийг бууруулахад ашиглаж болох цогц систем нэвтрүүлсэнээрээ эрсдлийг бууруулах нөхцөлийг бүрдүүлдэг.

ЛэндМН-ийн зээлийн үйлчилгээ нь холбогдох хууль, журам, эдийн засгийн үзүүлэлтээр шаардлага хангаж байгаа түвшинг тогтоохдоо олгосон зээлийн хугацаа хэтрэлтийг байгууллагаас тогтоосон чанаргүй зээлд тавих лимит, болон бусад санхүүгийн байгууллагын ижил төстэй зээлийн үйл ажиллагааны чанартай харьцуулдаг.

Байгууллага нь зээл олгосны дараахь зээлийн багцын эрсдлийг хянах болон авлага барагдуулах үйл ажиллагааг зээлийн авлага барагдуулах нэгж болон дуудлагын төвтэй хамтран хэрэгжүүлдэг. Зээлийн хугацаа

хэтрэлтийг тухай бүр илрүүлэх, хугацаа хэтрэлтийн хандлагыг тодорхойлохдоо Анд Системс тех ХХК-иас боловсруулсан зээл бүртгэлийн систем, Удирдлагын тайлангийн системүүдийг хэрэглэдэг.

Байгууллага нь хугацаа хэтэрсэн зээлээс учирч болох алдагдалд зориулсан санг тухай бүр нь СЗХ-ноос тогтоосон зохицуулалтын хүрээнд байгуулан ажилладаг.

Байгууллагын чанаргүй зээлийн түвшин үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нийт ББСБ-ийн болон банкны салбарын дундажаас байнга илүү чанартай буюу доогуур хэмжээнд хадгалагдаж байгаа ба харгалзах эрсдлийн санг СЗХ-ноос тавьсан шалгуурын хүрээнд тухай бүр нь байгуулан ажиллаж байна.

## 2. Үйл ажиллагааны эрсдлийн удирдлага

Байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарах дараахь хүчин зүйлүүдээс байгууллагад учирч болох алдагдал болон нэр хүндийн эрсдэл үүсэх боломжтой. Үүнд:

i. Байгууллагын үндсэн үйл ажиллагааг зохицуулах бодлого, журам байхгүй эсвэл шаардлага хангахгүй байх;
ii. Байгууллагын үндсэн үйл ажиллагааг зохицуулах бодлого, журмыг мөрдөхгүй байх;
iii. Байгууллагын мэдээлэл, технологийн систем доголдох, ажиллагаагүй болох, харилцагчийн мэдээллийн нууцлал алдагдах;
iv. Хувь хүний санамсаргүй алдаа болон санаатай гэмт хэргийн шинж чанартай үйл ажиллагаа;
v. Байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад орчны үзэгдэл, үйл явдал;

Эдгээр эрсдлээс сэргийлэх зорилгоор үйл ажиллагааны эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Байгууллага нь зээлийн эрсдлийг үнэлэх, зээл олгох, төлүүлэх, мөнгөн хөрөнгөтэй харьцахтай холбоотой үйл ажиллагаануудаа хүний санаатай болон санамсаргүй үйлдлээс хамаарал бага байх технологийн шийдлийг нэвтрүүлэх замаар эрсдлээ удирдан ажиллаж байна.

Байгууллага нь мэдээлэл технологийн шийдэл, мэдээллийн системүүдийн найдвартай ажиллагаа, харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлаа удирдах үйл ажиллагаагаа Анд Системс ХХК-ийн технологийн шийдэл болон гэрээт үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлж байна.

Байгууллагын бизнесийн үйл ажиллагааны хамгийн үнэт хөрөнгө болох мэдээлэл, системүүдийг хөндлөнгийн гэмт халдлагаас хамгаалах, байгалийн болон хүний хүчин зүйлээс шалтгаалан үүсч болох гамшиг, аюулт үзэгдлээс сэргийлэх зорилгоор үүлэн серверийн үйлчилгээ үзүүлэгч олон улсын нэр хүнд бүхий байгууллагатай хамтран ажиллаж байна.

Байгууллага нь эрчим хүчний хангалт, интернет холболт, сүлжээний орчны тогтвортой тасралтгүй байдлыг хангах шаардлагын хүрээнд холболтын нөөц эх үүсвэртэй байх бодлогыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Байгууллага нь одоогийн байдлаар үйл ажиллагааны эрсдлээс шалтгаалсан ямар нэгэн алдагдалд орсон тохиолдол байхгүй.

### a. Төлбөрийн чадварын эрсдлийн удирдлага

Байгууллага нь зээлийн үйл ажиллагааны тогтвортой өсөлтийг хангах, бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ биелүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг хангаж ажиллах зорилгоор төлбөрийн чадварын эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Зээлийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад шаардлагатай өөрийн хөрөнгийн болон арилжааны зээлийн эх үүсвэрээр хангах үйл ажиллагааг байгууллагын гол хувь нийлүүлэгч хариуцан ажилладаг.

Байгууллага нь одоогийн байдлаар төлбөрийн чадварын эрсдэлтэй холбоотой ямар нэгэн алдагдалд орсон тохиолдол байхгүй.

### b. Эрхзүй, зохицуулалтын орчны эрсдлийн удирдлага

Байгууллага нь өөрийн үйл ажиллагаагаа СЗХ, Монголбанк, болон Монгол улсын бусад хууль тогтоомж, эрх зүйн орчны хүрээнд явуулдаг.

Байгууллага нь өдөр тутмын үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэн ажиллаж байгаа эсэх хяналтыг хэрэгжүүлэх нь нэн тэргүүнд байгууллагын удирдлагын багийн гишүүн бүрийн үүрэг байдаг ба ажилтан бүр өөрийн эрхэлж буй ажил үүргийг холбогдох хууль эрх зүйн орчинд нийцүүлэн гүйцэтгэх үүрэгтэй.

Байгууллага нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш байгууллагын нэр хүнд болон үйл ажиллагаанд хохирол учруулсан болон учруулж болох ямар нэгэн хууль, эрх зүйн орчны эрсдэлд орж байгаагүй болно.

### c. Зах зээлийн эрсдэл

Байгууллага нь гадаад болон дотоод эдийн засаг, бусад гадаад зах зээлийн орчны хүчин зүйлээс болж үүсдэг ханшийн хэлбэлзэл, хүүгийн түвшний өөрчлөлтөөс болж үүсч болох алдагдлаас сэргийлэх зорилгоор зах зээлийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Байгууллага нь одоогоор голчлон хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжиж байгаа ба зээлээр авсан эх үүсвэр нь зөвхөн төгрөгөөр илэрхийлэгдсэн учир ханшийн эрсдэл байхгүй.

Байгууллагын бусдаас авсан зээлийн хүү нь тогтмол ба бусдад олгож байгаа зээлийн үйлчилгээний үнийн түвшинтэй харьцуулахад хүүний эрсдлийн түвшин бага ба цаашид материаллаг нөлөө үзүүлэхүйцээр өсөх хандлага ажиглагдахгүй байна.

2018 01 19

# 3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | ЛЭНДМН ББСБ |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Хувьцааны нэрлэсэн үнэ | 10 төгрөг |
| Биржид бүртгүүлэх нийт хувьцааны тоо | 800,000,000 ширхэг |
| Нэмж гаргах хувь | 25% |
| Нэмж гаргах хувьцааны нийт тоо | 200,000,000 ширхэг |
| Үүнээс: Стратегийн хөрөнгө оруулагчид | 12.5% - 100,000,000 ширхэг |
| Нийтэд санал болгох | 12.5% - 100,000,000 ширхэг |
| Анхдагч зах зээлд санал болгох үнэ | 25 төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ | 5,000,000,000 төгрөг |
| Арилжаалах арга хэлбэр | Тогтоосон үнийн арга |

## Үнэт цаас гаргахын өмнө болон дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц

| Хувьцаа эзэмшигч | Хувьцаа гаргахаас өмнө | | Хувьцаа гаргасны дараа | |
|---|---|---|---|---|
| | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшлийн хувь | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
| **Анд Системс ХХК** | 600,000,000 | 100 % | 600,000,000 | 75 % |
| **Олон нийт** | - | - | 200,000,000 | 25 % |
| **Нийт** | | | **800,000,000** | **100 %** |

Хүснэгт26. Хувьцаа гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц

# 3.2 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

ЛэндМН ББСБ ХХК-ийн 25 % буюу 200,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган МХБ-ээр дамжуулан арилжих ба хувьцааны борлуулалтаас олох орлогыг компани үндсэн бүтээгдэхүүний санхүүжилтийн эх үүсвэрт зарцуулна.

**Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ: 5,000,000,000 төгрөг**

ЛэндМН ББСБ ХХК нь Монгол улсад өндөр хурдацтай тэлж буй финтек зах зээлийн анхдагч компани тул үйл ажиллагаа, шинэ хэрэглэгчийн өсөлт болон зах зээлийн эрэлтийг гүйцэд хангаж байх нь компанийн ирээдүйн амжилтын суурь билээ. Компани нь бизнесийн амьдралын мөчлөгийн "эхэн үедээ" явж байгаа бөгөөд Финтек бизнесийн зах зээлийн судалгаанаас харсанчилан тус салбарын хувьд "зах зээлийн тэргүүлэгч"-ийн байр суурийг хадгалахын тулд хэрэглэгчийн эрэлтийг "тогтвортой" хангаж, зорилтот зах зээлээ хурдтай тэлж байх нь маш чухал юм.

20180110

ЛэндМН аппликейшнийн түргэн шуурхай шийдэл харилцагчдын эрэлт хэрэгцээг хангаж буйн улмаас компанийн харилцагчдын тоо огцом өсч, зээлийн давтамж нэмэгдсэнээр 2018 оны эхний хагаст компанийн сарын бэлэн мөнгөний хэрэгцээ 360 саяас 1.8 тэрбум төгрөгийн хооронд байгаа нь компани бэлэн мөнгөний эх үүсвэрийг нэн тэргүүнд шийдэх шаардлагатай үндсэн шалтгаан болж байна.




График30. Бэлэн мөнгөний хэрэгцээ ба шинэ хэрэглэгчид

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө буюу үндсэн үйл ажиллагааны хүрээнд 2018 онд нийт 14 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлэх шаардлагатайгаас 5 тэрбум төгрөгийг нэмж хувьцаа гарган санхүүжүүлэхээр төлөвлөсөн бол үлдэж буй 9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг дараах хөрөнгө оруулалтын хувилбаруудаас аль хямд эх үүсвэртэйг сонгон хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэн ажиллах төлөвлөгөөтэй байна.

1. **Одоогийн хувьцаа эзэмшигч нэмэлт хөрөнгө оруулалт хийх**
   *Үнэт цаас гаргагчийн толгой компани болох Сингапур улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалт менежментийн үйл ажиллагаа эрхлэгч Анд Глобал компани нь ЛэндМН ББСБ ХХК-д нэмж 5-10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх бүрэн боломжтой бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.*

2. **Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах**
   *Үнэт цаас гаргагч нь нээлттэй өрийн хэрэгсэл гаргах боломжийг судалсан бөгөөд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах бэлтгэл ажлыг хангаад байна.*

3. **Гадаадын хөрөнгө оруулалтын сангаас хөрөнгө оруулалт татах**
*Үнэт цаас гаргагч компанид гадаадын хөрөнгө оруулалтын сангаас 5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх саналыг ирүүлсэн байгаа бөгөөд хэлэлцээрийн шатанд байна.*




График31. Нийт актив ба бэлэн мөнгөний үлдэгдэл

Дээрхи график ЛэндМН ББСБ ХХК нь ХК-ийн бүтцэд шилжин, хөрөнгө оруулалт төвлөрүүлснээр компанийн зээлийн үлдэгдэл, бэлэн мөнгөний үлдэгдэл хэрхэн өөрчлөгдөхийг харуулсан. 2016 оноос 2017 оны хооронд компани нийт 5.2 тэрбум төгрөгийн санхүүжилт төвлөрүүлсэн нь компанийн олгосон зээл болоод нийт хөрөнгийг огцом өсөхөд нөлөөлөв.

2018 оны балансын голлох үзүүлэлтүүдийн төсөөллийг сар бүрээр задлан харуулбал:




График32. Балансын бүтцийн төсөөлөл

Дээрхи графикт компанийн нийт хөрөнгө ба түүний голлох бүтэц, өр төлбөр болон эздийн өмчийг сар бүрээр харуулав. 2018 оны 2-р сард 5 тэрбум төгрөгийн энгийн хувьцааг борлуулж компанийн зээлийн эх үүсвэр болгон төвлөрүүлсэнээр компанийн эздийн өмч 83.3% өсөхөөр байна. Мөн 2018 оны туршид компани өрийн хэрэгсэл ашиглан нэмж 9 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөсөн нь компанийн нийт активыг 2017 оны эцэстэй харьцуулахад даруй 3.7 дахин нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.

2018 онд татан төвлөрүүлэх 5 тэрбум төгрөгийн хөрөнгө нь төвлөрүүлснээс хойш 3 сарын дунджаар компанийн бэлэн мөнгөний нийт хөрөнгөд эзлэх хэмжээг 27% буюу харьцангуй өндөр түвшинд хүргэж буйг дээрхи графикаас харж болно. Гэвч 2018 оны турш энэхүү хөрөнгийг зээлийн эх үүсвэрт ашигласнаар бэлэн мөнгөний үлдэгдлийг оны эцэст нийт хөрөнгийн 17% хүртэл бууруулах боломжтой.

Компанийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай мөнгөн гүйлгээний зардлуудыг нийт зардалд эзлэх хувиар доорхи хүснэгтэд харуулав. 2016 оны санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллээр компанийн мөнгөн гүйлгээний дийлэнхи буюу 93.9%-ийг зээл олгоход зарцуулсан байна. 2017 онд энэхүү үзүүлэлт өсч, нийт үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний 95.5% нь зээл олголтод зарцуулагдсан нь компанийн хөрөнгийн эх үүсвэр сайжирсантай холбоотой. Цаашид 2018 оноос энэхүү үзүүлэлтийг 98% давахаар төсөөлөгдөж байна.

| ЛЭНДМН ББСБ ХХК үндсэн үйл ажиллагаанд бэлэн мөнгөний хэрэглээний төсөөлөл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
| Гаргасан зээл | 93.96% | 95.52% | 98.21% | 98.67% | 98.80% | 98.85% | 98.92% |
| Цалин | 2.09% | 1.30% | 0.25% | 0.13% | 0.09% | 0.09% | 0.09% |
| Нийгмийн даатгал | 0.30% | 0.14% | 0.03% | 0.02% | 0.01% | 0.01% | 0.01% |
| Удирдлагын зардал | 3.40% | 2.28% | 0.42% | 0.16% | 0.12% | 0.10% | 0.09% |
| AND Systems шимтгэл | 0.00% | 0.49% | 0.35% | 0.23% | 0.15% | 0.11% | 0.09% |
| Татвар | 0.25% | 0.04% | 0.37% | 0.26% | 0.26% | 0.27% | 0.30% |
| Зээлийн хүү | 0.00% | 0.22% | 0.37% | 0.54% | 0.56% | 0.57% | 0.51% |

Хүснэгт27 Бэлэн мөнгөний хэрэглээний төсөөлөл

ЛэндМН ББСБ ХХК нь олон улсын жишиг Финтек шийдлийг Монгол улсад нутагшуулан хэрэглэгчиддээ бага, дунд хэмжээний шуурхай зээлийн үйлчилгээг хормын дотор авах боломжоор хангаан уламжлалт санхүүгийн үйлчилгээний салбарт шинэчлэлийг авч ирснээр удирдлагын зардлыг хэмнэн хөрөнгө оруулагчдын өгөөжийг нэмэгдүүлэх боломжтойг хүснэгтээс харж болно.

**Олон нийтээс татан төвлөрүүлэх 5 тэрбум төгрөгийг 100% үндсэн бүтээгдэхүүний зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт ашиглан зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлнэ.**

## 3.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

Компани өөрийн хувьцааг олон нийтэд санал болгох замаар босгосон хөрөнгийг 100% бичил хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн болгон харилцагч нартаа түгээснээр компанийн цэвэр зээлийн үлдэгдэл өсч, сар бүр шаардагдах бэлэн мөнгөний хэрэгцээг хангах юм. Нийт олгосон зээлийн өгөөж (хүүгийн орлого/ дундаж зээлийн үлдэгдэл) 2017 онд 43% байсан бол 2018 онд 62%, 2019 онд 40% байхаар төсөөлж байна. Доорхи үзүүлэнд компанийн 2017 оны сарын бодит өгөөж ба 2018 оны сар бүрийн өгөөжийн таамаглалыг үзүүлэв.




График33. Сарын хөрөнгийн өгөөж ба зээлийн үлдэгдэл

2017 онд ЛэндМН ББСБ ХХК-ийн сарын шимтгэлийн орлого нийт зээлийн үлдэгдлийн дунджийн 5.3-7.6% тэнцэх хэмжээтэй байсан бол энэхүү тооцоолол нь 2018 онд 3.7-7.0% байх төсөөлөлтэй байна. Ийнхүү 2018 онд сарын зээлийн өгөөж буурч байгаа нь компанийн харилцагчдын насжилт ахиж, урамшууллын оноо өсөнөөр дундаж харилцагчийн шимтгэл буурч буйтай холбоотой.

Ийнхүү огцом тэлж буй финтекийн шийдлээр дамжин олгогдож буй зээлийн эрэлтийг хангахын тулд ЛэндМН ББСБ 2017 онд давхардсан дүнгээр нийт 17.7 тэрбум төгрөгийн зээлийг харилцагчиддаа олгосныг сараар задлан доорхи байдлаар харуулав.




График34. 2017 оны зээлийн үйл ажиллагаа

Компани 2017 оны эцсээр 23 мянга орчим харилцагчтай болох тооцоололтой байгаа бөгөөд 2018 оны эцэст нийт харилцагчдын тоог 60 мянгад хүргэн насжилт, орлогын түвшнээр авсан зорилтот зах зээлийн 18%, нийт зээлийн үнийн дүнгээр тооцоолсон зах зээлийн багтаажийн 21% хүртэл ахиулах төлөвлөгөөтэй байна

Финтекийн шийдэл нь иргэдийн өдөр тутмын хэрэглээний зээлийн үйлчилгээг хялбаршуулж, ойртуулж байгаа гэдэг утгаараа уламжлалт санхүүгийн бизнесүүдтэй үйл ажиллагааны цар хүрээ, өсөлтийг харьцуулах боломжгүй юм. Энэ ч утгаараа уламжлалт банк, санхүүгийн байгууллагуудтай харьцуулахад хөрөнгө оруулалтын өгөөж нь харьцангуй тогтвортой өсөлттэй байх боломжтой.

LendMN аппликейшн олонд танигдахын хэрээр 2017 оны сүүлийн хагаст харилцагчдын тоо огцом өсч байгаа бөгөөд энэ нь 2018 онд хадгалагдан компанийн бүтээгдэхүүн болон харилцагчдын демографын насжилт дээшилснээр 2018 онд нийт 196.5 тэрбум төгрөгийн зээл гарах шаардлага үүсэхээр байна.




График35. 2018 оны зээлийн үйл ажиллагаа

2018 0 1 10

# ҮНЭТ ЦААСНЫ ХАНШИЙН ӨГӨӨЖИЙН ТААМАГЛАЛ

| Нэгж хувьцааны өгөөж | 2017 | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт хувьцаа (сая ширхэг) | 600 | 800 | 824 | 855 | 901 | 958 |
| Эздийн өмч (сая төгрөг) | 6,055 ₮ | 15,048 ₮ | 20,079 ₮ | 27,362 ₮ | 36,503 ₮ | 48,839 ₮ |
| Дансны үнэ | 10.1 ₮ | 18.8 ₮ | 24.4 ₮ | 32.0 ₮ | 40.5 ₮ | 51.0 ₮ |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) | 0.1 ₮ | 5.0 ₮ | 6.3 ₮ | 8.8 ₮ | 10.6 ₮ | 13.4 ₮ |
| Ашгийн суурь үнэлгээ (P/E) | 10 | 10 | 10 | 10 | 10 | 10 |
| Эздийн өмчийн суурь үнэлгээ (P/B) | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| Боломжит ханш (P/E)-д суурилсан | 1.0 | 49.9 | 63.5 | 88.2 | 105.7 | 133.8 |
| Боломжит ханш (P/B)-д суурилсан | 20.2 | 37.6 | 48.7 | 64.0 | 81.1 | 102.0 |
| Боломжит ханш (дундаж) | 10.6 ₮ | 43.8 ₮ | 56.1 ₮ | 76.1 ₮ | 93.4 ₮ | 117.9 ₮ |
| Жилийн өгөөж | | 313% | 28% | 36% | 23% | 26% |
| IPO өгөөж @ 25₮ | | 75% | 124% | 204% | 274% | 372% |
| Боломжит нийт үнэлгээ (сая төгрөг) | | 35,015 ₮ | 46,231 ₮ | 65,083 ₮ | 84,097 ₮ | 112,896 ₮ |

*2022 оныг хүртэлх жил бүрийн үнэт цаасны ханшийн таамаг: жишиг үнэлгээ P/E=10X, P/B=2*

Хүснэгт28. Хувьцааны ханшийн өгөөжийн таамаглал

Дээрхи хүснэгтэд ЛэндМН ББСБ ХХК-ийн 2022 он хүртэлх нийт хувьцааны тоо ширхэг, эздийн өмч (сая төгрөгөөр), мөн ашгийн төсөөллийг оруууллаа. Энэхүү тооцооллууд дээр тулгуурлан компанийн нэг хувьцааны ханшийн чиглэлийг тодорхойлохоор оролдож болох ба ингэхдээ бид жишиг P/E=10X болон жишиг P/B=2X үржүүлэгчдийг ашиглалаа. Тус үржүүлэгчдийг авч ашиглахдаа олон улсын финтек компаниудын жишиг харьцаа болон МХБ-ийн ТОП 20 индекст багтсан үнэт цааснуудаас хэт хөөсрөлттэй, алдагдалтай компаниудыг хасан дундажлан авсан харьцааны аль багыг авлаа.

Бидний авсан тооцооллоор олон улсын финтек компаниудын зах зээлийн үнэлгээн дээр үндэслэсэн жишиг дундаж харьцаа P/E=10X, P/B=2X[9] болон, МХБ-ийн ТОП 20 индекст багтсан үнэт цааснуудаас хэт хөөсрөлттэй, алдагдалтай компаниудыг хасан дундажлан авсан харьцааг авахад тус танилцуулгыг бэлдэх үеийн байдлаар P/E харьцаа нь хэт өндөр буюу дунджаар 47X, харин P/B харьцаа нь 3X байлаа. Бид P/E=10X, P/B=2X харьцааг жишиг болгон авч ашигласан буюу МХБ дээр арилжаалагдаж буй хувьцаат компаниудаас харьцангуй доогуур, олон улсын жишигт нийцүүлэн тооцоолж хөрөнгө оруулагчдад өгөөжийн таамаглалыг харьцангуй бодитоор харах боломжийг олгохыг зорьсон болохыг дурдах нь зүйтэй.

Компанийн боломжит ханшийг жишиг P/E, P/B болон эдгээр харьцааны дунджаар аван таамагласан байгаа нь хөрөнгө оруулагчдад олон талаас харах боломжийг олгож байгаа бөгөөд олон улсын жишигт Финтек бизнесийн ханшийн таамаглалыг гол төлөв нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг ба ханшийн харьцаанаас(P/E) авч таамагладаг болохыг онцлох хэрэгтэй.

[9] Qudian Inc P/E=11X, P/B=3X; SLM Corporation P/E=14.7X; P/B=2.2X, OneMain Holding Inc P/E=7X, P/B=1X

## САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

Компани санхүүжилтийн эх үүсвэрийг 5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн санхүүгийн чадавхиа сайжруулан харилцагчийн хүрээгээ тэлэх нь зах зээлд тэргүүлэх байр сууриа хадгалахад чухал ач холбогдолтой юм. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн чадавхид хэрхэн нөлөөлөх талаарх таамаглалыг доорхи хүснэгтүүдэд харуулсан болно.

### Хөрөнгийн эргэц *(Хүүгийн орлого / Хөрөнгө)*




График36. Хөрөнгийн эргэцийн харьцаа

Үндсэн хөрөнгийн эргэцийн харьцаа 5 жилийн турш тогтвортой өсч байгаа нь технологийн компанийн голлох давуу тал ба энэ нь компани биет хөрөнгө ба түүний элэгдэлтэй холбогдолтой зардал багатайгаар борлуулалтын орлогоо өсгөж чадаж буйг илтгэнэ. Харин нийт хөрөнгийн эргэц эхний 2 жилд (2017, 2018 онууд) огцом өсч харин 2019 болон 2020 онуудад дунджаар 30% суларч байгаа нь компанийн хэрэглэгчдийн чанар сайжирч, зээлийн шимтгэлийн хувь буурч байгааг илэрхийлнэ. Мөн 2019 оноос эхлэн зах зээл дээрхи зээлийн хүү болон салбар дундын өрсөлдөөн гэх мэт хүчин зүйлсүүд компанийн нийт хөрөнгийн эргэцийг сулруулах магадлалтай.

### Ашигт ажиллагааны харьцаа *(Ашиг / Хүүгийн орлого)*




График37. Ашигт ажиллагааны харьцаа

Компанийн хувьд 2016 он өнөөгийн бүтэц ба технологийг ашиглаж ажиллаагүй, үндсэндээ бизнесийн үйл ажиллагааны бэлтгэл үе байсан. Иймд 2016 онд компанийн зардлын хэмжээ орлогоос давсан нь ашигт ажиллагаанд

БҮРТГЭВ
№ 01

нөлөөлөн сөрөг утгатай гарсан.

Харин 2017 оноос компани ЛэндМН ББСБ ХХК нэрээр Монгол улсын анхны "Финтек шийдлийг" нутагшуулснаар харилцагчдын тоо огцом тэлж, мөн оны 11 сараас ашигт ажиллагааны бүсд шилжлээ. 2017 оны туршлага дээр суурилан компанийн амьдралын мөчлөгт үндэслэсэн бизнес төлөвлөгөөг тооцон үзэхэд ирэх 5 жилийн хугацаанд компанийн харилцагчдын зах зээл өнөөгийн тэлэлтийн хурдаа хадгалах боломжтой ба үүнтэй уялдан компанийн ашигт ажиллагааны харьцаанууд бусад салбартай харьцуулахад өндөр байх магадлалтай.

### Өгөөж *(Цэвэр ашиг / Хөрөнгө)*

График38. Өгөөж




Хөрөнгийн өгөөжийн хэмжээ ирэх 5 жилийн туршид 13-16%, хувьцаат капиталын өгөөж мөн хугацаанд 25-28% байх төсөөлөлтэй байна. Зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн шимтгэлийн орлогыг өсгөж, зардлыг тодорхой хэмжээнд барьснаар 2018 оноос эхлэн хөрөнгө болон хувьцаат капиталын өгөөжийг өрсөлдөхүйц түвшинд аваачих боломжтой. Үзүүлэнд тусгаснаар компанийн хувьцаат капиталын өгөөж ирэх 5 жилийн турш алгуурхан багасч байгаа тренд нь ирэх 5 жилд компани ашигтай ажиллахтай холбогдуулан эздийн өмч хуримтлагдсан ашгаар өсч хувьцаат капиталын өгөөжийг сулруулах хандлагатай.

### Санхүүгийн хөшүүрэг *(Нийт хөрөнгө / Эздийн өмч)*

График39. Санхүүгийн хөшүүрэг




2017 онд компанийн хэрэглэгчдийн тоо 23 мянга хүрэхээр таамагласан нь технологид суурилсан жижиглэнгийн зээлийн зах зээл хэр хурдан өсч болохыг харуулж байна. Харин 2017 онд

LENDMN
20180119

компанийн санхүүгийн хөшүүрэг өмнөх оноос төдийлөн өөрчлөгдөхгүй байгаа нь компани ихэнхи санхүүжилтыг өөрийн хөрөнгөөр буюу эздийн өмч хэсэгт бүртгэн санхүүжүүлсэнтэй холбоотой. 2018 оноос дээр дурдсан хэрэглэгчдийн зах зээлийн өсөлтийг хангахын тулд өрийн хэрэгсэл ашиглах шаардлагатай байгаа нь компанийн санхүүгийн хөшүүргийг 2020 онд 2.1 хүргэнэ гэж тооцов. Харин 2021 оноос компанийн хуримтлагдсан ашиг нэмэгдсэнээр эздийн өмч өсөх нь санхүүгийн хөшүүргийг аажмаар багасгах магадлалтай.

## Нийтлэг хэмжээст санхүүгийн тайлангууд ба 2018-2022 онуудын төсөөлөл

### Нийтлэг хэмжээст тайлан тэнцэл

| ТАЙЛАН ТЭНЦЭЛ (Сая төгрөг) | 2017 [1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах | 29.6% | 16.6% | 9.8% | 4.1% | 6.0% | 4.9% |
| Харилцагчдад олгосон нийт зээл | 65.7% | 82.8% | 91.0% | 97.2% | 96.0% | 97.8% |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц | -0.7% | -1.2% | -1.8% | -1.9% | -2.4% | -2.9% |
| Нийт цэвэр зээл | 65.0% | 81.6% | 89.1% | 95.2% | 93.6% | 94.8% |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 5.4% | 1.8% | 1.0% | 0.7% | 0.5% | 0.3% |
| **Нийт хөрөнгө** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** |
| Өр төлбөр | 14.2% | 39.9% | 51.1% | 52.3% | 51.3% | 45.9% |
| **Нийт өр төлбөр** | **14.2%** | **39.9%** | **51.1%** | **52.3%** | **51.3%** | **45.9%** |
| Эздийн өмч | 85.1% | 43.9% | 28.2% | 21.6% | 18.0% | 16.5% |
| Хуримтлагдсан ашиг | 0.8% | 16.2% | 20.6% | 26.1% | 30.6% | 37.5% |
| Өнгөрсөн оны хуримтлагдсан ашиг | -0.1% | 0.2% | 9.9% | 14.8% | 20.0% | 25.5% |
| Тайлант үеийн цэвэр ашиг | 0.9% | 15.9% | 12.7% | 13.2% | 12.7% | 14.2% |
| Тараасан ногдол ашиг | 0.0% | 0.0% | -1.9% | -1.8% | -2.0% | -2.1% |
| **Нийт эздийн өмч** | **85.8%** | **60.1%** | **48.9%** | **47.7%** | **48.7%** | **54.1%** |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** |

[1] *Хянаедэж бүү гүйцэтгэл*

Хүснэгт29. Нийтлэг хэмжээст тайлан тэнцэл

### Нийтлэг хэмжээст орлогын тайлан

| ОРЛОГЫН ТАЙЛАН (Сая төгрөг) | 2017 [1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| **Хүү ба түүнтэй адилтгах орлого** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** |
| Хүүгийн зардал | -4.1% | -9.4% | -20.6% | -24.0% | -25.2% | -23.2% |
| Зээлийн эрсдлийн сангийн зардал | -7.8% | -3.6% | -4.1% | -2.6% | -3.7% | -3.6% |
| **Цэвэр хүүгийн орлого** | **88.1%** | **87.0%** | **75.3%** | **73.4%** | **71.1%** | **73.2%** |
| Цалин | -26.7% | -7.1% | -5.5% | -4.6% | -4.6% | -4.4% |
| Бусад зардал | -45.8% | -11.5% | -7.0% | -5.7% | -5.0% | -4.3% |
| Системийн засвар үйлчилгээний зардал | -9.0% | -8.9% | -8.6% | -6.5% | -4.7% | -4.0% |
| **Нийт үндсэн үйл ажиллагааны зардал** | **-81.5%** | **-27.4%** | **-21.0%** | **-16.8%** | **-14.3%** | **-12.7%** |
| **Татварын өмнөх ашиг** | **6.6%** | **59.6%** | **54.3%** | **56.6%** | **56.8%** | **60.5%** |
| Татвар | -0.7% | -9.2% | -9.7% | -11.4% | -12.1% | -13.5% |
| **Цэвэр ашиг** | **6.0%** | **50.4%** | **44.5%** | **45.1%** | **44.7%** | **47.0%** |

[1] *Хянаедэж бүү гүйцэтгэл*

Хүснэгт30. Нийтлэг хэмжээст орлогын тайлан

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC

LENDMN

2018 ..

## Нийтлэг хэмжээст мөнгөн гүйлгээ (Орлого-100%)

| МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Сая төгрөг) | 2017 [1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| **Хүүгийн орлого** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** | **100.0%** |
| | | | | | | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | | | | |
| Гаргасан зээл | -1761.1% | -2479.5% | -3750.9% | -4269.3% | -4408.3% | -4479.1% |
| Зээлийн эргэн төлөлт | 1309.0% | 2276.1% | 3609.0% | 4159.0% | 4331.6% | 4418.6% |
| Хүүгийн орлого | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% |
| | | | | | | |
| Цалин | -26.7% | -7.1% | -5.5% | -4.6% | -4.6% | -4.4% |
| Удирдлагын зардал | -42.1% | -10.6% | -6.2% | -5.1% | -4.4% | -3.9% |
| Системийн засвар үйлчилгээний зардал | -9.0% | -8.9% | -8.6% | -6.5% | -4.7% | -4.0% |
| Татвар | -0.7% | -9.2% | -9.7% | -11.4% | -12.1% | -13.5% |
| Зээлийн хүү | -4.1% | -9.4% | -20.6% | -24.0% | -25.2% | -23.2% |
| **Нийт үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **-434.5%** | **-148.6%** | **-92.5%** | **-62.0%** | **-27.8%** | **-9.3%** |
| | | | | | | |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | | | | |
| Үндсэн хөрөнгө худалдан авалт | -9.9% | -1.9% | -0.4% | -0.4% | -0.4% | 0.0% |
| Биет бус хөрөнгө худалдан авалт | -15.5% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% |
| **Нийт хөрөнгө оруулалт** | **-25.4%** | **-1.9%** | **-0.4%** | **-0.4%** | **-0.4%** | **0.0%** |
| | | | | | | |
| САНХҮҮЖИЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | | | | | |
| Нэмж гаргасан хувьцаа | 517.4% | 63.1% | 5.1% | 4.7% | 5.3% | 5.2% |
| Нэмж авсан зээл | 164.2% | 113.6% | 93.6% | 53.8% | 39.9% | 12.8% |
| Зээлийн эргэн төлөлт | -64.7% | 0.0% | 0.0% | 0.0% | 0.0% | -2.0% |
| Ногдол ашиг [2] | 0.0% | 0.0% | -6.8% | -6.3% | -7.1% | -7.0% |
| **Нийт санхүүжилт** | **616.9%** | **176.6%** | **91.9%** | **52.2%** | **38.2%** | **9.1%** |
| | | | | | | |
| **Цэвэр мөнгөн гүйлгээ** | **156.9%** | **26.2%** | **-1.0%** | **-10.1%** | **10.0%** | **-0.1%** |
| | | | | | | |
| Эхлэл Бэлэн Мөнгө | 50.5% | 26.3% | 35.4% | 24.1% | 11.1% | 16.4% |
| Эцсийн бэлэн мөнгө | 207.5% | 52.5% | 34.4% | 14.1% | 21.1% | 16.3% |

*[1] Хуулэвдэж буй аудитлагт*

*[2] Компанийн ногдол ашгийн бодлогоор доод тал нь жилийн ашгийн 20% байхаар тусгасан*

Хүснэгт31. Нийтлэг хэмжээст мөнгөн гүйлгээ

## DuPONT ШИНЖИЛГЭЭ

DuPont шинжилгээний арга нь аливаа бизнесийн үйл ажиллагааны эздийн өмчид ногдох өгөөжийг 3 түвшинд задалж тухайн бизнесийг тодорхой цаг хугацааны туршид нэгдүгээрт ашигт ажиллагаа, хоёрдугаарт үндсэн үйл ажиллагааны оновчтой байдал, гуравдугаарт санхүүгийн хөшүүрэг гэх мэт 3 үндсэн үзүүлэлтүүдийг давхар илэрхийлдгээрээ онцлогтой.

ЛэндМН ББСБ ХХК-ийн 2017-2022 онуудын санхүүгийн бодит ба таамагласан үзүүлэлтүүд дээр хийсэн DuPont шинжилгээг доорхи хүснэгтүүдээр үзүүлэв.




Хүснэгт32. 2017 Дупонт шинжилгээ

2017 онд компанийн эздийн өмчийн өгөөж ихэд сул буюу 0.99% гарч байгаа нь ЛэндМН-ийн хөрөнгийн өгөөж болох 0.85%-ийг санхүүгийн 1.17 хөшүүргээр тодотгосон хэмээн ойлгогдож байна.




Хүснэгт33. 2018 Дупонт шинжилгээ

2018 онд компанийн цэвэр ахиуц ашиг чангарч, мөн хөрөнгийн эргэц сайжирсан нь ЛэндМН-ийн шимтгэлийн орлого огцом өссөнтэй холбоотой. Ингэснээр компанийн хөрөнгийн өгөөж 15.9%-д хүрч өнгөрсөн оны хөрөнгийн өгөөжийг 18 дахин өсгөх төсөөлөлтэй байна.Түүнчилэн компани санхүүгийн хөшүүрэг илүүтэйгээр ашиглаж байгаа нь компанийн ашигт ажиллагааг хувьцаа эзэмшигчдэд илүү өндөр өгөөж хүртэх боломжийг нээж болохоор байна.




Хүснэгт34. 2019 Дупонт шинжилгээ

2019 онд компанийн үндсэн үйл ажиллагаанд төдийлөн их өөрчлөлт орохооргүй байгаа ба хөрөнгийн өгөөж (ROA) суларч буй байдал нь компанийн хэрэглэгчдийн дундаж зээлжих чадвар сайжирснаар хүүгийн орлого сулрах магадлалтайг илтгэнэ. Гэсэн хэдий ч нэгэнт ашигтай ажиллаж буй компанийн

санхүүгийн хөшүүргийг нэмэх нь хувьцаа эзэмшигчдэд ногдох өгөөжийг 25%-аас дээш байлгах боломжтой юм.




Хүснэгт35. 2020 Дупонт шинжилгээ

2020 оноос компанийн өнөөгийн эрхэлж буй бичил зээлийн үйлчилгээ тогтворжилтийн үед шилжин санхүүгийн хөшүүрэг боломжит өндөх түвшинд байх хандлагатай бөгөөд хувьцаат капиталын өгөөж өмнөх оноос төдийлөн өөрчлөгдөхгүй хэмээн таамаглав.




Хүснэгт36. 2021 Дупонт шинжилгээ

Бизнесийн амьдралын мөчлөгийн онцлогыг авч үзвэл 2021 оноос тус бичил хэрэглээний зээлийн зах зээлд зээлж болох байр суурь тогтворжиж, тогтмол харилцагчдын сегмент хэдийнэ үүссэн байна гэж үзэж байгаа. Иймд хөрөнгийн өгөөж бага зэрэг суларч, санхүүгийн хөшүүрэг өнгөрсөн жилээс буурсан байдалтай байхаар таамаглагдаж байна.




Хүснэгт37. 2022 Дупонт шинжилгээ

2022 оноос компанийн хуримтлагдсан ашгийн хэмжээ эздийн өмчийг өсгөснөөр санхүүгийн хөшүүргийн харьцаа огцом унах хандлагатай байгаа бөгөөд нийт эздийн өмчийн өгөөж өмнөх онтой ижил түвшинд байхаар тооцоологдож байна.

## DuPont шинжилгээний тайлбар

| DuPont шинжилгээ | 2017 | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Цэвэр ахиуц ашиг | 5.97% | 50.39% | 44.53% | 45.11% | 44.73% | 47.00% |
| Нийт хөрөнгийн эргэцийн харьцаа | 0.14 | 0.32 | 0.29 | 0.29 | 0.28 | 0.30 |
| Хөрөнгийн өгөөж ROA | 0.85% | 15.94% | 12.73% | 13.15% | 12.69% | 14.19% |
| Эздийн өмчийн өгөөж ROE | 0.99% | 26.54% | 26.05% | 27.57% | 26.08% | 26.23% |
| Санхүүгийн хөшүүрэг | 1.17 | 1.66 | 2.05 | 2.10 | 2.05 | 1.85 |

Хүснэгт38. Дупонт шинжилгээний тайлбар

ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьд DuPont шинжилгээнээс энэхүү компанийн онцлогууд харагдаж байна. Үүнд

1. Цэвэр ахиуц ашиг тогтмол өсөлттэй

Шинэ технологи ба автомат шийдэлд суурилсан шинэ үеийн бизнесүүд нь хүнээс хамааралтай үндсэн үйл ажиллагааны зардал бага гэдэг утгаараа уламжлалт санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас давуу талтай.

2. Нийт хөрөнгийн эргэц тогтмол өсөлттэй

Компани хангалттай шинэ үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулахгүй байгааг илэрхийлж болох ч ЛэндМН-ийн хувьд үндсэн хөрөнгө дээр суурилалгүйгээр зах зээлийг эзлэх боломжтой технологийг эзэмшиж байгаа нь онцлог юм.

3. Эздийн өмчийн өгөөж, санхүүгийн хөшүүрэг

ЛэндМН-ийн эздийн өмчийн өгөөж нь компанийн хөшүүрэг буурсан үед ч харьцангуй өндөр буюу 25%-аас дээш байх хандлагатай байна. Тиймээс тус компани цаашид зөвхөн хувьцаанаас гадна өрийн хэрэгслээр зээлийн эх үүсвэр бүрдүүлэх нь оновчтой байх магадлалт их юм.

## 3.4 АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ




Схем9. Анхдагч зах зээлд байршуулах хуваарь

### 3.4.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

ЛэндМН ББСБ ХХК-ийн 2018 оны 01 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 18/01 тоот шийдвэрээр ЛэндМН ББСБ ХХК-ийн нэмж гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох нэг бүрийн үнийг 25 төгрөг байхаар шийдвэрлэв.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас нийтэд санал болгох үнийг тогтоохдоо 2017 оны 10 сарын 31-ний байдлаарх аудитлагдсан санхүүгийн тайлан болон Гэрэгэ Эстимэйт ХХК-с гаргасан "Бизнесийн үнэлгээ"-ний үр дүнг харгалзан үндэслэн аль болох олон хувьцаа эзэмшигч нарт эзэмшүүлэх зарчмыг баримтлан тогтоосон болно.

#### БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

ЛэндМН ББСБ ХХК-ийн 2017 оны 11-р сарын 30-ний өдрийн байдлаарх хараат бус, хөндлөнгийн бизнесийн үнэлгээг захиалагч компанитай байгуулсан 2017 оны 11-р сарын 13-ны өдрийн 2017/02 тоот гэрээний дагуу Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 274/240 тоот тушаалаар батлагдсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын хүрээнд, Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв.

Үнэлгээний зорилго нь ЛэндМН ББСБ ХХК хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох (IPO) үйл ажиллагаанд зориулж тус компанийн 100 хувийн өмчлөлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар тооцоолоход оршино.

## Үнэлгээнд ашигласан арга аргачлал

Үнэлгээний зорилготой уялдуулан *Үнэ цэнийн суурь*-д нээлттэй чөлөөт зах зээл дээр төсөөлж буй арилжаагаар хүрч болох хамгийн их магадлалтай үнийн илэрхийллийг авав.

Үнэлгээнд захиалагч компанийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангууд, хууль эрх зүйн бичиг баримтуудыг ашигласан бөгөөд захиалагч компанийн бизнесийн болон санхүүгийн загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр үнэлгээний загварыг компанийн санхүүгийн загвартай уялдуулан боловсруулав. Үнэлгээний загварын орц, төсөөллийн тооцоолол хийхэд үнэлгээний зорилготой уялдуулан болгоомжтой, хянамгай байх хандлагыг баримтлав.

Үнэлгээнд хэрэглэдэг үндсэн гурван хандлагын талаарх товч тайлбар болон тухайн аргаар хийсэн үнэлгээний талаар доор тоймлон үзүүлэв.

### 1. Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. ЛэндМН ББСБ-ын нийт хөрөнгийг үнэлэхэд барааны тэмдэгт буюу брэндийн үнэлгээг хийх шаардлагатай бөгөөд уг үнэлгээнд зардалд суурилсан болон зах зээлд суурилсан аргуудыг ашиглахад шаардагдах мэдээлэл байхгүй байна. Харин орлогын хандлагыг ашиглах боломжтой боловч энэ нь үнэлгээний ажлын зорилго болох тус компанийн бизнесийн үнэ цэнийг тооцоолох орлогын хандлагын аргачлалтай давхцаж байгаа болно. Иймд барааны тэмдэгтийн үнэлгээг тусгайлан хийж үнэлгээнд ашиглах нь ач холбогдол багатай бөгөөд хөрөнгөд суурилсан аргаар ЛэндМН ББСБ-ын бизнесийн үнэ цэнийг тогтоох тохиромжгүйг илтгэж байна.

### 2. Зах зээлийн харьцуулалтын хандлага

Монгол Улсын финтекийн зах зээл хөгжлийн эхэн үед байгаа өнөө үед ЛэндМН ББСБ-тай ижил төстэй бизнесийн мэдээлэл байхгүй байна. Харин олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа нээлттэй арилжаалдаг финтек компаниудын мэдээлэл найдвартай бөгөөд олдоцтой байна. Хэдий тийм ч ЛендМН ББСБ-ийн бизнесийн үнэлгээг олон улсын финтек компаниудын үржигдэхүүн болон санхүүгийн үзүүлэлттэй харьцуулан хийхэд 1) харьцуулалтаар авсан компаниудын үржигдэхүүнүүд нь зөрүү ихтэй (тухайлбал Үнэ, бүртгэлийн өртгийн харьцаа (Price/Book) 6,24 – 28,54 хооронд гарсан), 2) ЛэндМН ББСБ-ийн үнэлгээг гаргахын тулд олон улсын зах зээлийн болон компанийн үзүүлэлтэд хийх тохируулгын коэффициентыг тодорхойлоход хүндрэлтэй зэрэг бэрхшээлүүдтэй тулгарч байна. Иймд олон улсын хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа нээлттэй арилжаалж байгаа зарим нэр бүхий финтек компаниудыг сонгон авч үржүүлэгчийг тодорхойлж орлогын аргаар хийсэн ЛэндМН ББСБ-ын үнэлгээний үр дүнг дэмжих, харьцуулах зорилгоор ашиглав.

2018 01 19

### 3. Орлогын хандлага

Орлогын хандлага гэдэгт тухайн хөрөнгийн өмчлөлөөс олохоор тооцоолсон эсвэл олсон мөнгөн урсгалд үндэслэн үнэ цэнийг тогтоодог ерөнхий зарчимтай олон аргуудыг багтаан үзэж болно. Үнэлгээний зорилго, үнэлгээнд хамрагдсан бизнесийн онцлогийг харгалзан энэхүү үнэлгээний ажилд *Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга*, тодруулбал *Ногдол ашгийн хямдруулалтын загвар*-ыг ашиглав.

### *Үнэлгээний загварын үндсэн орц, төсөөллийн тухай*

1. Компанийн зээлийн тоо, хэмжээний ирээдүйн төсөөллийн тухай

ЛэндМН ББСБ ХХК нь 2017 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар 18,173 харилцагчдад нийт 70,860 ширхэг 12,3 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Компанийн ирээдүйд гаргах боломжит зээлийн тоо, хэмжээний талаарх төсөөллийг хийхэд суурилсан үндэслэл, зах зээлийн шинжилгээний үр дүнг доор тоймлон харуулав. Үүнд:

- ЛэндМН ББСБ нь 1 сар хүртэл богино хугацаатай хэрэглээний зээлийг гар утасны тусгай аппликэйшнээр дамжуулан харилцагчдад хүргэдэг бөгөөд зээл олгох шийдвэр гаргах, зээлийн хэмжээ, хүүг тооцоолохдоо тусгайлан боловсруулсан математик загварыг ашигладгаараа онцлог юм.
- ЛэндМН ББСБ нь одоогийн банкны болон банк бус санхүүгийн байгууллагын хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнтэй шууд өрсөлдөхөөс илүүтэй шинээр бичил зээлийн зах зээлийг өргөжүүлж ажиллана гэдэг хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл, одоогийн байдлаар санхүүгийн байгууллагаас зээл авах боломжгүй эсвэл хугацаа ихээр шаардагдах бага хэмжээний, богино хугацааны хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнийг шинээр гаргаж ажиллана гэсэн үг.
- Дэлхий дахинд энэхүү финтек буюу санхүүгийн уламжлалт үйлчилгээг орчин үеийн технологийн тусламжтайгаар маш богино хугацаанд, маш бага зардлаар хүргэдэг зах зээл нь өндөр хурдтай тэлж байна. Эрнст энд Янг компанийн 2017 онд хийсэн судалгаагаар[10] Хятад улс нь 69%-ийн финтек хэрэглээний индексээр дэлхийд тэргүүлж байна.
- Финтек бүтээгдэхүүний зах зээл нь уламжлалт санхүүгийн үйлчилгээний зах зээлээс ялгарах өвөрмөц онцлогтой бөгөөд хууль эрх зүйн хязгаарлалт багатай Ази Номхон далайн орнуудад финтекийн зах зээл нь эхний 2-3 жилд огцом өсөөд түүнээс цааш өсөлт тогтворжих хандлагатай байна. Тухайлбал, Хятад улсад интернетээр зээлийн бүтээгдэхүүн авсан хэрэглэгчдийн тоо 2013 оноос хойш огцом өсөж 2017 оны байдлаар 180 орчим сая хүрээд байгаа бөгөөд Меритз Стратеги ҮЦК-ийн судалгааны хүрээлэнгийн тооцооллоор 2020 онд тус улсын интернетээр зээл авдаг хэрэглэгчдийн тоо 220 сая хүрч, хүн амын 13-16% эзлэх ажээ[11]. Энэ жишгээр авч үзвэл Монгол Улсын финтекийн зах

[10] Ernst and Young (2017): ***Fintech Adoption Index 2017. The Rapid Emergence of Fintech.*** Retrieved 15 November 2017, from: http://www.ey.com/Publication/vwLUAssets/ey-fintech-adoption-index-2017/$FILE/ey-fintech-adoption-index-2017.pdf

[11] Meritz Strategy Daily (2017). 8 March , 2017 Issue

зээл тогтворжих үе буюу 2021, 2022 оны үед 400,000-500,000 хүнийг хамрах тооцоолол гарч байна.

- 2017 оны 11-р сарын байдлаар ЛэндМН ББСБ-ийн харилцагчдын мэдээллийн санд хийсэн судалгаагаар тус компанийн зорилтот зах зээлийг 24 – 35 насны, 700,000-аас дээш төгрөгийн цалингийн орлоготой иргэд гэж тодорхойлж болно. Үндэсний Статистикийн Хорооны судалгаагаар 2017 оны 2-р улирлын байдлаар Монгол Улсын 24-35 насны сард 700,000-1,500,000 төгрөгийн орлоготой иргэний тоо 331,981 байна [12]. Зах зээлийн шинжээчдийн багийн Фэйсбүүк аналитикс судалгаагаар 24-35 насны, Улаанбаатар хотод оршин суудаг, 1-3 хүүхэдтэй, ухаалаг гар утас ашигладаг иргэдийн тоо 210,000 орчим байна.
- ЛэндМН ББСБ нь Монгол Улсын финтек үйлчилгээний зах зээл дээр тэргүүлэх байр суурьтай ажиллахаар зорьж байна. Хэдий тийм ч бусад орнуудын туршлагаас харахад финтекийн зах зээлд өрсөлдөгчид харьцангуй богино хугацаанд нэвтэрч орж ирж байна. Монгол Улсын банкны зах зээл дээр томоохон банкууд нь дангаараа зээлийн зах зээлийн 20-25 хувийг эзэлж байна. Иймд финтек зах зээлийн тогтворжилтын үе буюу 2022-2023 он гэхэд ЛэндМН ББСБ нь финтек зах зээлийн 25%-ийг эзэлнэ гэж тооцоолов.

Дээрх шинжилгээнд үндэслэн ЛэндМН ББСБ-ын финтек бүтээгдэхүүний ирээдүйн өсөлтийн үндсэн үзүүлэлтүүдийг 2023 он хүртэл дараах байдлаар тооцоолсон бөгөөд 2023 оноос хойш тогтвортой үргэлжилнэ гэж үзсэн болно.

| Үзүүлэлтүүд | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Харилцагчдын тоо | 23 000 | 57 500 | 92 000 | 110 400 | 121 440 | 125 000 | 125 000 |
| Жилд гарах зээлийн тоо | 99 694 | 709 665 | 1 249 360 | 1 634 196 | 1 810 008 | 1 858 674 | 1 820 000 |
| Өдөрт гарах зээлийн дундаж тоо | 273 | 1 944 | 3 423 | 4 477 | 4 959 | 5 092 | 4 986 |
| Дундаж зээлийн хэмжээ (мян.төг) | 177,5 | 252,0 | 340,3 | 440,3 | 549,5 | 667,8 | 781,3 |
| Зээлийн хэмжээ (сая.төг) | 17 700 | 178 824 | 425 166 | 719 558 | 994 673 | 1 241 277 | 1 421 953 |

Хүснэгт39. Финтек бүтээгдэхүүний ирээдүйн өсөлт

- Тус таамаглалыг үнэлгээний компани ЛэндМН ББСБ ХХК-с хараат бус байдлаар тооцож гаргасан болно.

Үнэлгээний загварт ЛэндМН компанийн зээлийн болон итгэлцлийн гэрээгээр санхүүжилт татах хэмжээг өнөөгийн зохицуулалтын хүрээнд дээд хэмжээнд байхаар авч ашиглав. Хэрэв компанийн менежментийн зүгээс шаардагдах санхүүжилтийг зээлээр биш дүрмийн санг нэмэгдүүлэх замаар татах тохиолдолд өмчлөлийн үнэ цэнэ нь бидний тооцоолсон хэмжээнээс мөн өндөр гарах боломжтой.

## 2. Хорогдуулах хувийн тооцооллын тухай

[12] http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_037V2, http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_03

20180119

Ногдол ашгийн хямдруулалтын загварт авч хэрэглэсэн "Хорогдуулах хувь" гэдэг нь тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хүлээж байгаа хөрөнгө оруулалтын зардал гэж ойлгож болно. Иймд хорогдуулах хувийг тухайн хөрөнгө оруулалтын эрсдэлтэй уялдуулж тогтоодог. Хорогдуулах хувийг Бондын өгөөж дээр Эрсдэлийн урамшууллыг нэмэх аргаар (Bond-Yield-Plus-Premium-Approach) тодорхойлов. Хорогдуулах хувийг тооцоолоход дараах хүчин зүйлсийг авч үзсэн. Үүнд:

- ЛэндМН ББСБ-ийн үндсэн үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа тул тус компанийн гаднаас татсан зээлийн санхүүжилтийн хүүг хорогдуулах хувийн тооцоололд бенчмарк хүүгээр авахад тохиромжтой. Түүнчлэн, хөрөнгө оруулалтын эрсдэлийн зүгээс авч үзэхэд тус компанид хувь эзэмшлийн хөрөнгө оруулалт хийхэд зээлийн хөрөнгө оруулалт хийхтэй харьцуулахад эрсдэлийн урамшууллын зөрүү өндөр биш (3-5%) байх боломжтой.
- ЛэндМН ББСБ ХХК нь 2017 оны 11-р сард авсан 1 тэрбум төгрөгийн, жилийн 16 хувийн хүүтэй зээлийн санхүүжилтэд үндэслэн хорогдуулах хувийн бэнчмарк хүүг тогтоов.

Дээрх шинжилгээнд үндэслэн хорогдуулах хувийг дараах байдлаар 20% байхаар тооцоолж үнэлгээнд ашиглав.

*Хорогдуулах хувь (20%) = Зээлийн хүү (16%) + Эрсдэлийн урамшуулал (4%)*

### 3. Компанийн ногдол ашгийн болон хөшүүргийн бодлогын тухай

ЛэндМН компанийн өмчлөлийн үнэ цэнийг энэхүү санхүүгийн бизнесийн ирээдүйн ашигт ажиллагааны боломжид үндэслэн тооцоолсон бөгөөд санхүүгийн эх үүсвэрийн хамгийн сайн ашиглалтын зарчмыг баримталсан болно. Иймд тус компанийн менежментийн багаас баримтлах ногдол ашгийн болон хөшүүргийн бодлогын нөлөөг тусгайлан авч үзэж оруулаагүй болно бөгөөд энэ нь үнэлгээний зорилготой уялдуулан баримталсан болгоомжтой, хянамгай байх зарчимтай нийцнэ гэж үзэж байна.

Тодруулбал, компани нь өндөр өсөлтийн эхний жилүүдэд хэдийгээр өндөр ашигтай ажиллах боловч дараагийн жилүүдэд нэмэлт санхүүжилт шаардагдах тул ногдол ашиг тараахгүй байхаар үнэлгээний загварт тусгасан болно. Хэрэв компанийн менежмент нь өсөлтийн жилүүдэд ногдол ашиг тараасан тохиолдолд өмчлөлийн үнэ цэнэ нь бидний тооцоолсон хэмжээнээс өндөр гарах боломжтой.

Үнэлгээний загварт ЛэндМН компанийн зээлийн болон итгэлцлийн гэрээгээр санхүүжилт татах хэмжээг өнөөгийн зохицуулалтын хүрээнд дээд хэмжээнд байхаар авч ашиглав. Хэрэв компанийн менежментийн зүгээс шаардагдах санхүүжилтийг зээлээр биш дүрмийн санг нэмэгдүүлэх замаар татах тохиолдолд өмчлөлийн үнэ цэнэ нь бидний тооцоолсон хэмжээнээс мөн өндөр гарах боломжтой.

20180119

## Орлогын хандлагаар хийсэн үнэлгээний үр дүн

| | | |
|---|---|---|
| 1 | **Цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ** | **19,525,023,574** |
| 2 | Хөрөнгө оруулалтын дотоодын өгөөжийн хувь | **29,9%** |
| 3 | Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа, нэрлэсэн дүнгээр, жилээр | **9** |
| 4 | Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа, хорогдуулсан дүнгээр, жилээр | **11** |
| 5 | ӨМЧЛӨЛИЙН НИЙТ ҮНЭ ЦЭНЭ, төгрөгөөр | **27,851,690,241** |

Хүснэгт40. Орлогын хандлагаар хийсэн үнэлгээний дүн

ЛэндМН ББСБ-ийн өмчлөлийн нийт үнэ цэнийг 2017 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар 27 851 690 241(хорин долоон тэрбум найман зуун тавин нэгэн сая зургаан зуун ерэн мянга хоёр зуун дөчин нэгэн) төгрөг байхаар тооцоолов.

## Үнэлгээний үр дүн

Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу үнэлгээчин нь үнэлгээний үр дүнд заавал нэгээс дээш тооны үнэлгээний аргыг ашиглах ёстой гэсэн шаардлага байхгүй бөгөөд аль нэг аргын нарийвчлал болон найдвартай байдалд итгэх итгэл өндөр байхад бусад аргуудыг ашиглахыг шаарддаггүй. Дараах хүчин зүйлийг үндэслэн энэхүү үнэлгээнд орлогын хандлагын үр дүнг авч ашиглав. Үүнд:

(a) үнэлгээний ажлын нөхцөл болон зорилгоор тодорхойлогдсон тохиромжтой үнэ цэнийн суурь,
(b) боломжит үнэлгээний хандлага болон аргуудын давуу болон сул талууд,
(c) тухайн аргыг хэрэглэхэд шаардагдах найдвартай мэдээллийн олдоц ямар байсан зэрэг орно.

ЛэндМН ББСБ ХХК хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох (IPO) үйл ажиллагаанд зориулсан тус компанийн 100 хувийн өмчлөлийн үнэ цэнийг 2017 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар **27 851 690 241** (хорин долоон тэрбум найман зуун тавин нэгэн сая зургаан зуун ерэн мянга хоёр зуун дөчин нэгэн) төгрөг байхаар тооцоолов.ЛэндМН ББСБ-ийн өмчлөлийн нийт үнэ цэнийг 2017 оны 11-р сарын 30-ний өдрийн байдлаар 27 851 690 241 (хорин долоон тэрбум найман зуун тавин нэгэн сая зургаан зуун ерэн мянга хоёр зуун дөчин нэгэн) төгрөг байхаар тооцоолов.

Гэрэгэ Эстимэйт ХХК-с гаргасан "Бизнесийн үнэлгээ"-ний үр дүнд үндэслэн хувьцааг олон нийтэд санал болгохоос өмнөх нэгж хувьцааны үнэ цэнийг тодорхойлход дараах байдалтай байна.

## Орлогын хандлагаар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнэ

Нэгж: төгрөг

| | |
|---|---|
| **Орлогын хандлагаар тооцсон бизнесийн үнэ цэнэ** | **27,851,690,241** |
| **Нийт хувьцааны тоо** | **600,000,000** |
| **Нэгж хувьцаанд ногдох цэвэр үнэ цэнэ** | **46.42** |

Хүснэгт41. Нэгж хувьцааны үнэ цэнэ

ЛэндМН ББСБ ХХК-ийн нэмж гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгох үнийг 25 төгрөгөөр тогтоон нийт 200,000,000 ширхэг хувьцааг нэмж гаргахад нэгж хувьцааны үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолвол дараах байдалтай байна.

Орлогын хандлагаар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн өөрчлөлт

Нэгж: төгрөг

| Агуулга | Хувьцааны тоо | Бизнесийн үнэ цэнийн өөрчлөлт | Нэгж хувьцаанд ногдох цэвэр үнэ цэнэ |
|---|---|---|---|
| Олон нийтэд санал болгохоос өмнөх хувьцааны тоо | 600,000,000 | 27,851,690,241 | 46.4 |
| Нэмж гаргах хувьцааны тоо | 200,000,000 | 5,000,000,000 | 25.0 |
| Нийт | 800,000,000 | 32,851,690,241 | 41.1 |

Хүснэгт42. Нэгж хувьцааны үнэ цэнийн өөрчлөлт

Үнэт цаас гаргагчийн ХЭХ-ын 2018 оны 01 сарын 19-ний өдрийн 18/01 тоот шийдвэрээр нийтэд санал болгох үнийг 25 төгрөг байхаар тогтоосон байна. Энэ нь хөрөнгө оруулагч нарт үнэт цаасыг нийтэд санал болгохоос өмнөх бизнесийн үнэлгээнээс 46%, үнэт цаасыг олон нийтэд санал болгосны дараах компанийн бизнесийн үнэ цэнийн өөрчлөлттэй харьцуулахад даруй 39%-ийн өгөөж хүртэж болохуйц үнийн түвшинд санал болгогдож байна.

### 3.4.2 АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ АРГА ХЭЛБЭР

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын гуравдугаар бүлэгт заасны дагуу ТОГТООСОН ҮНИЙН АРГА-аар олон нийтэд нээлттэй арилжаална.

**Санал болгох хүрээ**

- МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 13.1.5-рт заасан буюу хувьцааны бүртгэлийн III-р ангиллын үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үнэт цаас нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн компанидаа бичгээр мэдэгдсэн байна.
- МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 13.1.4-рт заасныг мөн Үнэт цаас гаргагчийн 2018 оны 01 сарын 19-ний өдрийн 18/01 тоот ХЭХ-ын шийдвэрийг үндэслэн стратегийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгон арилжаална.
- Мэдэгдлийн загварыг андеррайтерийн компаниас гаргаж бусад үнэт цаасны компаниудад хүргүүлж болно.

**Үнэт цаасны захиалга**

- Олон нийтэд санал болгох хувьцааны захиалгыг Монголын хөрөнгийн биржийн гишүүн бүх брокер дилерийн компаниар дамжуулан авна.

20180119

- Стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг андеррайтерийн компани үнэт цаас гаргагч хамтран стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулагчдаас тусгайлан авна.
- Захиалга бүртгэлийн эхлэх, дуусах хугацааг Үнэт цаас гаргагч болон андеррайтерийн компани нь СЗХ-ноос шийдвэр гаргасны дараа МХБ-тэй хамтран тогтооно.
- Хөрөнгө оруулагч нь журамд зааснаы дагуу мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээд биш байх тохиолдолд брокерийн компанидаа мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчид санал болгосон үнэт цаас болохыг ойлгосон тухай мэдэгдлийн маягтыг баталгаажуулж өгсөний үндсэн дээр захиалга өгнө.
- Үнэт цаас гаргагчийн харилцагчдын захиалгыг Андеррайтерийн гар утасны захиалга авах аппликейшнээр дамжуулан авна.
- Үнэт цаас гаргагчийн харилцагч нь бусад үнэт цаасны компаниас сонгон үйлчлүүлж, худалдан авах захиалга өгөх бүрэн боломжтой.
- Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлэх брокер дилерийн компаниа сонгож, мэдэгдэл гаргасны дараа худалдан авах хувьцааны тоо ширхэг, үнийн дүнг тогтоож брокерт захиалгаа өгнө.

## Үнэт цаасны арилжаа

- Арилжаа явуулах хугацааг үнэт цаас гаргагч болон андеррайтерийн компани нь СЗХ-оос зөвшөөрөл гарсаны дараа МХБ-тэй хамтран тогтооно.
- Олон нийтэд санал болгох хувьцааны арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан бүх брокер дилерийн компаниас ирүүлсэн нийт захиалгын үндсэн дээр явуулна.
- Үнэт цаасны арилжааг явуулах үед олон нийтэд санал болгох хувьцааны тоо ширхэгээс худалдан авах захиалгын тоо ширхэг илүү гарсан тохиолдолд "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 29-рт зааснаы дагуу хувь тэнцүүлэх аргыг ашиглан арилжааг явуулна.
- Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгож буй үнэт цаасыг үнэт цаас гаргагчийн зүгээс стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулагч хэмээн үзсэн тухайн хөрөнгө оруулагч нарт андеррайтер хуваарилалт хийж, арилжааг явуулна.

## Олон нийтэд танилцуулах

- Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод зориулан үнэт цаас гаргагчийн танилцуулга уулзалт зохион байгуулах
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зар сурталчилгаа, мэдээллийг хүргэх, уулзалт зохион байгуулах
- Үнэт цаасны талаарх хэвлэмэл танилцуулга материалыг тараах
- Стратегийн хөрөнгө оруулагчдын хувьд андеррайтер үнэт цаасны танилцуулга хийнэ.

## Үнэт цаас худалдан авах мөнгө байршуулах

- Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг дансандаа байршуулахдаа дараах 2 аргаас сонгож байршуулах боломжтой.
  1. **Андеррайтерийн компанийн "Номиналь данс"-руу шилжүүлэх.**
     Шинээр данс нээлгэсэн дансны дугаар нь гарч амжаагүй байгаа болон өөрийн дансандаа шилжүүлэх зааварчилгаа ойлгомжгүй байгаа харилцагчдын хувьд Овог нэр, Регистрийн дугаараа гүйлгээний утга хэсэгт бичиж аль ч банкнаас шилжүүлж болно. Андеррайтер нь холбогдох гүйлгээний утгын дагуу Арилжааны Төлбөр Тооцоо ХХК-д байрлах харилцагчийн данс руу гүйлгээг хийж харилцагчид мэдэгдэнэ.
  2. **Харилцагч өөрийн нэрийн үнэт цаасны данс руу шилжүүлэх**
     Шинээр данс нээлгэсэн харилцагчид данс нээгдэж(1хоног) брокерийн компаниас 12 оронтой дансны дугаараа авсны дараа заасвын дагуу банк хоорондын шилжүүлэг хийж болно.

| | |
|---|---|
| **Хүлээн авагч банк** | Арилжааны Төлбөр Тооцоо Банк |
| **Хүлээн авагчийн дансны нэр** | Харилцагчийн өөрийн нэр |
| **Хүлээн авагчийн дансны дугаар** | ............/Данс нээлгэсэн брокероос авах / |
| **Гүйлгээний утга** | Хувьцааны мөнгө |

-

Хүснэгт43. Мөнгө байршуулах заавар

## АРИЛЖААНЫ ШИМТГЭЛ БА ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

- Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг(данс эзэмшдэг) үнэт цаасны компанитай хийсэн гэрээнд заасан хувиар хувьцааны арилжааны шимтгэл төлнө.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 19.1.3 "ногдол ашгийн орлого", 20.1.4 "Хувьцаа, бусад үнэт цаас борлуулсан орлого" –д тус хуулийн 23.2.4-т зааснаар 10 хувийн татвар ногдуулна гэж заасан байна.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1.3 "Хувьцаа үнэт цаас борлуулсаны орлого", 9.1.3 "Ногдол ашгийн орлого"-д тус хуулийн 17-р зүйлд зааснаар 10 хувийн татвар ногдуулна гэжээ.
- Дээр дурьдсан хувь хүний болон аж ахуй нэгжийн үнэт цаас борлуулсан орлогын албан татварыг арилжаанд оролцсон хувь хүн, хуулийн этгээд жилийн эцэст нэг удаа тооцоолон төлөх тухай хуульд заасан байна.

*Эх сурвалж: ХХОАТ хууль, ААНОАТ хууль*

20180119

## 3.5 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагчийн дүрэмд хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар тодорхойлохоор заасан байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах
- Компанийг татан буулгах үед үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх
- Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах
- Хуульд заасан бусад

## 3.6 ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

### АНДЕРРАЙТЕРИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч болон андеррайтерийн хооронд байгуулсан 2017 оны 11 сарын 06-ны өдрийн 201/А015 тоот "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ"-ний хавсралт 2 буюу "Ажлын даалгавар"-ын 2.2-т заасны дагуу:

*Андеррайтер нь "Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг анхдагч зах зээлд бүрэн борлуулахад дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллах бөгөөд анхдагч зах зээлд бүрэн борлогдоогүй тохиолдолд бүрэн борлуулж дуусах хүртэл хөрөнгө оруулагчдад танилцуулж, санал болгох ажлыг зохион байгуулна" хэмээн заасан байна.*

### ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

*Үнэлгээг Үнэлгээний Олон Улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэлгээний ажлын зориулалтын дагуу хийж гүйцэтгэнэ. Тайланд үнэлгээ хийсэн аргачлал, үнэлгээнд нөлөөлсөн хүчин зүйлсийн үндэслэлийг нарийн тусгасан байх бөгөөд Үйлчлүүлэгчийн хүсэлтээр аливаа нэмэлт үнэ төлбөргүйгээр гуравдагч этгээдэд өөрийн хэрэглэсэн аргачлал болон үндэслэлийг батлан харуулах үүрэг хүлээнэ.*

*Гүйцэтгэгч нь мэргэжлийн байгууллагын хувьд өөрийн гаргасан тайлангийн үнэн зөвийг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.*

20180119

## ХУУЛИЙН КОМПАНИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

*Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн оновтой менежментээр гүйцэтгэж, гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Үйлчлүүлэгчийн зөвлөхийн хувиар ажиллах бөгөөд Үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах*

*Зөвлөх нь Үйлчлүүлэгчид Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, өөрийн бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллах, гэрээний явцад гарган өгсөн зөвлөгөө үйлчилгээ, холбогдох бичиг баримт нь үнэн зөв, бүрэн гүйцэд гэдгийг үүгээр баталж байна.*

## АУДИТЫН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ

*Бидний аудитын зорилго нь санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдааны улмаас үүссэн аливаа нэг материаллаг буруу илэрхийлэл байхгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн тухайн санхүүгийн тайлан нь Компанийн санхүүгийн байдал, санхүүгийн үзүүлэлт болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, шударгаар илтгэсэн эсэх талаар Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт("СТОУС" гэх)-ын дагуу дүгнэлт гаргахад оршино.*

*Бид аудитын ажлаа Аудитын олон улсын стандартын дагуу хийнэ. Тэдгээр стандартууд нь биднээс хараат бус байх ба бидний аудиттай хамааралтай ёс зүйн бусад шаардлагуудыг биелүүлж ажиллахыг шаарддаг.*

20180119

# 3.7 ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН ДҮГНЭЛТҮҮД

**ЛэндМН ББСБ ХХК**
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгж)

Аудитлагдсан Санхүүгийн Тайлан
2017 оны 10 дугаар сарын 31

EY
Building a better working world

**АГУУЛГА**

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Хараат бус Аудиторын Тайлан

Ашиг алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан ............ 1
Санхүүгийн Байдлын Тайлан ............ 2
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан ............ 3
Мөнгөн Гүйлгээний Тайлан ............ 4

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

Санхүүгийн тайлангийн тодруулгууд ............ 1
1 Компанийн талаарх мэдээлэл ............ 5
2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого ............ 5
3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд.. 12
4 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолууд болон үнэлэмжүүд ............ 15
5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба Сегментийн мэдээлэл ............ 15
6 Удирдлагын болон үйл ажиллагааны зардал ............ 16
7 Орлогын албан татвар ............ 17
8 Нэгж хувьцаанд ногдох ашиг ............ 18
9 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө ............ 18
10 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа ............ 19
11 Биет бус хөрөнгө ............ 20
12 Үндсэн хөрөнгө ............ 21
13 Бусад хөрөнгө ............ 21
14 Хаалттай бондын өглөг ............ 22
15 Бусад өр төлбөр ............ 22
16 Хувьцаат капитал ............ 22
17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага ............ 23
18 Болзошгүй өр төлбөр ба Үүрэг хариуцлага ............ 28
19 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт ............ 29
20 Холбоотой талын ажил гүйлгээ ............ 29
21 Тайлагналын өдрийн дараах үйл явдал ............ 31
22 Өмнөх хугацааны үлдэгдлийн дахин тайлагнал ............ 32
23 Монгол хэл дээрх орчуулга ............ 32

20180119

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ЛэндМН ББСБ ХХК-ийн (өмнө нь "Дуусашгүй Үндарга ББСБ ХХК" нэртэй байсан) /цаашид "Компани" гэх/ Гүйцэтгэх захирал **Махвал овогтой Түвшинжаргал**, компанийн санхүүгийн удирдлагыг хариуцан ажилладаг ерөнхий нягтлан бодогч **Дэмбэрэлдовд овогтой Отгонгэрэл** бид 1-ээс 32 дугаар хуудаснаас бүрдсэн энэхүү санхүүгийн тайлан нь 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал болон мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант 10 сарын хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.

**М.Түвшинжаргал**
Гүйцэтгэх Захирал

**Д.Отгонгэрэл**
Ерөнхий Нягтлан Бодогч

Огноо: 2017 оны 12 дугаар сарын 8

EY
Building a better working world

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид**

---

**Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн өөрсдийн хийсэн тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг зайлшгүй өгөх эсвэл ийм тодруулга хангалттай бус бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

A member firm of Ernst & Young Global Limited

20180119

EY
Building a better working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид**

---

**Дүгнэлт**

Бид ЛэндМН ББСБ ХХК ("Компани")-ийн 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон арван сарын хугацааны ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон арван сарын хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

**Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

A member firm of Ernst & Young Global Limited

МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИЗ МОНГОЛИЯ ҮЦК
MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

20180119

ББСБ ХХК
LENDMN
УЛААНБААТАР ХОТ

EY
Building a better working world

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**ЛэндМН ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид**

---

**Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

**Бусад**

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг өөр аудитор гүйцэтгэж, уг тайланд 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр зөрчилгүй дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон 10 сарын хугацааны ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тайлбар тодруулгууд аудитлагдаагүй болно.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа юг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

**Эрнст энд Янг Монголия Аудит ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

**ПЕТР МАРКИ**
Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2017 оны 12 дугаар сарын 8

A member firm of Ernst & Young Global Limited

*ЛэндМН ББСБ ХХК*
***2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон 10 сарын хугацааны Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан***

| | Тодруулга | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлаг-даагүй) |
|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 5 | 469,100 | 1,956 |
| Хүүгийн зардал | 5 | (34,078) | - |
| **Хүүгийн цэвэр орлого** | | 435,022 | 1,956 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал | 10 | (11,590) | - |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | | 423,432 | 1,956 |
| Удирдлагын болон үйл ажиллагааны зардал | 6 | (486,558) | (1,109) |
| Бусад зардал | | (8,346) | (10) |
| **Татварын өмнөх ашиг/(алдагдал)** | | (71,472) | 837 |
| Орлогын албан татварын зардал | 7 | (1,343) | (119) |
| **Тайлант хугацааны цэвэр ашиг/(алдагдал) буюу Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)** | | (72,815) | 718 |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал) (төгрөгөөр)** | | | |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг (алдагдал) (төгрөгөөр) | 8 | (0.73) | 0.02 |

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно. 1

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA ҮЦК LLC

2018 01 19

LENDMN

*ЛэндМН ББСБ ХХК*
*2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх Санхүүгийн Байдлын Тайлан*

| | Тодруулга | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан*) |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 9 | 320,043 | 507,939 |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | 10 | 2,110,270 | 124,160 |
| Урьдчилж төлсөн орлогын албан татвар | | 240 | - |
| Бусад хөрөнгө | 13 | 44,521 | 14,700 |
| | | 2,475,074 | 646,799 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ** | | | |
| Биет бус хөрөнгө | 11 | 270,210 | 295,000 |
| Үндсэн хөрөнгө | 12 | 64,337 | 23,073 |
| | | 334,547 | 318,073 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | 2,809,621 | 964,872 |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | | |
| Хаалттай бондын өглөг | 14 | 300,200 | - |
| Бусад сан | 15 | 15,805 | - |
| Бусад өр төлбөр | 15 | 71,813 | 170,092 |
| Орлогын албан татварын өглөг | | - | 162 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | 387,818 | 170,254 |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Хувьцаат капитал | 16 | 2,500,000 | 800,000 |
| Хуримтлагдсан алдагдал | | (78,197) | (5,382) |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | | 2,421,803 | 794,618 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ** | | 2,809,621 | 964,872 |

* Энд үзүүлсэн тодорхой дүнгүүд нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн байдлын тайлантай холбоогүй бөгөөд Тодруулга 22-д толилуулсан дахин тайлагналуудыг оруулсан болно.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTSK LLC

ЛЭНДМН ББСБ ХХК
LENDMN

20180119

СЗХ
БҮРТГЭВ

*ЛэндМН ББСБ ХХК*
*2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон 10 сарын хугацааны*
*Өмчийн Өөрчлөлтийн Тайлан*

| | Тодруулга | Хувьцаат Капитал мян.төг | Хуримтлагдсан ашиг(алдагдал) мян.төг | Нийт эздийн өмч мян.төг |
|---|---|---|---|---|
| **2016.01.01-ний өдрийн байдлаар** | | 400,000 | 2,082 | 402,082 |
| Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлого (аудитлагдаагүй) | | - | 718 | 718 |
| **2016.10.31-ний өдрийн байдлаар (аудитлагдаагүй)** | | **400,000** | **2,800** | **402,800** |
| **2017.01.01-ний өдрийн байдлаар** | | **800,000** | **(5,382)** | **794,618** |
| Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй алдагдал | | - | (72,815) | (72,815) |
| Нэмж гаргасан энгийн хувьцаа | 16 | 1,700,000 | - | 1,700,000 |
| **2017.10.31-ний өдрийн байдлаар** | | **2,500,000** | **(78,197)** | **2,421,803** |

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно. 3

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA ҮЦК LLC

ЛэндМН ББСБ ХХК
LENDMN

MIRAE ASSET Securities

lendmn УНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

*ЛэндМН ББСБ ХХК*
*2017 оны 10 дугаар сарын 31-р дуусгавар болсон 10 сарын хугацааны*
*Мөнгөн Гүйлгээний Тайлан*

| | Тодруулга | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлагдаагүй) |
|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Татварын өмнөх ашиг/(алдагдал) | | (71,472) | 837 |
| Тохируулга: | | | |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал | 10 | 11,590 | - |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 6 | 8,317 | 403 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 6 | 24,790 | - |
| Хуримтлагдсан хүү | | 200 | - |
| Бусад сангийн өөрчлөлт | | 15,805 | - |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг/(алдагдал)** | | (10,770) | 1,240 |
| *Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрүүдийн өөрчлөлтүүд:* | | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны цэвэр өсөлт | | (1,997,700) | (3,000) |
| Бусад хөрөнгийн цэвэр өсөлт | | (29,821) | - |
| Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт | | 54,721 | - |
| **Үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ** | | (1,983,570) | (3,000) |
| Орлогын албан татварын төлөлт | | (1,745) | - |
| **Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ** | | (1,985,315) | (1,760) |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | | |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | 12 | (49,866) | (5,047) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | | (153,000) | (147,000) |
| Үндсэн хөрөнгө худалдан борлуулсны орлого | | 285 | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ** | | (202,581) | (152,047) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Нэмж гаргасан энгийн хувьцаанаас орсон мөнгө | | 1,700,000 | - |
| Хаалттай бонд гаргаснаас орсон мөнгө* | | 645,000 | - |
| Зээлээр авсан эх үүсвэр* | | 750,000 | - |
| Хаалттай бондын эргэн төлөлт* | | (345,000) | - |
| Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт* | | (750,000) | - |
| **Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ** | | 2,000,000 | - |
| **Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт** | | (187,896) | (153,807) |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 9 | 507,939 | 400,034 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 9 | 320,043 | 246,227 |
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ /Хүү/** | | | |
| Хүлээн авсан хүү | | 460,100 | 1,066 |
| Төлсөн хүү | | (34,078) | - |

* 2017 оны 10 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон 10 сарын хугацааны санхүүгийн үйл ажиллагааны хөдөлгөөнд хаалттай бондын хуримтлагдсан хүү 200 мянган төгрөгөөс өөр мөнгөн бус өөрчлөлт ороогүй.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC

ЛэндМН ББСБ ХХК LENDMN

20180119

**1 Компанийн талаарх мэдээлэл**

ЛэндМН ББСБ ХХК нь анх 2006 онд "Дуусашгүй Үндарга ХХК" нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2015 оны 6 дугаар сард Санхүүгийн Зохицуулах Хорооноос (цаашид "СЗХ" гэх) зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар компанийн нэр "Дуусашгүй Үндарга ББСБ ХХК" болж өөрчлөгдсөн. 2016 оны 12 сард тус компани нэрээ өөрсдийн үндсэн технологитой уялдуулан дахин өөрчилж, "ЛэндМН ББСБ ХХК" болсон. "ЛэндМН ББСБ ХХК" нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. ЛэндМН ББСБ ХХК нь СЗХ-ноос 2015 оны 6 дугаар сарын 24-ны өдөр олгосон, 1/493 тоот, банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Уг тусгай зөвшөөрлөөр Монгол Улсад зээлийн үйл ажиллагаа явуулах эрхийг олгодог болно.

*Үндсэн үйл ажиллагаа.* Компани нь өөрийн шууд толгой компани болох Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Анд Системс ХХК-ийн хөгжүүлэн гаргасан ЛэндМН технологийг ашиглан, зээлийн үйлчилгээ огт/хангалттай хэмжээнд авч чаддаггүй хүмүүст гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу 24/7 цахим зээлийн үйлчилгээг үзүүлдэг. ЛэндМН технологи нь Анд Системс ХХК-ийн хөгжүүлэн гаргасан "финтек" шийдэл бүхий технологи бөгөөд технологийн лиценз нь Анд Системс ХХК-ийн өөр нэг охин компани болох Анд Системс Тек ХХК дээр бүртгэлтэй байдаг.

Компанийн шууд толгой компани нь Анд Системс ХХК бөгөөд эцсийн толгой компани нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек гараааны компани болох Анд Глобал Пте.Лтд юм.

Компанийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 5-дугаар хороо, "Нью Майнд Групп"-ын байр.

Компанийн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн. Тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөг ("Төг")-өөр тайлагнасан.

**2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого**

*Тайлан бэлтгэх суурь ба нийцлийн мэдэгдэл.* Эдгээр санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс бэлтгэн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын (үүнд СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт ("НББОУС" болон тэдгээрийн тайлбарууд бүгд орно) дагуу, түүхэн өртгийн зарчим дээр үндэслэн бэлтгэгдсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг доор толилуулав. Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай мөрдсөн болно.

*Санхүүгийн хэрэглүүрүүд – Хэмжилтийн үндсэн нэр томьёо.* Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас нь хамааруулан бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр доор тайлбарласны дагуу бүртгэлд тусгадаг.

*Бодит үнэ цэнэ* нь ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгийг худалдах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх үнэ юм. Бодит үнэ цэнийг хамгийн сайн илэрхийлэх дүн нь идэвхитэй зах зээлийн арилжааны үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ.

Идэвхтэй зах зээлд арилжаалагддаг буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тухайн хөрөнгө болон өр төлбөрийн зарласан үнэ болон тухайн байгууллагын эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийг тоо ширхэгээр үржүүлэн гаргана. Тухайн компаний эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн тоо ширхэг нь зах зээлийн өдрийн өдөр тутмын арилжааны тоо ширхэгээс их бөгөөд позицийг нэг арилжаагаар зарах захиалга өгснөөр зах зээлийн зарласан үнэнд нөлөөлөх нөхцөл байдал үүсгэж байсан ч, энэ аргыг үүнийг ашиглах боломжтой.



2018 01 19

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

Зах зээлийн мэдээлэл хомс бүхий зарим санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд, тэдгээрийн бодит үнэ цэнийг дискаунтчилагдсан мөнгөн урсгалын аргаар эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл зэргийг үндэслэн тооцоолно. Мөн зах зээл дээрх, харилцан хамааралгүй этгээдийн хооронд саяхан хийгдсэн ажил гүйлгээний үнийг баримтлана.

Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнийг ашиглан) боломжит өгөгдлүүдийг ашиглан, үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү түлгээрлэн бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшингийн бодит үнэ цэнэ гэж тус тус ангилна.

Өртөө гэдэг нь хөрөнгийг худалдан авах үед мөнгөөр төлсөн болон бусад хэлбэрээр төлсөн төлбөрийн бодит үнэ цэнэ бөгөөд үүнд хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан ажил гүйлгээний зардлууд ч мөн багтана. Бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй эсвэл хөрөнгийн зах зээлээс үнийг нь тодорхойлох боломжгүй, өмчөөрх хөрөнгө оруулалт болон дээрхтэй адил өмчийн хэрэглүүрээр арилжаалагдах үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг өртгөөр нь хэмжинэ.

*Гүйлгээний зардлууд* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал гэдэг нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх байсан зардал юм. Гүйлгээний зардалд агент, борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад, зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг болон хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэнд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу нэмэгдэл, санхүүжилтийн зардлууд, дотоод удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

*Хорогдуулсан өртөг* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн дүнгийн аливаа эргэн төлөлтийг хасан, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардал, мөн үнийн аливаа нэмэгдэл эсвэл хөнгөлөлтийн дүнгийн, үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй бөгөөд тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох зүйлийн дансны үнэд оруулан тусгасан болно.

*Үр ашигт хүүгийн арга* нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн өдөр хүртэл дискаунтлах бол хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагдаагүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм нэмэгдэл, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
ЛЭНДМН ББСБ ХХК
LENDMN
2018 . 11 . 13

## 2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)

***Санхүүгийн хөрөнгийн ангилал.*** Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. (а) зээл болон авлага; (б) худалдан борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө; (в) дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө болон (г) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийг дотор нь 2 ангилдаг: (i) анх хүлээн зөвшөөрөх үед ийнхүү ангилагдсан, ба (ii) худалдан борлуулах зорилгоор эзэмшихээр болсон. Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн хөрөнгө нь бүгд "зээл болон авлага" хэмээн ангилагдсан болно.

***Зээл болон авлагад*** Компани ойрын ирээдүйд худалдах төлөвлөгөөгүй бөгөөд тогтмол, тодорхойлж болохуйц төлбөртэй, деривативын бус, хөрөнгийн зах зээлд бүртгэлгүй бүх санхүүгийн хөрөнгийг хамруулдаг. Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд дараах зүйлсийг СТОУС-н хэмжилтийн шаардлагын үүднээс "зээл болон авлага" хэмээн ангилсан болно: Үүнд Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө ба Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа.

***Санхүүгийн өр төлбөрийн ангилал.*** Компанийн бүх санхүүгийн өр төлбөрүүд нь бусад санхүүгийн өр төлбөрөөр хэмжин ангилах ба бүгд хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

***Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх.*** Бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр бүртгэгддэг. Анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн найдвартай нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ байдаг. Бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн хооронд зөрүү үүссэн нөхцөлд л, тухайн зөрүү дүнгээр анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг бүртгэдэг бөгөөд энэхүү бодит үнэ цэнэ нь ижил төрлийн хэрэглүүрийн саяхан арилжаалагдсан дүн болох нь эсвэл зөвхөн зах зээл дээрээс бэлэн олж болохуйц мэдээлэл дээр үндэслэж, үнэлгээний аргачлалаар тооцсон болох нь нотлогдсон байх ёстой.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("энгийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан хүлээлгэн өгөх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдаа, худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Компани санхүүгийн хөрөнгийг хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн өдрөөр тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээн зөвшөөрнө. Бусад бүх худалдан авалтыг компани санхүүгийн хэрэгслийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

***Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах.*** Компани санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг хүлээн авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) Компани хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл шаардлага хангасан, дамжуулан өгөх хэлцэлд оролцсоны үр дүнд (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлээгүй мөн авч үлдээгүй боловч хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Нөгөө тал нь хөрөнгийг бүхэлд нь гуравдагч этгээдэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр борлуулах бодит боломжгүй байгаа нөхцөлд хяналтыг авч үлдсэнд тооцно.

***Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах.*** Санхүүгийн өр төлбөрийн төлөх үүргийн хугацаа дууссан, санхүүгийн өр төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдсөн болон уг өр төлбөрийг төлөх үүрэг дуусгавар болсон үед санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна. Санхүүгийн өр төлбөрийн хугацаа дуусаагүй үед тухайн өр төлбөрийн нөхцөл их хэмжээгээр өөрчлөгдсөн үед, эсвэл зээлдүүлэгчээс хуучин өр төлбөрийнхөө оронд өөр нөхцөлтэй, шинэ өр төлбөр солих хүлээж авсан тохиолдолд, өмнөх өр төлбөрийг данснаас хасч, шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд шинэ болон хуучин болон шинэ өр төлбөрийн дансны үнийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

**2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

***Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт.*** Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бий болсон, хөрөнгийн эсвэл бүлэг хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон цаг хугацаанд найдвартайгаар тооцоолж болохуйц нөлөө үзүүлэх, нэг буюу хэд хэдэн үйл явдал үүссэн тухайн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хэрэв Компани санхүүгийн хөрөнгийг тусад нь үнэлэхэд үнэ цэнийн бууралт болсныг харуулах бодит нотолгоо байхгүй болохыг тодорхойлсон бол тухайн хөрөнгийг зээлийн эрсдлийн ижил төрлийн шинж чанартай санхүүгийн хөрөнгийн бүлэгт багтаан хамтатган үнэлдэг. Үнэ цэнийн бууралтыг илтгэх шинж байгаа эсэхийг үнэлэхдээ Компанийн харгалзан үзэх үндсэн хүчин зүйл нь эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн эсэх юм.

Түүнчлэн, үнэ цэнийн бууралт үүссэн эсэхийг илэрхийлэх бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохдоо дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ:

- Хуваарьт төлбөрийн аль нэг нь хугацаа хэтэрсэн бөгөөд хугацаа хэтрэлт нь төлбөр тооцооны системээс үүссэн саатлтай холбоогүй;
- Компанийн олж авсан мэдээллээр зээлдэгч нь санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлд орсон нь баталгаажсан; эсвэл
- улсын буюу орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал зээлдэгчид нөлөөлөхүйцээр өөрчлөгдсөнөөс зээлдэгчийн төлбөр төлөлтийн байдал муудсан.

Тодруулга 10-д тайлбарласнаар харилцагчдад олгосон зээлүүд нь богино (1 сар хүртэл) хугацаатай бөгөөд тайлагналын өдрөөс энэхүү санхүүгийн тайлангууд батлагдахаас өмнөх өдөр хүртэлх хугацаанд хугацаа хэтрээгүй эсвэл маш бага хугацаа хэтрэлттэй байсан. Тиймээс тусгайлсан үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын нөөцийг бүртгэх нөхцөл байдал үүсээгүй юм. Иймд харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлэх аргачлал дээр үндэслэж хийдэг.

Хэрэв хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бөгөөд түүний гэрээний нөхцлийг өөрчлөн тохиролцсон эсвэл нөхцлүүдийг зээлдэгч эсвэл үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал муудсаны улмаас өөрчилсөн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг нөхцөл байдал өөрчлөгдөхийн өмнөх үр ашигт хүүг ашиглан тооцно.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг нөөцийн сангийн дансанд бүртгэж, хөрөнгийн дансны үнийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын (зээлийн ирээдүйн хэрэгжээгүй алдагдлыг оруулаагүй дүнгээр) анхны үр ашигт хүүгээр тооцсон өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэнэ.

Хэрэв үнэ цэнийн бууралтын алдагдлын дүн дараагийн тайлант үеүдэд буурсан бөгөөд алдагдлын уг бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон бодит үйл явдалтай холбох боломжтой бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант хугацааны үнэ цэнэ бууралтын сангийн дансаар буцаана.

Хөрөнгийг нөхөн төлүүлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан бөгөөд алдагдлын дүн тодорхой болсны дараа найдваргүй болсон авлагыг үнэ цэнийн бууралтын санг ашиглан данснаас хасна. Өмнө нь найдваргүй гэж тодорхойлогдон данснаас хасагдсан авлага эргэн төлөгдсөн тохиолдолд эргэн төлөгдсөн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтын алдагдлын дансны кредитэд бичнэ.

***Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө.*** Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд кассан дахь бэлэн мөнгө, банкинд байршуулсан хугацаагүй хадгаламжууд, мөн банкуудад 3-аас доош сарын хугацаатай байршуулсан, өндөр хөрвөх чадвар бүхий мөнгөн хөрөнгүүд орно. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хязгаарлалт бүхий балансууд нь мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд тусгагддаггүй.

***Үйл ажиллагааны түрээс.*** Компани нь түрээсийн гэрээнд түрээслэгчээр оролцож, өмчлөлийн ихэнх эрсдэл болон өгөөж нь түрээслүүлэгчээс Компанид шилжин ирээгүй тохиолдолд түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилж, тухайн тайлант хугацааны орлого, үр дүнгийн тайланд (түрээсийн зардлаар) бүртгэнэ.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
LENDMN
ЛэндМН ББСБ ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
СЗХ



**2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Хэрэв хөрөнгийг үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хуваарилан түрээсийн орлогоор бүртгэнэ.

***Үндсэн хөрөнгө.*** Компанийн эзэмшиж буй үндсэн хөрөнгүүдийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тусгана. Урсгал засвар, үйлчилгээний өртгийг гарсан үед нь зардлаар бүртгэнэ. Үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн томоохон бүрэлдэхүүн хэсгийг шинэчлэсэн бол, холбогдох өртгийг капиталжуулж, хуучин сольсон хэсгийн дансны үнийг зарлагадана.

Тайлант хугацааны эцэст удирдлага үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх аливаа үзүүлэлт байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв ийм үзүүлэлт байгаа нөхцөлд хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох ба энэ хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр тодорхойлогддог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулан үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэдэг. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан тооцоолол өөрчлөгдсөн нөхцөлд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно.

Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг дансны дүнтэй харьцуулан тооцож, тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ (үйл ажиллагааны бус орлого, зардал хэсэгт).

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

| | Ашиглагдах хугацаа, жилээр |
|---|---|
| Тавилга, эд хогшил, оффисын тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Компьютер ба техник тоног төхөөрөмж | 3 жил |

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь хөрөнгө хуучирсан, ашиглагдах хугацаа нь дууcч буй гэж үзвэл Компани хөрөнгийг борлуулснаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнг хэлнэ. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст хянаж, шаардлагатай гэж үзвэл өөрчилнө.

***Биет бус хөрөнгө.*** Гүүдвилээс бусад биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд Компанийн үндсэн биет бус хөрөнгө нь лиценз юм.

Худалдан авсан компьютерийн програм хангамжийн лицензүүдийг өртөг дээр тэдгээрийг ашиглахад бэлэн болгохтой холбогдон гарсан зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгүүдийг тэдгээрийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна:

| | Ашиглагдах хугацаа, жилээр |
|---|---|
| ЛэндМН технологийн лиценз | 10 жил |

Үнэ цэнэ нь буурсан бол биет бус хөрөнгийн дансны үнийг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон түүний бодит үнэ цэнээс борлуулах зардлыг хассан дүнгийн аль их дүн хүртэл бууруулна.

***Орлогын албан татвар.*** Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэглэгдэж байсан, хэрэгжих нь тодорхой болсон хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд үг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл шууд өмчид бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC
20180119
120
ЛэндМН ББСБ ХХК
LENDMN

**2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдох ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталгаажуулсан гэж тооцож татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогоос бусад зүйлд ногдуулсан албан татваруудыг үйл ажиллагааны зардал хэсэгт бүртгэдэг.

Хойшлогдсон орлогын татварыг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлагналын зорилгоор тооцогдсон бүртгэлийн үнийн түр зөрүүн дээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өглөгийг бүх татварт тооцогдох түр зөрүүн дээр хүлээн зөвшөөрнө. Татвар тооцогдох түр зөрүү болон татварын алдагдлыг шилжүүлэх зорилгоор хойшлогдсон татварын хөрөнгүүд нь татвар тооцогдох болох татварын ирээдүйн орлогын боломжит хэмжээгээр бүртгэгдэнэ.

***Татварын тодорхой бус байр суурь.*** Компанийн татварын тодорхой бус нөхцөл байдлын талаар удирдлага тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзнэ. Татварын албанаас авч хэлэлцэж байгаа татварын тодорхой бус нөхцөл байгаа үед удирдлага татварын өглөгийн дүнг тодорхойлохдоо нэмэлт татварын ногдуулалт үүсэх нөхцөлийг илүүд тооцож бүртгэдэг. Үнэлгээ нь тайлант үеийн эцэст хэрэглэгдэж байсан, үндсэндээ хэрэгжих нь тодорхой болсон хууль тогтоомжийн тайлбар эсвэл шүүх болон тухайн асуудлын талаарх бусад зохицуулалтыг үндэслэн хийгддэг. Тайлант хугацааны эцэст орлогоос бусад зүйлс дээр төлөх төлбөр торгууль, алданги хүү, татвар хураамжтай холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхдөө түүнийг барагдуулахад гарах зарцуулалтын талаар удирдлагын хамгийн сайн үнэлгээнд үндэслэн тооцоолно. 2017 оны 10 дугаар сар 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр компанийн удирдлага татварын тодорхой бус байр сууръд зориулж сан байгуулах шаардлагагүй гэж үзсэн.

**Нэмэгдсэн өртгийн албан татвар.** Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа нь (зээл олголт г.м) НӨАТ-с чөлөөлөгдсөн байдаг ба Компанийн удирдлага Компанид санхүүгийн бус үйлчилгээнээс үүдэлтэй НӨАТ-ын өр төлбөр байхгүй хэмээн дүгнэсэн болно. Тиймээс, 2017 оны 10 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, компани нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй болно.

***Өр төлбөр болон зардлын сан.*** Өр төлбөр болон зардлын сан нь төлөгдөх хугацаа болон хэмжээ нь тодорхой бус санхүүгийн бус өглөг юм. Компани урьд нь тохиосон үйл явдлын үр дүнд өнөөгийн эрх зүйн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд уг үүргийг биелүүлэхэд эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг төлөх магадлалтай, мөн уг үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжтой тохиолдолд зардлын санг хуримтлуулан байгуулна.

**Бусад өглөг.** Бусад өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан тооцож хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

***Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт.*** Хүүгийн орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцлүүдийг хэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. ЛэндМН зээл олголт бүрт ногдуулах хураамжийн орлого нь хүүний орлого гэж нэрлэгдэхгүй боловч үр ашигт хүүний нэг хэсэг юм.

Зээл болон бусад өрийн хэрэгслүүдийн эргэн төлөгдөх магадлал бага болсон үед тэдгээрийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэх бөгөөд түүнээс хойш өнөөгийн үнэ цэнийн өсөлтийг тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын алдагдлыг тооцоход ашигласан үр ашигт хүүгийн үндсэн дээр тооцоолох хүүгийн орлогоор бүртгэдэг.

СЗХ
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
№ 01



**2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг ерөнхийдөө аккруэл суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн байгаа үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

***Хувьцаат капитал.*** Энгийн хувьцааг эздийн өмч гэж ангилдаг. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварын дараах орлогоос хасах дүнгээр эздийн өмчид тусгадаг.

**Гадаад валютын хөрвүүлэлт.** Компанийн үйл ажиллагааны валют нь түүний үйл ажиллагаагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны валют юм. Компанийн үйл ажиллагааны болон тайлагналын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм.

Мөнгөн зүйлст тооцогдох хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлүүдийг тайлант хугацааны хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй.

***Хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах.*** Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө.

**Ажиллагсадын зардал болон холбогдох шимтгэлүүд.** Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Компанийн ажиллагсад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт болон нөхөн олговортой бусад болино хугацаат хуримтлагдах чөлөө авалтыг ажиллагсад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Компанийн ажиллагсад чөлөө авалтыг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авалтыг) чөлөө авах үед тус тус хүлээн зөвшөөрдөг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу тэтгэврийн, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар бүртгэдэг. Энд дурьдсан улсын тогтмол шимтгэлтэй сангуудад болон тогтмол шимтгэлтэй хөтөлбөрт төлдөг төлбөрүүдээс гадна Компани өөр ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмжийн төлбөр хийх хууль эрх зүйн буюу зохиомол үүрэг хүлээгээгүй болно.

***Нэгж хувьцаанд ногдох ашиг.*** Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг (алдагдал)-г Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох ашиг буюу алдагдлыг тайлант хугацааны турш орлцоотой байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хувааж гаргана. Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг (алдагдал)-г Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)-г (хувьцаанд хөрвөх давуу эрхтэй хувьцааны хүү эсвэл хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондын хүүгийн татварын дараах зардлуудаар тохируулсан) тайлант хугацааны турш оролцоотой байсан жигнэсэн дундаж энгийн хувьцааны тоон дээр энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бүх хэрэгслүүдийг хөрвүүлэхэд нэмэгдэх үүсэх боломжит энгийн хувьцааны тоог нэмж гаргасан нийт энгийн хувьцааны тоонд хувааж гаргана.

***Сегментийн тайлагнал.*** Үйл ажиллагааны сегментүүдийг компанийн үйл ажиллагааны гол шийдвэр гаргагчдад бэлтгэн өгдөг тайлан мэдээллийн дагуу санхүүгийн тайландаа тайлагнадаг. Нийт сегментүүдийн орлого, үр дүн болон хөрөнгийн 10 ба түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлж буй сегментийг тусад нь тайлагнана.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC
ЛэндМН ББСБ ХХК
LENDMN
УЛААНБААТАР ХОТ

**2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

***Холбоотой талуудын ажил гүйлгээ.*** Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(а) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
- (i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
- (iii) Компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(б) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:
- (i) Аж ахуй нэгж болон Компани нь нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- (ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох Компанийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- (iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- (iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
- (v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлалтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
- (vi) Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- (vii) (а)(i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн)гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- (viii) Аж ахуй нэгж нь эсвэл Компанийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг харгалзахдаа зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан болно.

Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 20-с харна уу.

**3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд**

Компани 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсан бүртгэлийн бодлогуудаа энэ санхүүгийн жилд тууштай мөрдөж байгаа болно.

<u>Шинэ болон өөрчлөгдсөн стандарт болон стандартын тайлбарууд</u>

| | |
|---|---|
| • НББОУС 7 Нэмэлт өөрчлөлт | *Мөнгөн гүйлгээний тайлан: Толилуулгын санаачилга* |
| • НББОУС 12 Нэмэлт өөрчлөлт | *Орлогын албан татвар: Бодит бус алдагдалд хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөх* |
| • СТОУС 12 Нэмэлт өөрчлөлт | *Бусад аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалтын толилуулга: 2014-2016 СТОУС-үүдэд жил бүр хийгддэг сайжруулалтуудад орсон, СТОУС 12-н хамрах хүрээний нэмэлт тайлбар* |
| • СТОУС 14 | *Зохицуулах байгууллагатай холбоотой хойшлуулсан данс* |

Дээрх шинэ стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй.

3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)

<u>Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд</u>

Шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн боловч хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаа нь хараахан болоогүй байгаа Стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлтүүдийг доор жагсаасан бөгөөд Компани тэдгээрийг хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаанаас нь эхлэн нягтлан бодох бүртгэлдээ мөрдөхөөр төлөвлөж байна:

| | |
|---|---|
| • СТОУС 2 Нэмэлт өөрчлөлт | *Хувьцаанд суурилсан төлбөрийн ангилал болон хэмжилт*[1] |
| • СТОУС 4 Нэмэлт өөрчлөлт | *СТОУС 4 Даатгалын гэрээтэй санхүүгийн хэрэглүүр*[1] |
| • НББОУС 40 Нэмэлт өөрчлөлт | *ХОЭТХХ-н шилжүүлэг*[1] |
| • СТОУС 10 болон НББОУС 28 Нэмэлт өөрчлөлт | *Хөрөнгө оруулагч болон Хараат компани/Хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт болон хөрөнгөөрх хөрөнгө оруулалт*[4] |
| • СТОУС 9 | *Санхүүгийн хэрэглүүр*[1] |
| • СТОУС 15 | *Харилцагчтай байгуулсан гэрээний орлого*[1] |
| • СТОУС 16 | *Түрээс*[2] |
| • СТОУС 17 | *Даатгалын гэрээ*[3] |
| • СТОУСТХ 22 | *Гадаад валютаарх ажил гүйлгээ болон Урьдчилж төлсөн төлбөр*[1] |
| • СТОУСТХ 23 | *Орлогын албан татварын тодорхой бус асуудлууд*[2] |
| • 2014-2016 жилийн СТОУС-н ээлжит сайжруулалт | *СТОУС-уудын 2016 оны 12 дугаар сард хэвлэн гаргасан нэмэлт сайжруулалтууд*[1] |

1 *2018 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхлэн мөрдөгдөнө*
2 *2019 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхлэн мөрдөгдөнө*
3 *2021 оны 1 дүгээр сарын 1 ба түүнээс хойш эхлэх тайлант хугацаанаас эхлэн мөрдөгдөнө*
4 *Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хугацаа нь хараахан тодорхой болоогүй. Аж ахуйн нэгжүүд хугацаанаас нь өмнө мөрдөж болно.*

Компанийн санхүүгийн тайланд хамааралтай байж болох СТОУС-уудын талаарх нэмэлт мэдээллүүд:

(а) Санхүүгийн Хэрэглүүрүүд

СТОУС-н Зөвлөл 2014 оны 9 сард СТОУС 9-н сүүлийн хувилбарыг хэвлэлтэн баталсан. Энэхүү стандарт нь санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон хэмжилт, үнэ цэнийн бууралт, болон хэджийн бүртгэлийг шинэчлэсэн. Компани СТОУС 9-г 2018 оны 1-р сарын 1-с мөрдөж эхэлнэ. СТОУС 9-г мөрдсөнөөр санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллүүдийг доор хураангуйлан харуулав:

(i) Ангилал ба хэмжилт

Компани нь СТОУС 9 –г мөрдсөнөөр санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал болон хэмжилтэнд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Тухайлбал, гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилго бүхий бизнесийн загварт багтах өрийн хэрэглүүрүүдийг, хэрэв тус өрийн хэрэглүүрүүдийн мөнгөн гүйлгээ нь гол төлөв үндсэн ба хүүгийн төлбөрөөс бүрдэж байвал, хүлээн зөвшөөрсөн үеэс эхлэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

(ii) Үнэ цэнийн бууралт

СТОУС 9-ийн шаардлагаар СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнэ нь орлого, үр дүнгийн тайланд бүртгэгддэггүй түрээсийн авлага, зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны гэрээ, хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгддэг зээлийн хэрэгсэлд байгуулах үнэ цэнийн бууралтын алдагдлыг ирээдүйн 12 сараар эсвэл ашиглалтын хугацаагаар хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвар дээр үндэслэн бүртгэнэ. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварын хэрэгтээ нь үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх хэмжээг ихэсгэх ба учир нь НББОУС 39-ийн дагуу үнэ цэнийн бууралтыг зөвхөн бодит нотолгоон дээр үндэслэн тооцохтой харьцуулахад уг загвар нь санхүүгийн хөрөнгийг анх бүртгэхдээ ирээдүйн 12 сард хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү байдлаар үнэ цэнийн бууралтын алдагдлын санг байгуулдаг.

**3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон Толилуулгад орсон өөрчлөлтүүд (Үргэлжлэл)**

Гүйцэтгэх удирдлага СТОУС 9-ийг нэвтрүүлснээр ирээдүйд компанийн санхүүгийн үзүүлэлт, санхүүгийн хөрөнгийн хүрээнд тайлагнах дүнгүүдэд нөлөөлж, СТОУС 9-ийн дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар зээлийн эрсдлийн алдагдлын сан урьдчилан байгуулахаар төлөвлөж байна. Компани уг стандартыг нэвтрүүлэхдээ санхүүгийн хэрэглүүрт хүлээгдэж буй зээлийн алдагдлын ойролцоолсон тооцоолол илүү нарийн дүн шинжилгээ хийж, ирээдүйн хүчин зүйлсийг багтаан бүх холбогдох мэдээллийг ашиглан гүйцэтгэнэ.

(б) Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

СТОУС 15 нь харилцагчидтай хийсэн гэрээнээс үүдэлтэй орлогыг тооцох шинэ таван алхам бүхий загварыг бий болгосон. СТОУС 15-ын дагуу орлогыг бараа бүтээгдэхүүн борлуулсан эсвэл үйлчилгээг үзүүлсний үр дүнд Компанийн хүлээж авахаар хүлээгдэж буй төлбөрийг тусгасан дүнгээр хүлээн зөвшөөрнө. СТОУС 15-ын зарчмууд нь орлогыг хэмжих, хүлээн зөвшөөрөх илүү зохион байгуулалттай арга барилаар хангасан. Тус стандарт нь нийт орлогын задаргааг, гүйцэтгэлийн үүргийн тухай мэдээлэл, гэрээний хөрөнгө ба өр төлбөрийн дансны үлдэгдлийн өөрчлөлт болон гол үнэлэмж ба тооцооллуудыг санхүүгийн тайланд толилуулах тоон болон чанарын шаардлагуудыг багтаасан. Уг стандарт нь СТОУС-ын дагуу одоогийн байдлаар мөрдөгдөж буй бүх орлого хүлээн зөвшөөрөх шаардлагыг орлоно. Компани СТОУС 15-г 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Компанийн удирдлага нь СТОУС 15-г мөрдсөнөөр санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

(в) Валютын ханшийг тодорхойлох ажил гүйлгээний огноо

СТОУТХ-тайлбар 22 нь гадаад валютаар төлсөн буюу хүлээн авсан урьдчилгаа төлбөрийн валютын ханшийг тодорхойлох зорилгоор ажил гүйлгээ гарсан өдрийг тодорхойлно. Тайлбар нь 2018 оны 1 дүгээр сарын 1-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө. Компани 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тус тайлбарыг мөрдсөнөөр санхүүгийн байдал болон санхүүгийн үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

(г) Орлогын татварын зардал

СТОУТХ-тайлбар 23 нь орлогын татварын бүртгэлийн эргэлзээний нөлөөг хэрхэн шийдвэрлэхийг тусгасан НББОУС12 Орлогын татварт тавигдах шаардлагыг дэмждэг. Тус тайлбар нь 2019 оны 1 дүгээр сарын 1-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүдэд мөрдөгдөнө. Компани 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тус тайлбарыг мөрдсөнөөр санхүүгийн байдал болон санхүүгийн үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

## 4 Нягтлан бодох бүртгэлийн гол тооцооллууд болон үнэлэмжүүд

Компани нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд нөлөөлөх таамаглал болон тооцоолол хийдэг. Тооцоолол болон үнэлэмжүүдийг тасралтгүй хянаж, дахин үнэлдэг бөгөөд энэ нь удирдлагын туршлага болон нөхцөл байдалд зохистой гэж үзсэн ирээдүйн үйл явцын талаарх хүлээлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүд дээр суурилдаг. Удирдлага нь тооцооллоос гадна, нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэх явцад өөрсдийн үнэлэмжийг хийх шаардлагатай болдог. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнд хамгийн их нөлөөлөх үнэлэмжүүд болон дараагийн тайлант хугацааны хөрөнгө, өр төлбөрийн дансны дүнд ихээхэн нөлөө үзүүлэх тооцооллуудыг нэгтгэн толилуулж байна:

***Зээл болон авлагын үнэ цэнийн бууралтын алдагдал.*** Компани гаргасан зээлүүдийн үнэ цэнэ нь буурсан эсэхийг бүлгээр нь тогтмол шалгадаг. Компани тайлант хугацаанд үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг тогтоохдоо зээл бүрийг тус тусад нь авч үзэхээсээ өмнө, эхлээд бүлгээр нь авч үзэн, уг бүлгийн ирээдүйн мөнгөн урсгал нь хэмжигдэхүйц хэмжээнд буурсныг илтгэх мэдээлэл байгаа эсэх дээр үнэлгээ хийнэ. Үнэ цэнийн бууралтыг илтгэх мэдээлэлд зээлдэгчийн эргэн төлөлтийн байдалд сөрөг өөрчлөлт гарсан, эсвэл улс орны эдийн засгийн өөрчлөлт нь зээлийн авлагууд эргэн төлөгдөхгүй байгаатай шууд холбоотой гэх мэт мэдээллүүд багтана.

Удирдлага нь хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалын төлөвийг ижил төрлийн зээлийн эрсдлийн шинж чанартай хөрөнгүүдийн түүхэн алдагдлын мэдээлэл болон ижил төрлийн хөрөнгүүдийн үнэ цэнийг бууралтыг илтгэх бодит нөхцөл байдлууд дээр үндэслэн тооцоолон гаргана. Ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон цаг хугацааг тооцоолон гаргахад ашигласан арга болон тооцооллуудыг тогтмол хугацаанд эргэн хянаж, тооцоолсон дүн болон бодит алдагдлын дүнгийн зөрүүг аль болох багасгаж хорьдог.

Бодит алдагдлын дүн нь тооцоолсон алдагдлын дүнгээс 20%-р их эсвэл бага гарах тохиолдолд, зээлийн авлагын үнэ цэнийн бууралтын алдагдлын дүнг 2,318 мянган төгрөгөөр (2016: 0) ихэсгэх эсвэл багасгах болно. Дангаараа том үнийн дүнтэй зээлийн авлагуудын үнэ цэнийн бууралтын алдагдлын тооцоолол нь тухайн зээлийн эргэн төлөгдөх дүнг харгалзан үзэж, ирээдүйн мөнгөн урсгалын дискаунт-чилагдсан дүн дээр суурилна.

***Биет бус хөрөнгө.*** Компанийн биет бус хөрөнгө нь Монгол улсын нутаг дэвсгэрт зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай эрх бүхий 50 жилийн хугацаатай ЛэндМН системийн лицензээс бүрдэнэ. Удирдлага лицензийг ашиглахаар хүлээж буй хамгийн сайн тооцоололдоо үндэслэн лицензийн ашиглалтын хугацааг 10 жил байна гэж тооцоолсон. Хүлээгдэж буй ашиглах хугацаа болон технологийн дэвшлийн өөрчлөлт нь лицензийн ашиглалтын хугацаанд нөлөөлж болох ба ирээдүйд хорогдуулгын хугацаанд өөрчлөлт хийхэд хүргэж болзошгүй юм.

## 5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба Сегментийн мэдээлэл

2017 болон 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаанд Компани бизнесийн нэг сегментэд үйл ажиллагаа явуулсан бөгөөд энэ нь Монгол улсын нутаг дэвсгэрт иргэдэд шуурхай зээлийн үйлчилгээ үзүүлэх юм. Компанийн гол шийдвэр гаргагчдад мэдээллэсэн мэдээлэл нь Компанийн нөөцийг нэгтгэсэн мөн үйл ажиллагааны сегментийн санхүүгийн мэдээлэл байхгүй тул нөөцийн хуваарилалт ба гүйцэтгэлийн үнэлгээний зорилгоор Компанийн үйл ажиллагааны үр дүнг бүхэлд нь авч үздэг. Тиймээс, үйл ажиллагааны сегменттэй холбоотой мэдээлэл тусгагдаагүй болно. Компанийн үндсэн үйл ажиллагаа болон үйлчлүүлэгчид нь Монгол улсын нутаг дэвсгэрт байршсан тул газар зүйн сегментийн мэдээлэл мөн тусгагдаагүй болно. 2017 болон 2016 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацаанд Компанийн орлогын 10 ба түүнээс дээш хувийг дангаараа бүрдүүлсэн харилцагч байгаагүй.

**5 Хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого ба Сегментийн мэдээлэл (үргэлжлэл)**

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг-даагүй) |
|---|---|---|
| Хүүгийн орлого | | |
| Банкинд байршуулсан харилцах, хадгаламж | 13,431 | 1,941 |
| Бусад хүүгийн орлого | 1,645 | - |
| ЛэндМН шимтгэлийн орлого | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа - ЛэндМН систем | 454,024 | 15 |
| **Нийт хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого** | 469,100 | 1,956 |
| Хүүгийн зардал | | |
| Хэвлэгдсэн бонд болон зээлийн хүү | (34,078) | - |

ЛэндМН шимтгэлийн орлого нь ЛэндМН системээр олгогдох байгаа зээлийн нэг удаагийн шимтгэлийн орлогыг илэрхийлдэг. Энэхүү шимтгэлийн орлого нь СТОУС-ын дагуу үр ашигт хүүгийн нэг хэсэг бөгөөд тухайн зээлийн гэрээний хугацаанд хойшлогдон бүртгэгддэг.

**6 Удирдлагын болон үйл ажиллагааны зардал**

| | Тодруулга | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг-даагүй) |
|---|---|---|---|
| Цалингийн зардал | | 145,686 | - |
| Зар сурталчилгаа, маркетингийн үйлчилгээний зардал | | 127,860 | - |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | | 55,854 | 300 |
| ЛэндМН системийн засвар үйлчилгээний зардал (Тодруулга 20) | | 35,153 | - |
| Биет бус хөрөнгийн хорогдол | 11 | 24,790 | - |
| Бусад сангийн зардал | 15 | 15,806 | - |
| Түрээсийн зардал | | 15,693 | - |
| Нийгмийн даатгалын шимтгэл | | 15,687 | - |
| Банкны шимтгэл | | 10,697 | 20 |
| Засвар үйлчилгээний зардал | | 8,359 | - |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 12 | 8,317 | 403 |
| Бусад зардал | | 22,677 | 386 |
| **Нийт удирдлагын болон үйл ажиллагааны зардал** | | 486,558 | 1,109 |

## 7 Орлогын албан татвар

Тухайн хугацаанд орлого, үр дүнгийн тайланд бүртгэгдсэн орлогын албан татварын зардлыг доор үзүүлэв:

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг-даагүй) |
|---|---|---|
| Тайлант хугацааны орлогын албан татвар | 1,343 | 119 |
| Тайлант хугацааны орлогын татварын зардал | 1,343 | 119 |

Компани орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийг орлогын татвар ногдохгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тохируулга хийх замаар тооцон бүртгэдэг. Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 3 тэрбум (2016: 3 тэрбум) хүртэлх төгрөгний албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3 тэрбум (2016: 3 тэрбум) төгрөгнөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар (2016: 25 хувь) орлогын албан татвар төлдөг.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Компанид хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв.

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг-даагүй) |
|---|---|---|
| Татварын өмнөх ашиг (алдагдал) | (71,472) | 837 |
| Хуулиар заасан 10 хувиар тооцсон татварын зардал (2016: 10%) | (7,147) | 84 |
| Татварын нөлөө: | | |
| - Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох хүүгийн орлого | 1,343 | 119 |
| - Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал | 2,286 | - |
| - Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татвар | 4,861 | (84) |
| Тайлант хугацааны орлогын албан татварын зардал | 1,343 | 119 |

СТОУС болон Монгол Улсын татварын хууль, тогтоомжуудын хооронд тайлагналын зорилгоос үүдэн санхүүгийн тайлангийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар тооцох суурь хооронд түр зөрүү үүсдэг.

Компани энэ тайлант хугацаанд 48,610 мянган төгрөгийн татварын алдагдалтай (2016: 0) байсан ба энэ нь дараагийн 2 санхүүгийн жилийн татвар ногдох орлогод шилжүүлэн тооцох боломжтой. Шилжүүлсэн алдагдлын дүн нь тухайн тайлант хугацааны татварын орлогын дүнгийн 50 хувиас хэтрэх ёсгүй.

Компани дараалийн 2 санхүүгийн жилд 2017 оны татварын алдагдлыг шилжүүлэн тооцох хэмжээний татварын орлого олох эсэх нь тодорхой бус тул хойшлогдсон татварын хөрөнгө үүсгээгүй.

Компанийн 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдөөр дуусгавар болсон тайлант хугацааны орлогын албан татварын бодит хувь нь (1.88%) (2016: 14.22%) байв.

## 8 Нэгж хувьцаанд ногдох ашиг

Компанид нэгж хувьцаанд ногдох ашгийг шингэрүүлэх, энгийн хувьцаанд хөрвөх боломжтой санхүүгийн хэрэглүүр байхгүй. Тиймээс нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрүүлсэн ашгийн дүн адилхан. Тайлангийн дараа хийгдсэн хувьцаа хуваалтаар тохируулагдсан нэгж хувьцаанд ногдох ашиг дараах байдалтай байна:

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (аудитлаг-даагүй) |
|---|---|---|
| Ашиг/(алдагдал) | | |
| Тайлант хугацааны цэвэр ашиг(алдагдал) буюу Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй ашиг/(алдагдал) | (72,815) | 718 |

| | Хувьцааны тоо 2017 оны 10 сарын 31 | 2016 оны 10 сарын 31 (аудитлаг-даагүй) |
|---|---|---|
| Үндсэн болон хөрөгдүүлсэн нэгж хувьцаанд ногдох энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо | 900,990 | 400,000 |
| Тайлангийн дараах хувьцаа хуваалтын нөлөө (Тодруулга 21) | 98,085,149 | 39,600,000 |
| | 99,075,908 | 40,000,000 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал) | MNT | MNT |
| Компанийн хувьцаа эзэмшигчдийн тайлант хугацааны: | | |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг (алдагдал) (төгрөгөөр) | (0.73) | 0.02 |
| Нэгж хувьцаанд ногдох шингэрүүлсэн ашиг (алдагдал) (төгрөгөөр) | (0.73) | 0.02 |

## 9 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Кассанд байгаа бэлэн мөнгө | 362 | 1,174 |
| Банкны харилцах данс | 319,681 | 506,765 |
| **Нийт мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө** | 320,043 | 507,939 |

Банкны харилцах дансан дахь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь Монголын арилжааны банкуудад байршсан харилцах дансны үлдэгдэл бөгөөд барьцаалагдаагүй болно. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны дүнтэй нь ойролцоо байна. Бүх мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ буураагүй гэж ангилсан. 2017 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар банкны харилцах дансан дахь мөнгөн хөрөнгийн жилийн хүү нь 0.0%-9.75% байна (2016 оны 12 дугаар сарын 31: 0.0%-3.7%).

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нь бүгд Монгол төгрөгөөр байршсан.

10 Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| ЛэндМН системээр олгогдсон зээл | 2,118,260 | 20,919 |
| Бусад зээл-Түлхүүр удирдлагад олгосон зээл (Тодруулга 20) | 3,600 | 103,241 |
| Харилцагчдад олгосон нийт зээл болон урьдчилгаа | 2,121,860 | 124,160 |
| Хасах нь: Зээлийн үнэ цэнийн бууралтын сан | (11,590) | - |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | 2,110,270 | 124,160 |

Компанийн бизнесийн загварын дагуу, ЛэндМН технологийг ашиглан зээл авсан зээлдэгчид нь богино хугацаанд хэрэглээгээ санхүүжүүлэх зорилготой хувь хүмүүс байдаг.

Компани нь зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцохдоо зээлийн багцыг бүлгийн болон тусгай үнэлгээний ангилалд хувааж үздэг. Үнийн дүн том эсвэл төлөгдөх хугацаа нь их хугацаагаар хэтэрсэн зээлийн авлагуудыг тусгай үнэлгээний ангилалд оруулан, үнэ цэнийн бууралтыг нь хэмжинэ. Бусад зээлүүд нь бүлгийн үнэлгээний ангилалруу ангилагдна. Тусгай үнэлгээний ангилалд буй зээлийн авлагад үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг тогтоохдоо авлагуудын төлөгдөх хугацаа нь хэтэрсэн эсэхийг нэн түрүүнд харгалзана. Мөн үнэ цэнийн бууралтыг үүсгэх нөхцөл байдал үүссэн эсэхийг шалгах, тэдгээр нь хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлсөн эсэхийг харгалзана. 2017 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар тусгай үнэлгээний ангилалд багтсан зээлийн авлагуудад зээлийн үнэ цэнэ бууралтын сан үүсгэх шаардлагагүй гэж дүгнэсэн ба хүлээн зөвшөөрсөн зээлийн үнэ цэнэ бууралтын сан нь бүлгийн үнэлгээний ангилалд багтсан зээлийн авлагууд дээр үүсгэсэн болно.

ЛэндМН системийг ашиглан, хэрэглэгчдэд олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын санд гарсан өөрчлөлтүүдийг доор үзүүлэв:

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| 1-р сарын 1-ний байдлаар | - | - |
| Тайлант хугацааны өөрчлөлт | 11,590 | - |
| 10-р сарын 31/12-р сарын 31-ний байдлаар | 11,590 | - |

### 11 Биет бус хөрөнгө

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| **Өртөг** | | |
| 1-р сарын 1-нээр | 300,000 | - |
| Нэмэгдэл | - | 300,000 |
| Нийт | **300,000** | **300,000** |
| **Хуримтлагдсан хорогдол** | | |
| 1-р сарын 1-нээр | 5,000 | - |
| Тайлант хугацааны хорогдол (Тодруулга 6) | 24,790 | 5,000 |
| Нийт | **29,790** | **5,000** |
| **Дансны цэвэр дүн** | **270,210** | **295,000** |

Компанийн биет бус хөрөнгө нь 2016 оны 12 дугаар сард шууд толгой компани болох Анд Системс ХХК-с худалдаж авсан, зээлийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий ЛэндМН технологийг Монгол улсын нутаг дэвсгэрт ашиглах тусгай эрх бүхий лицензээс бүрдэнэ. ЛэндМН технологи нь харилцагчийг бүртгэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, төлөлт хийх, тайлагнах, харилцагчид техникийн туслалцаа үйлчилгээ үзүүлэх, болон ЛэндМН аппликэйшнээс бүрдэнэ. ЛэндМН системийн тусгай лизенцийг авахад 1 удаагийн 300,000 мянган төгрөг төлөх ёстой ба Компани энэ төлбөрийг бүрэн төлж барагдуулсан.

Лиценз нь анх 2016 оны 12 дугаар сард туршилтын зорилгоор 5 жилийн хугацаатай олгогдсон ба туршилтын хугацаа 2017 оны 7 сарын 1-ний өдрөөр дуусгавар болж, лицензийн хугацааг 2016 оны 12 дугаар сараас хойш нийт 50 жил болгож, нэмэлт төлбөргүйгээр сунгасан. 2 тал харилцан тохиролцсон үед эсвэл Компани зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй болсноос бусад тохиолдолд лицензийн гэрээг цуцлах нөхцөл байхгүй. Лицензийн хугацаа хэдийгээр 50 жил боловч, удирдлага лицензийн ашиглалтын хугацааг 10 жил гэж дүгнэж байгаа тул, лицензийг 10 жилээр хорогдуулан бүртгэж байгаа.

*ЛэндМН ББСБ ХХК*
*Санхүүгийн Тайлангийн Тодруулгууд – 2017 оны 10 дугаар сарын 31*

## 12 Үндсэн хөрөнгө

| | Тавилга, оффисын хэрэгсэл мян.төг | Компьютер, тоног төхөөрөмж мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|
| **2017 оны 10 дугаар сарын 31** | | | |
| Өртөг | | | |
| 2017 оны 1-р сарын 1-нээр | 19,312 | 4,764 | 24,076 |
| Нэмэгдсэн | 18,312 | 31,554 | 49,866 |
| Данснаас хассан | - | (330) | (330) |
| 2017 оны 10-р сарын 31-нээр | 37,624 | 35,988 | 73,612 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | |
| 2017 оны 1-р сарын 1-нээр | 274 | 729 | 1,003 |
| Тайлант хугацааны элэгдэл (Тодруулга 6) | 2,377 | 5,940 | 8,317 |
| Данснаас хассан | - | (45) | (45) |
| 2017 оны 10-р сарын 31-нээр | 2,651 | 6,624 | 9,275 |
| **Дансны цэвэр дүн** | 34,973 | 29,364 | 64,337 |
| **2016 оны 12 дугаар сарын 31** | | | |
| Өртөг | | | |
| 2016 оны 1-р сарын 1-нээр | 940 | 1,329 | 2,269 |
| Нэмэгдсэн | 18,372 | 3,435 | 21,807 |
| Данснаас хассан | - | - | - |
| 2016 оны 12 сарын 31-нээр | 19,312 | 4,764 | 24,076 |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | |
| 2016 оны 1-р сарын 1-нээр | 71 | 332 | 403 |
| Тайлант жилийн элэгдэл | 203 | 397 | 600 |
| 2016 оны 12-р сарын 31-нээр | 274 | 729 | 1,003 |
| **Дансны цэвэр дүн** | 19,038 | 4,035 | 23,073 |

Үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулсан зээлийн хүүгийн зардал байхгүй. Мөн өр төлбөрийн барьцаанд байгаа үндсэн хөрөнгө байхгүй.

## 13 Бусад хөрөнгө

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан) |
|---|---|---|
| Бусад авлага | 851 | - |
| Холбоотой талуудаас авах авлага (Тодруулга 20) | 30,000 | 14,700 |
| Урьдчилж төлсөн төлбөр | 13,670 | - |
| | 44,521 | 14,700 |



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
ЛЭНДМН ББСБ ХХК LENDMN УЛААНБААТАР ХОТ

**14 Хаалттай бондын өглөг**

Компанийн хувьцаа эзэмшигчид 2017 оны 10 дугаар сарын 30-нд Компанийг 1,000,000 ширхэг, тус бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай бонд гаргах шийдвэр гарган баталсан. Үүний дагуу 2017 оны 10 дугаар сарын 31-нд Компанийн 300,000 ширхэг хаалттай бондыг шууд толгой компани болох Анд Системс ХХК худалдан авсан. Хаалттай бонд нь барьцаагүй. Мөн уг хаалттай бондыг олон нийтэд худалдахаар санал болгоогүй бөгөөд аль нэг хөрөнгийн зах зээл дээр бүртгэлгүй, худалдагддаггүй учир "хаалттай" гэж нэрлэсэн. Хаалттай бондын хүү нь хугацааны туршид хуримтлагдан, хугацааны эцэст төлөгдөх нөхцөлтэй. 2017 оны 10 дугаар сарын 31-ний хаалттай бондын дансны дүнд 200 мянган төгрөгний хүү хуримтлагдан бүртгэгдсэн.

**15 Бусад өр төлбөр**

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан) |
|---|---|---|
| **Бусад санхүүгийн өр төлбөр** | | |
| Шууд толгой компанид өгөх өглөг (Тодруулга 20) | - | 153,000 |
| Гуравдагч талд өгөх өглөг | 41,813 | 1,800 |
| **Нийт бусад санхүүгийн өр төлбөр** | 41,813 | 154,800 |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | | |
| Орлогын албан татвараас бусад татварын өглөг | 30,000 | 15,492 |
| Ирээдүйн болзошгүй татварын өр төлбөрийн сан | 15,805 | - |
| | 45,805 | 15,492 |
| **Нийт бусад өр төлбөр** | 87,618 | 170,292 |

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх шууд толгой компанид өгөх өглөг нь Анд Системс ХХК-д өгөх, 2016 онд худалдан авсан лицензийн төлбөрийн үлдэгдэл бөгөөд Компани энэ үлдэгдлийг 2017 онд бүрэн төлж барагдуулсан.

Бусад өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 17-с харна уу.

Ирээдүйн болзошгүй татварын өр төлбөрийн сангийн хөдөлгөөнийг толилуулав:

| | 31.10.2017 мян.төг | 31.12.2016 MNT'000 мян.төг |
|---|---|---|
| 1-р сарын 1-ний байдлаар | - | - |
| Тайлант хугацаанд тооцоологдсон сан (Тодруулга 6) | 15,805 | - |
| 10-р сарын 31/12-р сарын 31-ний байдлаар | 15,805 | - |

**16 Хувьцаат капитал**

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Нийт зөвшөөрөгдсөн бөгөөд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг нь 2,500,000 (2016: 800,000) бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөг (2016: 1,000 төгрөг) болно. Гаргасан бүх хувьцаа нь бүрэн төлөгдсөн. Нэгж энгийн хувьцаа 1 саналын эрхтэй.

## 16 Хувьцаат капитал (Үргэлжлэл)

| | Нийт хувьцааны тоо | Хувьцаат капитал мян.төг |
|---|---|---|
| **2016 оны 1-р сарын 1-нээр** | **400,000** | **400,000** |
| Шинээр нэмж гаргасан хувьцаа | 400,000 | 400,000 |
| **2016 оны 12-р сарын 31-нээр** | **800,000** | **800,000** |
| Шинээр нэмж гаргасан хувьцаа | 1,700,000 | 1,700,000 |
| **2017 оны 10-р сарын 31-нээр** | **2,500,000** | **2,500,000** |

Монгол улсын иргэн Гарамсүрэнгийн Идэрмаа нь 2017 оны 7-р сарын 28-нд өөрийн эзэмшдэг Компанийн 800,000 ширхэг энгийн хувьцааг Анд Системс ХХК-д шилжүүлсэн. Үүний дараа 2017 оны 9-р сарын 27-нд Компани шинээр тус бүр нь 1,000 төгрөгний нэрлэсэн үнэтэй, 1,700,000 ширхэг энгийн хувьцаа гаргасан ба гаргасан бүх хувьцааг Анд Системс ХХК худалдан авч, төлбөрийг мөнгөөр бүрэн төлсөн. Компанийн шууд толгой компани нь Анд Системс ХХК бөгөөд эцсийн толгой компани нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек төрлийн компани болох Анд Глобал Пте.Лтд юм. Тайлант хугацааны дараах, хувьцаат капиталд гарсан өөрчлөлтүүдийг Тайлагналын өдрийн дараах үйл явдлын тодруулгаас харна уу.

Хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн эзэмшлийн хувийг доорх хүснэгтээр харуулав:

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Анд Системс ХХК | 100.0% | - |
| Иргэн Г.Идэрмаа | - | 100.0% |
| | **100.0%** | **100.0%** |

## 17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага

### 1. Танилцуулга

Компанийн үйл ажиллагаанд эрсдэл учрах нь зайлшгүй бөгөөд эдгээр эрсдэлд зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, болон үйл ажиллагааны эрсдэл багтах ба уг эрсдлүүдийг Компанийн Гүйцэтгэх захирал удирдан зохицуулна. Эрсдлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдлийг тогтмол тодорхойлж, хэмжиж, хянах ба ингэснээр эрсдлийг хангалттай хэмжээнд нөхөх өгөөжийг өгөх бизнесийн сегментрүү хөрөнгө оруулах, Компанийн хөрөнгө оруулалтын эрсдлийг тохируулсан өгөөжийг боломжит хамгийн их хэмжээнд барих явдал юм. Эрсдлийн удирдлагын дээрх процесс нь Компанийн тогтвортой хөгжилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Компанийн гишүүн бүр өөр өөрсдийн ажил үүргийн хүрээндэх эрсдэлд хариуцлагатай хандах ёстой.

Бие даасан эрсдлийн удирдлагад байгаль орчин, техник технологи болон эдийн засгийн салбарын эрсдлүүд хамаарахгүй бөгөөд тэдгээрийг Компанийн стратеги болон бизнес төлөвлөгөөгөөр зохицуулна.

Компани нь эрсдлийн удирдлагын албан ёсны нэгдсэн бодлоготой бөгөөд энэ бодлого нь эрсдлийг арилгах бус, эрсдэл болон өгөөжийн харьцааг хамгийн ашигтай хэмжээнд барих явдал юм. Эрсдлийн удирдлагын алба ёсны бодлоготой байснаар:



20180119

**17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)**

(I) Эрсдлийг удирдах гишүүд нь эрсдлийн удирдлагын шаардлага болон хэмжилтийн системийн талаар бүрэн ойлголттой байна;
(II) Хөрөнгийг хуваарилан зарцуулахдаа эрсдлийг тооцоолно;
(III) Компанийн үйл ажиллагааны чиглэл нь авч чадах/хүлээн зөвшөөрөх эрсдлийн хэмжээтэй уялдана.

**2. Эрсдлийн удирдлагын бүтэц**

Компанийн эрсдлийн удирдлагыг одоогоор Гүйцэтгэх захирал ерөнхийд нь хариуцан ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд Гүйцэтгэх захирал эрсдлийн бодлого болон авч чадах/хүлээн зөвшөөрөх эрсдлийг тусгасан зээлийн эрсдлийн бодлогыг тус тус баталдаг. Компани одоогоор Захирлуудын Зөвлөлөө байгуулж, гишүүдийг томилох шатандаа явж байгаа бөгөөд томилогдсон гишүүд нь Компанийн эрсдлийн удирдлагын бүтцийг бүхэлд нь төлөвлөн, зохион байгуулах Эрсдэл хариуцсан захирлыг томилох болно. Шинээр томилогдох Захирлуудын зөвлөл нь компанийн дотоод аудиторыг мөн томилно.

**3. Зээлийн эрсдэл**

Компанийн үндсэн зээлийн эрсдэл нь одоо явуулж буй зээлийн үйл ажиллагааны үр дүнд олгосон зээлүүд нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл юм. Зээлийн эрсдэл нь 1) зээлийн лимитийг тогтоох, батлах үе шат, болон 2) зээл олголтын дараах гүйцэтгэлийг хянах үе шатууд дээр үүсэж болно. Зээлийн лимитийг тогтоох, батлах үе шат дээр ЛендМН системийн кредит оноог тогтоох модуль нь зээлдэгчийн кредит оноог буруу гаргаснаар тухайн зээлдэгчийн зээлийн лимит болон шимтгэлийн дүнг буруу тогтоох явдлуудаас үүдэн зээлийн эрсдэл үүсэж болно. ЛэндМН системийн кредит оноог тогтоох уг модуль нь өмнөх зээлүүдийн хугацаа хэтэрсэн байдал болон хугацаа хэтэрсэн төлбөр зэрэг түүхэн мэдээллүүд дээр тулгуурлан, процессоо автоматаар засаж сайжруулдаг алгоритм бүхий модуль юм. Уг модуль нь шинэ мэдээлэл системд орж ирэх бүрт зээлдэгчдийн кредит оноог автоматаар шинэчлэж, дараа дараагийнхаа кредит оноог тогтоох алгоритмаа шинэчлэн засах бүтэц бүхий өөрөө өөрийгөө автоматаар засаж сайжруулдаг систем юм. Компанийн удирдлагууд зөвхөн зээлийн лимитийн дүнгүүдийн хязгаар болон шимтгэлийн түвшинг системд оруулж өгөх ба ЛэндМН систем нь өөрөө автоматаар зээлийн шийдвэрээ гаргаж, кредит оноог тогтоох алгоритмаа улам сайжруулаад явдаг байна. Компани хугацаа хэтэрсэн зээлүүдийг хугацаа хэтэрсэн хоногоор нь (1, 30, 60, 90 хоног) тус тус бүлэглэн, тэдгээрийн дүнг зорилтот хувьтай харьцуулан, хянаж явдаг.

Компанийн зээлийн эрсдэл нь ЛэндМН систем кредит оноог тогтоогоод, зээл олгосны дараа бас үүсэж болно. Авлага хариуцсан алба болон Дуудлагын тусламж үйлчилгээний төвийн багийнхан хамтдаа зээлдэгчдийн төлбөр төлөлтийн байдал, өөрчлөлт болон хугацаа хэтэрсэн зээлийг өдөр тутам хянадаг.

Авлага хариуцсан алба нь ЛендМН системийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг ялгаж, мэдэгдэх үүрэг бүхий модуль нь зөв ажиллаж байгааг шалгах үүрэгтэй бөгөөд тухайн модулийн мэдээллийг зээлдэгчийн эргэн төлөлтийн байдал өөрчлөгдөх бүрт шинэчлэнэ. Дуудлагын тусламж үйлчилгээний төв нь авлага хариуцсан албаны шууд удирдлаган дор ажиллах ба уг төв нь харилцагчдад зээлийн эргэн төлөлтөө дээр үнэн зөв мэдээлэл, тусламж зөвлөгөөг түргэн шуурхай хүргэдэг.



2018 01 19

**17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)**

**3. Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

**Ямар нэгэн барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалтыг харгалзан үзэхгүйгээр өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшин**

Доорх хүснэгтэнд санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүдийн өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшинг харуулав. Өртөж болох зээлийн эрсдлийн хамгийн өндөр түвшин нь нийт дүнгээр харагдана.

| | Эрсдлийн хамгийн өндөр түвшин | |
|---|---|---|
| | 31.10.2017 мян.төг | 31.12.2016 мян.төг |
| Банкин дах бэлэн мөнгө | 319,681 | 506,765 |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | 2,110,270 | 124,160 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 30,851 | 14,700 |
| Олгохоор батлагдсан зээл | 1,229,305 | 8,877 |
| | 3,690,107 | 654,502 |

**Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн сайжруулалт**

Банкин дах бэлэн мөнгө болон харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй болно

17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)

3. Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн зээлжих чанарын шинжилгээ, бүлгээр:

| | Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтгүй мян.төг | Хугацаа хэтэрсэн боловч тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтгүй: 30 хоногийн дотор мян.төг | 31-60 хоног хэтэрсэн мян.төг | 61-90 хоног хэтэрсэн мян.төг | 90-с дээш хоног хэтэрсэн мян.төг | Бүлгийн үнэлгээгээр үнэ цэнийн бууралт мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2017 оны 10-р сарын 31-нээр** | | | | | | | |
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 320,043 | - | - | - | - | - | 320,043 |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | | | | | | | |
| ЛэндМН | 2,035,308 | 57,446 | 14,233 | 3,365 | 6,908 | (11,590) | 2,105,670 |
| Бусад зээл | 3,600 | - | - | - | - | - | 3,600 |
| Холбоотой талаас авах авлага | 30,000 | - | - | - | - | - | 30,000 |
| Нийт | 2,388,951 | 57,446 | 14,233 | 3,365 | 6,908 | (11,590) | 2,460,313 |
| **2016 оны 12-р сарын 31-нээр** | | | | | | | |
| Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө | 507,939 | - | - | - | - | - | 507,939 |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | | | | | | | |
| ЛэндМН | 20,919 | - | - | - | - | - | 20,919 |
| Бусад зээл | 103,241 | - | - | - | - | - | 103,241 |
| Холбоотой талаас авах авлага | 14,700 | - | - | - | - | - | 14,700 |
| Нийт | 646,799 | - | - | - | - | - | 646,799 |



20180119

## 17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)

### 4. Төлбөрийн чадварын эрсдэл

Компани нь үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд өдөр бүр зах зээлийн эрэлт нь өсөн нэмэгдэж байгаа зээлийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд олгоход болон компанийн өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай, хангалттай хэмжээний санхүүжилтийн эх үүсвэртэй байх явдал нь төлбөрийн чадварын эрсдлийн удирдлагын гол зорилго юм. Хэрэглэгчдэд олгох зээлийн бүтээгдэхүүний гол санхүүжилтийг шууд толгой компаниас зээлээр эсвэл өмчөөр хөрөнгө оруулалт хэлбэрээр татан авдаг. Компанийн үйл ажиллагаа нь эрчимтэй өргөжиж байгаа тул, гуравдагч талууд болох арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, болон хувийн хөрөнгийн сан гэх мэт бусад хөрөнгө оруулагч байгууллагуудаас зээлийн санхүүжилт татахаар хэлэлцээрүүд хийгдэж байна.

**Санхүүгийн өр төлбөрийн дуусвар хугацааны шинжилгээг доор үзүүлэв:**

Дараах хүснэгтэнд 2016 оны 12 дугаар сарын 31 болон 2017 оны 10 дугаар сарын 31-нээрх Компанийн санхүүгийн өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээг гэрээнд тусгагдсан дискаунтчилагдаагүй дүнгүүд дээр тулгуурлан үзүүлэв. Доорх хүснэгтэнд Компанийн хадгаламжийн түүх дээр үндэслэгдэн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний дүнг хамруулаагүй болно.

| | Нэхэмжилсэн үед | 3 сарын дотор | 3-6 сарын дотор | 6-12 сарын дотор | 1-5 жилийн дотор | 5-с дээш жилийн дараа | Нийт санхүүгийн өр төлбөр (Дискаунтчилаг даагүй) |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2017 оны 10-р сарын 31-нээр** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** | **мян.төг** |
| Олгохоор батлагдсан зээл | 1,229,305 | - | - | - | - | - | 1,229,305 |
| Бондын зээлийн өглөг | - | - | - | 354,000 | - | - | 354,000 |
| Бусад өр төлбөр | 453 | 41,360 | - | - | - | - | 41,813 |
| | **1,229,758** | **41,360** | - | **354,000** | - | - | **1,625,118** |
| **2016 оны 12-р сарын 31-нээр** | | | | | | | |
| Олгохоор батлагдсан зээл | 8,877 | | | | | | 8,877 |
| Бусад өр төлбөр | 154,600 | - | - | - | - | - | 154,600 |
| | **163,477** | - | - | - | - | - | **163,477** |

Компанийн удирдлага нь олгохоор батлагдсан бүх зээл нь богино хугацаанд олгогдохгүй гэж үзэж байна. Санхүүгийн тайлангийн тодруулга 21-ээс тус үүргийг биелүүлэхтэй холбоотой өр төлбөр болон өмчийн хөрөнгө санхүүжилтийн мэдээллийг харна уу.

**17 Санхүүгийн Эрсдлийн Удирдлага (Үргэлжлэл)**

**б. Зах зээлийн эрсдэл**

Санхүүгийн хэрэгслүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал нь хүүгийн түвшний өөрчлөлт, эсвэл гадаад валютын ханшийн өөрчлөлт гэх мэт зах зээлийн үнийн өөрчлөлтөөс болж өөрчлөгдөх эрсдлийг зах зээлийн эрсдэл гэнэ. Компани уг эрсдлийг боломжит нөлөөллийн дүн шинжилгээгээр хянан зохицуулдаг ба компанийн зээлийн авлагууд нь богино хугацаатай тул зах зээлийн томоохон эрсдэл Компанид байхгүй.

**Зээлийн авлагууд урьдчилж төлөгдөх эрсдэл**

Харилцагч зээлээ хугацаанаас нь өмнө, урьдчилан төлөх тохиолдолд, ирээдүйн хүүг бүтнээр нь төлөх нөхцөлтэй тул зээлийн авлагууд урьдчилж төлөгдөх эрсдэл байхгүй.

**Үйл ажиллагааны эрсдэл**

Үйл ажиллагааны эрсдэл нь системийн алдаа, хүний алдаа, залилан, болон гадны нөлөөллийн улмаас алдагдал хүлээх эрсдэл юм. Уг эрсдлийг удирдан хянахгүй бол, компанийн үйл ажиллагаа доголдох бөгөөд ингэснээр компанийн нэр хүнд муудах, хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох гэх мэт сөрөг үр дагавартай. Компани нь үйл ажиллагааны эрсдлийг бүхэлд арилгах чадахгүй ч, эрсдлийн удирдлагын нэгдсэн бодлогыг чанд мөрдөх, үйлчилгээний баг болон ерөнхий үйл ажиллагааны багын ажил үүргийг тусгаарлах, системийн аюулгүй байдлыг бүрэн хангах, болон ажилтнуудын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх замаар үйл ажиллагааны эрсдлийг удирдан, багасган ажиллаж байна.

**18 Болзошгүй өр төлбөр ба Үүрэг хариуцлага**

***Зарга, маргаан.*** Компани бизнесийн хэвийн үйл ажиллагаанхаа хүрээнд өөрийн эсрэг нэхэмжлэл хүлээн авах магадлал бий. Удирдлага өөрсдийн үнэлэмж, тооцоо, компанийн мэргэжилтнүүдийн зөвлөмжид үндэслэн зарга, нэхэмжлэлтэй холбоотой материаллаг хохирол хүлээхгүй гэж үзэж байгаа тул санхүүгийн тайланд үүнтэй холбогдуулж аливаа сан хуулэн зөвшөөрөөгүй болно.

***Татварын хууль, зохицуулалт.*** Монгол улсын татвар, валют болон гаалийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, мөн үе үе өөрчлөгдөх болзошгүй байдаг. Удирдлагын үнэлэмж, тайлбараар хууль журмыг ажил гүйлгээ, үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байдлыг холбогдох төрийн албаны зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол гардаг.

Монгол Улсын татварын алба хууль тогтоомжийг тайлбарлаж үнэлэхдээ илүү хатуу байр суурь баримтлах талтай байдаг ба өмнө нь санал зөрөлдөж байгаагүй үйл ажиллагаа, ажил гүйлгээг татварын алба хожим нь үгүйсгэх боломжтой. Үүнээс үүдэж томоохон хэмжээний нэмэлт татвар, торгууль болон алдангийг ногдуулах магадлалтай байдаг. Татварын хяналт шалгалт орох үед өмнөх таван жилийн татварыг шалгадаг тул эдгээр татварын жилүүд хяналт шалгалтанд нээлттэй хэвээр үлддэг. Зарим тохиолдолд татварын хяналт шалгалтанд илүү урт хугацааг хамруулах явдал байдаг.

Монгол Улсын татварын хууль журам, зохицуулалтаар нэмэгдсэн өртгийн албан татвар, суутган татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үнэ шилжүүлэлт болон бусад зүйлстэй холбоотой зарим зүйл, заалт, асуудлаар тодорхой зааварчилгаа байдаггүй. Зарим нэг тохиолдолд удирдлага хуулийн энэхүү тодорхой бус зүйлсийн тухайд компанийн татварын ерөнхий хувийг бууруулах чиглэлд тайлбарлан хэрэглэдэг. Сүүлийн үед явагдсан захиргааны болон шүүхийн практик шинжилгээний үр дүнд дээрх тодорхой бус байдлын талаарх байр суурь илүү их хатуу хяналт шалгалтанд өртөх талтай болсон. Хэдийгээр татварын албанаас тавигдах шаардлага компанийн санхүүгийн байдал болон нийт үйл ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлэх боломжтой болович, холбогдох нөлөөллийг найдвартай хэмжих боломжгүй юм. Компанийн удирдлага холбогдох хууль тогтоомжийг зохистойгоор тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байгаа бөгөөд компани татвар болон бусад хууль тогтоомжийн талаарх компанийн байр суурийг тогтвортой хадгалах болно.

**18 Болзошгүй өр төлбөр болон Үүрэг хариуцлага (Үргэлжлэл)**

Удирдлага одоогоор татвар болон бусад хууль тогтоомжоос үүсэх эрсдэлийг бага гэж дүгнэж байгаа бөгөөд татварын эрсдэлийг цаашид тогтмол эргэн харж үнэлэх бөгөөд дээрх дүгнэлт нь одоогоор урьдчилан мэдэгдэх боломжгүй ирээдүйн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж магадгүй. Компанийн удирлага 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар болон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар татварын тодорхой бус байдалтай холбоотой сан хөрөнгө хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзэж байна.

*Олгохоор баталсан зээлийн үүрэг.* Энэхүү үүргийн үндсэн зорилго нь харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтын эх үүсвэр бэлэн байлгахад оршино. Зээл олгохоор амласан амлалт нь харилцагчийн ЛэндМН системээс түүнд олгохоор батлагдсан нийт зээлийн ашиглаагүй байгаа хэсгийг хэлнэ. Олгохоор баталсан зээлийн үүргийн эрсдлийн хувьд, Компани нийт дүнгээр зээлийн эрсдэлд орж болно. Гэхдээ харилцагч тусгайлан заасан зээлийн нөхцлүүдийг биелүүлсэн нөхцөлд зээлийг бодитоор олгох боломжтой учир, зээлийн эрсдлийн дүн нь олгохоор баталсан зээлийн үүргийн нийт дүнгээс бага байна. 2017 оны 10 сарын 31-ний байдлаар Компанийн олгохоор баталсан зээлийн үүргийн нийт дүн нь 1,229,305 мянган төгрөг байна (2016 оны 12 сарын 31-нд 8,877 мянган төгрөг байсан).

**19 Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт**

***Бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан аргууд болон үнэлэмжүүд***

Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнийг ашиглан) боломжит өгөгдлүүдийг ашиглан, үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү тулгаарлан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшингийн бодит үнэ цэнэ гэж тус тус ангилна. Удирдлага санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн түвшингээр нь ангилахдаа өөрсдийн үнэлэмжийг ашиглана. Хэрэв бодит үнэ цэнийг тодорхойлоход тохируулга ихээхэн хийгдэж өгөгдлийг ашиглаж байгаа бол тухайн хэмжилт нь 3-р түвшинд хийгдэж байна гэсэн үг. Ашиглаж буй өгөгдлийн ач холбогдлыг бодит үнэ цэнийн хэмжилттэй бүхлээр нь харьцуулан авч үзнэ.

Компанийн бүх санхүүгийн хэрэглүүрүүд нь богино хугацаатай учир, тэдгээрийн бодит үнэ цэнэ нь дансны дүнтэй ойролцоо байна.

**20 Холбоотой талын ажил гүйлгээ**

Гол удирдах ажилтнуудын нийт олговрыг доорх хүснэгтээр харуулав:

| | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлагдаагүй) |
|---|---|---|
| Цалин | 28,521 | - |
| Эрүүл мэнд, нийгмийн даатгал | 3,138 | - |
| | 31,659 | - |

**20 Холбоотой талын ажил гүйлгээ (Үргэлжлэл)**

2017 оны 10 дугаар сарын 31 болон 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх холбоотой талуудын үлдэгдлийг доорх хүснэгтээр харуулав:

| | Тод-руулга | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2016 оны 12 сарын 31 мян.төг (Дахин тайлагнасан) |
|---|---|---|---|
| Компанийн гол удирдах ажилтнуудад олгосон зээл | (i) | 3,600 | 4,172 |
| Компанийн гол удирдах ажилтнуудад ЛэндМН системээр олгосон зээл | (ii) | 2,155 | 1,640 |
| Хамаатай талд өгөх өглөг (Тодруулга 15) | (iii) | - | 153,000 |
| Хамаатай талаас авах авлага (Тодруулга 13) | (v) | 30,000 | 14,700 |
| Хамаатай талд өгөх өглөг (Хаалттай бонд Тодруулга 14) | (iv) | 300,200 | - |
| | | 335,955 | 173,412 |

2017 оны 10 дугаар сарын 31 болон 2016 оны 10 дугаар сарын 31-р дуусгавар болсон 10 сарын тайлант хугацаанд холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний дүнг доорх хүснэгтээр харуулав:

| | | 2017 оны 10 сарын 31 мян.төг | 2017 оны 10 сарын 31 мян.төг (Аудитлаг-даагүй) |
|---|---|---|---|
| Олгосон зээлийн хүүгийн орлого | (i), (ii) | 1,434 | 150 |
| Хаалттай бондын өглөгийн хүүгийн зардал | (iv) | 3,286 | - |
| ЛэндМН системийн үйлчилгээний төлбөр (Тодруулга 6) | (vi) | 35,153 | - |
| | | 39,873 | 150 |

(i) Компанийн гол удирдах ажилтнуудад олгосон зээл нь хувь хүнд олгосон 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр 3,600 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэг зээл юм. Хувь хүнд олгосон зээл нь барьцаагүй, жилийн 12 хувийн хүүтэй, 11 сарын дотор төлөгдөх нөхцөлтэй.

(ii) ЛэндМН системээр гол удирдах ажилтнуудад олгосон зээл – Компани 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон 10 сарын хугацаанд 24,556 мянган төгрөгийн зээлийг гол удирдах ажилтнуудад олгосноос 22,401 мян.төгрөг нь бүрэн төлөгдөж, 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр 2,120 мян.төгрөгийн дуусаагүй үлдэгдэлтэй байна. ЛэндМН системийн дуусаагүй зээл нэг сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй боловч 35 мян.төгрөгийн системийн шимтгэлтэй.

(iii) Компани 2016 оны 12 дугаар сард өөрийн шууд толгой компани болох Анд Системс ХХК-с Монгол улсын нутаг дэвсгэрт зээлийн үйл ажиллагаа явуулах, ЛэндМН системийг ашиглах тусгай эрх худалдаж авсан. ЛэндМН технологи нь харилцагчийг бүртгэх, зээлийн шийдвэр гаргах, зээл олгох, төлөлт хийх, тайлагнах, харилцагчид техникийн туслалцаа үйлчилгээ үзүүлэх, болон ЛэндМН аппликэйшнаас бүрдэнэ. ЛэндМН системийн тусгай лизенцийг авахад 1 удаагийн 300,000 мянган төгрөг төлсөн. Лиценз нь анх 2016 оны 12 дугаар сард туршилтын зорилгоор 5 жилийн хугацаатай олгогдсон ба туршилтын хугацаа 2017 оны 7 сарын 1-р дуусгавар болж, лицензийн хугацааг 2016 оны 12 дугаар сараас хойш нийт 50 жил болгож, нэмэлт төлбөргүйгээр сунгасан. 2 тал харилцан тохиролцсон үед эсвэл Компани зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй болсоноос бусад тохиолдолд лицензийн гэрээг цуцлах нөхцөл байхгүй. 2016 оны 12 сарын 31-ний байдлаар Компани лицензийн төлбөрт нийт 147,000 мянган төгрөг төлсөн ба үлдсэн дүн болох 153,000 мянган төгрөг нь 1 жилийн дотор төлөгдөх нөхцөлтэй байсан.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
БҮРТГЭВ №01



**20 Холбоотой талын ажил гүйлгээ (Үргэлжлэл)**

(iv) Санхүүгийн тайлангийн 14-р тодруулга дээр тодруулсан-лан, хамаатай тал болох Анд Системс ХХК-д өгөх хаалттай бондын өглөг нь барьцаагүй, жилийн 18 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай болно. Үүнээс гадна, компани 2017 оны 8 сарын 22нд Анд Системс ХХК-руу дахин хаалттай бонд гаргаж, 345,000 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Энэ бонд нь тус бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 18 хувийн хүүтэй, 3 сарын дотор төлөгдөх нөхцөлтэй, 345,000 ширхэг бонд байсан бөгөөд энэ бондыг 2017 оны 9 сарын 27-нд бүрэн төлж барагдуулсан.

(v) Хамаатай тал болох Анд Системс ХХК-с авах авлага нь барьцаагүй, хүүгүй, нэхэмжлэсэн үед төлөгдөх нөхцөлтэй.

(vi) Компани 2017 оны 7 сарын 1-нд Анд Системс ХХК-тай хэрэглэгчдийн кредит оноог тогтоох үйлчилгээ болон ЛэндМН системийн засвар үйлчилгээний гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу Анд Системс ХХК-д сар бүр төлөх дүн нь тухайн сарын зээлийн ажил гүйлгээний тоо ширхэг дээр тулгуурлагддаг.

**21 Тайлагналын өдрийн дараах үйл явдал**

Дараах ажил гүйлгээнүүд нь тайлант хугацааны эцсийн өдөр болон санхүүгийн тайланг хэвлэн нийтлэх зөвшөөрөл олгогдсон өдрийн хооронд явагдсан болно:

1. Компани нь 2017 оны 10-р сарын 30-нд нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 2,000,000 ширхэг энгийн хувьцааг 2,000,000 мянган төгрөгөөр гаргасан бөгөөд энэ хувьцааг шууд толгой компани болох Анд Системс ХХК худалдаж авсан. Дээрх ажил гүйлгээг Санхүүгийн Зохицуулах Хороо 2017 оны 11-р сарын 13-нд зөвшөөрсөн бөгөөд Анд Системс ХХК нь тухайн өдөр хувьцааны төлбөрийг бүрэн төлсөн.

2. Компани нь 2017 оны 11-р сарын 10-нд нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, сарын 16 хувийн хүүтэй бөгөөд хүүгийн төлбөрийг улиралд 1 удаа төлөх нөхцөлтэй, 1 жилийн хугацаатай, 1,000,000 ширхэг хаалттай бонд гэнд гаргасан. Гаргасан бүх бонд нь эцсийн толгой компанийн нэг хувьцаа эзэмшигчид тухайн өдрөөр борлуулагдсан. Мөн Компани уг өдөр Анд Системс ХХК-д борлуулсан байсан 300,000 ширхэг хаалттай бондыг буцаан худалдаж авсан.

3. Компанийн хувьцаа эзэмшигчид 2017 оны 11-р сарын 14-нд 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нэг энгийн хувьцааг тус бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 100 ширхэг хувьцаанд хуваах шийдвэр гаргасан ба ингэснээр нийт зөвшөөрөгдсөн болон гаргасан (бүрэн төлөгдсөн) энгийн хувьцааны тоо ширхэг 450,000,000 болсон.

4. Компани нь 2017 оны 11-р сарын 30-нд нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 150,000,000 ширхэг энгийн хувьцааг 1,500,000 мянган төгрөгөөр нэмж гаргасан бөгөөд нэмж гаргасан уг хувьцааг шууд толгой компани болох Анд Системс ХХК бүхэлд нь худалдаж авсан. Дээрх ажил гүйлгээний зөвшөөрлийн аваахаар Санхүүгийн Зохицуулах Хороонд тухайн өдрөө хүсэлт илгээсэн бөгөөд энэхүү санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн өдрийн байдлаар уг зөвшөөрөл хараахан гараагүй байна.

5. Компанийн хувьцаа эзэмшигчид 2017 оны 12-р сарын 1-нд компанийн Захирлуудын зөвлөлийг 5 гишүүнтэйгээр батлав.

Дээрх тайлагналын өдрийн дараах ажил гүйлгээнүүдийн 3 дугаар зүйлээс бусад нь энэхүү санхүүгийн тайланд ямар нэгэн залруулгаар ороогүй гэж компанийн удирдлагууд үзэж байна.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
LENDMN
20180119

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
... он ... сар ... өдөр

СЗХ
... он ... сар ... өдөр
БҮРТГЭВ



**22 Өмнөх хугацааны үлдэгдлийн дахин тайлагнал**

Холбоотой талын авлага болон суутган татвар дутуу илэрхийлэгдсэн тул харьцуулах үзүүлэлтүүдийг дахин тайлагнав.

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан дахь залруулгын нөлөөллийг доорх хүснэгтэнд харуулав.

| | 2016 оны 12 сарын 31 өмнөх тайлагналаар мян.төг | Дутуу бүртгэсэн холбоотой талын авлага болон суутган татварыг залруулах нь мян.төг | 2016 оны 12 сарын 31 дахин тайлагналаар мян.төг |
|---|---|---|---|
| Бусад хөрөнгө | - | 14,700 | 14,700 |
| Бусад өр төлбөр | 155,392 | 14,700 | 170,092 |

Энэхүү залруулга нь 2016 оны 1-р сарын 1-ний өдрөөрх эзний үлдэгдэлд нөлөөгүй болно.

**23 Монгол хэл дээрх орчуулга**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбарын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
УЛААНБААТАР ХОТ

ЛэндМН ББСБ ХХК
LENDMN
УЛААНБААТАР ХОТ

20180119

MDSKhanLex

# "ЛЭНДМН ББСБ" ХХК-ИАС АНХ УДАА НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТУХАЙ

## ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

| | |
|---|---|
| ХЭНД: | "ЛэндМН ББСБ" ХХК-д |
| Хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Нью Майнд Групп ХХК-ийн байр |
| Утас/Факс: | (976-77) 222949 |

| | |
|---|---|
| ХЭНЭЭС: | "Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН |
| Хаяг: | Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас/Факс: | (976-11) 330048, (976-11) 330049 |
| Огноо: | 2017 оны 12-р сарын 08-ны өдөр |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
... он ... сар ... өдөр



СЗХ
он сар өдөр

MDSKhanLex

Монгол Улс, Улаанбаатар хот 14200
Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2
Сентрал Тауэр 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048
Факс: +976 11 330049
Олон улс: +1 (978) 9033574

2017.12.08 № Д-17/225

**"ЛЭНДМН ББСБ" ХХК-д**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж,

Нью Майнд Групп ХХК-ийн байр

**"ЛЭНДМН ББСБ" ХК-ИАС ГАРГАХ ХУВЬЦААНЫ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬ ЗҮЙН ХУВЬД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

***Нийтлэг үндэслэл***

"Өмгөөллийн ЭмДиЭс энд ХаанЛекс" ХХН нь Санхүүгийн зохицуулах хорооны 2014.01.29-ны өдрийн 25 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд 2 хуулийн нөхөрлөл нэгдэж өөрчлөн байгуулагдсаны дараа СЗХ-ны 2016.02.24-ний өдрийн 42 дугаар тогтоолоор шинэчлэн бүртгэгдсэн Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1 СЗХ-ны тогтоолын хуулбар)-ийн хувьд энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргах эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "ЛэндМН ББСБ" ХХК (цаашид "ЛэндМН" эсхүл "Компани" гэх) нь хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч улмаар бид 2017.10.23-ны өдөр "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ" (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

Энэхүү хууль зүйн дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 23.1-т "... хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно", 4.2-т "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаасыг гаргаж болно" гэж хуульчилсны дагуу ЛэндМН нь нэмж гаргах энгийн эрхийн хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдах эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна. Тус Компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д заасны дагуу хувьцаагаа Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" эсхүл "Хороо" гэх).



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
LENDMN
20180119

Монголын хөрөнгийн бирж (цаашид "МХБ" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон гаргахаар төлөвлөсөн байна.

Энэхүү хувьцааны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2015.11.23-ны өдрийн 408 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2015.12.30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012.02.10-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан "МХБ ТӨХК-ийн Арилжааны журам"-ын дагуу явагдана.

Бид хууль зүйн дүгнэлт гаргах зорилгоор ЛэндМН-ээс түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчийн шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтыг эх хувиар болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн холбогдох мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, дүгнэлт гаргахдаа (а) үнэт цаасны танилцуулгад тусгагдсан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв, (б) бидэнд ирүүлсэн бүх бичиг баримтад дурдсан мэдээлэл үнэн, зөв; (в) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг бодит, зөв; (г) бидэнд ирүүлсэн бичиг баримтуудын хуулбар нь тэдгээрийн эх хувьтай нийцсэн, бүрэн; (д) бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй гэж үзсэний үндсэн дээр, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн доор дурдсан хууль зүйн дүгнэлт гаргаж байна:

1. **Компани хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх**

"ЛэндМН ББСБ" ХХК нь анх "Компанийн тухай" хуулийн дагуу нэг гишүүн (Монгол Улсын иргэн Н.Эрдэнэсайхан РД: ЧП60032016)-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2006.01.13-ны өдөр "Дуусашгүй-Ундарга" ХХК нэрээр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. (Улсын бүртгэлийн дугаар: 9015003079, Регистрийн дугаар: 5039754) (Хавсралт 1.3).

"Дуусашгүй-Ундарга" ХХК нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" болон "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн дагуу СЗХ-ны 2015.06.24-ний өдрийн 293 дугаар тогтоолоор (Хавсралт 1.4) Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 1.5) авсныг болон үүнтэй холбоотойгоор дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан болохыг 2015.07.07-ны өдөр тус компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэсэн байна.

"Дуусашгүй-Ундарга ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2016.06.20-ны өдрийн 06/01 дугаар шийдвэр (Хавсралт 1.6), мөн өдөр үүсгэн байгуулагч Н.Эрдэнэсайхан болон Монгол Улсын иргэн Г.Идэрмаа (РД: ХД65022409) нарын хооронд байгуулсан "Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ" (Хавсралт 1.7)-ний дагуу тус компанийн нийт энгийн хувьцаа, түүнд хамаарах эрхийг 100 хувь Г.Идэрмаад шилжүүлэхээр болсныг "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"[1]-ын дагуу СЗХ-ны даргын 2016.07.25-ны өдрийн 215 дугаар тушаал (Хавсралт 1.8)-аар зөвшөөрч, энэхүү хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт болон үүнтэй холбоотойгоор дүрэмд оруулсан өөрчлөлтийг 2016.07.29-ний өдөр Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэсэн байна.

[1] СЗХ-ны 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 71 дугаар тогтоолоор батлагдсан

"Дуусашгүй-Ундарга ББСБ" ХХК-ийн оноосон нэрийг "ЛэндМН ББСБ" ХХК болгон өөрчлөх тухай Компанийн Хувьцаа эзэмшигчийн 2016.10.10-ны өдрийн 16/03 дугаартай шийдвэр (Хавсралт 1.9) болон үүнтэй холбоотойгоор дүрэмд оруулсан өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2016.12.23-ны өдрийн 326 дугаар тушаал (Хавсралт 1.10)-аар зөвшөөрсний дагуу мөн өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна байна.

Хувьцаа эзэмшигч Г.Идэрмаа нь 2017.07.31-ний өдөр "Бэлэглэлийн гэрээ" (Хавсралт 1.11)-гээр ЛэндМН-ийн нийт энгийн хувьцааг 100 хувь, мөн тус хувьцаагаар гэрчлэгдсэн бүх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг Компанийн удирдлагын эрхийн хамт Монгол Улсын хуулийн этгээд болох Гадаадын хөрөнгө оруулалттай "Анд Системс" ХХК-д бүрэн шилжүүлснийг болон үүнтэй холбоотойгоор дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг 2017.10.03-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна.

Компани нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

**2. Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдний компанийг удирдах чадвар, удирдлага туршлагын байдлын талаар**

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй ЛэндМН-ийн дүрэмд тус компанийн эрх бүхий албан тушаалтныг тусгайлан тодорхойлоогүй байна. Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дах заалтын дагуу ЛэндМН-ийн дүрэм зэрэг холбогдох баримт бичигт үндэслэн тус компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэгт Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч(ид), компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Борлуулалт, үйлчилгээний албаны дарга, Ерөнхий нягтлан бодогч нарыг хамруулан авч үзэв.

ЛэндМН-ийн цорын ганц Хувьцаа эзэмшигч "Анд Системс" ХХК нь "Компанийн тухай" хуулийн дагуу нэг гишүүн (Сингапур Улсын хуулийн дагуу 2017.03.29-ний өдөр үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн "Анд глобал" ХХК РД: 201708763К (Хавсралт 2.1))-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2015.09.24-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн (Улсын бүртгэлийн дугаар: 9019084069; РД: 6005861) Монгол Улсын хуулийн этгээд (Хавсралт 2.2) юм.

"Анд Системс" ХХК нь ЛэндМН-ийн цорын ганц хувьцаа эзэмшигч болсноос хойш ЛэндМН-ийн Компанийн тухай хуульд заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг "Анд Системс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Анар хэрэгжүүлж ирсэн байна. Энэхүү бүрэн эрх нь"Анд Системс" ХХК-ийн үүсгэн байгуулагч, цорын ганц хувьцаа эзэмшигч "Анд Глобал" компанийн 2017.08.01-ний өдрийн шийдвэр (Хавсралт 2.3), Оюуны өмч, улсын бүртгэлийн Ерөнхий газрын 2017.05.01-ний өдрийн Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаагаар нотлогдож байна (Хавсралт 2.4). Ч.Анар нь "ЛэндМН -ийн ТУЗ-ийн гишүүн юм.

ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчийн 2017.11.14-ний өдрийн 17/14 дугаартай шийдвэр (Хавсралт 2.5)-ээр тус компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсныг 2017.12.01-ний өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна. Энэхүү дүрмийн 6.1-д заснаар ЛэндМН -ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг "Анд Системс" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэх бөгөөд ЛэндМН нь мөн ТУЗ-тэй байхаар дүрэмд өөрчлөлт оруулсан байна. (Хавсралт 2.6).

"Анд Системс" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2017.10.30-ны өдрийн 17/11 дугаартай шийдвэр (Хавсралт 2.7, 2.8)-ээр тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажиллаж байна:

1. ТУЗ-ийн дарга Чинбаатарын Анар, МУИС-ийг Системийн инженер мэргэжлээр төгссөн. 2006-2009 оны хооронд Жи-Мобайл ХХК-ийн Үүсгэн байгуулагч, Ахлах технологийн ажилтан, 2011-2015 онд APGO ХХК-ийн Төслийн менежер, 2015-2017 оны хооронд "Анд Системс" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2017.03.29-ны өдрөөс одоог хүртэл "Анд Глобал" компанийн Захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.9).
2. ТУЗ-ийн гишүүн Очирсүрэнгийн . Турк улсын Bogazici их сургуулийг Менежментийн чиглэлээртөгссөн, Монгол Улсын хугацаагүй эрхтэй Мэргэшсэн нягтлан бодогч, АНУ-ын Нью Хэмшер мужийн Мэргэшсэн нягтлан бодогч, Мэргэшсэн аудитор. 2010-2015 оны хооронд "PwC Mongolia"-д Аудитын ахлах менежер, 2015-2016 оны хооронд "PwC UK"-д Аудитын менежер, 2016-2017 онд Санхүү хариуцсан захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай бөгөөд 2017.08.01-ны өдрөөс одоог хүртэл "Анд Глобал" компанийн Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.10).
3. ТУЗ-ийн гишүүн Пүрэвсүрэнгийн Отгонбаяр, 2005 онд ШУТИС-ийн КТМСургуулийг Програм хангамжийн бакалавр зэрэгтэй, 2007 онд ШУТИС-КТМСургуулийг Програм хангамжийн магистр зэрэгтэй төгссөн. 2007-2016 оны хооронд "Мобиком" ХХК-ийн Төслийн менежер, 2016-2017 оны11 сар хүртэл "Анд Системс" ХХК-ийн Технологийн албаны даргаар тус тус ажиллаж байгаад 2017 оны11 сараас "Анд Системс Тех" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.11).

ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчийн 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн шийдвэр (Хавсралт 2.12)-ээр тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан ажиллаж байна:

1. ТУЗ-ийн дарга Д.Бат-Очир, 1994-1998 оны хооронд МУИС-ийн Эдийн засгийн Сургуулийг Эдийн засагч-Санхүүч мэргэжлийн бакалавр зэрэгтэйгээр, 006-2008 оны хооронд АНУ-ын Брандайз Их сургуулийг Олон улсын бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн. 2011-2014 оны хооронд "Хас банк"-ны Гүйцэтгэх захирлаар, 2014-2015 оны хооронд "Хас банк"-ны Ерөнхий захирлаар, 2016 оноос одоог хүртэл "Юнити Партнерс"-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.13).
2. ТУЗ-ийн гишүүн О.Болдбаатар (*дээрхээс танилцана уу*)
3. ТУЗ-ийн гишүүн Ч.Анар (*дээрхээс танилцана уу*)
4. ТУЗ-ийн гишүүн С.Оюун, 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн Сургуулийг Банк санхүүч мэргэжлийн бакалавр, 2009 онд ИБУИНВУлсын Сундерландийн Их сургуулийг Банк санхүүч мэргэжлийн магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн. Одоогоор "Кингдом Консалтинг" ХХК-ийн Гүйцэтгэх захирал, "Анд глобал" компанид Монгол талыг хариуцсан захирал, "Кингдом Инвест ББСБ"-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна (Хавсралт 2.14).
5. ТУЗ-ийн гишүүн А.Билгүүн, 2007 онд Канад улсын Сэнт Мэрис Их сургуулийг Санхүүч мэргэжлээр, Мэргэшсэн санхүүгийн Шинжээч цолтойгоор төгссөн. 2009-2012 оны хооронд "Монгруд" ХХК-ийн Гүйцэтгэх захирал, "Прайм Инфо" ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2007-2009 оны хооронд Канад улсын "Топ Кросс Секьюритис"-д Хөрөнгө оруулалтын банкны мэргэжилтнээр ажиллаж байсан бөгөөд 2012 оноос одоог хүртэл "Эм Ай Би Жи" ҮЦК-ийн Гүйцэтгэх захирал, 2015 оноос "Эрдэнэ Ресорс Девелопмент Корп"-ийн Бизнес хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байна. (Хавсралт 2.15)



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
20180119
LENDMN

ЛэндМН-ийн Гүйцэтгэх захирал М.Түвшинжаргал нь компанийн Хувьцаа Эзэмшигчийн 2016.12.05-ны өдрийн 16/07 дугаартай шийдвэр (Хавсралт 2.16)-ээр, Борлуулалт үйлчилгээний албаны дарга О.Амгаланбаяр нь Гүйцэтгэх захирлын 2017.02.01-ны өдрийн 2017/16 дугаартай тушаал (Хавсралт 2.17)-аар, Ерөнхий нягтлан бодогч Д.Отгонгэрэл нь Гүйцэтгэх захирлын 2017.08.31-ний өдрийн 2017/62 дугаартай тушаал (Хавсралт 2.18)-аар тус тус томилогдон ажиллаж байна.

1. М.Түвшинжаргал нь ШУТИС-ийг Инженер мэргэжлээр, СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагын бакалавр, магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн. 2016 он хүртэл "Ньюфонд ББСБ"-ын Зээлийн ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан бөгөөд 2016.12.05-ны өдрөөс ЛэндМН-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна (Хавсралт 2.19).

2. О.Амгаланбаяр нь Олон улсын эдийн засаг, бизнесийн дээд сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 2010-2014 оны хооронд "Жи-мобайлнет" ХХК-ийн менежер, 2014-2016 оны хооронд "Дон-Эсэн" ХХК-ийн ерөнхий менежерээр ажиллаж байсан. 2017.02.01-ний өдрөөс одоог хүртэл ЛэндМН-ийн Борлуулалт, үйлчилгээний албаны даргаар ажиллаж байна (Хавсралт 2.20).

3. Д.Отгонгэрэл нь Хөдөө Аж Ахуйн Их сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 2009-2017 онд Ньюфонд ББСБ-ын Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан. 2017.08.31-ний өдрөөс ЛэндМН-ийн Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна (Хавсралт 2.21).

ЛэндМН-ийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэгт заасны дагуу компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан болохыг доорх хүснэгтэд харуулав:

| № | Овог нэр | Албан тушаал | КЗ-ын гэрчилгээ олгосон байгууллага[2] | Огноо дугаар | Хавсралт дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Ч.Анар | ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүн | Компанийн засаглалын хөгжлийн төв | 2017.12.01 №0130849 | Хавсралт 2.22 |
| 2 | О.Болдбаатар | ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүн | Компанийн засаглалын хөгжлийн төв | 2017.12.01 №0130848 | Хавсралт 2.23 |
| 3 | Д.Бат-Очир | ЛэндМН-ийн ТУЗ-ийн дарга | АХБ, Компанийн Засаглалын Хөгжлийн Төв | 2015.03.19 | Хавсралт 2.24 |
| 4 | М.Түвшинжаргал | Лэндмн-ийн Гүйцэтгэх захирал | Компанийн засаглалын хөгжлийн төв | 2017.12.01 №0130845 | Хавсралт 2.25 |
| 5 | П.Отгонбаяр | Лэндмн-ийн Ерөнхий нягтлан | Компанийн засаглалын хөгжлийн төв | 2017.12.01 №0130850 | Хавсралт 2.26 |

[2] www.frc.gov.mn

6

20180119

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бодогч | | | |
| 6 | С.Оюун | Лэндмн-ийн ТУЗ-ын гишүүн | Компанийн засаглалын хөгжлийн төв | 2017.12.01 №0130853 | Хавсралт 2.27 |
| 7 | А.Билгүүн | Лэндмн-ийн ТУЗ-ын гишүүн | Компанийн засаглалын хөгжлийн төв | 2017.12.01 №0130851 | Хавсралт 2.28 |
| 7 | Ч.Намираа | ТУЗ-ын нарийн бичгийн дарга | Компанийн засаглалын хөгжлийн төв | 2017.12.01 №0130847 | Хавсралт 2.28 |

ЛэндМН-ийн Гүйцэтгэх захирал М.Түвшинжаргалыг ББСБ-ын эрх бүхий албан тушаалтнаар ажиллах зөвшөөрлийг СЗХ-ны даргын 2016.12.21-ний өдрийн 7/3727 дугаартай тушаал (Хавсралт 2.29)-аар олгосон байна. 2017.12.01-ны өдөр шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Бат-Очир, гишүүн О.Болдбаатар, Ч.Анар, С.Оюун, А.Билгүүн нарын зөвшөөрлийг авахаар СЗХ-нд хандаад байна. (Хавсралт 2.30)

ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч "Анд Системс" ХХК-ийн болон ЛэндМН-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, ЛэндМН-ийн Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан бөгөөд компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

**3. Компанийн дүрэм бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх**

Хууль зүйн дүгнэлт гаргахтай холбогдуулан компанийн доор дурдсан дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүдийг хянасан болно. Үүнд:

| № | Дүрэм журмын нэр | Баталсан этгээд | Огноо | Дугаар | Хавсралт № |
|---|---|---|---|---|---|
| 1 | "ЛэндМН ББСБ" ХХК-ийн дүрэм | Хувьцаа эзэмшигчийн шийдвэр | 2017.08.25<br>2017.11.014 | 2017/03<br>17/14 | 3.1<br>2.6 |
| 2 | "LENDMN" аппликейшнээр олгох Цахим зээлийн үйл ажиллагааны журам | М.Түвшинжаргал | 2016.12.23 | 07 | 3.2 |
| 3 | Дотоод хяналтын журам | М.Түвшинжаргал | 2016.01.04 | 2017/09 | 3.3 |
| 4 | Нягтлан бодох бүртгэлийн журам | М.Түвшинжаргал | 2017.03.21 | 29 | 3.4 |
| 5 | Нууцын заавар<br>Нууцын журам | М.Түвшинжаргал | 2017.01.04<br>2017.12.04 | 2017/01<br>124 | 3.5<br>3.5.1 |
| 6 | Дуудлагын төвийн ажилтны үйлчилгээний стандарт | М.Түвшинжаргал | 2017.08.31 | 2017/61 | 3.6 |



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA ҮЦК LLC
20180119
LENDMN ББСБ ХХК

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Хөдөлмөрийн дотоод журам | М.Түвшинжаргал | 2017.01.02 | 2017/04 | 3.7 |
| 8 | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам | М.Түвшинжаргал | 2017.05.20 | 2017/45 | 3.8 |
| 9 | Ногдол ашгийн бодлого | ЛэндМН ТУЗ | 2017.12.01 | 17/02 | 3.9 |

"ЛэндМН ББСБ" ХХК-ийн дээр дурдсан дүрэм, дотоодоо мөрдөж буй заавар, журмууд нь хууль тогтоомжид нийцэж байна. "Компанийн засаглалын кодекс шинэчлэн батлах тухай" СЗХ-ны 2014.05.07-ны өдрийн 162 дугаар тогтоолд зааснаар Хөрөнгийн биржийн "А" самбарт бүртгэгдээгүй байгаа компаниудын хувьд уг кодексийг мөрдлөг болгохыг зөвлөсөн байдаг. ЛэндМН нь IPO хийх бэлтгэл ажлын хүрээнд Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авч, Компанийн дүрмээ шинэчлэн баталж, 5 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ байгуулж, Эрх бүхий албан тушаалтнуудаа компанийн засаглалын сургалтанд хамруулсан байна. Түүнчлэн IPO амжилттай болсны дараа зохион байгуулагдах Хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар хэлэлцэн батлуулах зорилгоор "ЛэндМН ББСБ" Хувьцаат компанийн дүрмийн төсөл(Хавсралт 3.9), ХК-ийн анхны ТУЗ сонгогдсоны дараа зохион байгуулагдах ТУЗ-ийн анхны хурлаар батлуулах зорилгоор "ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам(Хавсралт 3.10)-ын төсөл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын (Хавсралт 3.11) төслийг тус тус боловсруулсан байна. Эдгээр дүрэм, журмын төслүүд нь цаашид энэхүү найруулгаараа батлагдана гэж үзвэл Компанийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай зэрэг Монгол Улсын хуулиуд, СЗХ-ны журам, Компанийн засаглалын кодекст нийцэж байна.

**4. Бусадтай байгуулсан худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэрээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх**

Бид дараах гэрээ болон загвар гэрээг компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэж үзэж, хянав.

***Лицензийн гэрээ.*** ЛэндМН нь "LendMN" аппликейшн, түүний системийг ашиглах, системийг онцгой эрхтэйгээр ашиглах түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, хэрэглэгчид хүргэх, дагалдах засвар үйлчилгээг авах, мэдээллийн нууцлал, системийн төлбөр тооцоо зэрэг асуудлыг 2017.01.02-ны өдөр "Анд Системс" ХХК-тай байгуулсан ""LendMN" Программ хангамж түрээсээр ашиглуулах, ашиглах гэрээ" (Хавсралт 4.1)-ээр зохицуулж ирсэн. Дээрх гэрээний дагуу ЛэндМН нь " Монгол Улсын Оюуны Өмч, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын даргын 2017.04.14-ний өдрийн тушаалаар бүртгэгдсэн 8504 дугаартай Зохиогчийн эрхийн гэрчилгээ (Хавсралт 4.2) бүхий "Анд Системс" ХХК-ийн өмчлөлийн "LendMN" /application, core system/ бүтээлийг онцгой эрхтэйгээр ашигладаг байна. Гэрээний талууд 2017.01.02-ны өдөр "Анд Системс" ХХК-тай байгуулсан ""LendMN" Программ хангамж түрээсээр ашиглуулах, ашиглах гэрээ"-г шинэчлэн 2017 оны 7 сарын 03-ны өдөр Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ (Хавсралт 4.3), Үйлчилгээний гэрээ (Хавсралт 4.4) гэсэн 2 тусдаа гэрээ байгуулсан байна. Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээгээр ЛэндМН (аппликейшн болон кор систем) програм хангамжийг Монгол Улсад онцгой эрхтэйгээр зөвхөн ЛэндМН-д ашиглуулах харилцааг зохицуулсан бол,



20180119

Үйлчилгээний гэрээгээр тус програм хангамжтай холбоотой бүх төрлийн үйлчилгээний харилцааг зохицуулсан байна. Эдгээр гэрээ нь Монгол Улсын Иргэний хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд нийцсэн байна.

ЛэндМН-ийн IPO хийх бэлтгэл ажлын хүрээнд толгой компани "Анд Системс" ХХК нь өөрийн Хувьцаа эзэмшигчийн 2017.10.26-ны өдрийн 17/11 дугаартай шийдвэр (Хавсралт 4.5)-ээр тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдаж, өөрийн 100 хувийн эзэмшлийн "Анд Системс Тех" ХХК байгуулсныг 2017.10.30-ны өдөр улсын бүртгэлд (Хавсралт 4.6 "Анд Системс Тех" ХХК-ийн гэрчилгээ) бүртгэсэн байна. "Анд Системс Тех" ХХК нь мэдээлэл технологийн үйл ажиллагаа, програм хангамжийн үйлчилгээ болон гадаад худалдааны (Хавсралт 4.7–"Анд Системс Тех" ХХК-ийн дүрэм) чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх бөгөөд толгой компани болох "Анд Системс" ХХК-аас 8504 дугаартай Зохиогчийн эрхийн гэрчилгээтэй ЛэндМН (аппликейшн болон кор систем) програм хангамж бүтээлийг өмчлөх эрхийг шилжүүлэн авсныг ОӨУБЕГ-ын Оюуны өмчийн газар 2017.11.20-ны өдөр А/941 тоот тушаалаар бүртгэж, 8504 дугаартай зохиогчийн эрхийн гэрчилгээ (Хавсралт 4.8)-г "Анд Системс Тех" ХХК-ийн нэр дээр олгосон байна. Улмаар "Анд Системс" ХХК болон "ЛэндМН ББСБ" ХХК-ийн хооронд 2017 оны 07 сарын 03-ны өдөр байгуулсан Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ болон Үйлчилгээний гэрээний холбогдох заалтын дагуу эрх залгамжлалын журмаар уг гэрээнүүдийн эрх үүрэг нь "Анд Системс Тех" ХХК-д хамаарч байна.

***Цахим зээлийн гэрээ.*** ЛэндМН-ийн хэрэглэгчидтэй хийдэг "Цахим зээлийн эрх нээх гэрээ" (Хавсралт 4.11)-ээр Зээлдэгчийн "LendMN" аппликейшнээс сонгон илгээсэн тухайн хүсэлт бүрийн дагуу гэрээнд заасан нөхцөлөөр Зээлдэгчийн дансанд зээлийн мөнгөн хөрөнгийг шилжүүлэх, Зээлдэгч хугацаандаа зээл, түүний шимтгэл, хүүг эргүүлэн төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулж байна. Зээлийн доод хэмжээ 50.000 төгрөг, дээд хэмжээ 1.000.000 төгрөг байна. ЛэндМН-ийн зээлийн бүтээгдэхүүн нь хугацаанаас хамаарсан 4 төрөлтэй: (i) 7 хоногийн, (ii) 14 хоногийн, (iii) 21 хоногийн, (iv) 30 хоногийн хугацаатай. Зээлдэгч зээлийг хугацаанд нь төлсөн тохиолдолд хүү тооцохгүй бөгөөд хугацаа хэтрүүлсэн тохиолдолд сарын 5%-ийн хүү тооцохоор гэрээнд заасан. Зээлийн бүтээгдэхүүн тус бүр нь тухайн зээлдэгчийн зээлийн скоре, төрөл, хэмжээнээс хамаарсан ялгаатай шимтгэлтэй байх бөгөөд зээлийг хугацаанаас өмнө төлсөн нь зээлийн шимтгэл төлөх нөхцөлд өөрчлөлт оруулахгүй байна. Энэхүү зээлийн гэрээг Зээлдэгч өөрт ойр байрлах нотариатаар гэрчлүүлэх, эсвэл өөрийн биеэр компани дээр ирж байгуулах замаар "зээлийн гэрээг бичгээр байгуулах" хуулийн шаардлагыг хангаж байна. Уг Цахим зээлийн эрх нээлгэх гэрээг нэг жилийн хугацаагаар байгуулж, цаашид сунгах боломжтой. Уг гэрээний дагуу зээлдэгч анхны удаа зээл авч, зээлийн мөнгийг зээлдэгчийн дансанд шилжүүлснээр гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлтэй байна.

***Хамтын ажиллагааны гэрээ.*** ЛэндМН нь эрсдэлийг бууруулах, төлбөр хариуцагчийн санхүүгийн хариуцлагыг сайжруулах үүднээс Монголбанкны ажиллуулж буй зээлийн мэдээллийн санд байгаа иргэд, аж ахуйн нэгжийн зээл, хүлээж болзошгүй үүрэг, үнэт цаас, бусад актив өр төлбөр болон холбогдох бусад мэдээллийг харилцан солилцох зорилгоор Монголбанкны Хяналт шалгалтын газрын захиралтай 2016.08.08-ны өдөр "Хамтын ажиллагааны гэрээ" (Хавсралт 4.12) байгуулсан байна.

***Хөлсөөр ажиллах гэрээ.*** ЛэндМН ХХК-ийн тухайн үеийн хувьцаа эзэмшигч нь Гүйцэтгэх захирал М.Түвшинжаргалтай 2017.03.02-ны өдөр "ЛэндМН ББСБ" ХХК-ийн гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ" (Хавсралт 4.13)-г 3 жилийн хугацаатай байгуулсан бөгөөд түүнд Гүйцэтгэх удирдлагын статус, бүрэн эрх, чиг



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

СЗХ БҮРТГЭВ № 01

MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC

LENDMN ББСБ ХХК

20180119

үүрэг, хариуцлага, сонгох, огцруулах нөхцөл, цалин урамшуулал зэргийг тодорхойлж, Гүйцэтгэх захирлаас компанийн өдөр тутмын үйл ажиллагааг үнэн зөвөөр, шударгаар, гагцхүү компанийн ашиг сонирхолд нийцүүлэн удирдан зохион байгуулах эрх зүйн үндсийг тогтоосон байна.

*Хөдөлмөрийн гэрээний загвар.* Ажилтнуудтай байгуулдаг Хөдөлмөрийн загвар гэрээ (Хавсралт 4.14) нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

*Нууцлалын гэрээний загвар.* Ажилтнуудтай байгуулдаг Нууцлалын загвар гэрээ (Хавсралт 4.15) нь Байгууллагын нууцын тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хуульд нийцсэн байна.

*Оффисын түрээсийн гэрээ.* ЛэндМН нь Сүхбаатар дүүрэг, 5-р хороо хаягт байрших "Нью Майнд Групп" ХХК-ийн барилгын нэг давхрын 101.59 ам.метр бүхий оффисын зориулалттай талбайг сар бүр нийт 1.523.850 төгрөгийн түрээсийн төлбөртэйгээр "Нью Майнд Групп" ХХК-тай байгуулсан 2017.01.02-ны өдрийн гэрээ(Хавсралт 4.16)-гээр түрээслэн үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой гэж үзсэн дээр дурдсан гэрээнүүд Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн, хэрэгжих боломжтой байна.

Түүнчлэн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан үнэт цаасаа бүртгүүлэхэд бэлтгэх ажиллагааны хүрээнд Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХаанЛекс" ХХН-тэй "Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ" (Хавсралт 1.2), "Мирэ эссет Секьюритис Монгол ҮЦК" ХХК-тай "Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ", "Андеррайтерын үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.17), Эрнст энд Янг Монгол Аудит ХХК-тай Аудитын үйлчилгээний гэрээ(Хавсралт 4.18, 2017.11.08-ны өдрийн гэрээ байгуулахыг зөвшөөрсөн хариу албан тоот), "Гэрэгэ Эстимэйт" ХХК-тай байгуулсан "Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ" (Хавсралт 4.19)-г тус тус байгуулсан нь хуульд нийцсэн, хэрэгжих боломжтой байна.

5. **Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа бол хуульд заасан журмын дагуу байгуулсан эсэх**

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандаж сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй дор дурдсан хэлцлүүдийг бидэнд ирүүлснийг хянав:

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний зэр түүний гол нөхцөл | Гэрээний огноо, дугаар/ Хавсралт№ | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох | Хуулийн шаардлага хангасан эсэх | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Анд Системс" ХХК | "Зээлийн гэрээ"-2 сарын хугацаатай, сарын 1,5 хувийн хүүтэй, 75 сая төгрөгийн зээлдүүлсэн | 2017.02.22, №10000001 /Хавсралт 5.1 | Сонирхлын зөрчилтэй | Хангасан хэш[1] 2017.11.02 | 2017.04.05-ны өдөр хаасан / |

[1] Хувьцаа эзэмшигчийн шийдвэр



D. [signature]

МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК ХХК
MIRAE ASSET SECURITIES MONGOLIA LLC
УЛААНБААТАР ХОТ

20180119



ЛЭНДМН ББСБ ХХК
LENDMN
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

СЗХ

БҮРТГЭВ 01
СЗХ БҮРТГЭВ

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | "Анд Системс" ХХК | "Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ"- жилийн 18 хувийн хүүтэй, 2017.11.22-ны өдрийг хүртэл хугацаатай, 345,000,000 /гурван зуун дөчин таван сая/ төгрөгийн хаалттай өрийн бичиг гаргаж худалдсан | 2017.08.22 №01 /Хавсралт 5.2 | Их хэмжээний[4] бөгөөд сонирхлын зөрчилтэй | Хангасан ХЭШ 2017.11.02 | 2017.09.27-ны өдөр хаасан |
| 3 | "Анд Системс" ХХК | "Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ"- жилийн 18 хувийн хүүтэй 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгийн өрийн бичиг гаргаж "Анд Системс" ХХК-д худалдсан | 2017.10.30 №02 /Хавсралт 5.3 | Их хэмжээний[5] бөгөөд сонирхлын зөрчилтэй | Хангасан ХЭШ 2017.11.02 | 2017.11.10-ны өдөр хаасан |
| 4 | "Кингдом Инвест ББСБ" ХХК | "Зээлийн гэрээ"-2 сарын хугацаатай, сарын 2 хувийн хүүтэй, 250,000,000 төгрөгийг зээлсэн | 2017.06.02 №06/2017 /Хавсралт 5.4 | Их хэмжээний[6] | Хангасан ХЭШ 2017.11.02 | 2017.09.27-ны өдөр хаасан |
| 5 | "Чойжин Брос ББСБ" ХХК | "Зээлийн гэрээ"-2 сарын хугацаатай, сарын 1.5 хувийн хүүтэй, 320,000,000 төгрөгийг зээлсэн | 2017.08.30 № ЗГ170801 /Хавсралт 5.5 | Их хэмжээний[7] | Хангасан ХЭШ 2017.11.02 | 2017.09.27-ны өдөр хаасан |
| 6 | Нью Майнд Групп ХХК | "Түрээсийн гэрээ" – СБД, 5-р хороо, "Нью майнд" группын 101.59 ам.метр бүхий байрыг 2018.01.02-ний өдрийг хүртэл түрээслэх | 2017.01.02 /Хавсралт 4.13 | Сонирхлын зөрчилтэй | Хангасан ХЭШ 2017.11.02 | Хэрэгжиж байгаа бөгөөд хэрэгжих боломжтой |
| 7 | Иргэн Ж.Оюун | "Хаалттай өрийн бичиг худалдах, | 2017.11.10 | Их хэмжээний | Хангасан | Хэрэгжиж байгаа |

[4] 2017.06.30-ны өдрийн байдлаар актив нь 1,050,669,400 төгрөг /2017 оны 2-р улирлын санхүүгийн тайлан Хавсралт 5.10/

[5] 2017.09.30-ны өдрийн байдлаар актив нь 2,454,947,000.00 төгрөг /2017 оны 3-р улирлын санхүүгийн тайлан Хавсралт 5.11/

[6] 2017.03.31-ний өдрийн байдлаар актив нь 762,675,200 төгрөг /2017 оны 1-р улирлын санхүүгийн тайлан Хавсралт 5.9/

[7] 2017.06.30-ны өдрийн байдлаар актив нь 1,050,669,400 төгрөг /2017 оны 2-р улирлын санхүүгийн тайлан Хавсралт 5.10/



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA ҮЦК LLC
20180119
LENDMN

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | гэрээ | худалдан авах гэрээ"- жилийн 16 хувийн хүүтэй 1.000.000.000 /нэг тэрбум/ төгрөгийн өрийн бичгийг 1 жилийн хугацаатай гаргаж иргэн Ж.Оюунгэрэлд худалдсан | /Хавсралт 5.6 | хэлцэл[8] | ХЭШ 2017.11.02 | бөгөөд хэрэгжих боломжтой |
| 8 | М.Түвшин жаргал | "Зээлийн гэрээ" – 25 сарын хугацаатай, сарын 1%-ийн хүүтэй, 8.000.000 төгрөгийг зээлсэн | 2016.12.01 №06/2016 /Хавсралт 5.7 | Сонирхлын зөрчилтэй | Хангасан ХЭШ 2017.11.02 | 2017.12.06-ны өдөр хаасан |

Тус компани сүүлийн 3 жилд хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй 8 гэрээ иргүүлсэн. Компанийн тухай хуульд заасны дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг Гүйцэтгэх захирлад олгосон шийдвэрийг тус компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Ч.Анар гаргаж, Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулсан байна. Эдгээр 8 гэрээний 2 гэрээнээс бусад нь хэрэгжиж дууссан, дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна. Дурдсан 8 гэрээг Компанийн тухай хуулийн 11, 12 дугаар бүлэгт заасан журмын дагуу байгуулсан байна. Одоо хэрэгжилтийн шатанд байгаа 2 гэрээ нь цаашид хэрэгжих боломжтой гэж үзэв.

**6. Үйл ажиллагааны гол үндэслэл болсон аливаа тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болох нөхцөл байгаа эсэх;**

"ЛэндМН ББСБ" ХХК (Хуучин нэрээр "Дуусашгүй ундарга" ХХК) СЗХ-2015.06.24-ний өдрийн 293 дугаар тогтоолоор "Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа" эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Уг тусгай зөвшөөрөл нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар (Хавсралт 6.1) хүчин төгөлдөр бөгөөд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна. СЗХ-ны 2017.11.13-ны өдрийн 9/3314 дугаар албан бичиг (Хавсралт 6.2)-т ЛэндМН-д захиргааны хариуцлага ногдуулсан талаар мэдээлэл СЗХ-ны бүртгэлд бүртгэгдээгүй болохыг дурдсан байна.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Оюуны өмчийн газраас 2017.11.02-ны өдөр ирүүлсэн 10/9172 дугаартай албан бичигт (Хавсралт 6.3) дурдсанаар ЛэндМН-ийн нэр дээр ямар нэгэн барааны тэмдэг, зохиогчийн эрх, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар дагуу бүртгэгдээгүй байна гэсэн хэдий ч тус компани барааны тэмдгээ бүртгүүлэхээр ОӨУБЕГ-т хандсаныг тус газар 2017.11.2-ний өдрийн 14 цаг 17 минут 34 секундэд хүлээн авсан байна (Хавсралт 6.4). Мөн "Анд Системс Тех" ХХК-тай Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээний дагуу  дагуу ОӨУБЕГ-ын Оюуны өмчийн газарт 2017.11.20-ны өдөр бүртгэгдсэн, 8504 дугаартай зохиогчийн эрхийн гэрчилгээ (Хавсралт 4.6) бүхий ЛэндМН (аппликейшн болон кор систем) програм хангамж бүтээлийг ашиглаж байгаа тухай дээр дурдсан болно.

---

[8] 2017.09.30-ны өдрийн байдлаар актив нь 2,454,947,000.00 төгрөг /2017 оны 3-р улирлын санхүүгийн тайлан Хавсралт 5.11/

7. **Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх**

ОӨУБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын Нийслэлийн улсын бүртгэлийн газраас 2017.10.25-ны өдөр ирүүлсэн 002738573 тоот албан бичиг (Хавсралт 7.1)-т дурдсанаар ЛэндМН-ийн өмчлөлд бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгө байхгүй болно.

"ЛЭНДМН" ХХК нь 0830УБО улсын бүртгэлийн дугаартай ZVW305057939 арлын дугаартай Toyota Prius маркийн тээврийн хэрэгсэл (Хавсралт 7.2) өмчилдөг бөгөөд тус тээврийн хэрэгслийг бусдад барьцаалаагүй болно[9]. "Монре даатгал" ХХК-тай 2016.12.01-ний өдөр нэг жилийн хугацаатай байгуулсан 16155200647122 тоот "Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын" гэрээ (Хавсралт 7.4)-ээр уг машины жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг жолооч хязгааргүйгээр байгуулсан байна. Тус даатгалыг 2017.11.21-ний өдөр 17151003611202 тоот "Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын" гэрээ (Хавсралт 7.5)-ээр нэг жилийн хугацаатай үргэлжлүүлэн байгуулсан байна

Нийслэлийн газрын албанаас 2017.10.30-ны өдөр ирүүлсэн 03/4053 тоот албан бичигт дурдсанаар нийслэлийн газрын мэдээллийн санд ЛэндМН-д газар эзэмшүүлж, ашиглуулсан тухай бүртгэл байхгүй (Хавсралт 7.6).

ЛэндМН нь үнэт цаас эзэмшдэггүй болно.

8. **Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;**

Лэндм-ийн Хувьцаа эзэмшигчийн 2017.12.08-ны өдрийн 17/18 дугаартай шийдвэр (Хавсралт 8.1)-ээр:

1. Компанийн одоо гаргасан байгаа нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 600,000,000 (зургаан зуун сая) ширхэг энгийн хувьцаан дээр 85,714,286 (наян таван сая долоон зуун арван дөрвөн мянга хоёр зуун наян зургаа) ширхэг энгийн хувьцааг нэмж гарган олон нийтэд санал болгох;
2. "Гэрэгэ Эстимэйт" ХХК-ийн гаргасан ""ЛэндМН ББСБ" ХХК-ийн Хараат бус бизнесийн үнэлгээний тайлан", "Мирэ Эссет Секьюритис Монгол" ҮЦК-ийн андеррайтерийн мэргэжлийн зөвлөгөөг харгалзан Компанийн нэмж гаргасан 85,714,286 ширхэг буюу компанийн нийт гаргасан хувьцааны 12.5 (арван хоёр аравны таван) хувьтай тэнцэх энгийн хувьцааны олон нийтэд санал болгох нэг бүрийн үнийг 30 (гучин) төгрөгөөр тогтоож, Биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийтэд санал болгож, хувьцаа гаргахаас өмнөх болон дараах хувь эзэмшлийг доор дурдсанаар тогтоохоор шийдвэрлэсэн:

| Хувьцаа эзэмшигч | Хувьцаа гаргахаас өмнө | | Хувьцаа гаргасны дараа | |
|---|---|---|---|---|
| | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшлийн хувь | Эзэмшиж буй хувьцааны тоо | Эзэмшлийн хувь |
| Анд Системс ХХК | 600,000,000 | 100 % | 600,000,000 | 87.5 % |
| Олон нийт | - | - | 85,714,286 | 12.5% |
| Нийт дүн | | | 685,714,286 | 100% |

[9] http://mpr.gov.mn/public/uccsearch.aspx



20180119

3. Анхлагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь 2,571,428,580 (хоёр тэрбум таван зуун далан нэгэн сая дөрвөн зуун хорин найман мянга таван зуун наян) төгрөг байхаар тооцож уг мөнгөн хөрөнгийг Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулах;
4. одоогийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасан тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байна.

ЛэндМН ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын энэхүү шийдвэр нь Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.6, 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4, 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, "ЛэндМН ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6.1.1, 6.2.7 дахь заалт, хувьцаа эзэмшигч "Анд Системс" ХХК (цаашид "Хувьцаа эзэмшигч" гэх)-ийн дүрмийн 6.1.6(а) дахь заалтуудад нийцсэн байна.

Нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулсан, компани, түүний холбогдох этгээд болон гуравдагч этгээдээс гаргуулсан мэдээллүүдийг шинжилсний үндсэн дээр Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж үзэв.

**9. Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд нь хэн болох**

ЛэндМН ББСБ ХХН-ийн хуулийн этгээдийн нэгдлийн хамаарлыг доорх схемд харуулав.




Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэлийн төв архивын газраас 2017.10.26-ны өдөр 002769272 тоот албан бичгээр ирүүлсэн ЛэндМН-ийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 9.1)-г тус өдрийн байдлаар гаргуулан судлав. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ЛэндМН-ийн хувьцааг Монгол Улсын хуулийн этгээд "Анд Системс" ХХК 100 хувь эзэмшиж байна.

"Анд Системс" ХХК-ийн 2015.09.24-ны өдөр батлагдсан дүрмийн дагуу (Хавсралт 9.2) "Анд Системс" ХХК-ийн хувьцааг Сингапур улсын хуулийн этгээд "Анд глобал" компани 100 хувь эзэмшиж байна.

Сингапур улсын нягтлан бодох бүртгэл, компанийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн байгууллага (Accounting and corporate Regulatory Authority)-ын цахим

хуудсанд тавигдсан мэдээллийг[10] үндэслэн (Хавсралт 9.3) "Анд Глобал" компанийн энгийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг дараах хүснэгтээр харуулж байна. Үүнд:

| № | Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр | Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|---|
| 1 | Iro Consulting Singapore PTE.LTD | 4,000,000.00 | 34% |
| 2 | Батболдын Долгоон | 1,470,589.00 | 13% |
| 3 | Гаравсүрэнгийн Илэрмаа | 2,855,883.00 | 24% |
| 4 | Таками Юичи | 1,529,412.00 | 13% |
| 5 | Ясуёо Мацумото | 677,995.00 | 6% |
| 6 | Бусад этгээд (5%-аас бага) | 1,230,827 | 10% |
| **Нийт** | | 11,764,706.00 | 100% |

Дээр дурдсан цахим хуудасны мэдээллээс үзвэл[11] (Хавсралт 9.4) "IRO Consulting Singapore" ХХК-ийн хувьцааг доор дурдсан хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Үүнд:

| № | Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|
| 1 | Пүрэвсүрэнгийн Наранбаяр | 10% |
| 2 | Үүеэгийн Отгонбаяр | 20% |
| 3 | Чинбаатарын Анар | 20% |
| 4 | Очирсүрэнгийн Болдбаатар | 20% |
| 5 | Пүрэвсүрэнгийн Отгонбаяр | 20% |
| 6 | Таками Юичи | 10% |
| **Нийт** | | 100% |

"ЛэндМН ББСБ" ХХК-ийн 100 хувийн хяналтыг Монгол Улсын хуулийн этгээд болох "Анд Системс" ХХК (түүний ТУЗ) хэрэгжүүлж байна. "Анд Системс" ХХК-ийн 100 хувийн хяналтыг Сингапур Улсын хуулийн этгээд "Анд Глобал" компани хэрэгжүүлж байна. Иргэний хуулийн 26.4-т: "Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд орно" гэж заасан тул бид дээрх компаниудын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргахад хамгийн нөлөө бүхий хувь хүн (хүмүүс) үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв. Ингэхдээ Компанийн тухай хуулийн компанийн нэгдлийн талаар зохицуулсан 6 дугаар зүйл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон 99.1-д дурдсан зохицуулалтыг анхааралдаа авсан болно.

Дээрх бүх шинжилгээний үндсэн дээр энэхүү хуулийн дүгнэлтийг гаргах бэлэн байдлаар:

[10] https://www.acra.gov.sg
[11] https://www.acra.gov.sg

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

1. **Чинбаатарын Анар** нь:
   - ✓ "IRO Consulting Singapore" ХХК-ийн энгийн хувьцааны 20 хувийг эзэмшигч;
   - ✓ "IRO Consulting Singapore" ХХК-ийн Гүйцэтгэх захирал;
   - ✓ "IRO Consulting Singapore" ХХК ("Анд глобал" компанийн 34 хувийг эзэмшигч)-ийн харьяат компани болох "Анд Глобал" ХХК-ийн гурван захирлын нэг;
   - ✓ "Анд глобал" компанийн 100 хувийн охин компани болох "Анд Системс" ХХК-ийн ТУЗ-ийн дарга;
   - ✓ "Анд Системс" ХХК-ийн 100 хувийн охин компани болох, үнэт цаас гаргагч ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүн, түүнчлэн
2. **Очирсүрэнгийн Болдбаатар** нь:
   - ✓ "IRO Consulting Singapore" ХХК-ийн энгийн хувьцааны 20 хувийг эзэмшигч;
   - ✓ "Анд Глобал" ХХК-ийн гурван захирлын нэг;
   - ✓ "Анд Системс" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн;
   - ✓ ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүн болох нь тус тус тогтоогдож байна.

Ч.Анар, О.Болдбаатар нар нь хамтдаа "ЛэндМН ББСБ"-ын жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч хэмээн тодорхойлж байна. Энэхүү дүгнэлт нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдах байна.

**10. Тухайн компанийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон нэмэлт шинжилгээ, судалгаа**

ЛэндМН нь 2017.11.07-ны өдрийн байдлаар 2,419,403.60 төгрөгийн татварын илүү төлөлттэй[12], гаалийн байгууллагад гаалийн татварын[13] болон нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэлийн өр, төлбөргүй[14] байна.

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэж, хөндлөнгийн мэдээлэл цуглуулж зарим нэмэлт шинжилгээ судалгаа (Due diligence) хийж, гаргасан нэмэлт дүгнэлтийг Хавсралт-10.1-10.14-өөс танилцана уу.

**11. Үнэт цаас гаргагчийн зарим онцлог**

IPO хийхээр зорьж буй ЛэндМН-ийн хувьд дараах онцлогтой болохыг төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллага, хөрөнгө оруулагчдад танилцуулах нь зүйтэй гэж үзэв.

***IPO хийж байгаа анхны ББСБ.*** ЛэндМН нь хувьцаа нэмж гарган биржээр дамжуулан нийтэд санал болгон арилжаалж, улмаар нээлттэй хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдахаар зорьж байгаа анхны ББСБ гэдгээрээ онцлог юм. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002 он)-ийн 5.1-т "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулна" гэж заасан. Өөрөөр хэлбэл уг хууль зөвхөн хязгаарлагдмал хариуцлагатай компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэнэ гэсэн хязгаар тавиагүй, мөн хувьцаат компани банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоогүй. Түүнчлэн Компанийн тухай хуулийн 23.1-т эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр нь

[12] Улсын [illegible] 2017.11.07-ны өдөр [illegible] (Хавсралт 10.1)
[13] Гаалийн [illegible] 2017.10.25-ны [illegible] 03-1/4224 [illegible] (Хавсралт 10.2)
[14] [illegible] 2017.11.03-ны өдрийн [illegible] (Хавсралт 10.3)



MIRAE ASSET
SECURITIES
MONGOLIA UTSB
LLC

LENDMN

20180119

алинаа хориг, хязгаарлалт тогтоохгүйгээр "хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно" гэж заасан.

Иймд онолын хувьд ч, хууль зүйн хувьд ч IPO  хийх нь ББСБ-уудад нээлттэй байна.

***ЛэндМН ББСБ-ын хувьд хууль тогтоомжид заасан зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаарх мэдээлэл хөрөнгө оруулагчдын хувьд ач холбогдолтой.*** "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 13.1-д "Банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрч болохгүй", 13.2-т "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах төлбөрийн баталгааны нийт дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 70 хувиас илүүгүй байна", 13.3-д "Тухайн банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, баталгааны дээд хэмжээ нь банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 10 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас тус тус хэтэрч болохгүй" гэж тус тус заасан байдаг. ЛэндМН нь үйл ажиллагаандаа дээрх ББСБ-д тавигдах хуульд заасан шаардлагыг хангаж ажиллаж байна. Мөн СЗХ-нд 2017.09.30-ны өдөр хүргүүлсэн "Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт"-ийн тайлан (Хавсралт 11.2)-аас үзвэл ЛэндМН нь СЗХ-ны "Банк бус санхүүгийн байгууллагын зохистой харилцааны шалгуур үзүүлэлт"-үүдийг  хангаж байна.

***ЛэндМН үйлчилгээгээ цахим хэлбэрээр үзүүлдэг онцлогтой.*** ЛэндМН нь Зээлийн үйлчилгээг мэдээллийн технологи дээр суурилан үзүүлдэг. Зээлээ хугацаанд нь төлсөн тохиолдолд хүүгүй боловч зээл авахад зээлдэгч нэг удаа шимтгэл төлнө. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн хүүгийн талаарх зохицуулалтыг тодорхойлсон Иргэний хууль (цаашид "ИХ" гэх)-ийн 452.1-д "Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно" гэж заасан тул ЛэндМН зээлээ хүүгүй олгож байгаа нь ("LENDMN аппликейшнээр олгох цахим зээлийн үйл ажиллагааны журам"-ын 4.4-т: зээлдэгч зээлээ хугацаандаа төлсөн бол "0 хувь"-ийн хүүтэй байна) хуульд нийцсэн бөгөөд энэ талаар цахим хуудсаар мэдээлсэн байна (ИХ-ийн 452.3).

Иргэний хуулийн 452.2-т: "Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд заах болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд энэ хэсгийг хэрэглэхгүй" гэж заасан байдаг. "LENDMN аппликейшнээр олгох цахим зээлийн үйл ажиллагааны журам"-ын 4.5-д: "хугацаа хэтэрсэн зээлд сарын 5 хувь буюу хугацаа хэтрүүлсэн хоног тутам 0.5 хувийн хүү бодогдоно" гэж заасан нь хүүгийн хэмжээг талууд тохиролцон тогтоох зарчимд нийцэж байгаа бөгөөд харин хугацаа хэтрүүлбэл нэмэгдүүлсэн хүүг хэрэглэх талаар уг журамд заагаагүй нь угаас үндсэн хүүгүй байгаатай холбоотой байна. Хэдийгээр журмын 4.5 дахь заалт байгаа ч ЛэндМН-ийн уг аппликейшнээр олгосон зээлд 5 хувийн хүү тооцож авсан, хоног тутам 0.5 хувийн хүү тооцож авсан нэг ч тохиолдол гараагүй (Хавсралт 7.8- Гүйцэтгэх захирлын баталгаа хийсэн бичиг) бөгөөд дурдсан журмын 4.5-ын сүүлчийн өгүүлбэрт "Энэхүү хүүг нэмэгдүүлэх эсэхийг ББСБ-ын Гүйцэтгэх удирдлага шийдвэрлэнэ" гэж заасныг үзвэл Гүйцэтгэх захиралд журмаар уг бүрэн эрхийг олгосон байна. Зээлийн үйлчилгээнээс өөр үйл ажиллагаа эрхлэхгүй ББСБ нь зээлийн хүү авахгүйгээр зардлаа нөхөх боломжгүй учраас Зээлдэгч нэг удаа зээлийн шимтгэл төлдөг байна. Зээлийн шимтгэл нь зээлийг ашигласан хугацаанаас



MIRAE ASSET SECURITIES MONGOLIA UTsK LLC

ЛЭНДМН ББСБ ХХК
LENDMN

20180119

хамаарахгүй, харин зээлдэгчийн кредит түвшин, зээлийн хэмжээ, зээлийн хугацаанаас хамаарч "LendMN" аппликейшинд (хиймэл оюун ухаан) тооцоологдсон тогтмол дүн байдаг байна.Аппликейшнээр үзүүлэх зээлийн үйлчилгээнд хүү тооцолгүй 1 удаа шимтгэл авч байгаа нь мэдээллийн технологи ашиглан үзүүлэх үйлчилгээг хэрэглэгчид энгийн, ойлгомжтой болгоход чиглэсэн байна.

## 12. ҮНДСЭН ДҮГНЭЛТ

"ЛЭНДМН" КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ДУРДСАН МЭДЭЭЛЭЛ ҮНЭН ЗӨВ, ХУУЛЬД НИЙЦСЭН БАЙНА. Энэ талаарх нотлох баримтуудтай Хавсралт 12–оос танилцана уу.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН,
ХУУЛЬЧ Д.ДҮГЭРЖАВ



20180119

## 3.8 АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК нь Монгол улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"[13] болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"[14]-ийн холбогдох заалтуудын дагуу үнэт цаас гаргагч ЛэндМН ББСБ ХХК(РД: 5039754)-тай 2017 оны 11 сарын 06-ны өдөр 2017-А015 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулан ажилласан болно.

Андеррайтер нь тус гэрээний ажлын даалгаврын хүрээнд ЛэндМН ББСБ ХХК-ийн үйл ажиллагааны цар хүрээ, зорилтот зах зээлийн ирээдүйн боломж, хувьцааг олон нийтэд санал болгоход хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжил болон олон нийтэд хүртээмжтэй байдалд оруулах хувь нэмэр, нийгмийн хариуцлага, компанийн засаглал зэрэг олон талт судалгааг явуулан холбогдох хууль, дүрэм журмын дагуу хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудын хараат бус дүгнэлтэд үндэслэн энэхүү "Үнэт цаасны танилцуулга"-ыг боловсруулан, Андеррайтерийн мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна.

Бид Андеррайтерийн дүгнэлтийн цар хүрээг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

1. Үнэт цаас гаргагчийн тухай
2. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны тухай
3. Үнэт цаас гаргагчийн бизнесийн ирээдүйн боломжийн тухай
4. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээллийн тухай
5. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын тухай
6. Хөрөнгө оруулалтын өгөөж
7. Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө
8. Үнэт цаасыг олон нийтэд санал болгох төлөвлөгөөний "Хөрөнгийн зах зээлийн хөгжил"-д оруулах хувь нэмэр:
9. Хөрөнгө оруулагчдын анхаарах зүйлс
10. Нэгдсэн дүгнэлт

[13] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.1-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгохдоо андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулна гэж заасан бөгөөд, тус хуулийн 41.1-д Андеррайтерийн үйл ажиллагааг "Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдан авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ" хэмээн заасан.

[14] МХБ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 12 сарын 30-ны өдрийн 2015/14 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан тус журмын 4.1-д "Хүсэлт гаргагч нь Биржийн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд /цаашид "андеррайтер" гэх/-тэй гэрээ байгуулан бүртгүүлэх ажиллагааны бэлтгэлийг хангана" хэмээн заасан.

## 1. Үнэт цаас гаргагчийн тухай

Үнэт цаас гаргагч нь анх 2006 онд байгуулагдаж, 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдөр СЗХ-ноос "Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа" эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр СЗХ-ны даргын тушаалаар компанийн оноосон нэрийг "ЛэндМН ББСБ" ХХК болгон өөрчилсөн байна.

Үнэт цаас гаргагч нь нь Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хослуулсан "Финтек" шийдлийг танилцуулсан бичил хэрэглээний зээлийг гар утаснаасаа шуурхай авах боломжийг анх удаа нутагшуулснаараа онцлогтой юм.

Үнэт цаас гаргагчийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Анд Системс ХХК-ийн охин компани болох Анд Системс тех ХХК нь 2017 оны 7 сарын 1-ний өдөр байгуулсан "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх(лиценз)-ийн гэрээ"-ээр ЛэндМН ББСБ ХХК-д 50 жилийн хугацаатайгаар "LendMN" аппликейшнийн оюуны өмчийг Монгол улсын нутаг дэвсгэрт онцгой эрхтэйгээр ашиглах эрхийг олгосон нь технологийн шийдлийг тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн үнэт цаас гаргагчийн толгой компани болох Сингапур улсад бүртгэлтэй Анд Глобал компани нь Сингапур, Филиппин, Малайз, Индонез, Япон зэрэг Ази Номхон Далайн орнуудын зах зээлд "ЛэндМН финтек шийдэл"-ийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа нь хэдийгээр өрсөлдөгч компаниуд төрөн гарсан ч технологийн шийдлийн хувьд олон улсын түвшнээс хоцрохгүй байнга сайжруулан хөгжүүлэх боломжтой гэсэн итгэлийг төрүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ын гишүүд болон гүйцэтгэх удирдлага нь бүгд компанийн засаглалын сургалтанд хамрагдсан бөгөөд тухайн салбартаа олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, хоорондоо нэгдмэл сонирхолгүй, бие даан шийдвэр гаргах чадвартай буюу компанийн сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэн компанийн тогтвортой хөгжлийг ханган ажиллах бүрэн боломжтой бөгөөд МХБ ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11.1.4[15] болон 12.1.6[16]-ын заалтуудыг тус тус хангаж байгаа болно.

[15] Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах туршлагатай байх.

[16] Үнэт цаас гаргагч, түүний хувьцааны хяналтын багцыг эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал нь татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх, хэрэв ертэй тохиолдолд

20180119

## 2. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагааны тухай

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын санхүүгийн зах зээлд гар утаснаасаа түргэн шуурхай бичил хэрэглээний зээл авах "шинэ шийдэл"-ийг нэвтрүүлснээрээ иргэдийн өдөр тутмын санхүүгийн зээлийн харилцааг хялбаршуулж байгаа нь компанийн үйл ажиллагааны үр дүнгээр тодорхойлогдож байна.

Үүнд компани нь 2016 оны 12 сард туршилтын байдлаар эхлүүлсэн ЛэндМН бичил хэрэглээний зээлийн шийдлийг 2017.11.30-ны байдлаар буюу 11 сарын хугацаанд нийт 90,000 гаруй хэрэглэгч татан суулгаж, 20 орчим хувь буюу 19,000 орчим нь харилцагч болон үйлчлүүлсэн байна.

Зээлийн эргэн төлөлтийг урамшуулан шимтгэлийн хэмжээг шатлалтайгаар бууруулах тогтолцоог нэвтрүүлсэн нь ① харилцагчдын эргэн төлөлтийг дэмжиж хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээг харьцангуй бага буюу 1.1 хувь байхад нөлөөлсөн ② 1 харилцагчийн зээл авах давтамж өсөн дунджаар 3.5 удаа зээл дахин авч байна ③ 1 харилцагчийн зээл авах дундаж дүн тогтмол өсч байгаа гэсэн үзүүлэлтүүдээр харагдаж байна.

## 3. Үнэт цаас гаргагчийн бизнесийн ирээдүйн боломжийн тухай

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны өнөөгийн чиглэл буюу "Бичил хэрэглээний зах зээл"нь гол төлөв иргэд хооронд болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээгээр явагддаг бөгөөд бэлэн статистик мэдээлэл хомс тул бид бизнесийн онцлогийг харгалзан дараах 5 аргачлалаар зах зээлийн багтаамжийг таамаглан судаллаа.

Нэгж: төгрөг

| | Судалгааны арга | Зах зээлийн багтаамж |
|---|---|---|
| 1 | Нас болон орлогын түвшинд суурилсан хэрэглэгчид | 1 их наяд |
| 2 | Технологи хэрэглээгээр тодорхойлсон хэрэглэгчид | 600 тэрбум |
| 3 | Өрхийн орлого, зарлагад суурилсан хэрэглэгчдийн судалгаа | 1.35 их наяд |
| 4 | Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үзүүлэлт | 600 тэрбум |
| 5 | Бизнесийн мөчлөг дээр үндэслэсэн зах зээлийн багтаамж | 960 тэрбум |
| | Зах зээлийн багтаамж /дундаж/ | 900 тэрбум |

*Эх сурвалж: Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зах зээлийн судалгаа*

Финтек бичил хэрэглээний зээлийн үйлчилгээ нь иргэдийн санхүүгийн бодит хэрэгцээнээс гадна гар утасны аппликэйшн ашиглах чадварыг давхар

өр зээлийн талаар үнэт цаасны танилцуулгад дэлгэрэнгүй мэдээлсэн байх;

20180119

тооцох шаардлагатай бөгөөд, технологийн хэрэглээ нь цаг хугацаа өнгөрөх тусам хурдацтай нэмэгдэх хандлагатай байдаг. Дээрх 5 аргачлалаар ЛэндМН ББСБ-ийн үзүүлж буй бичил хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамжийг үнийн дүнгээр тооцоолон үзэхэд ойролцоогоор 900 тэрбум төгрөг байхаар таамаглагдаж байгаа боловч цаашид иргэдийн гар утасны технологи ашиглах чадвар дээшлэх зэрэг үзүүлэлт нь зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх боломжтой.

Түүнчилэн банк санхүүгийн байгууллагуудын хэрэглээний зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд өсөлттэй байж, 2016-2017 онуудад жилд дундаж өсөлт 12% байгааг авч үзэхэд бичил хэрэглээний зээлийн зах зээлийн багтаамж ирэх 5 жил буюу 2018-2022 онуудад 1.8 их наяд төгрөг хүртэл өсөх боломжтой гэж таамаглав.

СЗХ-ны банк бус санхүүгийн байгууллагын газраас гаргасан 2017 оны 2 улирлын тайланд дурдсанаар нийт зээлийн дунд эзлэх хэрэглээний зээлийн үзүүлэлт өндөр байна. Тухайлбал хэрэглээний зээл нь иргэдэд олгосон зээлийн 49.9% буюу 132 тэрбум төгрөгийг, эргэн төлөлтийн дүн хамгийн өндөр буюу 106 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь 41.5% буюу 230 тэрбум төгрөг байна.

Харин ЛэндМН ББСБ ХХК-ийн бичил хэрэглээний зээлийн онцлог нь богино хугацаатай тул харьцангуй хурдан эргэн төлөлт хийгддэг нь компанийн үйл ажиллагааны эргэлтийг дэмжин зээлийн үлдэгдлийг харьцангуй доогуур түвшинд байлгах, нийт олгосон зээлийн дүн өндөр байх нөхцлийг бүрдүүлж байна.

ЛэндМН ББСБ ХХК нь нийт зах зээлийн багтаамжийн хувьд 2018-2022 онуудад зах зээл дээрх нийт боломжит хэрэглэгчдийн 17%-23%-д хүрч үйлчилгээгээ үзүүлэхээр зорин ажиллаж байна. Дээр дурдсанчилан Финтек технологийн шийдэл нь түргэн шуурхай хялбар зээлийн үйлчилгээг санал болгож, салбартаа "Шинэ зах зээл" үүсгэж байгаа гэдэг утгаараа зээлийн давтамж, эргэн төлөлтийн хурд, хөрөнгийн эргэц зэргийг уламжлалт зээлийн бүтээгдэхүүнтэй харьцуулах боломжгүй юм. Иймд зах зээлд эзлэх хувийг нийт боломжит харилцагчдын хэдэн хувьд нь хүрч ажиллах вэ гэдгээс тооцох нь зохистой юм. Компанийн зүгээс цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бичил бизнесийн зээл зэрэг шинэ бүтээгдэхүүн нэмэгдэхэд компанийн үйлчилгээ үзүүлэх цар хүрээ үүнээс тэлэх боломжтой гэж таамаглаж байна.

20180119

## 4. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээллийн тухай

Компани нь бизнес төлөвлөгөөний хүрээнд 2018 онд нийт 14 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлэх шаардлагатайгаас 5 тэрбум төгрөгийг нэмж хувьцаа гарган 9 тэрбум төгрөгийг өрийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

### Тайлан тэнцлийн таамаглал

| ТАЙЛАН ТЭНЦЭЛ (Сая төгрөг) | 2017[1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгө ба түүнтэй адилтгах | 2,085.0 | 4,155.7 | 4,036.7 | 2,354.4 | 4,489.4 | 4,440.2 |
| Харилцагчдад олгосон нийт зээл | 4,635.4 | 20,738.0 | 37,362.6 | 55,734.7 | 71,966.5 | 88,267.8 |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын нөөц | (46.4) | (311.1) | (747.3) | (1,114.7) | (1,799.2) | (2,648.0) |
| Нийт цэвэр зээл | 4,589.0 | 20,426.9 | 36,615.3 | 54,620.0 | 70,167.3 | 85,619.8 |
| Үндсэн ба биет бус хөрөнгө | 380.6 | 462.4 | 424.8 | 387.2 | 355.5 | 238.8 |
| | | | | | | |
| **Нийт хөрөнгө** | **7,054.6** | **25,048.1** | **41,078.9** | **57,361.6** | **75,003.2** | **90,298.8** |
| | | | | | | |
| Өр төлбөр | 1,000.0 | 10,000.0 | 21,000.0 | 30,000.0 | 38,500.0 | 41,460.0 |
| | | | | | | |
| **Нийт өр төлбөр** | **1,000.0** | **10,000.0** | **21,000.0** | **30,000.0** | **38,500.0** | **41,460.0** |
| | | | | | | |
| Эздийн өмч | 6,000.0 | 11,000.0 | 11,599.0 | 12,383.6 | 13,515.2 | 14,943.0 |
| Хуримтлагдсан ашиг | 54.6 | 4,048.1 | 8,479.9 | 14,978.0 | 22,988.0 | 33,895.8 |
| Өнгөрсөн оны хуримтлагдсан ашиг | (5.4) | 54.6 | 4,048.1 | 8,479.9 | 14,978.0 | 22,988.0 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | 60.0 | 3,993.4 | 5,230.5 | 7,544.2 | 9,518.8 | 12,811.5 |
| Тараасан ногдол ашиг | - | - | (798.7) | (1,046.1) | (1,508.8) | (1,903.8) |
| **Нийт эздийн өмч** | **6,054.6** | **15,048.1** | **20,078.9** | **27,361.6** | **36,503.2** | **48,838.8** |
| | | | | | | |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **7,054.6** | **25,048.1** | **41,078.9** | **57,361.6** | **75,003.2** | **90,298.8** |

[1] Хүлээгдэж буй гүйцэтгэл

### Орлогын тайлангийн таамаглал

| ОРЛОГЫН ТАЙЛАН (Сая төгрөг) | 2017[1] | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Хүү ба түүнтэй адилтгах орлого | 1,005.0 | 7,925.6 | 11,746.7 | 16,724.7 | 21,279.9 | 27,257.8 |
| Хүүгийн зардал | (41.3) | (746.7) | (2,420.0) | (4,013.3) | (5,370.0) | (6,330.9) |
| Зээлийн эрсдлийн сангийн зардал | (78.2) | (284.4) | (480.2) | (438.8) | (778.3) | (971.0) |
| | | | | | | |
| **Цэвэр хүүгийн орлого** | **885.6** | **6,894.6** | **8,846.5** | **12,272.5** | **15,131.6** | **19,955.9** |
| | | | | | | |
| Цалин | (268.3) | (569.9) | (648.1) | (767.6) | (981.1) | (1,202.2) |
| Бусад зардал | (460.4) | (907.7) | (819.4) | (958.0) | (1,056.1) | (1,170.3) |
| Системийн засвар үйлчилгээний зардал | (90.2) | (702.3) | (1,005.1) | (1,087.9) | (1,002.6) | (1,101.3) |
| | | | | | | |
| **Нийт үндсэн үйл ажиллагааны зардал** | **(818.9)** | **(2,170.0)** | **(2,472.5)** | **(2,813.5)** | **(3,039.9)** | **(3,473.8)** |
| | | | | | | |
| **Татварын өмнөх ашиг** | **66.7** | **4,724.6** | **6,374.0** | **9,459.0** | **12,091.8** | **16,482.1** |
| | | | | | | |
| Татвар | (6.7) | (731.1) | (1,143.5) | (1,914.7) | (2,572.9) | (3,670.5) |
| | | | | | | |
| **Цэвэр ашиг** | **60.0** | **3,993.4** | **5,230.5** | **7,544.2** | **9,518.8** | **12,811.5** |

[1] Хүлээгдэж буй гүйцэтгэл

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний үндэслэл, санхүүгийн таамаглал, Финтек шийдлийн хувьд Монгол улсад анхдагч бөгөөд харилцагчийн хүрээгээ тэлэх боломж өндөр, манай улсын иргэдийн технологи хэрэглээний түвшин болон хэрэглээний зээлийн эрэлт өндөр байгаа зэрэг суурь үзүүлэлтүүдийг авч үзэхэд ЛэндМН ББСБ ХХК нь бизнес төлөвлөгөөний дагуу зах зээлд эзлэх байр суурийа нэмэгдүүлэх хангалттай нөөц боломж байна гэж дүгнэж байна.

20180119

## 5. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын тухай

ЛэндМН ББСБ ХХК-ийн 2018 оны 01 сарын 19 өдрийн ТУЗ-ын шийдвэр, 2018 оны 01 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 18/01[17] тоот шийдвэрийг үндэслэн нийт энгийн хувьцааны 25% буюу 200,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган 5'000'000'000 (таван тэрбум) төгрөгийг татан төвлөрүүлж бичил хэрэглээний зээлийн санхүүжилтэнд зарцуулахаар шийдвэрлэжээ.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтийг үндэслэн "Олон нийтээс санхүүжилт татан төвлөрүүлэх" үндэслэл нь дараах байдлаар тодорхойлогдож байна.

5.1 Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний дагуу 2018 онд бичил хэрэглээний зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд нийт 14 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд үүний 5 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх.

5.2 ЛэндМН ББСБ ХХК-ийн бичил хэрэглээний зээлийн эрэлт огцом нэмэгдэж байгаа бөгөөд хэрэглээний зээлийн улирлын мөчлөгийн онцлогоос хамааран 2018 оны 1-р улиралд бэлэн мөнгөний эрэлт өсөх хандлагатай байгаа тул эх үүсвэрийг нэн тэргүүнд шийдэх шаардлагатай.

5.3 Финтек шийдэлд суурилсан санхүүгийн үйлчилгээний бизнес загварыг нэвтрүүлсэн олон улсын туршлагаас харахад бизнесийн амьдралын мөчлөгийн эхэн үед харилцагчийг тэлэх бодлого явуулах нь цаашид зах зээлд анхдагчийн байр сууриа хадгалах эсэхийг тодорхойлох хүчин зүйл болдог хэмээн тодорхойлсон байх тул энэхүү санхүүжилт нь компанийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж байна.

[17] Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 5/171 тоот мэдэгдлийг үндэслэн "Нийтэд 12.5%-ийг санал болгох тухай" Үнэт цаас гаргагчийн 2017 оны 12 сарын 07 өдрийн ТУЗ-ын шийдвэр, 2017 оны 12 сарын 08 өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 17/18 тоот шийдвэр хүчингүй болж өөрчлөгдсөн болно.

20180119

## 6. Хөрөнгө оруулалтын өгөөж

| Нэгж хувьцааны өгөөж | 2017 | 2018Т | 2019Т | 2020Т | 2021Т | 2022Т |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт хувьцаа (сая ширхэг) | 600.0 | 800.0 | 820.0 | 846.1 | 883.8 | 931.4 |
| Эздийн өмч (сая төгрөг) | 6,054.6 ₮ | 15,048.1 ₮ | 20,078.9 ₮ | 27,361.6 ₮ | 36,503.2 ₮ | 48,838.8 ₮ |
| Дансны үнэ | 10.1 ₮ | 18.8 ₮ | 24.5 ₮ | 32.3 ₮ | 41.3 ₮ | 52.4 ₮ |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) | 0.1 ₮ | 5.0 ₮ | 6.4 ₮ | 8.9 ₮ | 10.8 ₮ | 13.8 ₮ |
| Ашгийн үнэлгээ (P/E) | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| Эздийн өмчийн үнэлгээ (P/B) | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 |
| Боломжит (P/E)-д суурилсан ханш | 1.0 | 49.9 | 63.8 | 89.2 | 107.7 | 137.5 |
| Боломжит (P/B)-д суурилсан ханш | 20.2 | 37.6 | 49.0 | 64.7 | 82.6 | 104.9 |
| Боломжит ханш (дундаж) | 10.6 ₮ | 43.8 ₮ | 56.4 ₮ | 76.9 ₮ | 95.1 ₮ | 121.2 ₮ |
| Жилийн өгөөж | | 313% | 29% | 36% | 24% | 27% |
| IPO өгөөж @ 25₮ | | 75% | 126% | 208% | 281% | 385% |
| Боломжит нийт үнэлгээ (сая төгрөг) | | 35,015.3 ₮ | 46,231.3 ₮ | 65,082.8 ₮ | 84,097.4 ₮ | 112,896.5 ₮ |

*2022 оныг хүртэлх жил бүрийн үнэт цаасны ханшийн таамаг: жишиг P/E=10X, P/B=2*

ЛэндМН ББСБ ХХК нэгж хувьцаагаа олон нийтэд нэг бүр нь 25 төгрөгөөр санал болгож байгаа бөгөөд компани 2018 онд зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалан бизнес төлөвлөгөөний дагуу нийт 196 тэрбум төгрөгийн зээл гаргаж, 20 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэйгээр зах зээлийн багтаамжаа тэлж чадсан тохиолдолд хөрөнгө оруулагчид 75 хувийн хөрөнгө оруулалтын өгөөж хүртэж болохоор таамаглагдаж байна.

Энэхүү төсөөлөл нь харьцангуй гутранги байдлаар тооцоологдсон буюу МХБ(P/E дунджаар 47X, P/B 3X)[18], олон улсын финтек компаниудын жишиг дундаж харьцааны(P/E=10X, P/B=2X)[19] аль доогуур түвшнийг сонгож хөрөнгө оруулагчдад өгөөжийн таамаглалыг харьцангуй бодитоор харах боломжийг олгохыг зорьсон болно.

## 7. Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

### 7.1 МХБ ТӨХК бүртгэлийн шалгуур:

Компани нь МХБ ТӨХК-ийн ТУЗ-ийн 2015.12.30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 13.1.3-д заасны дагуу Бирж дээр арилжаалагдсан эсхүл үйл ажиллагаа явуулсан байвал зохих хугацааны болон үнэт цаасны олон нийтийн эзэмшилд байх доод хэмжээг тогтоогоогүй/25%/, шинэлэг санаа бүхий, эрсдэл өндөртэй, жижиг, дунд хэлбэрийн компани тул бүртгэлийн III ангиллын шалгуурыг хангаж байгаа гэж үзэж байна.

### 7.2 Санал болгох үнэ:

Компани нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий энгийн хувьцааг нэг бүр нь 25 төгрөгөөр санал болгохоор шийдвэрлэсэн. Гэрэгэ Эстимэйт үнэлгээний компанийн финтек санхүүгийн бизнесийн ирээдүйн ашигт

[18] Үнэт цаасны танилцуулгын хөрөнгө оруулалтын өгөөж хэсэгт дэлгэрэнгүй тайлбар орсон болно.

[19] Qudian Inc P/E=11X, P/B=3X; SLM Corporation P/E=14.7X; P/B=2.2X, OneMain Holding Inc P/E=7X, P/B=1X

20180119

ажиллагааны боломжид үндэслэн тооцоолсон нэгж хувьцаанд ногдох бизнесийн үнэ цэнэ 46.4 төгрөг байна. Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй үнэ болох 25 төгрөг нь тус үнэлгээнээс 46%-ийн доогуур байгаа нь анхдагч зах зээлд оролцож буй хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын өгөөжийн хувийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

7.3 **Санал болгох төлөвлөгөө**

Үнэт цаас гаргагч нь нийт энгийн хувьцааны 25% буюу 200,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган 5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлнэ. Үүнд нийт гаргаж буй 25%-ийн 12.5%-г олон нийтэд, 12.5%-г хаалттай хүрээнд стратегийн ач холбогдолтой хөрөнгө оруулагчдад санал болгохоор төлөвлөж байна. Компани нь олон нийтэд санал болгохдоо "Аль болох олон хувьцаа эзэмшигч нарыг хувьцаа худалдан боломжоор хангах" бодлогыг барьж буй нь "Хөрөнгийн зах зээлийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх" ач холбогдолтой хэмээн үзэж байна.

## 8. Үнэт цаасыг олон нийтэд санал болгох төлөвлөгөөний "Хөрөнгийн зах зээлийн хөгжил"-д оруулах хувь нэмэр:

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11-р зүйлийн 11.1, 11.2-т заасны дагуу тус үнэт цаасыг нийтэд санал болгох төлөвлөгөөний онцлогийг дараах байдлаар тодорхойлж байна.

8.1 Нийтэд санал болгохдоо аль болох олон хувьцаа эзэмшигчид тархаан байршуулснаар "Хөрөнгийн зах зээлийн хүртээмжтэй байдал"-д хувь нэмэр оруулан, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх

8.2 Нийт нэмж гаргаж буй хувьцааны 50%-г стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгож буй нь компанийн хувьд стратеги, бизнес төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх үндэс болох

8.3 Үнэт цаасны захиалгыг гар утсаар авах боломжоор хангаснаар цаашид манай улсад гар утсаар дамжуулан хувьцааны арилжаанд ороход иргэдийг бэлдэх

8.4 Компанийн "Ногдол ашгийн бодлого"-топ "нийт цэвэр ашгийг тухайн жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх түвшинд ногдол ашиг хуваарилж болно" хэмээн тодорхойлсон нь компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхийн зэрэгцээ, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

## 9. Хөрөнгө оруулагчдын анхаарах зүйлс

9.1 Тус үнэт цаас нь МХБ ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын Хувьцааны бүртгэлийн III ангиллын дагуу

20180119

*"Мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгон арилжаалагдах" бөгөөд тус журмын 13.1.5-д заасны дагуу "Мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болох бөгөөд энэ тохиолдолд тухайн үнэт цаас нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бичгээр мэдэгдсэн байна"*

хэмээн заасны дагуу хөрөнгө оруулагчид тус үнэт цаасны эрсдлийн хүчин зүйлстэй танилцан харилцагч үнэт цаасны компанидаа бичгээр мэдэгдсэний үндсэн дээр захиалгаа өгөхийг анхааруулж байна.

9.2 Тус үнэт цаасны хөрөнгө оруулалтын өгөөжийн тооцооллыг үнэлгээний компанийн бизнесийн үнэлгээний тайлан, үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө, зах зээлийн багтаамж, ирээдүйн боломж дээр үндэслэн гаргасан боловч технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн гэдэг утгаараа уламжлалт санхүүгийн бизнесээс илүү олон төрлийн эрсдлийн хүчин зүйлс байх тул үнэт цаасны танилцуулгын "Эрсдлийн шинжилгээ"-ний хэсэгтэй танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

## 10. Нэгдсэн дүгнэлт

Үнэт цаас гаргагчийн толгой компанийн зүгээс Сингапур, Филлипин, Малайз, Индонез, Япон зэрэг Ази Номхон Далайн орнуудын зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж буй ЛэндМН төслийг юун түрүүн Монгол улсын санхүүгийн салбарт амжилттай нутагшуулсан нь сайшаалтай явдал юм.

Андеррайтерийн зүгээс зах зээлийн судалгаан дээр ажиллах явцдаа ЛэндМН ББСБ ХХК нь "бичил хэрэглээний зээл"-ийн хэрэглэгчийн зан төлөв, зах зээлийн онцлогийг сайтар судалсны үндсэн дээр хэрэглээний зээлийн салбарт иргэдэд ойр "Санхүүгийн шинэ шийдэл"-ийг санал болгож чадсан тул харьцангуй богино хугацаанд 18,998 иргэдийг харилцагчаар татан 64,000 гаруй удаагийн зээлийг амжилттай олгож чаджээ хэмээн дүгнэж байна.

Бүтээгдэхүүн, санхүүгийн шийдлийн хувьд манай улсад шууд харьцуулах компани байхгүйн улмаас бид энэхүү бизнесийн ирээдүйн боломж, зах зээлийн багтаамжийг судлахын тулд олон улсын практик зэрэг маш олон талаас нь авч үзлээ. Судалгааны үр дүнд компани бизнес төлөвлөгөөгөө биелүүлж болохуйц хангалттай зах зээл буюу жилд дунджаар 900 тэрбум төгрөгийн зээл зөвхөн бичил зээлийн харилцаанд үүсдэг байх боломжтой хэмээн таамаглагдсан билээ.

20180119

Олон улсын туршлагаас харахад хиймэл оюун ухаан, санхүүгийн үйлчилгээг хослуулсан тус бизнес нь технологид суурилсан гэдэг утгаараа өрсөлдөөн өндөр байдаг тул ЛэндМН компанийн зүгээс "Тэргүүлэгч"-ийн байр сууриа хадгалахын тулд технологийн шийдлийг сайжруулах, зах зээлийг багтаамж, бичил зээлийн эрэлтэд үндэслэн харилцагчийн цар хүрээг нэмэгдүүлэх бодлогыг шуурхай баримталж ажиллах нь зүйтэй хэмээн харж байна.

Андеррайтер нь тус бизнесийн үйл ажиллагаатай танилцах явцад тус "Шийдэл" нь бизнесийн үр ашгаас гадна

1. Аль болох олон хувьцаа эзэмшигчид тархаан байршуулснаар "Хөрөнгийн зах зээлийн хүртээмжтэй байдал"-д хувь нэмэр оруулан, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх
2. Нийт нэмж гаргаж буй хувьцааны 50%-г стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгож буй нь компанийн хувьд стратеги, бизнес төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх үндэс болох
3. Компани "Ногдол ашгийн бодлого"-тоо "нийт цэвэр ашгийг тухайн жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх түвшинд ногдол ашиг хуваарилж болно" хэмээн тодорхойлсон нь компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхийн зэрэгцээ, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой
4. Нийтэд санал болгож буй нэгж хувьцааны үнэ болох 25 төгрөг нь Гэрэгэ Эстимэйт үнэлгээний компанийн тооцоолсон нэгж хувьцаанд ногдох бизнесийн цэвэр үнэ цэнээс/46.4 төг/ 46%, үнэт цаас гаргасны дараагаарх нэгж хувьцаанд ногдох бизнесийн цэвэр үнэ цэнээс/41.1төг/ 39% доогуур байгаа нь хөрөнгө оруулагчдын хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх
5. Үнэт цаасны захиалгыг гар утсаар авах боломжоор хангаснаар цаашид манай улсад гар утсаар дамжуулан хувьцааны арилжаанд ороход иргэдийг бэлдэх
6. Монгол улсын санхүүгийн зах зээлд дутагдаад буй "Зээлдэгчийн үнэлгээ"-ний өгөгдлийн санг бүрдүүлэхэд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах
7. Иргэд бага дүнтэй зээлийг хугацаа алдалгүй төлснөөр харилцагчдын санхүүгийн сахилга батыг сайжруулахад хувь нэмрээ оруулах
8. Монгол улсын анхны Финтек шийдлийг нэвтрүүлсэн компани МХБ дээр олон нийтийн компани болсон гэдэг утгаараа олон улсын зах зээлд Монгол улсын хөрөнгийн зах зээлийг таниулахад хувь нэмэр оруулах

20180119

## 3.9 АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА

"МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК" ХХК нь 2013 онд байгуулагдсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны брокер диллер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, номинал дансаар дамжуулан харилцагчдад брокерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэйгээр Монгол улс болон олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа Монгол-Солонгосын хамтарсан хөрөнгө оруулалттай компани юм. .

Компанийн толгой компани болох БНСУ-ын "KDB Дэү Секьюритис" компани нь 2016 онд тус улсын "Мирэ Эссет" санхүүгийн групптэй нэгдэж "Мирэ Эссет Дэү" санхүүгийн групп болсон ба одоо Ази номхон далайн улс орнууд, Их Британи, АНУ зэрэг санхүүгийн хөгжингүй зах зээлийг багтаасан нийт 10 улсад үйл ажиллагаагаа явуулдаг БНСУ-ын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банкны нэг билээ.

"МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК" ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээ нийт 4.7 тэрбум төгрөг бөгөөд 2017 оны 12-р сарын байдлаар удирдаж буй харилцагчдийн нийт хөрөнгө 82 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Компани нь байгуулагдсан цагаас хойш Монгол улсын хөрөнгийн зах зээлд хэд хэдэн анхдагч санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж байсан туршлагатай. Бид 2014 оны 6 сард олон улсын хөрөнгийн зах зээлд анх удаа бондын арилжааг хийж эхэлсэн бөгөөд, 2014 оны 7 сард БНСУ-ын хөрөнгийн зах зээлд анхны Монгол улсын санхүүгийн бүтээгдэхүүнийг танилцуулж, Худалдаа Хөгжлийн Банкны нийт 54 сая ам.долларын хадгаламжийн сертификатыг амжилттай гаргасан байна.

2017 оны 12-р сарын 1-ний өдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржийн ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн нийт арилжааны 17 хувийг гүйцэтгэж арилжааны үнийн дүнгээр хоёр дугаарт жагссан бол хоёрдогч зах зээлийн арилжааны 40 хувийг гүйцэтгэж арилжааны нийт үнийн дүнгээр мөн хоёр дугаарт жагсаж байна. Компани нь Хөрөнгийн зах зээл хөгжсөн орны туршлага ноухауг Монгол Улсдаа нэвтрүүлж Монгол Улсын хөрөнгийн зах зээлд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлэн хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

20180119

MIRAE ASSET Securities

**БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ**

lendmn

MIRAE ASSET Securities

**“МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК” ХХК**
Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-17, Блю Скай Тауэр 4 давхар, 406 тоот.
n.tsevegmed@miraeasset.com
Утас:(976) 7011-0806

| Үнэт цаасны материалтай холбоотой мэдээлэл өгөх хариуцлагатан | | |
|---|---|---|
| Байгууллагын нэр | ЛЭНДМН ХХК | “МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК” ХХК |
| Хариуцах ажилтан | М.Тувшинжаргал | Н.Цэвэгмид |
| Албан тушаал | Захирал | Захирал |
| Утас | 9908-8809 | 9999-9881 |
| Цахим шуудан | tuvshinjargal@lend.mn | n.tsevegmed@miraeasset.com |

2018 01 19